



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ПРОТОКОЛ

1991 оны II
сарын 12-өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Ардын Их Хурлын II хуралдааны 2 дахь өдрийн ажиллагаа өглөөний 9⁰⁰ цагт Ардын Их Хурлын хуралдааны танхимд эхлэв. Хуралдааныг Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан даргалав. Хуралдаанд 427 депутат хүрэлцэн ирэхээс 400 депутат ирсэн, ирц 93 хувь байв. Депутат Г.Чингэл, Г.Батмөнх, Ц.Охинтогтох, Н.Сампилноров нар өвчтэй, Л.Лантуу, Г.Сүрэнжаргал нар гадаадад ажлаар явсан байв.

Хуралдааны нэр дээр байгууллага, хамт олон, хөдөлмөрчдөөс ирсэн санал, хүсэлт, утас, цахилгааныг Ардын Их Хурлын орлогч дарга Н.Батбаяр 9⁰⁶ цагт уншиж сонсгов.

9¹⁷ цагаас Дэгийн II булэг II-р зүйлээс эхэлж хэлэлцэв. 2II-р тойргийн депутат Д.Дагвацорж, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 36-р тойргийн депутат Р.Бэцэндээмбэрэл, 46-р тойргийн депутат Ю.Жаргал, 341-р тойргийн депутат П.Бямбажав, 351-р тойргийн депутат Б.Мөнгөн, 183-р тойргийн депутат Ц.Намсрай, 361-р тойргийн депутат Л.Чулуунбат, 349-р тойргийн депутат Ц.Баянбилэг 7-р тойргийн депутат Ц.Балдорж, 228-р тойргийн депутат Н.Адъялаха, 19-р тойргийн депутат Б.Батсайхан, 151-р тойргийн депутат Б.Алгаа, 422-р тойргийн депутат Н.Төмөртогоо, 313-р тойргийн депутат Н.Чагнаа, АИХ-ын дарга Ж.Уртнасан депутатуудын гаргасан саналуудтай холбогдуулан депутат С.Баяраа тайлбар хэлэхийг хүсэв. I-р тойргийн депутат С.Баяр зарим тайлбар хэлэв. Депутатуу, цааш нь үргэлжлүүлэн саналаа гаргав. 101-р тойргийн депутат Р.Доржбат, 63-р тойргийн депутат Х.Пүрэвдагва, 227-р тойргийн депутат Б.Баасанхүү, 202-р тойргийн депутат Ж.Адъяа, 356-р тойргийн депутат Л.Шархүү, 32-р тойргийн депутат Д.Мандах, АИХ-ын дарга Ж.Уртнасан саналаа таслахад зүйл зүйлээр нь хэлэлцүүлэх санаа гаргав. Энэ саналыг зөвшөөрсөн 314 /92%, татгалзсан 20/5%, түдгэлzsэн 7 /2%, бүгд 341.

Ж.Уртнасан чуулганы дэгтэй холбогдуулан зарим тайлбар хэлэв. II булгийн II-р зүйлийн I-р хэсгээс эхлэн хэлэлцье гэв. 104-р тойргийн депутат Д.Жагварал, 13-р тойргийн депутат Л.Цог, 45-р тойргийн депутат М.Энхсайхан, 48-р тойргийн депутат С.Жадамбаа, 149-р тойргийн депутат Т.Аннагар, 167-р тойргийн депутат Ш.Гүрбааар, 303-р тойргийн депутат Ж.Норовсамбуу, АИХ-д оруулж ирсэн төслийн нэрээр байлгах уу? гэдэг саналыг

зөвшөөрсөн 288/90%, татгалзсан 62 /17%, түдгэлзсэн 8/2% бүгд 358 /83%, I-р бүлгийн II дүгээр зүйлийн 2-р заалтыг хасъя гэсэн саналыг зөвшөөрсөн 327/81%, татгалзсан 63/15%, түдгэлзсэн 10/2%, бүгд-400 /93%, Мөн зүйлийн 3-р заалтыг хэвээр үлдээе гэсэн саналыг зөвшөөрсөн 382/94%, татгалзсан 18/4%, түдгэлзсэн 4 /0%, бүгд-404 /94%, Мөн зүйлийн 4-р хэсгийн "а" заалтыг үлдээе гэдэг дээр зөвшөөрсөн 377/94%, татгалзсан 18/4%, түдгэлзсэн 3/0%, бүгд-398/83%, 12-р тойргийн депутат Г.Очирбат 4-р зүйл дээр санал хэлэв. 9-р тойргийн депутат С.Зори 245-р тойргийн депутат У.Чинбат, 55-р тойргийн депутат Ц.Адья-сурэн, 167-р тойргийн депутат Ш.Гүрбазар, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, 393-р тойргийн депутат Д.Баасанжав, 289-р тойргийн депутат Ж.Отгон, 50-р тойргийн депутат А.Далхжав, АИХ-ын дарга Ж.Уртнасан "Б" заалтыг редакци хийж үлдээе гэдэг дээр зөвшөөрсөн 277/69%, татгалзсан 115/28%, түдгэлзсэн 9/2%, бүгд-401 /93%, Хүн бур 10 + нэмэх минут заалт төсөлд оруулах уу гэсэн саналыг зөвшөөрсөн 204/49%, татгалзсан 192/46%, түдгэлзсэн 13/03%, бүгд 95%, Улсын Бага Хурал, түүний комисс гэдэг дээр нэмэлт хийхгүйгээр гэдгийг зөвшөөрсөн 336/82%, татгалзсан 64 /15%, түдгэлзсэн 6/1%, бүгд-406 /95%, 264-р тойргийн депутат Б.Бандь, 44-р тойргийн депутат Ш.Сүрэнжав, 258-р тойргийн депутат Ш.Гунгаадорж, 287-р тойргийн депутат Ч.Хурц, 132-р тойргийн депутат С.Чулуванбаатар, 26-р тойргийн депутат Д.Сүрэнхорлоо, 31-р тойргийн депутат Д.Дожодорж нар уг халэв.

Хуралдаан II⁰⁰ цагт завсарлаад II²² цагт үргэлжлэв.

21-р тойргийн депутат И.Мөнхдорж, 12-р тойргийн депутат Г.Очирбат, 360-р тойргийн депутат Д.Найдан, 153-р тойргийн депутат Д.Чойжамы, 315-р тойргийн депутат У.Бат-Эрдэнэ, 407-р тойргийн депутат Б.Нүүрэй, 96-р тойргийн депутат Н.Сэндэнжав, редакцийн комисст өгч засуулаад үлдээе "Г" заалт дээр санал хурааж зөвшөөрсөн 391/93%, татгалзсан 24/5%, түдгэлзсэн 3/000%, бүгд 408/95%, "Д" заалт дээр санал хураая. зөвшөөрсөн 353/86%, татгалзсан 44/10%, түдгэлзсэн 9 , бүгд -"-" "е" заалтыг дээдэхтэй нь уяцдуулья гэдэг талаар 234-р тойргийн депутат Д.Дэмбэрэл саналаа гаргав. 191-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, "е" заалтыг үлдээе гэдэг дээр санал хураалтад хусалт гаргав. Зөвшөөрсөн 375/93%,

татгалзсан 16/3%, түдгэлзсэн 12/2%, бүгд 403/94%,

13-р тойргийн депутат Л.Цог ажлын хэсэг нэгтэй байх уу? Хороо бүр ажлын хэсэгтэй байх уу? гэдгийг тодруулж санал хураалгаж өгөхийг хүсэв. 12-р тойргийн депутат Г.Очирбат "ё" заалтын талаар өөрийн гаргасан томьёололоо дахин хэлж, энэ талаар санал хураалгаж өгөхийг хүсэв. Депутат Г.Очирбатын саналыг төсөлд тусгах уу? үгүй юу? гэдэг дээр санал хураав. Зөвшөөрсөн 393/82%, татгалздан 54/13%, түдгэлзсэн 17 /4%, бүгд 404/94%, "ж" заалтыг үлдээх дээр санал хураав. зөвшөөрсөн 384, татгалзсан 15, түдгэлзсэн 6, бүгд -405.

234-р тойргийн депутат Д.Дэмбэрэл, 75-р тойргийн депутат Я.Хүрлээ, 328-р тойргийн депутат Б.Дашзваг, 163-р тойргийн депутат Б.Мижид, 24-р тойргийн депутат Р.Хатанбаатар, 277-р тойргийн депутат Л.Болд, 1-р тойргийн депутат С.Баяр, 71-р тойргийн депутат Т.Яцамсүрэн, 283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн, 258-р тойргийн депутат Ш.Гунгаадорж, депутат Г.Очирбатын гаргасан саналаас "24 цагийн дараа дахин хэлэлцэнэ" гэдэг үгийг хасъя гэсэн саналыг зөвшөөрсөн 340 /84%, татгалзсан 54/13%, түдгэлзсэн 9/2%, бүгд : 403, 239-р тойргийн депутат Ж.Отгон, 422-р тойргийн депутат Н.Төмөртогоо, 284-р тойргийн депутат Ш.Бадам, 33-р тойргийн депутат Д.Мөнхөө, 133-р тойргийн депутат Ц.Нацагдорж, 261-р тойргийн депутат Д.Пүрэв, 56-р тойргийн депутат Р.Гончигдорж нар санал гаргав.

Депутат Д.Мөнхөөгийн саналыг зөвшөөрсөн 376/91%, татгалзсан 23/4%, түдгэлзсэн 13/3%, "И" заалтыг хэлэлцье. 168-р тойргийн депутат Г.Вандандагва, 315-р тойргийн депутат У.Бат-эрдэнэ, 354-р тойргийн депутат Ш.Бороодой, "И" заалтыг хасъя гэсэн саналыг зөвшөөрсөн 328/80%, татгалзсан 63/15%, түдгэлзсэн 15 /3%, 5-р хэсгийн "а" заалтад редакц хийж үлдээх саналыг зөвшөөрсөн 381/93%, татгалзсан 16/3%, түдгэлзсэн 11/2%, бүгд 408/95%, "б" заалтыг хасъя гэсэн саналыг зөвшөөрсөн 339/82%, татгалзсан 62/15%, түдгэлзсэн 10/2%, бүгд 411/96%, "В" заалтыг хасъя гэсэн саналыг зөвшөөрсөн 328/80%, татгалзсан 57/14%, түдгэлзсэн 20/4%, бүгд 405/94%, 63-р тойргийн депутат Х.Пүрэвдагва, 167-р тойргийн депутат Ш.Гүрбазар, 191-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, 170-р тойргийн депутат Д.Лхагвасүрэн,

429-р тойргийн депутат Д.Рэнцэннацаг, 3-р тойргийн депутат Р.Барсболд, 50-р тойргийн депутат А.Далхжав, 315-р тойргийн депутат У.Бат-эрдэнэ, 273-р тойргийн депутат Н.Жанцан, 170-р тойргийн депутат Д.Лхагвасүрэн, 39-р тойргийн депутат Б.Ламжав, 69-р тойргийн депутат Ж.Ядамсүрэн, 283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн нар уг хэлэв. ~~5^b~~^V-т байлгахыг зөвшөөрсөн 108/26%, татгалзсан 285/70%, түдгэлзсэн 12/2%, бүгд 405/94%, ~~5^b~~^V-т хасах болов.

272-р тойргийн депутат С.Лунаа, 309-р тойргийн депутат Д.Батбаяр, 39-р тойргийн депутат Б.Ламжав, 283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн, 288-р тойргийн депутат С.Баярцогт нар уг хэлэв.

5^Г-д нэрсээр санал хураана гэж оруулахыг зөвшөөрсөн 250/61%, татгалзсан 133/32%, түдгэлзсэн 21/5%, бүгд 404/94%,

1-р тойргийн депутат С.Баяр Дэгд байгаа тул үүнийг хасах талаар дахин санал хураалт хийхийг хүсэв. 288-р тойргийн депутат С.Баярцогт тайлбар хийв. 340-р тойргийн депутат Б.Сумьяа 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 94-р тойргийн депутат Б.Сандуйжав, Ц.Элбэгдорж нар уг халж дахин санал хураав. С.Баярцогтын саналыг зөвшөөрсөн 187/46%, татгалзсан 204/50%, түдгэлзсэн 15/03%, бүгд 406/95%, Нэрээр санал хураана гэж орохгүй болов.

427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж 10^e-ээр санал хурааж өгөхийг хүсэв. 288-р тойргийн депутат С.Баярцогт уг хэлэв. Ердийн олонхийн саналаар гэдгийг хасъя гэдгийг зөвшөөрсөн 98/24%, татгалзсан 295/72%, түдгэлзсэн 14/3%, бүгд 407/95%,

Хуралдаан 13⁰⁵ цагт завсарлаад 15 цагт үргэлжлэв.

АИХ-ын орлогч дарга Н.Батбаяр АИХ-ын чуулганы нэр дээр хөдөлмөрчдөөс ирүүлсэн захидал, цахилгааныг танилцуулав. 145-р тойргийн депутат Л.Лантуу, чуулганы оройн хуралдаанд гадаадаас хуралцэн ирж, 270-р тойргийн депутат П.Хаадгар, 150-р тойргийн депутат Балдан-Очир нар биеийн эрүүл мэнд муудсаны улмаас чуулганаас чөлөө авав.

Чуулганд ирвэл зохих 427 депутататаас 398 нь хуралцэн ирсэн байв. Чуулганы хэлэлцүүлэг үргэлжлэн депутат нар саналаа хэлэв.

396-р тойргийн депутат Б.Чимид, 46-р тойргийн депутат Ю.Жаргал, АИХ-ын дарга Ж.Уртнасан II9-р тойргийн депутат Д.Цээн-Ойдовын бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай чуулганы тогтоолын төслийг уншиж танилцуулав. Д.Цээн-Ойдовын сонгосон сонгуулийн тойргийн комиссын ажиллагааны талаар II6-р тойргийн депутат Н.Нямсүрэн, 46-р тойргийн депутат Ю.Жаргал, 39-р тойргийн депутат Д.Ламжав, 399-р тойргийн депутат Д.Чилхаажав, III-р тойргийн депутат Г.Бадарч, 264-р тойргийн депутат Б.Бањди, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 326-р тойргийн депутат Ж.Гомбожав, I-р тойргийн депутат С.Баяр, 406-р тойргийн депутат У.Тэрбиш, 257-р тойргийн депутат У.Цэрэндагва, 9-р тойргийн депутат С.Зориг, 23-р тойргийн депутат Ц.Энхбат, 49-р тойргийн депутат Л.Болд, 167-р тойргийн депутат Ш.Гурбазар нар саналаа хэлэв. АИХ-ын хуралдаан II-р зүйлийн 5-р заалтын Г-хэсгийн үргэлжлүүлж хэлэлцэв. Хэлэлцэм байгаа асуудалтай холбогдуулан 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 387-р тойргийн депутат Н.Энхсайхан, 54-р тойргийн депутат Б.Гомборагчаа, 107-р тойргийн депутат Л.Баяндалай, 407-р тойргийн депутат Б.Нүүрэй, II-р тойргийн депутат Ж.Бямбаа, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 19I-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, 318-р тойргийн депутат Ж.Уртнасан нар санал хэлэв.

"Г" заалт дээр депутатуудыг нэрээр нь санал хураана гэдгийг зөвшөөрсөн 219/53%, татгалзсан 166/40%, түдгэлзсэн 21/5%,

"Д" заалттай холбогдуулан 20-р тойргийн депутат Г.Дэндэв, 27I-р тойргийн депутат Ж.Даргахүү нар саналаа хэлэв. "Г" заалттай холбогдуулан хураалгасан саналын талаар I-р тойргийн депутат С.Баярын тайлбарыг сонсож, II-р тойргийн депутат Ж.Бямбаа саналаа гаргав.

"Д" заалтын талаар хураалгасан саналыг зөвшөөрсөн 339/89%, татгалзсан 26/6%, түдгэлзсэн 13/3%, бүгд 378/83%, Санал хураалтын горимтой холбогдуулан 106-р тойргийн депутат М.Жадамбаа, 25-р тойргийн депутат Л.Энэбиш, 235-р тойргийн депутат Ц.Өөлд, 163-р тойргийн депутат Б.Мижид, I-р тойргийн депутат С.Баяр, 383-р тойргийн депутат Б.Гүнджалам, 105-р тойргийн депутат Б.Чойжилсүрэн, 72-р тойргийн депутат А.Болат, 215-р тойргийн депутат Ж.Чунагсүрэн, 315-р тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ, 15-р тойргийн депутат Д.Лүндаажанцан, 27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж,

178-р тойргийн депутат Д.Энхбаатар, 1-р тойргийн депутат С.Баяр, 288-р тойргийн депутат С.Баярцогт, 151-р тойргийн депутат Е.Моголцог, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 84-р тойргийн депутат Н.Самат, 396-р тойргийн депутат Б.Чимид, 168-р тойргийн депутат Г.Вандандагва, 210-р тойргийн депутат Ж.Чунагсүрэн, 346-р тойргийн депутат Ч.Дэмбэрэлням, 285-р тойргийн депутат С.Батсүх нар уг халснээр депутатуудаас гаргах саналыг таслав. Гарсан горимуудын талаар санал хураах ажилд оров.

"АИХ-ын удирдлага шаардлагатай гэж үзвэл депутатуудын нэрээр санал хураана" гэсэн томъёололыг үлдээнэ гэдгийг зөвшеөрсөн 221/54%, татгалзсан 162/40%, түдгэлзсэн 20/4%,

"Тодорхой бүлгийн шаардлагаар нэрээр санал хураана" гэснийг зөвшеөрсөн 84/22%, татгалзсан 281/71%, түдгэлзсэн 25/06%,

"10-ний нэг нь зөвшеөрсөн буюу хүссэн нөхцөлд санал хураана" гэдгийг зөвшеөрсөн 83/20%, татгалзсан 306/74%, түдгэлзсэн 22/5% бүгд 411.

"Дөрөвний нэг нь хүссэн нөхцөлд санал хураана" гэснийг зөвшеөрсөн 176/43%, татгалзсан 199/48%, түдгэлзсэн 34/08%, бүгд 409/95%,

Чуулганы хуралдаан 17⁰⁰ цагт завсарлаж 17 цаг 27 минутаас ургажжлэв.

Хуралдааны ажиллагааны талаар горимын саналаа 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 72-р тойргийн депутат А.Болат, 264-р тойргийн депутат Б.Баньди, 207-р тойргийн депутат М.Моёор, 23-р тойргийн депутат Ц.Энхбат, 157-р тойргийн депутат Л.Одончимэд, 148-р тойргийн депутат Д.Баттулга, 15-р тойргийн депутат Д.Лүндээжанцан, 391-р тойргийн депутат Ш.Лхагваа нар гаргав. 316-р тойргийн депутат Г.Сосорбарам чуулганы даргад асуулга тавив. АИХ-ын дарга Ж.Уртнасан асуулгад хариулж, зарим зүйлийг тайлбарлав.

41-р тойргийн депутат

6 заалтын талаар Н.Пүрэвдорж, 315-р тойргийн депутат Ч.Батээрдэнэ нар саналаа халж төсөлд үлдээх талаар санал хураав. зөвшеөрсөн 307/91%, татгалзсан 18/5%, түдгэлзсэн 10/2%, бүгд 335/78%,

7 заалтыг хасья гэсэн санал ирлээ. Уүнийг санал хураалтаар шийдвэрлэв.

зөвшөөрсөн 304/78%, татгалзсан 70/17%, түдгэлзсэн 15/3%, бүгд 389.

Санал хураалтын дунтэй холбогдуулан горимын санал I98-р тойргийн депутат С.Батмөнх, 315-р тойргийн депутат Ч.Бат-эрдэнэ нар гаргав.

I2-р зүйлийн талаар 341-р тойргийн депутат П.Бямбажав, 155-р тойргийн депутат Л.Индорж/микрофонгүй ярив/

I2-р зүйл дээр санал хураав. Зөвшөөрсөн 375/93%, татгалзсан 17/4%, түдгэлзсэн 10/2%, бүгд 402. I3-р зүйлийг бүхэлд нь хэлэлцэхээр тогтоё гэж 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр санал гаргав. Уг зүйлийг батлахыг зөвшөөрсөн 392/97%, татгалзсан 6/1% түдгэлзсэн 2/000%,

I4-р зүйлийг хэлэлцэв. II-р тойргийн депутат Ж.Бямбаа, 311-р тойргийн депутат Д.Баяр, 163-р тойргийн депутат Б.Мижид, 15-р тойргийн депутат Д.Лүндээжанцан, 191-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, 354-р тойргийн депутат Ш.Бороодой, I-р тойргийн депутат С.Баяр, 184-р тойргийн депутат С.Билэгсайхан нар санал хэлэв.

I4-р зүйлийг батлах саналыг зөвшөөрсөн 367,/89%, татгалзсан 30/7%, түдгэлзсэн II/2%,

Гуравдугаар бүлгийг хэлэлцэв. I75-р тойргийн депутат Х.Чулуунбаатар, 294-р тойргийн депутат И.Бадарч, 180-р тойргийн депутат Д.Зарыкан, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 321-р тойргийн депутат С.Батхуяг, 315-р тойргийн депутат Ч.Бат-эрдэнэ, 188-р тойргийн депутат Б.Буянцэлгэр, 272-р тойргийн депутат С.Лунаа, 393-р тойргийн депутат Д.Баасанжав, 82-р тойргийн депутат А.Сарай, 9-р тойргийн депутат С.Зориг, I4-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 151-р тойргийн депутат Б.Алагaa, 163-р тойргийн депутат Б.Мижид, I-р тойргийн депутат С.Баяр, 400-р тойргийн депутат Л.Дамдинсүрэн, 39-р тойргийн депутат Д.Ламжав, I3-р тойргийн депутат Л.Цог, 314-р тойргийн депутат М.Гантэмэр нар саналаа хэлж, зүйл болон I6-р зүйлийн I-р заалтууд давхардсан учир хасах боломжтой гэж үзэв. Дээрхи заалтуудыг дэлгэрүүлэн тайлбарлаж 191-р тойргийн депутат Б.Лханаадорж, I4-р тойр-

гийн депутат С.Лхагвасүрэн, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж, 315-р тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 15-р тойргийн депутат Д.Лүндээжанцан, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, БНМАУ-ын Ерөнхийлөгч Н.Очирбат, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 358-р тойргийн депутат Б.Жанцансамбуу, I-р тойргийн депутат С.Баяр, 156-р тойргийн депутат Ж.Гантөмөр, 17-р тойргийн депутат Т.Очирхүү, II-р тойргийн депутат Ж.Бямбаа, 25-р тойргийн депутат Л.Энэбиш, 288-р тойргийн депутат С.Баяриогт, 13-р тойргийн депутат Л.Цог, 165-р тойргийн депутат Ч.Гомбосүрэн, 148-р тойргийн депутат Д.Баттулга, 355-р тойргийн депутат Х.Баянмөнх, 273-р тойргийн депутат Н.Жанцан нар уг хэлэв.

I5-р зүйлийг хасъя гэдэг дээр санал хураав. Зөвшөөрсөн 123/30%, татгалзсан 273/67%, түдгэлзсэн 12/3%, бүгд 408/96%/
Олонхи нь татгалзсан учир улдээхээр тогтов.

I6-р зүйлийн I-р заалтыг хасъя гэсэн саналыг зөвшөөрсөн 161/40%, татгалзсан 231/57%, түдгэлзсэн 14/3%, бүгд 406/95%,
Мөн зүйлийн 2-р заалтыг найруулан засч улдээе гэсэн саналыг зөвшөөрсөн 392/96%, татгалзсан 12/3%, түдгэлзсэн 5/1%, бүгд 409/96%,

Мөн зүйлийн 3-р заалтад "хуралдаан" гэсэн үгийг "аппаратын" гэсэн үгээр сольж улдээх саналыг зөвшөөрсөн 307/93%,
татгалзсан 18/5%, түдгэлзсэн 8/2%, бүгд 396/93%,

Дэгийг бүхэлд нь батлаад редакцийн комисст шилжүүлье.
27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж редакц хийсний дараа батлах нь зүйтэй гэсэн санал гаргав. 284-р тойргийн депутат М.Бадам, 304-р тойргийн депутат Лхагвасүрэн, 188-р тойргийн депутат Б.Буяндэлгэр, 157-р тойргийн депутат Л.Одончимэд, 178-р тойргийн депутат Д.Энхбаатар, 45-р тойргийн депутат М.Энхсайхан нар энэ саналыг дэмжих уг хэлэв.

Дэгээ зарчмын хувьд батлах уу? гэдэг дээр санал хураав.
зөвшөөрсөн 368/90%, татгалзсан 29/7%, түдгэлзсэн 10/2%,
бүгд 407/95%,

Дэгээ бүхэлд нь баталъя гэсэн саналыг зөвшөөрсөн 369/90%,
татгалзсан 28/7%, түдгэлзсэн 12/3%, бүгд 409/96%,

АИХ-ын дарга Ж.Уртнасан Үндэсний төрийн зөвлөлийг зохицуулах хорооны санаачлагч хэсгийн сонордуулах бичгийг чуулганд уншиж сонсгов. Сонордуулгатай холбогдуулан 148-р тойргийн депутат Д.Баттулга, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 101-р тойргийн депутат Р.Доржбат, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 184-р тойргийн депутат С.Билэгсайхан, 86-р тойргийн депутат С.Харжаубай, 10-р тойргийн депутат О.Дашбалбар, 406-р тойргийн депутат Ч.Тэрбиш, 10-р тойргийн депутат О.Дашбалбар нар үг хэлж дээрхи үүсгэл санаачлагын байгууллага албан ёсоор улсад бүртгэгдэж зөвшөөрөгдөөгүй учир АИХ-аас тусгай комисс томилж тэдэнтэй уулзах учрыг тодруулах хэрэгтэй, нэр томьёо, зорилго чиглэлийн хувьд ч ойлгомжгүй байна гэв.

АИХ-ын II хуралдааны дэгэнд депутатуудын гаргасан саналын дагуу эцэслэн редакц хийж маргааш өглөө комиссын дарга С.Баяр чуулганд сонсгох нь зүйтэй гэж тогтов.

Өнөөдрийн хуралдаан 19⁴⁵ цагт дуусав./Хуралдааны соронзон бичлэгийг хавсаргав/

ТАНИЛЦСАН:
ТЭМДЭГЛЭСЭН

Ж.УРТНАСАН
А.ЮНДЭНДОРЖ

АРДЫН ИХ ХУРЛЫН II ДҮГЭЭР САРЫН
I2-НЫ ХУРАЛДААН

Хуралдааны оролцоогүй: Депутат Г.Чингэл /339/,
Т.Батмөнх /376/, Ц.Охинтогтох /254/, Н.Самнилноров /199/
нар өвчтэй. Депутат Г.Сүрэнжаргал /299/ гадаадад ажлаар
яваа.

Хуралдаанд хоцорсон: Ц.Өөлд -15 минут, Б.Энхбаатар /178/
- I цаг 30, Л.Бодц /49/ -10 минут, С.Баярцогт /288/ -15
минут, Амарсанаа /141/, -30 минут, Г.Төмөрбаатар /238/ - I цаг,
Ж.Гүррагчaa /113/ - 3 цаг тус тус хоцорсон.

Л.Дашням /22/ - Хуралдаанд 2 цаг ороцсон, эмийн
чөлөөтэй гэсэн.

АЖЛЫН ХЭСЭГ

1991.XI.12.
Кассет № 38
9.00-9.15

21

Ардын Их Хурлын дарга Ш.Уртнасан: -депутат нэхдийн өглөөний амгаланг айлтгая. Өнөөдрийн хуралдаанд 426 депутат ирэх ёстой. Ирцийн байдлыг авч узвэл хуралдаанд депутат С.Баярцогт 10 минут, депутат Сүрэнжав 20 минут, депутат О.Дашбалбар 35 минут, депутат Баасанхүү 2 цаг тус тус ходорч ирлээ гэсэн II-ний өдрийн хуралдааны талаар ажлын хэсгээс ийм мэдээ ирүүлсэн байна.

Одоо өнөө өглөөнийхөө ирцийн байдлыг шалгаж үзье. Та бүгдийг ирц буртгэлтэд оролцохыг урьж байна. Ирц буртгэж байна.

Техникээ нэг шалгая, дахиад бэлтгэж байгаад ирцээ нэг үзье. Өнөөдөр хуралдаанд ирвэл зохих депутатын 395 буюу 92 хувь нь ирлээ гэж манай цахим техник мэдээлж байна. дахиж нэг шалгая, бэлтгэнэ үү. Ирцийг буртгэж эхэлж байна.

Техник алдаагүй ажиллажбайгаа юм байна. Байгаа хүн бол 400, гэхдээ 5 депутат "ирц" гэдгийг биш зөвшөөрсөн гэдгийг дарсан учраас энэ дээр будлиан гарчээ. Баярлалаа.

Манай депутатуудын ирцийн байдал ирвэл зохих 426 хүнээс 400 хүн буюу 98 хувь нь ирсэн байна. Хуралдаанаа үргэлжлүүлье. Манай Ардын Их Хурлын II хуралдааны нэр дээр цахилгаанаар, утсаар, бичгээр олон санал хүсэлт ирж байна. Үүнийг та бүхэнд өглөө хуралдаан эхлэхэд нэг удаа мэдээлж байя, өдрийн хоолны дараа мэдээлж байя. Хэрэв өдөртөө зайлшгүй та бүхэнд сонстох ийм зүйл гарвал орой завсарлахын, хуралдаан завсарлахын өмнө мэдэгдэж байя гэсэн ийм хүсэлтэй байна.

Өчигдөр хуралдааны анхны өдөр та бидний нэр дээр утас, цахилгаан, бичгээр ирсэн мэдээг ажлын хэсэг тоймлосон. Одоо манай орлогч дарга уншиж, та бүхэнд толилуулна.

Энэ компьютер маань бидэнд ийм мэдээ өгч байна. Ирээгүй ба ирц дарагдаагүй депутатууд Зоригт 9 дүгээр тойрог, Ялалт 259 дүгээр тойрог /суудалдаа суугаагүй энэ шууд ингэж хариу өгдөг юм байна шүү/, Батмөнх 376 дугаар тойрог, Болд 59 дүгээр тойрог, Г.Зуунай 143 дугаар тойрог, Н.Амарсанаа 147 дугаар тойрог, Ж.Адъяа 202 дугаар тойрог, С.Баяр I дүгээр тойрог, Р.доржбат 101 дүгээр тойрог, С.Чулуванбаатар 132 дугаар тойрог, Д.Цэн-Сидов II9 дүгээр тойрог, М.Жамсран 301 дүгээр тойрог, Ц.Батчулуун 402 дугаар тойрог, Д.Чилхаажав 399 дүгээр тойрог, Н.Самчильторов 199 дүгээр тойрог, Ц.Охинтогтох 254 дүгээр тойрог, Л.Дашням 22 дугаар тойрог, Ж.Гуррагчaa II3 дугаар тойрог, Л.Лантуу 145 дугаар тойрог, Б.Буянмөнх 177 дугаар тойрог, Б.Энхтуяа 388 дугаар тойрог, Л.Нүрэвдорж 27 дугаар тойрог, А.Рэгзэн 88 дугаар тойрог, Б.Дэмбэрэл 131 дүгээр тойрог, С.Бийлэгсайхан 184 дүгээр тойрог, Г.Чингэл 339 дүгээр тойрог, А.Анигаа 401 дүгээр тойргийн депутатууд суудал дээрээ байхгүй буюу сая ирциин бүртгэлд орсонгүй.

I дүгээр тойргийн депутат С.Баяр: -Дарга аа, би ирчихээд сууж байх юм, I дүгээр тойрог Баяр.

Ардын Их Хурлын орлогч дарга Н.Батбаяр

Эрхэм хүндэт депутатууд аа!

Та бүхэнд бид сая Их Хурлын даргын хэлсний дагуу байгууллага, хамт олон, хөдөлмөрчид, нам, олон нийтийн байгууллагуудаас Их Хурлын нэр дээр ируулж байгаа баримт бичгүүдээс сириуулж танилцуулж байя гэж тохирсныг мэдэгдлээ. Ер нь ируулсэн материалуудыг манай ажлын хэсэг бүлэглэж, цэгцэлж байгаа. Бид хоорондоо ярилцаад Их цааз, Улсын Бага Хурал, Засгийн газар, бусад манай хэлэлцэх тодорхой асуудалтай холбогдсон санал, хүсэлтуүдийг тухайн асуудлыг хэлэлцэх үед нь ярыж байх нь зүйтэй болов уу гэж үзлээ. Өнөөдөр ингээд ерөнхий зүйлтэй холбогдолтой зарим нэгэн зүйлүүдийг уншиж сонсгоё.

Хүндэтгэлийн бичиг. 1991 оны II дүгээр сарын 5. Улаанбаатар хот.

Цагаан морин жилд Монгол орныг бухэлд нь хамарч өрнөсөн тусгаар тогтолцоо, эрх чөлөө, төрт ёсны төлөө тэмцлийн хэрээр Монгол түмний түүхэнд анх удаа олон намын тогтолцоо бурэлдэж, олон ургальч хэзэл, ардчиллын хэм хэмжээ баталгаажиж, тэр улсаа төвхнүүлэн төвшитгэх түүхэн боломж нээгдсэн билээ. Монгол түмний саргэн мандлын цаг тооллын ахийг тавьсан энэ түүхэн үе нь хүнд хүчир ачаа бүхнийг уурч, бие сэтгэлээ үл хайрлан зүтгэхээ тэр, түмэндээ илэрхийлж Монгол оронд болсон анхны ардчилсан сонгуулиар түмэн олинохсоо итгэлийг хүлээж ардчилсан төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элч Ардын Их Хурлын депутат та бүхэнд Монголчуудын хувь заяаны түүхэн эгээгтэй энэ мэчид Монголын Ардчилсан Холбооны нийт гишүүд, дэмжигчдийн нэрийн өмнөөс энэхүү хүндэтгэлийн бичгийг толилуулж байна.

Та бүхэн Ардын Их Хурлын энэ удаагийн чуулганаар Монгол улсын их хууль Их цаазыг хэлэлцэж, үе үеийн Монголчуудын төрт ёс, эрх чөлөө, тусгаар тогтолцоохо төлөө алд биеэ алдруулан тэмцэж явсан ариун гэгээн зорилго, тэмцлийн явцад олж авсан дэвшилт бүхнийг хуульчлан батлах гэж байна.

Монгол түмний түүхэнд алтан усгээр бичигдэх энэхүү Их цааз бичгийг гар бие оролцон бүтээх түүхэн бөгөөд хосгүй аз завшаан чухам та бүхэнд тохоожээ. Энэ түүхэн ургийг нэр төртэй биелүүлж чадна гэж үе үеийн уламжлалаа хадгалан хлдсэн Монголчууд зөвхөн та бүхэнд итгэл хүлээлгэж байна.

Энэ ялдамд Монголын ард түмэн хичээл зүтгэл гарган санал оюунаа шингээж Улсын Бага Хурлын хуралдаанаар хоёр удаа нягтлан хэлэлцээд Ардын Их Хурлын ээлжит чуулганд өргөн барьж буй Монгол улсын Их цаазын төслийн өрөнхий хээл санааг Монголын Ардчилсан Холбоо бүрэн дэмжих байгааг илэрхийлье.

Ардын Их Хурлын депутат та бүхэн төрийн хүний түвшин ухаанаар монгол улсын их хуулийн уг, өгүүлбэрийг тунгааж хүн төрөлхтөний оюуны сан хэмрэгт монгол ухааны охь болж хүндтэй байр суурь эзлэх хэмжээнд Монгол улсын Их цаазыг соёрхон батална гэдэгт гүнээ итгэж байна.

Монгол түмний элч та бүхэнд амжилт хүсье. Та бүхий түүхэн үйлсийн мөр ариун цагаан байх болтугай. Монголын Ардчилсан Холбооны Ерөнхий зохицуулах зөвлөл гэсэн хүндэтгэлийн бичиг байна.

II-ний өдөр манай хуралдааны нэр дээр нийт 17 иргэн, хамт олноос захидал ирүүлж, санал хүсэлт тавьсан байна. Ерөнхий зүйлтэй холбогдолтой зарим зүйлийг сонордуулья.

1. Сүхбаатарын районы II иргэн /нэр, хаягаа бичээгүй байна. Цаашид бид нар ингэж тогтох байгаа, нэр, хаягтүй зүйлүүдийг уншихаа больё гэж. Одоо энийг больчих уу, нэр хаягтүй юм байна./

2. Үнэн сонинь Завхан аймаг дахь сурвалжлагч Бат-Өлзий /бичгээр/ - Ардын Их Хурлын хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг зүйл бүрээр депутатуудын саналыг нэрээр авч тооцох нь нэн зохистой.

3. Ардын Их Хурлын 180 дугаар тойргийн депутат Д.Жумдаанбаатар /бичгээр/ - Ардын Их Хурлаас дараах хоёр баримт бичиг гаргах санал дэвшүүлж байна.

1/дэлхийн улс түмнүүдэд хандаж уриалга гаргах.

2/өөрийн орны ард түмэндээ шинэ Үндсэн хуулиа хэрэгжүүлэх, шилжилтийн үеийн хүнд үеийг туулах талаар сонордуулга гаргах.

Бусад нь тодорхой асуудлуудтай холбогдсон зүйл байна.

1. 1991 оны II дүгээр сарын 7-нд зохион байгуулсан ардчиллыг дэмжих залуучуудын цуглаанаас гаргасан өргөх бичиг. Монголын радио, телевиз нь МХЗЭ, хөдөлгөөний харгис

явуултыг сурталчилсан, БНМАУ-ын дээд шүүх хууль бус энэхүү байгууллагын нэхэмжлэл шахалтаар Монголын залуучуудын холбооны өмч хөрөнгийг хураах шийдвэр гаргасныг дурдаад БНМАУ-ын Ерөнхийлөгч, Ардын Их Хурал, Улсын Бага Хуралд хандаж дараах саналыг тавьсан байна.

1. Улсын дээд шүүх нь гагцхүү хуулийг дээдлэн бусдаас хараат бус уйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэх. Дээд шүүхийн бүгд хурлын 1991 оны II 15 дугаар тогтоолын шударга зөв эсэхэд дүгнэлт өгч арга хэмжээ авах.

2. Монголын залуучуудын холбооны өмч хөрөнгийг улс төрийн хуучин тогтолцооны үеийн төржсөн МХЗЭ-ийн өмч гэж үзэж Засгийн газарт шилжүүлж байгаа тохиолдолд улсын хөрөнгө, ард түмний баялгаар бий болсон MAXH, олон нийтийн бусад төржсөн байгууллагын хөрөнгийг төр, засгийн мэдэлд шилжүүлж авах.

3. Зах зээлийн өнөөгийн нөхцөлд хүүхэд, залуучуудын соёл хумуужил, чөлөөт цагийн зориулалттай барилга байгууламжийн анхны зориулалтыг өөрчлөхгүй байх, хүүхэд, залуучуудын хэрэгцээт уйлдвэрлэл, уйлчилгээ явуулдаг байгууллагуудын улсын санхүүжилтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

Дээрх саналуудын хариуг 1991 оны II дүгээр сарын 15-ны дотор өгөхийг хүссэн байна. Энд зөвлөж ярьж байгаад хариу өгөх шаардлагатай болох нээ.

Өнөөдрийн нэгтгэсэн баримтаар ард иргэдээс нийтдээ 28 хүн бичгээр, цахилгаанаар 6, утсаар 6, хүлээн авах байраар 4 хүн ирж санал хүсэлтээ тавьсан байна. Ерөнхий асуудалтай холбогдсон зарим зүйлийг хэлье.

Чойбалсан хотын Орон сууц гудамжны 3 дугаар хорооны хөдөлмөрчид, Багануурын район, Сэлэнгэ аймаг дахь Монголын Ардчилсан Холбооны зохицуулах зөвлөл цахилгаан болон бичгээр Ардын Их Хурлын II хуралдааны ажиллагаанд амжилт хүссэн байна.

6.

2. Сүхбаатарын районы иргэн Ваанчиг бичгээр ирүүлсэн байна. Их Хурал шударга, шуурхай, өгөөжтэй болохыг өрөөгөөд тус хурлаар хүний оюуны чадал, хөдөлмөрийг урамшуулан тэтгэж, үйлдвэрийг олшруулж, тоног төхөөрөмжийг элбэршиүүлэх, байр сууцаар хангах иж бүрэн асуудлыг хэлэлцэх.

3. Октябрьин районаны ОСГ-ны IY дүгээр хорооны иргэн, IY хороолол, 33 дугаар байр, 109 тоотод суудаг Гээдэн /утсаар/ Ардын Их Хурлын депутат Э.Бат-Үүл Ардын Их Хурлын хуралдааныг хундэтгэхгүй европ хувцсыг хагас дутуу зангиагүй өмсчээ. Иймд европ хувцсаа бүрэн гүйцэд эсвэл үндэсний Монгол хувцсаа зохих ёсоор нь өмсөж хуралдааныг хундэтгэхийг өөрт нь сануулж өгөх.

4. Шинжлэх ухааны академийн ажилтан дагвадорж. Ардын Их Хурлын орлогч даргаар сонгогдсон Батбаяр нь сонгогчидтойгоо уулзалт хийгээгүй тул хөтөлбөрөө хэрхэн бие-луулж байгаагаа сонгогчилдоо тайлagnаж, тэдний санал хүсэлтийг сонсож байхыг анхааруулж өгөхийг хүсэв гэжээ.

Ии өөртөө хүлээж авлаа.

5. Сүхбаатарын районы ОСГ-ны IY дүгээр хорооны иргэн Балжинням /утсаар/ депутатууд Их Хурлаар хэлэлцэх асуудалд намын байр сууринаас хандахгүй байх.

6. Сүхбаатарын районы 25 дугаар хорооны Рашаантын 15-ын 47-д суудаг иргэн Жалбуу: -Ардын Их Хурлын II хуралдаанд Их цаазын тесэл хэлэлцэхэд иргэний хувьд суулгах зөвшөөрөл олгож өгнө уу.

Ер нь иргэд болон байгууллагуудаас Их Хуралд суулгахыг зөвшөөрч хүссэн олон хүсэлтууд ирж байгаа юм байна. Тэгээд Их Хурлын удирдлага, Ерөнхийлөгчтэй зөвлөөд Их Хурлын дэг хэлэлцэх болон дотоод ажилтай холбогдсон үед онцын шаардлагагүй болов уу. Тухайн тодорхой асуудал хэлэлцэж байгаа үед бол уг хүний хүсэлтийг Их Хурал өөртөө авч

7.

Хэлэлцэж шийдвэрлэж байх нь зүйтэй болов уу гэсэн саналтай байгаа. Дараагийн санал ч гэсэн энэтэй холбоотой юм байна.

Монголын ядуучуудын эвслийн тэргүүний үүрэг гүйцэтгэгч Хөдөө аж ахуйн яамны Цацал шуусийн ажилчин Эзвээ ...

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:

Н.НАРАНТУЯН

Бичээч

Ө.ОЛОНЧИМЭГ

1991-XI-12
Кассет № 39
9.15-9.30

Батбаяр /Ардын Их Хурлын орлогч дарга/ -Ардын Их Хурлын II хуралдаанд ядуучуудын эвслийн төлөөлөгч Ганболд, Хянгасхаан, Эзвээ нарны З хүнийг урилгаар оролцуулж өгөх, энд дээрхи зүйлд хамрагдах болов уу гэж бодож байна.

Сүхбаатарын районы ОСГ-ны II дүгээр хорооны иргэн Өөлд: Ардын Их Хурлын II хуралдааны ажиллагааг орон даяар радио, телевизээр дамжуулж өгөх, бололцоогүй бол Сүхбаатарын талбайн дөрвөн өнцөтг чанга яригч тавьж, хуралдааны үйл ажиллагааг байнга нэвтрүүлж байх, хариуг радио, телевизээр өгөх. Түүнчлэн чуулганы ажиллагааг радио, телевизээр шууд дамжуулж өгөхийг Сүхбаатарын районы I9 дүгээр хорооны иргэн Намжил, 28 дугаар хорооны иргэн Жамсранжав, 10 дугаар хорооны иргэн Дүгэржав, Найрамдалын районы I6 дугаар хорооны иргэн Бадамдорж нар утсаар хүссэн болно. За энийг ажлын хэсэгтэй ярилцъя. Ер нь бид нар өчигдөр радио, телевизийн удирдлагатай ярилцсан. Тэгэхэд бол энэ техникийн боломжоос шалтгаалан тэр болгон шууд нэвтрүүлэг хийх боломжгүй, харин бичлэг хийгээд оройн цагаар нэвтрүүлж байх бололцоотой гэж ярилцсан байгаа.

Октябрыйн районы ОСГ-ны 28 дугаар хорооны иргэн Жагай: Ардын Их Хурлын II хуралдааны нээлтийн ажиллагааг цахилгаан тасарснаас үзэж чадсангүй. Түлш, эрчим хүчний сайдад анхааруулж өгөхийн хамт, нээлтийн ажиллагааг телевизээр дахин нэвтрүүлж өгөхийг хүссэн байна. Ийм саналууд ирсэн байна. Бусад зүйлүүд тодорхой асуудалтай холбогдсон зүйлүүд байна.

Ж.Уртнасан -Ирсэн санал хүсэлттэй холбогдуулан үг хэлэх депутат байна уу? За хуралдаанаа үргэлжлүүлье. Дэгээ хэлэлцье. Бид өчигдөр дэгийнхээ нэгдүгээр бүлгийг хэлэлцэж дууссан. Өнөөдөр хоёрдугаар бүлэгт орж хэлэлцье. Хоёрдугаар бүлэг тодорхой асуудал хэлэлцэх журам, II дүгээр зүйл Монгол улсын Их цаазын төслийг хянан хэлэлцэх, батлах журмын тухай хэлэлцье.

Д.Лагвадорж /2II дүгээр тойргийн депутат/ -Би энэ II дүгээр зүйлийн нэгдүгээр заалтыг өр нь үндсээр нь зөвшөөрөхгүй байна. Яагаад үндсээр нь зөвшөөрөхгүй байна вэ гэвэл, энэ бол үндсэндээ аппаратын боловсруулсан төслийн хэмжээнд байна гэж ингэж хэлэх гэж байна. Тухайлбал ингэж л дээ. Ардын Их Хурал нь Монгол улсын Их цаазын төслийг Улсын Бага Хурлаас өргөн барьсан төслийг үндэс болгон хэлэлцэнэ гэж. Бид Монгол улс гэдгээ ч шийдээгүй, Их цааз гэдгээ ч шийдээгүй ийм хэмжээнд байгаа. Зөвхөн одоо Бага Хурлын боловсруулсан төслийн хэмжээнд ч энэ асуудлыг авч хэлэлцэж болохгүй. Энэ үндэс нь юу вэ гэвэл бид ард түмнээр төлөөлөгдсөн төлөөлөгчийн хувьд ард түмнээр хэлэлцүүлсэн тэр саналын дунг нэлээн үндэс болгож ярих учиртай. Ийм учраас энэ Их цаазын төслийг нийт ард түмнээр хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн дун болон Бага Хурлаас өргөн барьсан төслийг үндэс болгон хэлэлцэнэ гэж найруулах саналтай байна. Мөн энэ утгаар тэр дөрөвдүгээр заалтыг бас ингэж найруулах саналтай байна.

Ц.Элбэгдорж /427 дугаар тойргийн депутат/ -Энэ хурлын даргад нэг зүйл санал болгоход нэгдүгээр булгээ батлаад цааш нь явах нь зөв байх гэж бодож байна. Бид нар нэгдүгээр булгээ бүхэлд нь батлаагүй байгаа. Дараачийн нэг асуудал тэр нэрээр санал хураах дээр депутатуудын ердийн олонхийн саналаар гэдгийг хасъя гэсэн энэ саналыг өчигдөр тавьсан. Нэг удаа түрүүн нь хасъя гэдэг санал олонхи авсан, дараа нь 30-аас дээшхи гээд гар хөл өргөнө гээд энэ ярианаас ч болсон юм уу, эргээд хасахгүй гэдэг нь олонхи болсон. Ингээд үлдчихсэн байж байгаа. Энийг эргэж харья гэсэн байдлаар бас цаад дараачийн зүйлүүд рүү орсныг та бүхэн санаж байгаа байх. Ингээд энэ депутатуудын ердийн олонхийн саналаар гэдгийг хасъя гэсэн санал тавьж байна. 30-аас дээш депутатын хусэлт гарвал нэрээр санал хураах асуудал байж болох юм. Нэг бол ердөөсөө энэ дөрвөн үгийг хасаад цааш нь явъя.

Р.Ёндоңдэмбэрэл /36 дугаар тойргийн депутат/ -Би Их Хурлын

3.

дарга Уртиасан гуайд хандаж санал хэлмээр байна.Өчигдрийн хуралдааны явцаас харахад зарим зүйл ажиглагдаж байгаа.Нэгдүгээрт, мэдээжийн хэрэг та өчигдөрхөн шинээр сонгогдсон учраас хурал удирдах асуудал дээр танд тэвдэх сандрах зарим асуудал гарсан нь мэдээж, тэгэхдээ өнөөдрөөс эхлээд та бух зүйлийг тунгаан бодоод нэлээн нухацтай, хуралдааныг шуурхай явуулах ийм боломжтой болсон болов уу гэж би хувьдаа бодож байна.

Өчигдөр манай хуралдааны явцыг орой радио, телевизээр нэвтрүүлсэн.Ингээд зарим зүйлийг сонсож байхад мөн л одоо Ардын Их Хурлын II хуралдаан эхлэхдээ мөн л замбараагүй, үймсэн, асуудлыг нэг мөр шуурхай шийдэхгүй, цэд булаалдсан, ач холбогдол багатай уг, усгийг хөөцөлдөж, ингэж цаг барж байгаа асуудлыг бас шуумжилж ярьж байна.Ийм учраас дэгийг нухацтай боловч маш шуурхай, дайчин хэлэлцэж дуусгаж, үндсэн ажилдаа орох ийм шаардлага гарч байна.

Өнөөдрөөс манай ахмадууд, өндөр настангууд Засгийн газрын үйл ажиллагааг эсэргүүцэж суулт зарласан байгаа.Ийм учраас бид Их Хуралдаа ажил хэрэгч, шуурхай ормоор байна.За ингээд та Их Хурлын даргын хувьд ер нь уг хэлж байгаа депутатуудын чухам хэн нь хичнээн удаа хэлж байгаа энэ асуудал дээр бас бодож тунгааж үзмээр байна.Зарим нь босож өөрийнхөө саналыг тулгах гэсэн, удаа дараа нэг зүйлээ дахин давтан, энийг би Их Хурлын үймүүлж байгаа явдал гэж үзэж байгаа.Зарим нь бие биенийгээ дайрч доромжлох, гутгэх хуртэл асуудал гарч байгаа.Ийм учраас энэн дээр та тун хатуу ийм дэг журам баримталж, үйл ажиллагааг удирдахыг танаас хүсч байна.

Ю.Жаргал /46 дугаар тойргийн депутат/-Өнөөдөр бол Улсын маань нэр бол Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн нэрээрээ байгаа.Гол хуулийн маань нэр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль гэсэн нэрээрээ байгаа.Ийм учраас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурал, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж батлах гэж байгаа.Ийм учраас энэ дэгд Монгол улс Их цаазын

4.

төсөл гэж энэ хувилбараар нь нэрлэж болохгүй. Манай Их Хурлын депутатууд шинэ Үндсэн хуулиа хэлэлцээд улсдаа ямар нэр өгөх юм, хуульдаа ямар нэр өгөх юм бэ гэдгээ жич шийднэ. Ийм учраас байгаа нэрээр нь энэ дэгд бугдийг нь оруулах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

П.Бямбажав /34I дүгээр тойргийн депутат/ -Дээр уг хэлсэн депутатуудын саналыг дэмжиж байна. Юуны өмнө хурлын дэгийг булэг булгээр нь цэгцэлж ярьж дүгнээд, дараагийн булэгдээ шилжиж баймаар санагдаж байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хоёрдугаар булгийн нэгдүгээр зүйлийн заалтыг ард нийтээр Их Хурлын Үндсэн хуулийн төслийг хэлэлцүүлсэн дунг үндэс болгож Бага Хурлаас боловсруулсан төсөл дээр хэлэлцэх гэсэн найруулгатай болгомоор байна. Хоёрдугаар булгийн хоёрдугаар хэсгийг авчихвал зүйтэй юм уу гэсэн санал байна. Урьд өмнө нь хийгдчихсэн ажил учраас Их Хурлын хуралдааны дэгд байх зайлшгүй шаардлага байна уу үгүй юу гэдгийг үзмээр байна.

За эцэст нь Их Хурлын дарга, орлогч дарга наарт хандаж нэг зүйл байна. Дээр депутат ч хэллээ, өдөр өдрийн хуралдаанаар юм уу, өглөөний хуралдаан, оройны хуралдаан тус бурийн эцэст хэддүгээр тойргийн депутат хэн хэдэн удаа ямар асуудлаар санал ярьсныг тодорхой мэдээлж байх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Цаанаа биднийг тойргийн сонгогчид маань харж байгаа учраас энэ бас үр нелөөтэй байж болох байна.

Б.Мөнгөн /35I дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр зэрэг надад бас хэлэх уг байна. Юу вэ гэвэл, ер нь энэ депутатууд биднээс төсөл боловсруулах комисс юм уу, Бага Хурал зарим үйл ажиллагаагаа нууж байна. Энэ нь юу вэ гэвэл, тухайлбал, төсөл боловсруулах комиссоос оруулсан тэр үндсэн төслийг бидэнд өгсөнгүй. Бид энэ хувилбарыг бас гар дээрээ тавимаар байна. Ингээд энэ хоёр хувилбарыг зэрэг барьж хэлалцэх шаардлагатай байна.

Хоёрдугаарт, Бага Хурлаас эцэслэн боловсруулсан энэ хоёрдугаар төслийг ард түмэнд бас үзүүлсэнгүй. Бидэнд бол хөдөлмөрчид, янз бурийн хүмүүс уулзахдаа ер нь ард түмнээс энэ төслийн хоёрдугаар хувилбарыг нууж байна гэсэн ийм асуудал тавьж байгаа. Ийм учраас яагаад ер нь энэ Үндсэн хуулийн төслүүдийг нэг хэсгийг нь депутат биднээс, нэг хэсгийг нь ард түмнээс ингэж нуудаг байна вэ? Ийм учраас энэ хоёр төслийг хоёулангий нь бид гар дээрээ тавьж байж ингэж зэрэгцуулж харьцуулж хэлэлцэх шаардлагатай байна гэсэн ийм санал тавьж байна.

Ч. Намсрай /183 дугаар тойргийн депутат/-Дээр хэлсэн депутатуудын саналтай санал нэг байна. Энэн дээр би юу хэлэх гэж байна вэ гэхээр хоёрдугаар бүлгийг бухэлд нь өөрчилмөөр байна, энэ дэгийн хоёрдугаар бүлгийг. Өөрөөр хэлбэл Үндсэн хууль хэлэлцэх энэ асуудлыг тодорхой асуудал гэж бурхагдуулж, бусад асуудалтай холихгүйгээр данд нь дэгд зааж оруулах шаардлагатай байна. Дээр депутатууд хэллээ, энэний бүлгийг өөрчлөхдөө бид өнөөдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улс хэвээрээ, Үндсэн хууль хэвээрээ байж байгаагийн үндсэн дээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийн шинэ төслийг хэлэлцэх журам гэж энэ гарчгийг өөрчлөх хэрэгтэй, бүлгийг өөрчлөх хэрэгтэй.

II дүгээр зүйлд байгаа бүх зүйлийг Монгол улс Их цааз гэсэн энэ нэргүүдийг Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын шинэ Үндсэн хуулийн төсөл гэсэн ийм замаар өөрчилж, төслөө бид дэгдээ ингэж тогтоож хэлэлцэх шаардлагатай гэж, ингэж дээр депутатуудын хэлсэн энэ саналыг би дэмжиж байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, би энэн дээр хэлэхэд юу байна вэ гэхээр II дүгээр зүйлд энэ Үндсэн хуулийг хэлэлцэх дэс дарааллыг тогтоосон байгаа. Тэгэхээр энэн дээр юу хэлэх гэж байна вэ гэхээр Үндсэн хуулийг хэлэлцэх дэс дараалалд II дүгээр зүйлийн нэгд Ерөнхийлөгчийн илтгэлийг эхэлж оруулах ийм санал-

тай байна. Тухайлбал, энэн дээр илтгэлийн гол санаанд би юу хэлэх гэж байна вэ гэхээр Их цаазын төсөлд, Үндсэн хуулийн төслийн гол зарчмын асуудлыг ард нийтийн хэлэлцүүлгээс зөрүүтэй боловсруулсан шалтгаанаа илтгэлд тодорхой дурдаж өгөх хэрэгтэй гэж ингэж асуудал тавьж байна. Бугд Найрамдах Монгол Ард Улс гэсэн нэрийг ард нийтээс эндээс гаргасан саналаар бол 72 хувь нь, саналын 72 хувь, Их цааз гэсэн нэрийг 52 хувь нь хүлээж аваагүй гэсэн дун байгаа. Гэтэл яагаад өнөөдөр энэнээс зөрүүтэй боловсруулж, ард тумний саналыг харгалзаагүй юм бэ гэдэг асуудлыг илтгэлдээ тодорхой дурдаж өгөөсэй гэж ингэж хүсэж байна.

Дараагийн асуудал юу байна вэ гэхээр илтгэлийг хэлэлцэхдээ комиссоос боловсруулж оруулж ирсэн төслийг үндэслэж Улсын Бага Хурал эцэслэн боловсруулж Их Хуралд оруулж байгаа энэ төслийг үндэслэн хэлэлцэнэ гэж ингэж оруулах хэрэгтэй байна. Тэр ерөөсөө Улсын Бага Хурал ганцаараа бие дааж боловсруулаад оруулсан юм шиг ингэж яриад байгаа. Өчигдөр ингэж зарим депутатууд хэлж байсан. Улсын Бага Хурал санаачилсан гэж, ийм биш байх гэж бодож байна. Санаачлагч нь Улсын Бага Хурал байгаа юмаа гэж. Тэгэхээр Үндсэн хуулийг хэлэлцэхдээ эхлээд зарчмын гол зөрүүтэй байгаа асуудал дээрээ бид тохирч авах хэрэгтэй. Зүгээр түрүүн ярьж байсан. Ерөнхий санал шүүмжлэл явуулна гэсэн. Хэрэв ерөнхий санал шүүмжлэл явуулбал эцэс төгсгөлгүй баахан улсууд ярина, депутат бүхэн ярина, олон юм ярина, зөрүүтэй олон юм байгаа. Тэгэхээр энэ зарчмын гол асуудал дээр ерөөсөө нэгдүгээр хэлэлцүүлгээр гол үндсэн асуудлаа тохирч авах ийм саналтай байна. Нэг тийш нь болгож авах. Энэний дараагаар энэ гол үндсэн асуудлыг тохирч авсны дараа зүйл, заалт нэг бүрээр хэлэлцэх ийм шатанд орох хэрэгтэй гэж бодож байна, хоёрдугаар шатандаа. Зүйл, заалт нэг бүрээр хэлэлцсэнийхээ үндсэн дээр гуравдугаар заалт бол саналын зөрүүтэй байгаа зүйл, заалт нэг бурийг эцэслэн боловсруулж хэлэлцүүлэх ажлын хэсэг, хороодуудыг томилж хэлэлцэх ийм саналтай байна. Би энэ бүлэг дотроо ярьж байна.

Ж.Уртнасан -Гуравдугаар заалтыг уу?

Ч.Намсрай -Тийм.Ингээд эцэслэн боловсруулах бүлэг дээр булгийн боловсруулсан эцсийн заалтыг үндэслэж депутатуудын нийт хуралдаанаараа эцэслэн боловсруулаад тэр саналыг үндэслэн хэлэлцээд, хэлэлцэж батлах.Зөрүүгүй байгаа саналуудыг бол хэлэлцэж батлахдаа депутатуудын гуравны хоёрын саналаар, зөрүүтэй саналуудыг нэрийн жагсаалтаар батлах хэрэгтэй.Санал хураах хэрэгтэй гэсэн ийм саналтай байна.

Энэ юун дээр, уг хэлэх энэ асуудал дээр оролцохдоо бол энэ дэгд өчигдөр баталсан 12 дугаар зүйлд бий.Нэг зүйл дээр турван удаа депутатууд босно гэсэн энэ зүйлээ баримтлах хэрэгтэй гэж бодож байна.Их олон 430-аад хүн босно.Нэг зүйл бүр дээр босох учраас энэн дээр болох байх гэж бодож байна.Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, төсөл боловсруулсан комиссоос бол зүйл нэг бүр дээр тайлбар шаардаж, тайлбараа депутатууд авах хэрэгтэй, түүнээс биш ер нь консультаци сонсоод байх шаардлагагүй гэж бодож байна.Сонирхсон асуудал дээр зүйл нэг бүр дээр зөрүүтэй байгаа асуудлаар тайлбар асуулт тавьж, тайлбар авах хэрэгтэй гэж ингэж найруулах саналтай байна.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Д.БАЯНДҮҮРЭН

Бичээч Т.Уранчимэг

1991.XI.12
Кассет № 40
9.30-9.45

361 дүгээр тойргийн депутат Л.Чулдуунбат: Хэлэлцэж байгаа зүйлтэй холбогдуулж надад хоёр санал байна.

Нэгдүгээрт нь энэ зүйлийн З дугаар заалтан дээр Монгол улсын их цаазын төслийг хянан хэлэлцэх ажил нь анхны болон эцсийн хэлэлцуулэг гэсэн хоёр үе шаттай явагдана гэж заасан байна. Мөн 4 дүгээр заалтан дээр уг асуудлыг нийт депутатуудын гуравны хоёроос Их цаазын төслийн зүйлийг, мөн бүлгээр нь нарийвчлан хэлэлцэж батална гэж ингэж оруулжээ. Тэгэхлээр энэ саналыг, энэ асуудлыг нэгтгэж, нийлүүлж хийж болмоор санагдаж байна. Тухайлбал Монгол улсын Их цаазын төслийг хянан хэлэлцэж батлах ажил нь анхны буюу эцсийн хэлэлцуулэг гэсэн хоёр үе шаттай байна гэсэн уг найруулгаар, томъёоллоор нэгтгэж оруулбал ясан юм бэ гэсэн ийм санал байгаа юм.

За негee талаар 4 дүгээр заалтын З дугаар хэсэг дээр анхны хэлэлцуулгийн үед Их цаазын төсөлтэй холбогдсон илтгэл сонсох нээ. Илтгэлтэй холбогдсон асуудлыг одоо депутатууд гаргаж хариулт авах нээ. Хариулт авахдаа хариултыг Улсын Бага Хурал түүний комисс егнэ гэж ингэж орсон байна. Энэ хэсэг дээр Их Хуралд оруулж байгаа төрийн тамга, төрийн судл, төрийн тут, төрийн дуулалын эх зохиогчдыг оролцуулж хариулт сонсох буюу, шаардлагатай бол тайлбар авна гэж нэмэгдэл болгож оруулж өгвөл ясан юм бэ. Уржигдархан Чимид дарга ярьж байсан, энэ асуудалтай холбогдсон нарийн тайлбарыг бид мэдэхгүй гэж байгаа юм. Тэгэхлээр эх зохиогчдыг, яг хуралд орж байгаа эх зохиогчдыг оролцуулж тайлбар сонсвол ясан юм бэ гэсэн ийм саналтай байна.

349 дүгээр тойргийн депутат У.Баянбилэг: Хоёрдугаар булэг дээр Шаргал депутатын саналыг дэмжиж байна. II дүгээр зүйлийн I-д нэг заалт нэмж оруулахыг хүсч байна. Бага Хурлаас эцэслэн боловсруулсан Их цаазын төсөлд ард түмний санал тааруу тусгагджээ гэдгийг нийт сонгогчид ярьж байгаа. Ийм учраас Ардын Их Хурал нь Ардын Их Хурлын депутат, байнгын комисс, депутатын хэсэг, нутаг дэвсгэрийн бүлгээс боловсруулсан Үндсэн хуулийн төслийг Их Хурлын удирд-

лагын зөвлөлд өргөн барьснаар хэлэлцэх болно гэсэн санал оруулж өгмөөр байна. Мөн үүнтэйгээ холбогдуулаад 4 дүгээр хэсгийн в-гийн дараа мөн энэ төслийг удирдлагын зөвлөлийн зөвшөөрөн хэлэлцүүлэхээр оруулсан Их цаазын төслийг боловсруулсан хумусээс асууж танилцана гэж оруулж өгмөөр байна. Ийм нэг асуудалтай холбогдсон хоёр санал байна.

7 дугаар тойргийн депутат Ц.Балдорж: Энд зарим улсууд Бага Хурлаас өргөн барьсан төслийг хэлэлцэх нь буруу. Өөр төсөл хэлэлцэе гэсэн ийм санал гарч байх шиг байна. Энэ тэгэхээр үндсэндээ Бага Хурлаас өргөн барьсан тесөл биш гэж би хувьдаа бодож байна. Энэ бол бүх ард түмнээр хэлэлцүүлээд Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах комиссоос хийгээд, энэ олон хүний хүч хөдөлмөр шингэсэн энэ төслөө одоо ингэж үгүйсгэж болохгүй байхаа. Энэ дээр депутатууд жаахан ултай суурьтай хандвал яасан юм бэ гэсэн ийм бодол төрж байна. Магадгүй өчигдөр хэн нэгэн хүн энэ Бага Хурлаас санаачилсан гээд хэлчихсэн юм шиг байна. Энэ бол Бага Хурлаас санаачилсан ийм тесөл биш л дээ. Хэрвээ бид нар энэ төслийг хэлэлцэхгүй, өөр төсөл хэлэлцэнэ гэх юм бол үндсэндээ манай энэ хуралдаан ямар ч үр дүнгүй болоод бид юу ч хийж чадахгүйгээр тараад хүрнэ. Тэгэхээр энэ дээр жаахан бодолтой хандахгүй болбол өрөөсөө дур дураараа яриад байж болмооргүй байна. Зарим улсууд ард түмэн ингэж хэлсэн, сонгогч ингэж хэлсэн, ард түмний төчнөөн хувь нь ийм санал өгсөн гээд байна. Ард түмэн бол өрөөсөө энэ дээр зүгээр хэвлэл мэдээллээр дамжуулж хэсэг бүлгээрээ санал өгсөн болохоос биш, ер нь Монголын ард түмний насанд хүрсэн иргэдийн ч юмуу, төчнөөн хувь нь яг ингэж бодож байна гэсэн ийм судалгааг хэн ч хийж үзээгүй шуу. Энийг бодолцохгүй бол болохгүй. Зарим нэг байгууллагууд, зарим нэг нам ч юмуу, Засгийн газрын дэргэдэх төв ч юмуу, зарим нэг эрээвэр, хураавар судалгаа хийчихээд тэрийгээ нэгтгэж байдал, энийгээ дараа нь ард түмний төчнөөн хувь хэлсэн гэж ингэж улсуудын толгойг эргүүлэх бол буруу юм. Энийг бас жаахан бодолцохгүй бол болохгүй байх. Зүгээр тэр II дүгээр зүйлийн нэрийн тухайд гэвэл Монгол

улсын Их цаазын төслийг хэлэлцэн хянах гэж байна л даа. Энэ дээр бас бодож үзэх нь зүйтэй байх л даа. Яг энэ маань Их цааз болох юмуу их засаг болох юмуу, үндсэн хууль болох юмуу энэ маань явц дундаа илэрхий болох байх. Эхлээд нэгэнт байгаагаараа БНМАУ-ын Шинэ үндсэн хуулийн төслийг хянан хэлэлцэх гээд ингээд явахад буруутах юм байхгүй байхаа гэж ийм л юм хэлмээр байна.

I5I дүгээр тойргийн депутат Б.Алгаа:

228 дугаар тойргийн депутат Н.Альяажав: Энэ дээр хоёр, турван санал байна. Туруун бас улсууд ярьсан. Энэ дэгийг батлахдаа бүлэг тус бүрээр нь батлая гэж ярьж байна. Бид өчигдөр бас урьдчилж хэлэлцэхдээ зүйл бүрээр бид нар хэлэлцэж тохироод ингээд эцэст нь манай редакци нэгтгэсэн нэг саналаар бухэлд нь батлах юм байна ингэж ярьж тохирсон байх гэж бодож байна.

Ийм учраас тэр өчигдэрийн саналаар бүлэг тус бүрээр нь батлаад явах биш, зүйл зүйлээр нь ярьж дуусчихаад дараагаар нь тэр комиссоос гаргасан тэр хэмжээнд нь бид нар редакци хийлгүүлээд батлах юм байна гэсэн ийм саналыг би батлая гэж бодож байна.

Хоёрдугаарт 2 дугаар бүлгийн тухай асуудлаар ярихад нэр болбол үнэхээр түргүний гаргасан депутатуудын нэг адил саналтай байна. Энэ нэрний хувьд их зөрөөтэй байж байна. Хоёрдугаарт энэ зүйл дээр болбол энэ нэгдүгээр бүлэг, хоёрдугаар бүлгийн I дүгээр зүйл дээр бичсэн байгаа. Улсын Их Цаазын төслийг Улсын Бага Хурлаас өргөн барьсан төслийг үндэс болгон хэлэлцэнэ гэсэн. Энүүн дээр би үндсэндээ санал нийлэхгүй байна. Юу гэвэл үүний урьд Үндсэн хуулийн төсөл боловсруулах комисс бий болсон. Энэ комисс болбол төслөө боловсруулж бух ард түмнээр хэлэлцүүлсэн, дараагаар нь мөн депутатуудын зөвлөлгөөнөөр хэлэлцсэн. Ингээд үүний үндсэн дээр их хэмжээний засвар, өөрчлөлт орсон байх нь. Ийм учраас Ерөнхийлөгчийн оруулж байгаа юу болбол энэ бүх ард түмнээр хэлэлцүүлсэн энэ Үндсэн хуулийн төслийн тухай асуудлыг

хэлэлцүүлэх байх гэж бодож байна. Харин Бага Хурал болбол өөрийн боловсруулсан энэ өргөн барьж байгаа энэ Их цаазын хaa төслийг холбогдох тайлбартай нь Бага Хурлын дэргэдэх Хуулийн хороо оруулах юм болов уу гэсэн ийм санал байна. Ингээд хэлэлцүүлэхтэй холбогдуулж энэ Үндсэн хуулийн төслийг салбар хороодууж байна гэж байгаа бүлэг тус бүрээр хороод байх болов уу гэж бодож байна. Энэ хороон дээр бид тэр хоёр төслийг зэрэгцүүлж авч үзээд саналаа нэг нь тэргүнд өгье. Гэхдээ бидэнд харин энүүнд ажиллах тийм цаг бололцоо гаргаж өгөхөд бас нэг үдээс хойшийн хуралдаанд байдаг юмуу, үдээс өмнөх хуралдааныг зөвхөн энэ салбаруудаар хэлэлцүүлэхэд зориулж гаргаж өгөх болов уу гэсэн ийм саналыг хэлье.

19 дүгээр тойргийн депутат Б.Батсайхан: Надад нэг хоёр санал байна. Энэ дээр манай депутат нөхдүүд ярьж байх шиг байна. Энэ гол Бага Хурлаас гарсан саналыг өөр байдлаар авч үзэх ёстой болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл эцсийн хэлэлцэгдээд гүйцэтгэсэн байгууллага нь Бага Хурал. Их Хурлын өмнө энэ байгууллага зөв ч байсан, буруу ч байсан хариуцах ёстой болов уу гэж. Тийм учраас Монгол улсын их цаазын төслийг хэлж байгаа юм. Нэгэнт энэ их цааз юмуу эсвэл Үндсэн хууль гэж оруулж ирж байгаа нь болохоос Их цаазыг санал болгож оруулж ирж байгаа юм. Тухнээс Үндсэн хуулийг өөрчлөөд оруулж ирээгүй шүү дээ гэсэн нэг ийм санаа байна.

Хоёрдугаарт өгүүлбэрээр ингэвэл өрөөсөө бид бүхний маргалдаад байгаа зүйл болчих болов уу гэж бодож байна. Бага Хуралаас өргөсөн төслийг санал болгон хэлэлцэнэ гээд. Энэ дээр өөр тайлбарлаад байх шаардлага байхгүй. Энэ дээр үндэс болгоно гэхээр бас олон талын юм бодогдуулж байгаа байх. Тийм учраас санал болгон хэлэлцэнэ гээд засчихвал гэсэн саналтай байна.

Дараагийн дугаарт илтгэлд төслийг боловсруулах болсон шалтгаан, боловсруулсан явц, энэ бүгдийг танилцуулна гэсэн юм байгаа. Энэ дээр манайх бол өөрсдөөсөө гадна бүгд танилцсан байх

гэж бодож байна. Уүн дээрээс гадна гадаад үр дагаврыг тодорхой хэмжээгээр тайлбарлаж өгвэл хэрэгтэй байх. Манай Их цаазын төсөл маань нь батлагдах байх гэж найдаж байна. Ингээд батлагдахад гадаад олон улсын хэмжээнд манай Их цаазын төсөл ямар шүү хэм хэмжээнд хуульчлагдан батлагдаж олон улстайгаа харилцаатай байхад тус дөхөм үзүүлэх вэ гэдэг талаас тайлбарлаж өгвэл хэрэгтэй байх гэж бодож байна. Тэгээд эцэст нь нэг зүйлийг хэлэхэд өчигдөр депутат нөхөр Элбэгдоржийн гаргасан саналыг бас авч үзэх хэрэгтэй байх. Шийдвэрлэж өгөөгүй тарчихсан. Тэрийг бас анхааралдаа авна байх гэж бодож байна.

151 дугээр тойрог, депутат Б.Алгаа: Нэгдүгээр зүйл дээр Монголын ард түмний оюунаар бүтсэн БНМАУ-ын Үндсэн хуулийн төслийг хэлэлцэнэ гэж оруулмаар байна. Хоёрт байгаа хэлэлцээд өнгөрсөн зүйлийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж байгаа. Тэр дөрөвийн "а"-д байгаа Их цаазын төсөлд дээд байгаатайгаа санаа давхардаж байна. "а" булгийг хасах нь зүйтэй юм. Ер нь Их Хуралд түрүүчийн өдрийн хуралдааны байдлаас хараад цаашид бодож зүйл, хоёр үндсэн санааг хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт тасалж байгаа, шийдэх гэж байгаа асуудлаа хурал удирдах байгаа хурлын дарга зөвшөөрөх үү, татгалзах уу гэдгийг тодорхой болголгүйгээр дундаа учир нь олдохгүй явж байгаа тал байна.

Хоёрт хуралдааны зарчмын хувьд дэгээ барихгүй хожигдож ирсэн гарч байгаа асуудал, гараад явчихсан асуудал дээр өрөөсөө үргэлжилж байна. Өнөөдрийн байдлаар 20-иод хүн хожигдоод ирэхэд суудал дээрээ сууж байна. Жинхэнэ Их цаазаа хэлэлцээд ирсэн ээдрээтэй асуудал дээр ийм байдлаар үргэлжилвэл ард түмэн юу гэж ойлгох бол, биднээс ямар сургамж авах бол гэдгийг хүндэт депутатууд ч бодмоор байна.

422 дугаар тойргийн депутат Н.Төмөртогоо: За нэгдүгээрт түрүүчийн депутатуудын гаргасан саналыг дэмжиж байна. Энэ улсынхаа нэрийг одоохондоо өөрчлөөгүй, Үндсэн хуулиа өөрчлөөгүй байхад

ингэж дэгдээ өөр нэрээр оруулах нь буруу юм. Энийг засаж дэгдээ оруулах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт өнөөдөр Монголын ард түмэн одоо депутатууд ямар үндсэн хуулийн, ямар төслийг хэлэлцэхийг мэдээгүй байна. Тийм учраас энэ хэлэлцэх гэж байгаа төслөө ойрын хугацаанд радиогоор нэвтрүүлдэг юмуу, юугаар яадаг юм түргэн хугацаанд хургэх хэрэгтэй байна. Ард түмэн саналаа түргэн хэлье гэх юм бол билднийг хэлэхээс өмнө энийг уншиж үзээд санал онолоо, яаралтай саналаа Их Хурлын нэр дээр ирүүлэх нь зүйтэй юм уу гэж бодож байна. За энэ зүйлд орсон зарим өнгөрсөн хэлэлцчихсэн асуудлуудыг дахин хэлэлцээд хэрэггүй. Жишээ нь дэгийг хэдийд тараана гэсэн асуудлуудыг энд оруулах хэрэггүй байна. Дараа нь эрхэм хүндэт Их Хурлын даргаас хүсэх нэг зүйл байна.

Микрофонууд, бүх микрофон дээр хүнтэй байгаа тохиолдолд микрофоныхоо дэс дараагаар үг өгч байвал зүгээр байна. Гурав, зургаа гээд хаана яах гэж байгаа нь мэдэгдэхгүй. Тийм учраас үгүй бол микрофоноо дэс дараагаар нь байрлуулчихвал зүгээр байна. Дараа нь манай эрхэм хүндэт депутатууд сахилга батын хувьд жаахан муу байх шиг байна. Өчигдрийн байдлаас харахад олон депутатууд суудал дээрээ суухгүй, санал хураахад оролцохгүй, компьютероор санал өгч байхад өөрийнхөө суудал дээрээс өгөхгүй, өөр газар сууж байхад, тэгээд дотуур нь босож дуртай чөлөөтэй явах ийм байдлууд их харагдаж байна. Ялангуяа Бага Хурлын гишүүд, Улаанбаатар хотын депутатууд дээр ийм байдал их ажиглагдаж байна.

Хоёр цаг үнэхээрийн сууж чадахгүй хэл нь өвдөөд байгаа бол чөлөө гүйж, ажиллах цагаа богиносгож болно. Хэрэв боломжтой бол хоёр цаг суудал суудал дээрээ суугаад их наашаа, цаашаа зугаалж давхилгүйгээр энэ хурлаа хийвэл билдний чинь ард түмэн, манай Монголын ард түмэн харж байгаа шүү. Ийм учраас сахилга, дэг журмыг бодмоор байна.

Уртнасан:

Уучлаарай нэг тайлбар тавимаар байна. Бид их Үндсэн хуулиа хэлэлцээд эхлэх үед үнэхээр микрофоны ард олон хүн зогсох байх

Бид энэ компьютерт нэр авчихаад тэргүүгээр уншие гэж ингэж тохирч байгаа шуу. Унийг депутатууд анхаарна уу.

ЗІЗ дугаар тойргийн депутат Н.Чагнаа: БНМАУ-ын Үндсэн хуулийн шинэ төсөлгэдгийг зөвшөөрч байна, дэмжиж байна.

Нэгдүгээр, хоёрдугаар бүлгийн II дүгээр зүйлийн I дүгээрт хоёрдугаар өгүүлбэр оруулах саналтай байна. Үндсэн хуулийн зүйл бурийг нэг асуудал гэж үзэж депутатын санал авах ажлыг зохион байгуулна гэсэн утгатай өгүүлбэр оруулвал ямар вэ гэсэн саналтай байна.

Соронзон хальстай нийлж

тулгасан

Б.Энхтуяа

Бичээч

В.Оюун

1991-II-12

Кассет № 41
9.45-10.00

Н.Чагнаа / ЗІЗ-р тойргийн депутат/ -Мөн зүйлийн "в" дээр, дөрвийн "в" дээр Их цаазын гэдгийг аваад хариултыг Улсын Бага Хурал, түүний комисс өгнө гэсэн нэг уг байгаа. Түүний өмнө хариултыг Үндсэн хуулийн комисс, Улсын Бага Хурал өгч болно гэж бичвэл зүйтэй юу гэсэн санал байна. Цааш нь мөн зүйлийн "г" дээр тэр хоёрын "г"-д заасан хугацааг баримтална гэж төгсөөд, тайлбар гэж байгаа. Тэрний тайлбар гэдэг угийг аваад, түүний өмнө нэг өгүүлбэр хийе. Саналын зөрүүтэй зарчмын асуудал гарвал, түүнийг тусгайлан хэлэлцэж шийдвэрлэж болно гэсэн тийм өгүүлбэр оруулбал ямар вэ? Дээр нэг юм орчихож, түүний дээд талын тэр Ардын Их Хурлын депутатууд зүйл, бүлэг бүр дээр гэдгийн тэнд Ардын Их Хурлын депутатууд хуулийн бүлэг, зүйлийг дэс дараалан, нэг бурчлэн хэлэлцэж, бүлэг тус дээр гэвэл, бүлэг тус бүр дээр хүн саналаа хэлнэ гэсэн, зүйл тус бүр дээр ч гэсэн болно гэсэн санал байна.

Цааш нь хэлэхэд уг хэллэгийн хувьд, усгийн хувьд анхаарууштай юмнууд их байна. Тэрийг энд нуршихгүй. Зүгээр нэг л зүйлийг ярья. Жишээлбэл, "д"-г авья л даа. Тэгэхэд зүйл ангийг гэсэн байна. Анги гэсэн тийм уг өрөөсөө хэрэглэхгүй, булгийг л гэж хэлэх байх. Харин, харин гэж хоёр өгүүлбэр нэг зэрэг харин гэдгээр эхэлж байна. Тэгээд уг, усэг зөндөө байгааг редакцийн групп анхаарах шаардлагатай болно гэсэн санал байна. Баярлалаа.

Ж.Уртнасан -Редакцийн группийн ахлагч С.Баяр тайлбар хэлэх үү?

С.Баяр /Г дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр Их Хурлын даргаа нэг зүйл дээр тогтмоор байна л даа, редакцийн хэсэг ажлаа явуулах үүднээс. Нэгдүгээр булгийг баталчихаад хоёрдугаар бүлэгтээ орьё гэх юм бол бид нэгдүгээр бүлэг дээрээ бас зарим тохирох зүйлээ тохирчихоод тэгээд депутатуудад тарааж болж байна. Тэгэхдээ энэний тулд бас цаг хэрэгтэй. Бид бол эндээс хуралдаанаас гараад явах хэрэгтэй байна, тэгэх юм бол редакцийн

комисс.Өчигдрийнхөөрөө тохирсноор нэг, хоёрдугаар бүлгийг бүгдийг нь хэлэлцэж дуусаад, эцэслэн редакциа хийгээд энэ хувиа депутатуудад тараая гэдгээрээ байх юм бол бид хуралдаандаа оролцоод зохих тэмдэглэлээ хөтлөөд сууж баймаар байх юм.Энэ асуудлыг нэг шийдэж өгөхгүй юу гэсэн нэг ийм хүсэлт байх юм.

Ж.Уртнасан -Нэг, хоёрдугаар бүлгээ хамтад нь редакци хийвэл дээр биш уу дээ.Тэгээд депутатуудаа тараая.Хамгийн гол бүлэг маань энэ хоёрдугаар бүлэг шүү дээ.

Р.Доржбат /IOI дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр бид юуны урьд Их цаазын чухам ямар төслийг иш үндэс болгож авч хэлэлцэх юм бэ гэдэг дээрээ хатуу тогтмоор байна.Ингэж байж бид цаашаа дараагийн асуудлаа хэлэлцмээр байна.Тэгэхлээр энэ ямар ч нэртэй байлаа гэсэн бид энийг хэлэлцэх, эцэслэн боловсруулж батлах ийм л үүрэгтэй.Би Бадарч депутатын саналыг дэмжих байна.Яагаад вэ гэвэл, энэ төсөл бол Бага Хурлын тавин хэдэн гишүүдийн санал бишээ.Тэд нар дур зоргоороо энд боловсруулсан юм бишээ.Хэд хэдэн удаа авч хэлэлцэж, ард нийтээрээ бүгдээрээ хэлэлцэж, бололцоотой бүх саналуудыг энд тусгасан гэж үзэж байна.Ийм учраас бид дур дураараа нэг ийм юм хэлэлцэнэ, тийм юм хэлэлцэнэ гэдэг асуудал байж боломгүй санагдаж байна.Ийм учраас эцсийн эцэст юу гэж хэлэх гэж байна вэ гэвэл, дэгд бичигдсэн энэ төслийг л бид энэ хурал дээрээ энэ журмаараа хэлэлцэж, эндээс нь ургуулж хэлэлцэх байх гэж бодож байна.Надад ийм санал байна.

Х.Пүрэвдагва /63 дугаар тойргийн депутат/ -Энэ II дүгээр зүйлд бид нэг хоёр юмыг л анхаармаар байна л даа.Нэгдүгээрт нь энэ хуулийн төслийг оруулж байгаа субъект нь хэн бэ гэдгийг тодорхойлох хэрэгтэй байх.Энэ хуулийн төслийг Их Хуралд өргөн барьж байгаа нь бол Улсын Бага Хурал байх, субъектын хувьд.Хэрэв Улсын Бага Хурал гэдгийг бид эндээс аваад хаячих юм бол хуулийн төслийг Их Хуралд өргөн барьж байгаа субъектгүй болох нь байна шүү.Энийг бас манай эрхэм депутатууд нэг анхаармаар.Хоёрдугаарт, Их Хурлаар хэлэлцэх предмет маань

3.

энэ. Энэн дээр Монгол улсын Их цаазын төсөл гэсэн байгаа, энэ зүйлийг л хэлэлцье гэж ингэж бичсэн санаа нь энэ. Тэрнээс бол бид нар БНМАУ-ын Үндсэн хуулийг хэлэлцэнэ гэх юм бол нөгөө хуучин, одоо хүчинтэй байгаа Үндсэн хуулиа хэлэлцэх тийм агуулгаар тусчихна шуу дээ. Тийм учраас бид нарын энэ хөх дэвтэрт бичигдсэн энэ агуулга л гэж энэ нэрээр нь Монгол улсын Их цаазын төслийг хэлэлцэнэ гэж орсон юм. За баярлалаа.

Б. Баасанхүү /227 дугаар тойргийн депутат/ - Би депутат Баярын саналыг дэмжиж байна. Бид нэгдүгээр булгээ батлаагүй, зөвхөн зүйл зүйлээр хэлэлцээд явсан байгаа. Тэгэхээр энэн дээр ер нь санал зөрүүтэй, ер нь шийдмээр, засмаар ийм нэгэн зүйлүүд байгаа. Энийгээ өргэн харж засах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Өчигдрийн бидний хэлэлцсэн зүйлүүд дээр бас нэлээн маргаж, их нухацтай хэлэлцлээ ч гэсэн, алдсан юмнууд өргэж зэндөө байна. Тухайлбал, тэртээ тэргүй амралтыг хөдөлмөрийн хуулинд заасан байхад чинь бид бутэн сайнц амарна гээд байх шаардлагагүй байсан. Энийг Ардын Их Хурлын хуралдааныг ажлын өдруудийн өглөө, оройн хуралдаан болгон явуулна гэсэн бол энэ болох байсан жишээтэй. Мөн өөрөөр хэлбэл Ерөнхийлөгч, дэд өрөнхийлөгч, Ерөнхий сайдуудыгаа бид өөрсөдтэйгээ эн зэрэгцээ болгоод уг хэлэх эрх олгохгүй гэдгээр тогтсон. Үүнийг ард түмэн ер нь ямар хүлээж авч байгаа бол. Энийг өргэж хармаар санагдаж байна.

Ингээд ер нь дэгээ баталж байгаа явц дунд, дэггүй явдлууд дэврээд байх шиг байх юм. Ийм учир дэгээ өвтэйхэн баталъя гэвэл дэгтэйхэн байж байж хэлэлцмээр санагдаж байна. Ер нь замбараагүй тиймэрхүү байдал ажиглагдаад байх юм. Ер нь зарим зөрүүтэй саналтуудыг одоо тийм нэрээр авах асуудлыг ч гэсэн энэн дээр эхлээд хэрэгжүүлж өгөхөд ямар байна вэ? Зарим депутатууд, зөвшөөрөхгүй байгаа улсууд болон зөвшөөрч байгаа улсуудыг нэрээр гаргах хэрэгтэй юм. За ингээд хэлэлцэж

4.

байгаа хоёрдугаар бүлэг дээр саналаа ярья.

II дүгээр зүйлийн нэгд Ардын Их Хурал нь Монгол Улсын Их цаазын төслийг Улсын Бага Хурлаас өргөн барьсан төслийг үндэс болгон хэлэлцэнэ гэж байна. Үүнийг би зөвшөөрч чадахгүй байна. Яагаад гэвэл, монголын ард түмэн асар их олон сайхан саналуудыг оруулсан. Энэ төслийн хэлэлцэхэд их санаа бодлоо уралдуулж, өөрсдийнхэе чадах ядах хэрээр оролцсон гэж би бодож байна. Гэтэл энэ маань Бага Хурлаар дахин боловсргодоод гарч ирэхдээ нэг хэсэг нь хэрчигдээд гараад ирсэн байх гэж бодож байна. Ийм ч юм ажиглагдаж байгаа. Ийм учир миний санал бол Үндсэн хуулийг боловсруулах комиссын анхны боловсруулж оруулсан тэр төслийг бидний гар дээр яаралтай хэвлэн ирүүлээчээ. Бид энэ төсөлтэйгээ танилцаж байж, харьцуулан энд санал бодлоо хэлбэл арай боломжтой, нийлэмжтэй байх болов уу гэсэн саналыг оруулж байна. Ийм учраас дэгдээ хэрэв депутатууд хусвэл анхны төслийг депутатуудын гар дээр хувилж хүргэж, хэлэлцэж болно гэсэн ийм зүйлийг нэмж оруулж гэж бодож байна.

Мөн дервийн "д"-д байна, "ө"-д байна, зарчмын шинжтэй асуудал бүр дээр санал хурааж явуулна гээд хоёр зүйлд давхар орчихсон байх юм. Үүнийг анхаарч үзээд нэг зүйлд нь оруулбал арай дээр юу. Ер нь хоёр зүйл дээр л хоёулан дээр нь зарчмын зоруутэй асуудал дээр дахин санал хураана. Дийлэнх олон-хийн гуравны хоёрын гээд ингээд нэг нь негөөгөө бататгаж байгаа ч юм шиг, аль эсвэл үгүйсгэж байгаа ч юм шиг ийм юм орсон байна. Энийг анхаарч үзэж редакцийн засвар хийвэл зүгээр юм уу гэсэн ийм бодолтой байх юм.

Цааш нь нэг зүйл энэн дээр холбогдолгуй юм, гэвч урьдчилдаад санал оруулчихад, төрийн бэлгэдлийн тухай бид нэлээн ярилцана. Энэ талаар бэлтгэлтэй баймаар байна. Тэр ямар төслүүд байдаг юм бидний гар дээр урьдчилан узуулэх юм уу, уг байдаг юм бол, төрийн дууллын уг ирсэн байдаг бол тэрийг хэвлээд ирүүлбэл ясан юм бэ гэсэн саналтай байна. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Ж.Уртнасан -Депутатуудад анхааруулахад энэ хэлэлцэж байгаа асуудал руугаа л орж яримаар байна. Бид үнэхээр цаг багатай шүү дээ.

Ж.Альяа /202 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр дэгийн төслийн II дүгээр зүйлтэй холбогдуулан хоорондоо харилцан уялдаатай туравхан санал хэлье.

Нэгдүгээрт энэ зүйлийн дөрвийн "в" заалтын төгсгөл хэсэгт асуултын хариултыг Улсын Бага Хурал, түүний комисс хариулт өгнө гэсэн байгаа. Үүнийг асуултын хариултыг Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс, Улсын Бага Хурлын гишүүд, түүний комисс, эх зохиогчид өгнө гэж засаж найруулах санал байна. Саяын хэлсэн саналуудтай бас, тэгэхдээ агуулга нь ойролцоо.

Хоёрдугаарт, энэхүү дэгийн II дүгээр зүйлийн "ө" заалтыг үндэслэн хуулийнхаа жинхэнэ агуулга руу орж депутатуудынхаа хамтын оюун бодлыг чиглүүлэх зорилгоор, хоёрдугаарт хуралдааныхаа цагийг хэмнэх зорилгоор бас энэ дэгд нэг нэмэлт заалт оруулж уу гэсэн ийм санал оруулж байна. Тэгэхээр депутатууд бас тунгаанаа биз.

12 дугаар зүйлийн дөрвийн "д" заалтад асуулт хариулт тасалсны дараагээд цаашаа саналын юм явж байгаа. Энэ санал гаргах энэ тухай заалтын өмнө нь Улсын болон хууль, улсын нийслэлийн нэр, түүнчлэн төрийн судл, туг, дуулал, Ерөнхий-лөгчийн нас, орон нутгийн засаг захиргааны хэлбэр ямар байх талаар депутатуудын саналыг нэрээр авч, анхны хэлэлцүүлгийн дун гэж үзэж дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн утгатай санал оруулбал ямар вэ? Бид энэ юман дээр их цаг алдах өнгөтэй байна. Хүн бүхэн энүүгээр үг хэлнэ. Ер нь радио, хэвлэлээр сурталчилж байгаа бүх юман дээр ер нь дээрээс аваад доороо хуртэл энэ л нэг хэдэн нэрэнд эргэлзсэн ярилцлага их явагдаж байгаа. Энийг бас анхаараачээ гэсэн. Тэгэхдээ энэ нь бол тэр II дүгээр зүйлийнхээ "ө" заалтын нөгөө санал зөрөөтэй

зарчмын асуудал гэдэгтэй зөрчилдөхгүй байх. Энэн дээр олон асуудал бий. Та нар энийг хэлүүлэлт байхгүй.

Гуравдугаарт нь уг зүйлийн дөрвийн "г" заалтыг "д" заалт болгож, Үндсэн хуулийн төслийн талаар Ардын Их Хурлын депутатууд энэхүү дэгийн II дүгээр зүйлийн хоёрын "в"-д заасан хугацааг баримтлан хуулийн төслийн зүйл, булэг тус бүр дээр уг хэлж, санал гаргана гэсэн найруулга хийвэл ямар вэ гэсэн санал редакцид оруулж байна.

Л.Шархүү -/357 дугаар тойргийн депутат/-Энэ II дүгээр зүйлийн нэрийг саяын түрүүчийн гаргасан депутатуудын саналтай нэг байна. Энэн дээр БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийн төслийг хянан хэлэлцэх журам гэж батлуулж санал хураалгах саналтай байна.

Хоёрдугаарт нь, энэ манай дэг маань нэлээн хангалт муутай боловсруулагдсан дэг юм уу даа гэж ингэж санагдах байна. Энэн дээр ганцхан жишээ хэлэхэд өчигдөр БНМАУ-ын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч хоёрын уг хэлэх асуудал дээр бид нэлээд буй хугацаагаар маргалаа. Тэгэхлээр энэ Үндсэн хуулийн нэмэлтийн хууль дээр байж байхад энийг ингэж оруулж ирж ингэж маргуулж байгаа асуудал бидэнд цаг налээд алдагдуулж байна уу даа гэсэн ийм ойлгоцтой байна.

Гуравдугаарт нь, энэ аливаа хэлэлцэн асуудлын дараагаар ер нь цөөнх гэдгийг оруулснаас болж, нөгөө бусад гэдэг юм нэлээн томоохон сав байдагтай адилхан цөөнхийг суулийн үед юу вэ гэхээр зэрэг гурав дөрвөн удаа хэлсэн хүн чинь суулд нь би цөөнх болж хэлнэ гэж ихээхэн хурал сунжуулах төлөвтэй байх юм. Энэн дээр манай депутатууд нэг юм эрхбиш бодож байгаа байх гэж ингэж бодож байна.

Д.Мандах /32 дугаар тойргийн депутат/-Энэ шийдсэн асуудал дээрээ буцаад ярихаа больё. Ийм байдлаар, өчигдрийнхөө шийдсэнийг өнөөдөр буцаж яриад байна. Ийм байдлаар явбал бид

ур дунд хүрэхгүй. Ер нь энэн дээр ингэж бодогдож байна. Өөрийгөө ч нөхдөө ч, ард түмнээ ч бид өрөөсөө хүндлээ. Нөгөө талаар бол энэ өглөөнөөс аваад өрөнхий хэлэлцүүлэг шиг болчихлоо. Одоо тодорхой асуудлаар нь, өчигдрийнх шигээ зүйл зүйл ангиар нь, нэр нэрээр нь эхнээсээ хэлэлцээд санал хураагаад явья, тэгэхгүй бол энэ өрөнхий хэлэлцүүлэг шиг болчихлоо. Одоо ингээд санал таслах саналтай байна.

Ж.Уртнасан - Санал тасалъя гэсэн санал ирж байна. Зүйл зүйлээр хэлэлцье гэж байна.

Соронзон хальстай тулгах
нийлсэн

Митанс

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Т.Уранчимэг

1991.II.12.

К-42

10.00-10.15

Журтнасан: Саналыг таслах уу? Ургэлжлүүлэх уу? Гэдэг талаар санал хураалт явуулъя, зөвшөөрөх уу депутатууд аа. Санал хураалтанц бэлтгэнэ уу? Зүйлийнхээ дэс дараагаар хэлэлцье. Тэгэхгүй бол өрөнхий хэлэлцүүлэг шиг боллоо гэсэн нэгдсэн санал ирж байна.

Зүйлийнхээ заалт тус бүр дээр өхнээс нь явъя. Тэгэхгүй бол бид өрөнхий хэлэлцүүлэг шиг болоод цаг алдаад, шийдэж чадахгүй шиг болох нь байна. Зүйлийнхээ заалт тус бүрээр хэлэлцээд явъя. Санал хураалтанц бэлтгэнэ уу.

Баярлалаа. Ерөнхий хэлэлцүүлгийг бид зогсоож, санал авахыг тасаллаа. Одоо зүйлийнхээ заалт тус бүр дээр өхнээс нь яриад явъя гэдэг дээр депутатуудын олонхи нь буюу 314 хүн 92 хувийн санал өгсөн байна. 20 хүн буюу 5 хувь нь татгалзаж байна. 7 хүн буюу 2 хувь нь түдгэлзлээ.

Тэгэхээр олонхийн саналаар одоо II дүгээр зүйлийнхээ заалт тус бурийг өхнээс нь яриад явбал цаг хожино.

Бид депутатуудад баярлалаа. Нэлээн сунжирч, өрөнхий хэлэлцүүлэг шиг боллоо. Тийм учраас бид цэгцтэй, эхнийхээ зүйлийн заалт тус бүрээс өхнээс нь явъя гэдэг дээр тогтох байна. Тэгэхээр 2 тайлбар хэлмээр байна.

Энд ажлын группээс ийм тайлбар ирж байна. Ахны төсөл гэдгийг яриад байх юмаа. Ахны төсөл гэдгийг бух депутатуудад 6 дугаар сарын 15-нд тараасан гэсэн ийм тайлбар өгч байна.

Хоёрдугаарт, энэ түг, далбаа, төрийн сүлд, бэлгэ тэмдгийн асуудлаар өх зохиогчид одоо та бидэнд жижигхэн үзэсгэлэн гаргаж тайлбарлаж танилцуулах юм байна.

Гуравдугаарт, төрийн сүлдний уг, ая, Ардын эрх сонинд одоо нийтлэгдэж, нийтээр хэлэлцүүлэх юм байна.

2.

Ийм тайлбарыг ажлын группээс ирүүлж байна. Ардын эрхэд хэвлэгдсэн, одоо хэлэлцэж байгаа энэ саналыг авч байгаа гэж.

Дөрөв дэх тайлбар Бага Хурлын нэр дээр шуумжлэл ирээд байна. Бага Хурал бол субъект нь, энэ хуулийг ард түмний санал хүсэлтийг хулээн авч боловсруулсан, Их Хуралдаа өргөн барьж байгаа субъект бол Бага Хурал шүү. Хэрэв Бага Хурал гэдэг нэрийг хасахад хуврэл өзэнгүйдчихнэ гэдэг ийм тайлбар ирж байна.

Хоёрдугаар бүлгээ депутатуудынхаа саналаар II дүгээр зүйлийн I дүгээр заалтыг одоо яръя. I дүгээр заалтай холбогдолтой юмаа яриад явъя.

Дэгийн энд анхны бидэнд тараасан дээр бол Монгол улсын Их цаазын төслийг хянан хэлэлцэх гэдгийг ихэнх депутатууд БНМАУ-ын Үндсэн хуулийн төслийг хянан хэлэлцэх гэдэг ийм засвар оруулж гэж байна. Шинэ төслийг.

Ардын Их Хурлын ТО4 дүгээр тойргийн депутат Л.Жагварал:

БНМАУ-ын Үндсэн хуулийн шинэ төсөл гэж нэг хэсэг нь маргаад байна. Нэг хэсэг нь бол яг энэ гар дээр байгаа Монгол улсын Их цаазын төсөл хэлэлцэх гэдэг дээр маргаад байна. Энэ дээр миний санал бол энэ маргаантай асуудлыг таслахын тулд БНМАУ-ын Үндсэн хуулийн шинэ төсөл, Монгол улсын Их цаазыг хэлэлцэх гэж оруулмаар байна.

АИХ-ын ТЗ дугаар тойргийн депутат Л.Цог:

Энд санал хураахын өмнө⁶¹ ёөрийн тайлбар хийе гэж бодож байна. Миний энэ санал биш юм л даа. Тэгэхдээ хууль зүйн утгаараа нэхдэд зөв ойлгогдох ёстой болов уу гэж бодож байна. Ер нь заалны уур амьсгал бэлхнээ ойлгогдож байна. Санал хураах юм бол Үндсэн хуулийн төсөл гэсэн томъёолол дийлэнхийг авах юм шиг байна л даа. Нэхэд минь ингэж яарч болохгүй. Бид Үндсэн хуулиа хэлэлцэж эхлээгүй байна шүү дээ.

3.

Хэлэлцээгүй байж ингэж өөрчилж болмооргүй бодогдож байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, улсын Бага Хурал, түрүүн хүн хэлсэн. Үндсэн хуульд заасан эрхийнхээ дагуу хууль өргөн барих субъект мөн. Хэрвээ Үндсэн хууль гэсэн өөр төсөл байгаа бол тэдний ^{бүх} ард тумэн хэлэлцэж байж оруулж ирэх ёстой, өөр асуудал энэ. Үүнийг ялгахгүй бол бид юм төөрөөд, олонхийн саналаар хэлэлцэж эхлээгүй байж, төслийн ^{нэр} өөрчлөх ийм асуудал гарч байнаа. Жаахан тэвчих хэрэгтэй байна. Ер нь ойлгомжтой байна. Үүнийг дахин дахин тайлбарлах хэрэгтүй байх гэж бодож байна.

Ж.Уртнасан: Ойлгомжтой, депутатууд бүгдээрээ бид сэтгэл нэлээн хөдөлж байна.

424 дүгээр тойргийн депутат Бадамсурэн:

45 дугаар тойргийн депутат М.Энхсайхан: Би Их Хурлын депутатынхаа хувьд уг хэлэх гэж байна. Хэрвээ Үндсэн хуулийн шинэ төслийг гэдэг ерөнхий томъёолдоороо орвол эндээс МСДН-ын төсөл байгаа, МНН-ын төсөл байгаа, өөр хэд хэдэн хүний бүлэг төсөл байгаа. Олон төсөл, МАХН-ын төсөл байгаа. Бүгд зэрэг орж ирээ.

Их Хурал аль дээр нь хэлэлцэх вэ гэдэг дээрээ будилаан гарна. Дэгэнд тийм учраас яах гэж ороод байгаа юм бэ гэхээр хэн хуулийн зүгээс субъект болж орж байна вэ гэдгийг хэлж өгөхгүй бол болохгүй байгаа юм. Бид нар Үндсэн хуулийнхаа нэр, ус ямар байх ёстой вэ гэдэг дээр Үндсэн хуулиа яриад эхэлж байгаа явдал бол буруу. Монгол улс гэдэг дээр санаа нийлэхгүй байна. Тэгвэл тэрийг асуудал хэлэлцэх үед нь ярина. Их цааз гэдэг дээр санаа нийлэхгүй байна. Тэгвэл тэрийг асуудал хэлэлцэхэд л ярина. Бид дэгээ ярьж байна гэдгээ ойлгохгүй. Асуудлаа яриад эхлэхээр буруудаж байна.

Ж.Уртнасан: Уужлаарай бид чинь цувж ярихгүй бол замбараагүй байдалд орох нь байна. Энхсайхан депутатын хэлж байгааг дахин сануулмаар байна.

4.

Бид дэгээ хэлэлцэж байж, шууд Үндсэн хууль хэлэлцэх халбэр рүү орох гээд байна. Нэр томъёоллоо хөөцөлдөөд, үүнээс бид ангижирмаар байна. Үүнийг депутатууд анхаарна уу.

48 дугаар тойргийн депутат С.Жадамбаа:

Нэгдүгээрт, хуучин юмандaa дахин дахин эргэж ормооргуй байна.

Хоёрдугаарт, түрүүн тэр байнгын хорооны дарга Цогийн хэлснийг би зөвшөөрөхгүй. Яагаад гэвэл бид эхлээд ку тогтох хэрэгтэй байна вэ? хоёр зүйл яаралтай тогтмоор байна, депутатууд аа.

1. Энэ Их цааз байх уу? Үндсэн хууль байх уу? гэдгээ тогтмоор байна.

2. Үндсэн хууль цаащдаа хэлэлцэхэд бид ер нь ямар засаглалтай байх вэ гэдгээ авч үзэж байхгүй юм бол одоо өнөөдрийн энэ явдууд чинь бие биен. дээрээ давхардаад болж өгөхгүй байнаа, нөхдүүд минь.

Ийм учраас

Ж.Уртнасан: Дэгэн дээр яаж бичсэнээр бид баталчихгүй шүү дээ. Хэлэлцэх үедээ л үүнийгээ яръя л даа.

Бид Улсын Бага Хурлаас оруулж ирсэн субъект нь Улсын Бага Хурал юм. Оруулж ирсэн төслийг хэлэлцье. Хэлэлцэх үедээ нэр томъёогоо тогтоно биз. Одоо дэг дээрээ л яримаар байна, депутатууд аа.

Одоо 3 дугаар микрофон уг хэлье, тэгээд санал тасалъя.

149 дүгээр тойргийн депутат Т.Анигар:

Би энэ II дүгээр зүйлийн 1 дүгээр заалтанд ийм өөрчлөлт хиймээр байна. Ардын Их Хурал нь ард нийтээр хэлэлцүүлж улсын Бага Хурлаас хянан боловсруулж, өргөн барьсан шинэ Үндсэн хуулийн төслийг үндэс болгоно гэсэн уг, усгийн найруулга хийх саналтай байна.

424 дүгээр тойргийн депутат Х.Бадамсурэн:

Нэгдүгээр Одоо БНМАУ-ын Үндсэн хууль гэж байсаар байхад үүнийг ийм дур зоргоороо өөрчлөөд, энд будилуулж байгаа бол туйлын хариуцлагагүй.Өнөөдөр Бага Хурлын дарга тухайлбал Гончигдорж гэж байхад үүнийг ямар нэгэн Дорж ч юм уу болго-сонтой энэ ялгаагүй асуудал.Ингээд үүнийг энэ дэгийг боловсруулсан хүн бол зориуд анхаарах ёстой гэж бодож байна. Ингээд энэ нэгдүгээр зүйлийг дараах байдлаар найруулж, санал хураалгах саналтай байна.

Энд Ардын Их Хурал нь бүх ард түмнээр хэлэлцүүлэн хянаж засварласан,Бага Хурлаас өргөн барьсан БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийн төслийг үндэс болгон хэлэлцэнэ гэж оруулах саналтай байна.

167 дугаар тойргийн депутат Ш.Гурбазар:

Би ганцхан зүйлийг хэлье. Хурлын дарга, депутатууд аа,

БНМАУ-ын Ардын Их Хурлыг Ардын Их Хурал гэдгээ энэ маягаараа бол Ардын Их Хурал гэдэг нэг хаягаа хамгаалж чадахгүй нь ээ.

Соронзон хальстай тулгаж
НИЙЛСЭН

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

Бичээч Д.Цэндсүрэн

1991.XI.II.
Кассет № 43
10.15-10.30

Ж.Уртнасан -Санал хураалтаа явуулаад энэ асуудлыг амархан шийдэж болмоор байна. Хүндэт депутатууд нэг зүйлийг ойлгомоор байна. Бид Үндсэн хуулиа хэлэлцэж эхлээгүй, зөвхөн төслийг нь оруулж хэлэлцэх гэж байна. Чухам Үндсэн хууль гэх үү, Их цааз дэх үү, БНМАУ гэх үү, эсвэл Монгол гэх үү гэдгийг бид хэлэлцэж эхлээгүй байна. Үүнд шууд орчихоод байгаа учраас өрх олгож, бидэнд оруулж байгаа субъектын оруулсан нэрээр хэвээр үлдээе гэсэн санал хураалт явуулья.

Танхимаас: -Их хурлын даргаа субъектын тухайд гэвэл өөр субъект байгаа шүү дээ. Бага Хурлаас өөр субъект байгаа шүү дээ. Бид ямар үндэслэл яриад байнавэ гэхээр би саналаа хэлэхэд Үндсэн хуулийн төсөл боловсруулах комисс гэж бий. Тэр комисс боловсруулж ирээд Бага Хуралд оруулсан. Үүний дараа ард түмнээр хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлсний дараа тэр комисс нь дахин өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн төслийг боловсруулан комисс нь мөн дахин төслийг боловсруулж Бага Хуралд оруулсан. Энэ Үндсэн хуулийн комиссын боловсруулсан тэр төслийг л хэлэлцүүлье гэж би ярж байна.

Ж.Уртнасан -Уучлаарай, ингэж туульширмааргүй байна. Хэрвээ Үндсэн хуулийг боловсруулах комисс гэвэл Бага Хурлаас томилсон комисс байгаа шүү дээ. Тийм учраас бид энэ хуралд хэлэлцэх зүйлийг оруулж байгаа субъект Бага Хурал гэдэг дээр туйлбартай баймаар байна. Тиймээс Бага Хурлаас оруулж байгаа төслийг хэлэлцье гэсэн саналыг оруулж байна.

Бага Хурлаас оруулсан төслийг хэвээр үлдээе гэсэн дээр санал хураалт явуулья.

Санал өгсөн депутатуудын 80 хувь буюу 288 депутат зөвшөөрсөн санал өглөө. 17 хувь нь буюу 62 хүн татгалзаж байна. 2 хувь буюу 8 хүн түдгэлзлээ.

I-р зүйлийн 2-р заалтыг зарим депутатууд хасая гэсэн санал оруулсан. Үддээх, хасах гэсэн хоёр зүйл байна. Хажуу-гийн санал хасая гэсэн оруулж байна. Үүн дээр санал хураалт явуулья.

II-р зүйлийн 2-р заалтыг хасая гэсэн санал хураалт дээр эхэллээ.

Санал өгсөн депутатуудын 81 хувь буюу 327 хүн зөвшөөрсөн байна. 15 хувь буюу 63 депутат татгалзаж байна. Түдгэлзсэн 10 хүн буюу 2 хувь байна.

Танхимаас: -3-р микрофон дээрээс ярьж байна. Нэгдүгээр асуудлаар зөвхөн оруулсан төслөөр хэлэлцье би цөөнхийн талд орчих шиг боллоо. Тэхээр үүн дээр дахин санал хурааж өгнө уу, хумуус сайн ойлгосонгүй болох шиг болчихлоо. Ямар нэгэн найрууллагүйгээр оруулж гэчихлээ. Би найрууллагатай оруулсан гэж ойлгосон.

Ж.Уртнасан -Бид эргэж ярицааргүй байна. Хоёрдугаарт II-р зүйлийн 2-р заалтыг хаслаа.

Гуравдугаарт Монгол улсын Их цаазын төслийг хянан хэлэлцэхэд анхны ^{элгийн} хэлэлцүүлэгтэй байна гэсэн зүйл бий. Үүн дээр хэвээр үлдээх санал хураалт явуулж байна.

Санал өгсөн депутатуудын 94 хувь буюу 382 хүн зөвшөөрч байна. 4 хувь буюу 18 хүн татгалзлаа. 4 хүн буюу 4 хувь түдгэлzsэн байна.

Энд депутатуудаас анхааруулга ирж байна. Ардын Их Хурлын дарга танаа. Депутат Зоригийг өөрийн суудалд суухыг анхааруулж байна гэсэн байна. Депутат Зориг өөрийн суудалдаа сууна уу.

3.

Депутат Зориг өөрийн суудалд суухаар ирж байна. Одоо хэлэлцүүлгээ ургэлжлүүлье. 4-р заалтын "а"-г хэвээр үлдээх санал хураалт явуулж байна.

4-ын "а" заалтыг 94 хувь буюу 377 депутат зөвшөөрлөө. 4 хувь буюу 18 хун татгалзлаа, 3 хун түдгэлзсэн байна.

4-ын "б" заалт дээр тодорхой горимын санал гараагүй.

Б.Лигдэн /405-р тойргийн депутат/: -4-ын "б" заалтыг хасая гэсэн саналтай байна.

Ж.Уртнасан -Учлаарай, нэгдүгээрмикрофон сонсогдохгүй байна.

Г.Очирбат /12-р тойргийн депутат/: -4-р зүйлийг бид хэлэлцэхдээ "а", "б", "в" гэж явмааргүй байна. Яагаад гэвэл 4-р зүйлийн бүх юмнууд хоорондоо хэлхээ, холбоотой учраас 4-р зүйлийн усгээр дугаарласан хэсгүүдийн талаар би нэгмөсөн санал хэллээд, үүн дээр хойшно, урагш нь болгох юм байна, мөн хасах юм байна, миний хувийн санал, ингээд хэлчихвэл болох уу?

Ж.Уртнасан -Болж байна.

Г.Очирбат -4-р зүйлийн "б" заалт нь хасагдах хэрэгтэй, илтгэлийн агуулгыг энд бичих ямар ч хэрэггүй. "в" заалтын дараа шинэ заалт оруулья. Энэ нь юу бэ гэхээр Үндсэн хуулийн төслийн талаар өрөнхий санал шүүмжлэл явуулна. хун бүр 10 хуртэл минут гэж. Сая нэг депутат хэлж байсан, зарчмын хэдэн гол зүйлээ тогтох аваад, дараа нь булэг зүйлээр хэлэлцье гэсэн саналыг би зөв санал гэж бодсон. Зарчмын гол асуудлуудыг төсөл дотроос гаргаж ирэхийн тулд бид өрөнхий санал, шүүмжлэлийг нэг, хоёр өдөр явуулах ёстой гэж бодож байна. Яагаад гэвэл нийт Үндсэн хуулийн талаар бид тодорхой ойлголт байхгүйгээр бид оршил, нэгдүгээр зүйлээ яах вэ гэж ярьж болмооргүй юм.

Дараагийн санал гэвэл энэ нь жижиг зүйл, "д"-гийн суулчийн өгүүлбэр, зарчмын шинжтэй асуудал бур дээр санал хураалт явуулж, депутатын гуравны хоёрын саналаар шийднэ гэдэг нь илүү учраас түүнийг хасчихмаар юм. Түүний дараагийн "е"-г эхний өгүүлбэр нь хэвээр, энэ нь урьдах өгүүлбэрээ давтаж байгаа юм. Гэхдээ саналын зөрүүтэй зарчмын асуудлыг депутатуудын гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ гээд, түүний хооронд байгаа хувилбараар шийдвэрлэх саналтай байна, эсвэл уг асуудлын талаарх төслийн заалтыг дахин гүйцээн боловсруулан гэх мэт нуршсан зүйлийг хасах хэрэгтэй гэж бодож байна.

Үүнийг саналын зөрүүтэй зарчмын асуудлуудыг депутатуудын гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ гээд хоёрдмол утга байхгүйгээр биччихвэл яасан юм бэ?

Мөн энэ зүйлийн "з" дээр Ардын Их Хурал, Их цаазын төслийг бүхэлд нь зөвшөөрсөн нөхцөлд зохих саналын дагуу түүнийг зарчмын хувьд өөрчлөх, найруулан засах үүрэг бүхий депутатуудын хороог ажлын хэсгийн хамт байгуулж ажиллуулна гээд түүний дараагийн өгүүлбэрийг хасмаар байна. Ажлын хэсэгт Комисс ч орж болно, хэн ч орж болно. Харин ажлын хэсгийг хороод өөрсдөө байгуулах юм уу, бид эндээс нэрийг нь сонсож байгуулах юм уу гэдгээ тогтмоор юм. Үүнийг хороод нь ч байгуулж болох байх. Өчигдөр манай Бага Хурлын эрхэм гишүүдийн нэг нь тайлбарлаж байсан, бүлэг, булгээр нь хороо байгуулахаар Бага Хурлынхан бодож байгаа гэдэг нь үнэн бол таван хороо байгуулагдах юм уу, яах юм, тэгвэл таван хороо тус бүрдээ ажлын хэсэгтэй байх юм. Түүнийг би давтаж хэлэхэд хороод өөрсдөө байгуулах уу, аль эсвэл эндээс энэ булагийн энэ хороонд тийм хүн байна гэдгийг бид хэлж, ярилцах юм уу, үүнийг шийдвичихмээр байна.

Тэхээр үүнтэй холбогдуулж нэг санал байна. "Е" заалтын эцэст зөрүүтэй асуудлуудыг депутатуудын гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ гэсэн, үүнийхээ дараа хэрэв уул асуудлаар дахин

5.

санал хураах шаардлага гарвал 24 цагийн дараа дахин санал хураалт явуулна гэх. Яагаад би ингэж хэлж байна вэ гэхээр Үндсэн хуулийн аливаа асуудал нь маш их зарчмын асуудал юм. Түүн дээр нэг санал хураачихаад, үүгээр дарчихъя гээд дахин товч даруулаад байхыг би болохгүй гэж бодож байна. Зарчмын асуудлаар санал зөрөлдлөө, дараа нь 24 цагийн дотор, жишээ нь өнөөдөр 24 цагийн дотор, маргааш нь депутадууд хоорондоо ярилцаад, мөн хэсэг бүлэг, мэргэжлээрээ ярилцаад үүнийг ингэж томъёолох нь зүйтэй юм шиг байна гэсэн, өөрөөр хэлбэл мэдлэгтэйгээр дахин саналаа өгөхийн тулд энэ тодотголыг заавал тусгах хэрэгтэй юм гэж бодож байна.

Дараагийн 3-р зүйл нь мөн үүнтэй холбоотой юм. Энэ хоёрыг яагаад салгасныг би мэдэхгүй байна. Хороодууд байгуулна гэсэн зүйл яваад байна. Хэрэв эрхэм депутатууд зөвшөөрвөл би нэгэnt боссон учраас би үүнийгээ хэлчихмээр санагдаад байна.

5-р зүйлийн "а" гэдэг дээр анхны хэлэлцүүлгээр сайшасан төслийг депутатуудын хороонд эцэслэн гүйцээж боловсруулна гээд ажлын хэсэг нь гэж байгаа юм. Ажлын хэсэг гэдэг нь биш юм. Би түүнийг депутатуудын хороодд, дараа нь Ардын Их Хурлаас анхны хэлэлцүүлгээр тогтсон зармын тохиролцоог нэгбүрчлэн хянан узэх гээд дуусах хэрэгтэй юм. Түүний дунд комиссоор хэлэлцнэ, барина гэсэн зүйлүүдийг би хасая гэж байгаа юм. Мөн "б" заалтыг бүхэлд нь хасая. Харин "в" заалтыг шинээр найруулах хэрэгтэй гэж бодож байна. Яаж найруулах хэрэгтэй вэ гэвэл депутатуудын хороодын дарга нар тухайн бүлэгт оруулсан засвар, өөрчлөлтөө уншина, Ардын Их Хуралд танилцуулна гэх. Өөрөөр хэлбэл саналыг хороо, ажлын групп хоёр л ажиллана. Тэр ажлын групп, хороонд Улсын Бага Хурлаас байгуулсан комиссын гишүүд орж ажиллана. Түүнээс биш намууд хэлэлцээд, нэг их олон шат дамжлагатай бичсэн байна. Ер нь Үндсэн хуулийг төслийг боловсруулах ажлыг зохион

байгуулах комиссын бүрэлдэхүүнд намын төлөөлөгчид жил тойрон ажиллаа шүү дээ. Тиймээс энд дахин хэлэлцээд байхгүйгээр депутатууд байгуулсан хороогоороо хэлэлцээд, ажлын групптэйгээ ажиллаад, тэр хороо нь өөрийн тухайн булгийн саналыг Ардын Их Хуралд оруулж хэлэлцүүлбэл яасан юм бэ гэсэн санал байна.

Ж.Уртнасан -Баярлалаа, депутатууд аа! нэг зүйлийг анхааръя. Бид дахин хавтгайрч эхэлсэн юм шиг байна. Тиймээс эаалт тус бүр дээрээ саналаа хасая, үлдээе, редакц хийе гэсэн шугамаар явбал бид түргэн явах юм шиг байна. Үүнийг анхаарна уу? 5-р микрофон.

С.Зориг/9-р тойргийн депутат/ -Би саяны бичгийн хариут өгье. Заавал суудал дээрээ бүх санал хураалтанд сууна гэсэн заалт дэгд дээр заалт байхгүй. Ер нь нийт депутатуудын 75 хувь байхад санал хураана гээд Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулинд дээр заачихсан байгаа юм. Тийм учраас би санал хураалтад оролцохдоо манай тойргийн сонгогчдын эрх ашгийг хөндсөн асуудал байвал би саналаа өгнэ. Бусад үед өгнэ, өгөхгүй гэдэг нь миний эрхийн асуудал юм. Ямар ч утгагүй хэлэлцүүлэг дээр наадад санал өгөх ямар ч сонирхол алга. Дэгийг хоёр өдөр хэлэлцэж байгаа нь депутатуудын өөрсдийн зохион байгуулалтын үеийн асуудал болохоос биш, эцсийн эцэст миний бодлоор манай сонгогчдын эрх ашигт сунжуулж байгаа нь муугаар нэлэөлж байна.

Чинбат /245-р тойргийн депутат/ -Их хурлын даргад нэг зүйлийг хүсмээр байна. Голоор сууж байгаа депутатуудад микрофоныг олгох арга хэмжээ авч өгөхгүй юу. Өчигдрээс хойши микрофон одсонгүй. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлэх санал бодлууд их байна. Тэр бүрт хүн амьтны хөл, гарыг нь гэшигчихээд, холоос зутгээд байх нь үнэндээ хэдүү байна.

7.

Сонсогчдын санал, бодлыг илэрхийлж, хамгаалах бололцоо, нөхцөлөөр хангаж өгөхгүй гэж зориуд хүсэж байна.

4-р зүйлийн "а", "ё" заалт дээр хоёр санал байна. "а" заалтыг нь "б" болгоод, "б" заалтыг нь "а" болгох байралын зүйл байна. Өөрөөр хэлбэл Их цаазын төслийг гаргаж тавих, уүний шинэчлэх болсон шалтгаан, учир нь юу байгаа юм. Түүний үндэслэлийг нь эхлэж сонсоод, түүнийг боловсруулсан үйл явцыг нь бид сонсож, мэдсэний дараагаар түүний дагуу ард, нийтээр хэлэлцүүлсэн дун нь юу болсон ~~элгээдийг~~ сонсох нь зүйтэй болов уу гэсэн саналыг оруулж байна.

Ж.Уртнаасан -Уучлаарай, эрхэм депутатууд аа, бид ажлын техникийн хэсэгт та бүхний хүсэлтийг дамжуулсан юм. Голд сууж байгаа хумуус уг хэлэхэд хүндрэлтэй байна. Тийм учраас явуулын микрофоныг ажиллуулья гэж. Техникийн боломж дээд зэргээр хийгдсэн, энэ 6 микрофоноос өөр юм нэмэх ямар ч арга байхгүй гэсэн хариулт авсан. Техникийн боломж бид нарыг хязгаарлаж байна. Бид та бүхний хүсэлтийг дамжуулсан.

Ц.Альясурэн /55-р тойргийн депутат/ -Горимын санал байна. Бид хуралдааны ажиллагааг шуурхай явуулахын тулд зүйл дотроо "а", "б" гээд дугаарласан болгон дээрээ зогсоод байвал мөн хэлэлцээд байвал өнөөдрийн турш дэгээ хэлэлцэх байдалд хүрэх нь байна. Тийм учраас оруулж ирсэн саналыг эхэлж ярилцаад, энэ зүйлийн "а", "б" ч гэдэг юм уу үлдээх үү гэдэг дээр санал хурааж байя. Үүн дээр хэрэв зарчмын өөр санал байхгүй бол олонхийн саналаар авч, үргэлжлүүлээд явья. Хэрэв ингэвэл шуурхай болмоор санагдаж байна. Үүний дараагаар хажуугийн саналыг авч үзэх нь зүйтэй юм. Эхлээд хажуугийн санал хэлэлцэх нь хуралдааныг нэлээд удаашруулж, замбараагүй байдалд оруулах юм.

"б" заалтын хувьд гэвэл энэ нь байсан ч, байгаагүй ч ялгаа алга учраас энэ заалтыг үлдээх үү, угүй юу гэдэг дээр санал хурааля.

Соронзон хальснаас
тулгаж нийлсэн
Бичээч

Ч.Батчуул

Л.БАЯРМАА
С.ТУУЛ

1991-XI-12.

Кассета 44

10.30-10-45

2-р микрофон: I67-р тойргийн депутат Ш.Гурбазар:

-Хурлын дарга аа, учлаарай, би нэг санал хэлье.

Өөрийнхөө ажлын талаар нэг зүйл ярья. .Нэг юмыг хэлэхгүй байж болохгүй байна, Өчигдөр I депутат санаачилга гаргаад тэнд гэрэл асаад байна аа, унтраа гэсээр байгаад унтраалгасан, өнөөдөр одоо энд унтраагаад байна, энэ 4 гэрэл асаж байж, манай сурвалжлага бүрэн бүтэн явах ёстой. Энийг нэг ойлгож суудлаа ч гэсэн зохицуулж өгөхгүй юу. Одоо ямар ч зураг авах бололцоогүй болчихоод байна. Энэ чинь улс төрийн товчооны урдуур хурдан морины зураг авлаа гэж манай нэг хүнийг тэр жил шийтгэсэн шуу дээ. Тэрэнтэй адилхан энд нэг хоёр хүний толгой халх хэрэгтэй байна уу, ард түмэн юм узэх хэрэгтэй байна уу, энэ чинь удаан цаг хүний яриаг отож байгаад хэрэгтэй, угүйгий нь авах гэж л оператор тэнд зогсож байгаа шуу дээ. Энийг та нар нэг зөвөөр ойлгооч. Би зүгээр яхав ажлынхаа зүйлийг нэг удаа ярьчихаж болдог юм уу угүй юм уу. Энэ чинь асаж байх ёстой юмыг ордонд тоноглогдсон зориуд ордондоо тохирч тавьсан гэрэл, энэ хэдэн гэрэл нь асахгүй бол төхникийнхээ боломжийг хар л даа манай Монгол телевиз чинь монголд чинь ямар хүйтэн гэрэл гэж байх биш, ийм л юмаар халааж байж л ард түмэндээ юм узуулдэг учраас энийг нэг бодолцооч ээ, ордын хурлын зохион байгуулж байгаа хүмүүс ч гэсэн ойлгооч ээ. Ингээд загнаад тал талд нь унтраагаад байтал тэгээд юу ч гарахгүй шуу дээ, голдоо ганц нэг хүн уг хэлбэл гарч болох юм, зүгээр тэр ер нь хурлын үнэн болж чадах болов уу угүй болов уу.

Уртнасан: -Баярлалаа эрхэм депутат Гурбазараа, ард түмэнд та бид нүүр царайгаа харуулж байхын тулд таны хүсэлтээр гэрэл асаая. Харин толгой нь халж байгаа зарим депутатыг суудал сольж суухыг зөвшөөрье.

За депутатуудын саналыг хүлээж авлаа. Бид шуурхай явахын тулд ерөөсөө нэг ийм зүйл дээр санал хураачихмаар юм шиг байна. Бид хажуугийн саналыг эн тэргүүнд хэлэлцэж байгаа. Үндсэн их төслөө баримтлалгүй хажуугийн саналыг хэлэлцэх уу гэдэг дээр зарим депутатууд санал гаргаж байна. Хажуугийн саналыг өхөлж хэлэлцэе гэдгээр санал хураалт явуулчих уу.

Хэрэггүй шу. За баярлалаа.

5-р микрофон 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр: -За 4-ын Б-г хасч болохгүй үлдээх хэрэгтэй. Гэхдээ энд бол нэг зүйлийг нэмэх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Ерөнхийлөгчийн тэр илтгэлд бол АИХ-ын депутатуудын хууль санаачлах эрхийнхээ дагуу өгсөн санал, түүнийг хэрхэн туссан байдал гэдгийг энэ Б-д нэмж оруулах нь зүйтэй болов уу, За 2 дугаар санал бол бид түргүн II-ийн 2-ыг бол царт хасчихсан болов уу гэж бодож байна. Энийг өөр найруулгаар хэлэхийг зөвшөөрнө уу дарга аа. Тэгэхлээр энд ийм найруулга хийвэл ясан юм гэдэг саналтай байна. Төслийн бүлэг зүйлээр тодорхой хувилбарыг хэлэлцүүлэхээр бэлтгэсэн бол төслийн зохих үндэслэл гээд ингээд цаашдаа энэ өгүүлбэрийг хэвээр байлагавал ясан юм бэ, энэтэй холбогдуулж хэлэхэд бид мэдээж хэрэг субъектын хувьд бага хурлын төсөл дээр ярих нь зүйтэй, гэхдээ

энд депутатын хууль санаачилах эрх, депутатын хэсгүүдийн хувилбаруудыг хэлэлцэх ийм варент байхгүй бол болохгүй гэдэг ийм санал байна. 3-рт сая депутат нөхөр Очирбатын депутатуудын хорооны талаар гаргасан тэр үнэтэй саналуудыг энд тусгахыг хүсч байна.

Уртнасан:

-Бид санал хураалтаа цааш нь үргэлжлүүлж болж байна уу, эсвэл зөвхөн Б заалттай холбогдуулж хэлэх гэж байна уу.

-Дарга аа, хүний эрхийг заалаасаа эхлэх уу?

6-р микрофон: 393-р тойргийн депутат Д.Баасанжав: -Эрхэм хүндэт Хурлын даргадаа хүсэх юм байна. Бид хүний эрхийн тухай асуудлыг ярих гэж байна. Өнөөдөр депутатынхаа эрхийг энэ заалаасаа эхэлж угзэх хэлэх, узлэх илэрхийлэх төдийгүй үндсэн хуулийцаа саналаа өгөх боломжийг адилхан хангаж өгөөч гэж гүйж байна. I-рт, Ингээд 2-рт нь 4-ын А-д заасан энэ илтгэлийг гэдгийг би Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссын даргын илгэлийг бур оруулмаар байна. Яагаад ингэж байна вэ гэхлээр зэрэг өчигдөр Очирбатыг, Гончигдоржийг уг хэлүүлэх уу угүй юу гэх мэт ийм асуудал болсон. Тэгэхээр энэ чинь бас л эрхийн тухай асуудал. 2 дугаарт нь тэр 4-ын Б заалтыг хасах гэж хэрхэвч байж болохгүй гэж үзэж байна.

Энэнтэй холбогдуулаад түрүүн депутатат Бүрэвдагын хэлсэн улсын бага хурлын субъект байгаа тэр эрхийг хэзээ ч мартаж болохгүй. гэж бодож байна. Эцэст нь бид нь энэ төслийг Улсын Бага Хурлаар Үндсэн хуулийн тесэл боловсруулах комиссоос боловсруулж оруулж ирсэн энэ төслийг үндэс болгож хэлэлцэх гэдэг бол яг зөв. Гэхдээ бид нь үндэс болгож хэлэлцэх болохоос биш тэрнийг тэр хэвээр нь батална гээгүй гэж ойлгож байгаа. Үүнтэй холбогдуулаад бид нь юу хэлэх вэ гэхлээр бид ямар ч төсөлгүй, юу ч мэдэхгүй байгаа биш бидэнд 430 депутатын өвөрт 430 тесэл байхгүй, харин бидэнд энэ нэг төсөл байж байгаа гэдгийгээ бий бол эрхэм хүндэт депутатууд ингэж ойлгож хэлэлцэх байх аа гэж бодож байна. Тэгээд үүнтэй холбогдуулаад бид 4-ын Б бол чухлаар барахгүй энэ дээр боловсруулсан комиссын дарга, мэн түүнчлэн хянан хэлэлцэн хэлэлцэж өргөн барьсан Улсын Бага Хурлын дарга нар ч энэ дээр бидэнд тов тодорхой тодорхойлолтоо өгөх ч ёстой болох байх, угээ бол чөлөөтэйгээр хэлэх ийм боломжийг депутат бидэнд олгох ёстой болов уу гэж ингэж бодож байна.

-180 дугаар тойргийн депутат Отгон: -За энэ дээр би нэг ийм санал байна. 4-ын З- энэ АИХ-ын цаазын найруулах энэ депутатын хороо ажлын хэсгийг байгуулж ажиллуулна гэсэн энийг бол З дугаар заалтын урд нь оруулмаар байна. Энэ улсууд бол анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэгээ хүртэл бас ийм комисст орсон юм гэж дүгнэж, бодож байхад ажилц нэлээн дөхөм байх болов уу гэж, тусгай зуйл болгоод оруулчихмаар байна. 2-р зуйл ч юмуу, З дугаар зуйл ч гэдэг юм уу ингэж оруулмаар байна. 2 дахь асуудал бол анхны хэлэлцүүлгээрээ бид ямар хэмжээнд нь дуусгах вэ, эцсийн хэлэлцүүлгээрээ юу дуусгах вэ гэдгийн анхны, эцсийн гэдэг дээр нь бол тодотгол өгмөөр санагдаж байна. Анхны хэлэлцүүлгээрээ болбол бүлэг, зуйл бүрээр нь саналы нь аваад үүнийгээ ажлын хэсэг депутатын хороо нь өөрчлөөд эцсийн хэлэлцүүлэгт нь үүнд нь санал дүгнэлтээ өгөхөөр ингэж орохгүй бол анхны хэлэлцүүлэгч арван хэд, эцсийн хэлэлцүүлэг ч 2, З дахих ийм байдал орох бий гэсэн ийм санаанууд байгаа юм. 3 дахь асуудал бол ер нь зөвхөн энэ дэгийн нэрэн дээр манай Бага Хурлын эрхэм гишүүд индэрлэж босож ирж байх шиг байна. Цаашдаа ингээд Үндсэн хуулийн асуудал халэлцээд ярийн дээр зэрэг нь энэ хэдэн депутатууд юм мэддэггүй, гэж өөрийнхөө санааг тулгах ийм асуудал гарвал хэцүү

байна. Энүүн дээрээ анхаарч үзээчээ гэж хүсэх байна.

4-р микрофон: 50-р тойргийн депутат А.Далхжав: -Ер нь депутат нөхдүүдээ бас нэг хэлмээр юм санагдаад байна. Хэлэлцүүлгийн яңцад. Үндсэн хуулийн төсөл бүх ард түмнээр хэлэлцүүлэгдэх дээр гарсан, тэрнийг ард түмэн хэлэлцэнэ. Үндсэн хуулийн комисс түүнийг шүүн тунгааж боловсруулсан. Энийг Улсын Бага Хурал 2 шаттай-гаар хэлэлцэн, өнөөдөр бидний гар дээр ирчихээд байна, тэгээд энэ болитой материал дээр бид одоо үйлдвэрийндээ байгаа ард түмнийхээ саналыг нэмээд энэ дээр хэлэлцэж болох ийм хетелбөргүй зүйл дээр маргаж цаг их алдлаа. Ингэж цаг битгий алдаасай гэж бодож байна. Тэгээд тэр А зүйл дээр байгаа Үндсэн хуулийн илтгэлийг өхөлж сонсоно гэж байгаа. Сонсоны дараагаар I-2 өдөр өрөнхий санал шүүмжлэл заавал явах шаардлагатай. Энэ бол бид цаашдаа Үндсэн хуулийнхаа зүйл ангийг нарийвчлан ярихад асуудал нэлээд нэг тийшээгээ цэгцэрсэн байх ёстой болов уу гэж бодож байна. Ийм учраас өрөнхий санал шүүмжлэл зөвхөн үндсэн хуулийнхаа асуудлаар явуулах нь зүйтэй гэсэн ийм саналтай байна. За тэр диллер нь бол нэг тийм танилцуулга юм уу, бас л нэг ойлгохгүй нэг сунжирсан юм орсон байх юм, үүнийг угүй бол хасах юм, угүй бол өрөөсөө сурталчилгааны булангаар одоо зохицуулж болохоор ийм зүйл байна. Ялангуяа хуулийн зохицуулалтаас үүсч гарах нийгэм эдийн засаг, хууль зүйн үр дагавар гэдэг юм биднүүсийн сонирхлыг их татаж байгаа байх гэж бодож байна. Ямар үр дагавар гарахыг ямар эдийн засаг улс төрийн нөхцөл байдал нөлөөлөх юм, энэ юмыг тооцоо судалгаа янз бурийн имаар харуулсан байсан тийм сурталчилгааны юм байгаа юм болов уу гэж ингэж бодож байна.

Уртнасан:

-За баярлалаа, саналууд ер нь нэгтгэгдээд гарчихлаа гэж ойлгож болно. Ийм учраас саналаа шууд хэлэлцэж өхөлвэл санал хураалт явуулъя.

-4-р зүйлийн заалтын А,Б хэсэг дээр З санал байна. Байры нь солий гэсэн нэг санал байгаа юм. Үлдээж редакци хийэ гэсэн санал байгаа юм. В хэсгийг хасъя гэсэн санал олонхийх болж чадахгүй байх шиг байна. Ийм З санал байна. Тэгэхээр А заалтыг бид баталчихсан. Одоо Б заалтыг ярьж байгаа. Зүгээр ер нь энэ хоёр заалтын байрыг солих эсэх талаар санал хураалт явуулж болж байна уу. Хэрэггүй юу, за баярлалаа, тэгвэл шууд Б заалтаа яръя. Энэ Б

заалт олонхийн саналаар үлдэх нь шиг байна.Хасъя гэсэн хүмүүсийн санал цөөнх болж байна уу гэж би ойлгож байна.Энэ Б заалтыг редакци хийж үлдээе гэдэг дээр санал хураалт явуулъя.Б заалтыг редакци хийж үлдээе.За санал хураалтад бэлтгээрэй депутатууд. Б заалт үлдэж байгаа.За баярлалаа, 277 депутат зөвшөөрлөө, 115 депутат татгалзаж, 9 хүн тудгэлzsэн байна.Баярлалаа.

За Б заалтын дараа нэг депутатын санал байгаа юм.Нэг нэмэлт шинэ заалт оруулъя гэж.Үндсэн хуулийн төслийг хэлэлчүүлэг явуулахад хүн бур 10 минут уг хэлнэ гэсэн нэг тийм өрөнхий хэлэлцүүлгийн үед.Энэ заалтыг оруулах уу, болих уу, гэсэн заалт ер нь нэмэх уу гэдэг дээр санал хураалт явуулчихвал элж байна уу. Заалт энэ Үндсэн хуулийн төслийг анхны өрөнхий хэлэлцүүлгийг явуулахад хүн бурт 10 минут гэсэн заалт нэмье гэдэг дээр санал хураалт явуулъя.За депутатууд анхаараарай, санал хураалт явууллаа.

Олонхийн саналыг авч чадахгүй байна, 204 депутат буку 49% нь санал өглөө.192 депутат татгалзаж байна.Ийм учраас энэ заалт хэвээр үлдлээ.Нэмэлт орохгүй нь ээ.За В заалтыг хэлэлцье. Энэ дээр З санал байгаа юм.Бага Хурал түүний комисс өгнө гэсэн сүүлчийн өгүүлбэрийг Үндсэн хуулийн комисс, УБХ-ын Үндсэн хуулийн комисс гэсэн нэг санал орж ирсэн, эх зохиогчид оролцох нь зүйтэй гэсэн санал орж ирж байна.За Улсын бага хурал түүний комисс гэдэг маань цаанаа УБХ эрхэлсэн эх зохиогчдыг агуулж байгаа болов уу гэсэн ийм утга байгаа юм.Ийм учраас нэмэлт хийхгүйгээр В заалтыг хэвээр үлдээе гэдэг дээр санал хураалт явуулъя.Санал хураалтанд бэлтгэнэ уу, депутатууд.

За баярлалаа.Депутатуудын 336 нь 82 % нь зөвшөөрлөө. 64 депутат татгалзаж, 6 депутат тудгэлzsэн байна.За энэ заалтыг үлдээлээ.

За Г заалт дээр тодорхой горимын санал гарсангүй.Мөн хэвээр үлдээхээр санал хураалт явуулъя.

Г заалт дээр санал байна уу.

264-р тойргийн депутат Б.Банди: -Тэгэхээр энэ Г заалтын тухай тургун ч бас яригдаж байсан.Үндсэндээ нэг хэлэлчүүлгийн шат нэмэгдчихээр юм шиг байна.Ингэж яригдаж байсан.Тэгэхээр энд

бас миний хувьд жаахан цаг хугацаа хэмнэх үүднээс хэлэлцүүлгийг удаашруулахгүй байх үүднээс өр нь нэгэнт 2 шатны хэлэлцүүлэг явагдахаар бид нар дээр хэлэлцээд тохирчихлоо. Тэгэхлээр энэ хоёр шатныхаа хэлэлцүүлгийн хувьд булэг, зүйл бүр дээр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ярилцах боломжоор хангагдаж байгаа гэж үзэж байгаа. Гэтэл энэний оршил болгож байгаа 2 өдөр ярилцъя гэсэн зарим саналтай хүмүүс байгаа юм байна. Дээр ярыж байна. Гэтэл тэрнийг нь энэний урд талын санал хураалтаар бол 10 минут ярих асуудлыг бол татгалзаж байна депутатууд, ингээд бодоход оршил болгож ингэж ярихгүйгээр шууд анхны бөгөөд 2 дахь эцсийн хэлэлцүүлгэн дээр бүх санал бодлоо төвлөрүүлж ярыж болох байх гэсэн ийм санал байх юм. Ингээд илтгэлийн дараа асуулт, хариулт явагдана гэж байгаа. Энэ явагдаж дуусаад уг хэлнэ гэж Г заалтад орсон энэ заалтыг бухэлд нь хасаад шууд анхны бөгөөд эцсийн хэлэлцүүлгийн хед тухай тухайн зүйл анги дээрээ асуудлаа ажил хэрэгчээр ярилцах ийм санал бол хувьд байх юмаа. Ер нь тэгээд ярина гэдэг бол 10-аад зүйлд нарийн ярих юм бол 7, 8 зүйлийг л бид нь бүтэн жилийн турш ярысан шүү дээ. Ард түмнээрээ ч ярысан, Бага хурал дээр ч ярысан, одоо ингээд 2 өдөр ярина гэхэд дахиад л нэг нь Монгол улс гэж хэлнэ гээд босч ирнэ, негөөх нь БНМАУ гэж хэлнэ гээд ингээд л нэг хоёр өдөр л ярих л байх л даа. Тийм учраас ингэж цаг алдах хэрэг байна уу, угүй юу энэ Г заалтыг хасах саналтай байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

 Ш.БУРМАА

38

1991.XI.12
Кассет 45
10.45-11.00

44 дүгээр тойргийн депутат Ш.Сүрэнжав: -Туруун одоо мундагдаж байгааг хасуулчихлаа. Очирбат гуайн хэлдэг дээр бодууштай юм байсан шүү дээ. Ерөнхий санал шүүмжлэл явуулна гэж байна. Тэрийг сая тасалчихлаа. Одоо энэ дээр холбогдуулж хэлэхгүй бол ингээд энэ чинь давхиад харайж гаралдаа өнгөрөх нээ. Депутатууд зүйл бүр дээр уг хэлж санал гаргана гэж байна. Энэ Үндсэн хууль, Их цааз гэдэг чинь хоорондоо бие биенээсээ ургаж гарсан, тэгээд бүрдэж байх цогц юм аа. Тэгэхээр меч мөчөөр нь салгасан ганц, нэг нэр гэдэг дээр би нэг хэлчихээд энд очерлож очерлож өдөржин тэгээд сууж байх гэдэг бол утгагүй.

Хэрэв цаг олддог юм бол би холбогдуулж Их цааз гэдэг маань юу юм, энэ дээр би ямар санал, юугаар хэлж байна гэдгээ энд хамтад нь хэлэх, санаа бодлоо хэлэх юм байхгүй бол болохгүй. Тэгэхгүй бол зөвхөн энэ дээр ярина, бусдыг боль гээд тухайн үед энд тэндээс хамгираад ч юмуу, тэндээс зааварлаад болиулна шүү дээ. Тэгээд ямар байдлаар бид энийг хэлж ярих юм бэ? Тэр байтугай заримыг уг хэлэхийг зүйл бүр дээр хасна ч гэнэ уу, би ер нь ойлгохгүй байна. Тийм учраас ямар нэгэн хэмжээгээр турван хугацаа заасан байгаа шүү дээ. Тэр хугацаандaa оруулаад эхлээд Их цаазын тухайд бол өөрийнхөө бодож байгаа юмыг тодорхой гаргаж ирж, ерөнхий дүр зураг, тэр дотроос би энийг хэлж байна гэж цохож хэлээд уг булэгтэйгээ холбогдуулж хэлээд сууж баймаар байна. Тэгэхгүй энийг ингээд батлах юм бол зүйл бүр дээр гэхээр ийм болно. Энийг анхаарч үзэж, бусад нь ч гэсэн энэ саналыг дэмжих өгөөч.

Арлын Их Хурлын дарга Ж.Уртнасан: -Сүрэнжав депутат аа, таны "Г" заалт дээр засамжлан сайжруулсан өөрийн хувилбар байна уу? Зүйл бүрээр хэлэлцье гэдгийг та шүүмжиллээ шүү дээ. Тэгэхээр цогцоор хэлэлцэнэ гэдэгт өөрийн боловсруулсан хувилбар байна уу?

258 дугаар тойргийн депутат Ш.Гунгаадорж:

Тэгэхээр энд ганцхан юман дээр эрхэм депутатуудыг анхаарлаа хандуулаасай гэж бодож байна, саяын ярьсантай холбогдоод. Үндсэн хууль хэлэлцэх асуудал бол иэлээн яг-гүй болох нь ойлгогдож байна. Тэгэхээр энэ дээр их олон юм руу анхаарал сарниад гол юман дээр анхаарал төвлөрөх-гүй болчих вий гэж би их санаа зөвж байна. Тийм учраас Үндсэн хуулийг хэлэлцэхэд зарчмын гол асуудал дээр ерөнхий санал шуумжлэл явна гэдгийг биеийн нь даалгаж оруулмаар байна. Энэ дээр санал хураалгаж өгөөч ээ. Нагаад вэ гэхээр, Үндсан хуулиа хэлэлцээд зүйл бүрээр эхлэхээр бэлгэдлээс эхлээд шувуу байх уу, морь байх уу гэдгээс эхэлж маргасаар байгаад өнөө гол юмаа, анхаарлаа төвлөрүүлж чадахгүй болчих вий. Энэ дээр ялангуяа төрийн тогтолцооны системийн асуудал. Үндсэн хуулийн амин сүнс энэ байна. Эндээ хүрэлгүй наана нь баахан юман дээр зодолдсоор байгаад негөө гол асуудал дээрээ хурдэггүй юмуу, хүрэх дээр хүрхээр энийгээ шийдэж чадахгүй болчих вий. Энэ Үндсэн хуулийн чинь өнеөдөр гол асуудал маань манай төр, застгийн тогтолцооны систем ямар байх вэ гэдэг юмаа бүрэн мэнд тогтох авах асуудал нэлээн гол юм маань энэ байгаа. Тэгэхээр энэ дээр их анхаарал төвлөрөх ёстой. Энийг би хэлж, энэ дээр санал хураалгаж өгөөч ээ. Хичид нь оруулъя, "б"-гийн дараагаар юмуу, аль заалтан дээр оруулж өгөөч ээ. Ингэхгүйгээр шууд зүйлээс явчих юм бол бид төөрч хоцроод юу ч хийж чадахгүй болж болохоор шинж өнеөдөр харагдаж байна.

Ж.Уртнасан: -Эрхэм депутат Гунгаадорж гуай. Таны хэлж байгаа саналыг "г" заалтын эхэн дээр зарчмын гол асуудал дээр ерөнхий санал солилцож гээд тэгээд асуулт, хариулт тасалсны дараа гээд орж болох шуу. Зарчмын гол асуудал дээр ерөнхий санал солилцож гэдэг өгүүлбэрийг "г"-гийн эхэнд оруулъя.

287 дугаар тойргийн депутат Ч.Хури: -Анхны хэлэлцүүлэг чинь миний ойлгох байгаагаар хоёр үе шаттай явах юм шиг байна. Анхны хэлэлцүүлэг хоёр үе шаттай гэхээр

3.

эхлээд Очирбат гуай, манай депутатуудын, Гунгаадоржийн саяны хэлдэг үнэхээр бид нар бүгдээрээ ерөнхий нэг юмаа ярьж, зүгээ гаргачихъя. Тэрий дараагаар зүйл ангиараа ярих юм. Тэгэхээр хоёр хэлэлцүүлэг явах нь байна шүү, анхны хэлэлцүүлэг чинь. Тэгээд дараагаар энэ хэлэлцүүлсний үндсэн дээр хороодоо байгуулаад хороод ажлын хэсэгтэйгээр цаашаа ажиллаад санал авч орж ирж ярих юм. Нэгэнт ийм болсон учраас анхны хэлэлцүүлэг Очирбат гуайн хэлсний дагуу, анхны хэлэлцүүлгийн үед гол асуудал дээрээ 10 минут өгье. Дараагийнх нь зүйл ангиар хэлэлцдэг дээр хүн нэг бурт 7 минут, хуучин дэгээрээ явъя.

Тийм учраас энэ бол бидний энд хуран цугларсан энэ олон депутатуудын ирсэн гол ажил маань энэ төрийн тогтолцоог зөв тогтоох, энэ Үндсэн хуулиа батлах асуудал бидэнд хамгийн нэгдүгээр асуудал байгаа. Тийм учраас энийгээ бид ингэж хиймээр байна.

132 дугаар тойргийн депутат С.Чудуунбаатар:

-Би хуулийн төслийн 1 дүгээр хэлэлцүүлэг, 2 дугаар халалцүүлэг гэдгийг юу гэж ойлгож байгаа юм бэ гэхээр 1 дүгээр хэлэлцүүлэг энэ хуулийн узэл баримтлалын үндсэн асуудлаар депутатууд санал бодлоо илэрхийлж, түүн дээр нь санал хураагаад гол зарчмаа концептуальный асуудлууд, тодорхойлолтын юмнуудаа тогтох ёстой юмаа гэж ойлгож байгаа юм. Өөрөөр хэлбэл, энэ дээр олон юм бий, улсын нэрээс эхлээд засаглалын хэлбэр, эрх хэмжээ хуваах хуртэл депутатууд өөр өөр узэл бодолтой, сонгогчдоосоо янз янзын даалгавартай ирсэн. Тэгэхээр оруулж байгаа төслөөр ерөнхий шумжлэл зайлшгүй. Энэ нь анхны хэлэлцүүлэг гэж би ойлгож байгаа. Тэр ерөнхий шумжлэл яваад эхлэхээр байдал нь тодорхой болно. Энэ дээр гарч ирсэн зарчмын асуудлаар санал хураагаад гуравны хоёрын саналаараа нэр, ус, тэр зарчим концептуальный бүх юмаа тогтоод ингээд депутатын ажлын хэсэг байгуулах учиртай. Тэр ажлын хэсэг нь гүйцэтгэх уургийг хийх ёстой гэж ойлгож байгаа. Тэгээд хоёр дахь

хэлэлцүүлэг бол үүсгээр хөөж хэлэлцэнэ.

Үндсэн асуудлаараа зарчмаа тохиироогүйгээр хоёулангий нь зүйлээр, угзээр хөөцөлдөөд байх юм бол энэ хурал өрөөсөө дуусахгүй. Ингэж ойлгож байна.

Хоёрдугаарт, энэ булэг байгаа учлаарай, ийм редакц хийсэн юм. Нэгдүгээрт, би энийг бүгдийг хэлэх гэхээр цаг авчих байх. Хоёрдугаарт, Бага Хуралд байдаг болохоор зарим хүн бачуураад байх юм, биднийг босоод ирэхээр. Тэгэхээр би энэ дээр байгаа ганцхан зарчмын юм хэлье. Энэ төслийн, та бухний гар дээр байж байгаа төслийн 10 дугаар хуудсын "б, в" гэх мэтийн булгуудэд депутатын ажлын хэсэг, Үндсэн хуулийн төсөл боловсруулах комисс, депутатын ажлын хэсэгтэй хамт бий болох ажлын хэсэг, дээрээс нь намын булгуудийн төлөөлөгчдийн зөвлөл ч гэдэг юмуу, ийм их олон байгууллага, юмнууд гаргаж ирээд бүгдийг аваачаад депутатуудтай буюу Их Хуралтай эн зэрэгцүүлж тавиад байна. Тэгэхээр өчигдрөөс хойш олон депутат, энэ Улсын Бага Хурал, тэр байтугай Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, Улсын Бага Хурал энэ ул бутэх нөгөө гишүүд, эд нар бидний сэтгэлд нөлөөлөх гээд байна гэж болгоомжлоод байна. Тэр зөв байх аа. Тэгэхээр яг тэр байдал чинь ёстой Ерөнхийлөгч хэдэн удаа уг хэлэх вэ гэдэгтээ аюул нь байхгүй, энэ дотор байна шүү дээ. Тэгэхээр энийг хэлэлцэхдээ өөрөөр хэлбэл, энийг харж үзээрэй. Би бол энийг бүгдийг хасах саналтай байна.

Хэрвээ зөвшөөрвөл би энэ дэгийн энэ хэсэг дээр хэлсэн редакццаа өгье. Энэ бол нэгдүгээр хэлэлцүүлэг зарчмын асуудлаа тохирно, хоёрдугаар хэлэлцүүлэг депутатын хороо байгуулаад хороогоор хэлэлцсэний дараагаар депутатууд ^{и.ч.л.р.н.с.и.} пленарный хуралдаанаараа эцэслэн санал хурааж дуусна гэсэн зарчмын санал гаргаж байгаа юм. Энд уг үсэгчлэн ярихаа больё. Баярлалаа.

Ж.Уртиасан: -Эцсийн эцэст "г" заалтыг хасъя гэсэн санал оруулж байна уу?

С.Чулдуунбаатар: -Яг тэрэн дээрээ очихоор ярьж болно. Өөрөөр хэлбэл, б-ын "б, в" гээд байгаа. Мишээлэх юм бол,

5-ын "б" дээр хороо, ажлын хэсгийг гэж байгаа.Хороо гэдэг нь депутатын хороог хэлж байна.Ажлын хэсэг нь тэрэнтэй хамт нэг ажлын хэсэг байх нээ.Боловсруулсан Их цаазын төслийг Ардын Их Хурлын намуудын бүлгийн төлөөлөгч, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын ийм дөрвөн юмын хамтарсан хурлаар дахиад хэлэлцэх гэж байна.Тэгээд нэг дүгнэлт гаргана гэж байна.Тэрний дараа доод талын өгүүлбэр нь бол саналын зөрүүг арилгах арга хэмжээ авна гэж байгаа, бид нар.Тэр хэзээ ч бүтэхгүй.Тэрний дараагийн "в" болохоор бас л нэг ийм санаа байгаа юм. Тэгэхээр ийм юм бол энд хэрэггүй.Өөрөөр хэлбэл юу байх вэ гэхээр I дүгээр хэлэлцүүлгээр бүгд хуралдаан дээр ерөнхий санал шүүмжлэл явуулахгүй гэж олонх нь тогтвол хамаагүй. Зүйлчлэн хэлэлцлээ ч гэсэн.Хоёрдугаарх хэлэлцүүлэг дээр бас ялгаагүй, депутатын хороо байгуулахдаа хажуугаар нь ийм олон юм байгуулж болохгүй.Туруун депутат Гомбожавын Очирбат гуай их зөв ярих шиг санагдсан, надад.Юу гэхээр, хэрэв хороо байгуулах юм бол, депутатын хороо.Тэр хорооны ажлын хэсгийг хороо өөрөө байгуулах, аль эсвэл Их Хурал ажлын хэсгийг байгуулж өгөх ёстой гэсэн санал бол зарчмын юм шуу.Өөрөөр хэлбэл, хэндлэнгийн явуулга орчих вий гэж айгаад байгаа тэр улсууд ёстой ийм юман дээр айвал зүгээр байна гэж би хэлмээр байна.

И.Уртнасан: -Баярлалаа, депутат Чулуунбаатар аа. 5 дугаар заалтыг хэлэлцэхдээ бид зарчмын саналыг анхаарч узэж нээлттэй хэлдээе.Одоо гуравдугаар микрофонд зөвшөөрөл өгье.

26 дугаар тойргийн депутат Д.Сүрэнхорлоо:

-Сая зарим улсууд, санал давхардах гарч байна. Би ийм саналтай, бодож сууж байгаа хүн.Микрофон руу уралдаад олдохгүй ч үгүй байна.Тэгэхээр өдоо Үндсэн хуулийн төслийг Ерөнхийлөгч хэлэлцүүлэг.Тэгэхээр энэ илтгэлийн дараа депутатууд бид зарчмын санал шүүмжлэлээ ёс төртэйхэн тэр индэр гараад ярих байх аа гэж би ингэж бодож байгаа, тэгэх ч бэлтгэж байгаа.Тэгээд дараагаар нь энэ чинь нэгдсэн

6.

өрөнхий санал шүүмжлэл яваад улсууд өрөнхий, бүхэлд нь санал шүүмжлэлээ гаргах байх, дүгнэлт хийх байх. Тэгээд суулд нь батлахаад зүйл, ангиар хэлэлцэхдээ энэ микрофон руугаа уралдаад хүн бүгд юмаа ярих байх. Ийм зарчмын хуралдаан явуулах нь зүйтэй байх гэдэг саналтай байна.

Ж.Уртнасан: -Анхны хэлэлцүүлэг дээр зарчмын саналаа солилцож авьяа гэж.

Д.Сүрэнхорлоо: -Ерөнхийлөгч Үндсэн хуулийн төслийг хэлэлцүүлнэ шүү дээ. Эхлээд илтгэлээ тавина. Тэгэхээр бид зарчмын өрөнхий санал шүүмжлэл яваад зарчмын юмнуудаа энэ микрофон руу уралдахгүй угээ хэлэх байх гэж би бодож байна. Тэнд гараад угээ хэлэх ёстой, бур нэрсээр дуудагдаад, уг хэлэх хүн байвал. Байхгүй бол нэр дууслаа, дараа нь зүйл ангияа батлахаар хэлэлцэхэд микрофон руу гүйцгээд санал бодол, найруулгын чанартай юмнуудаа хэлэх юм байгаа биз дээ. Ийм л бодолтой байгаа. Энийг шийдэж өгөх нь зүйтэй байх.

Ж.Уртнасан: -Баярлалаа. Одоо 9 дүгээр микрофонд зөвшөөрөл өгье.

ЗИ дүгээр тойргийн депутат Д.Дожоосдорж: -Тэгэхээр энэ дээр надад маргаад байх юм алга байна. Үндсэн хуулийн төслийн талаар илтгэл тавиад дараа нь өрөнхий хэлэлцүүлэг болно гэж яриад байна. Тэрэн дээр ухаандаа, өрөнхий хэлэлцүүлэгт хүн бүхэн 10 минут хэлэх юм бол сая эдийн засагч нараар бодууллаа, 10 өдөр хуралдах юм байна. Хүн бүхэн 10 минутаар, 450 төлөөлөгч. Өнөөдөр зөвхөн дэг, Зоригийн хэлснээр сонгогчдын эрх ашигт хамаагүй, дотоодын асуудал гэдэг шиг тэр бол аргагүй үнэн. Бидний өөрсдийн замбараггүйгээс болж сая эдийн засагч нараар бодуулсан чинь хагас сая төгрөг, зөвхөн дэгэн дээр үрсэн байна. Ард түмний хөрөнгийг ингэж л үрж байна шүү дээ, зөхион байгуулалтгүйгээс болж.

Дараагийн өрөнхий хэлэлцүүлэг, өрөнхий илтгэл тавина гэж хүн бүхэн бодож байх шиг байна. Тэр бол мөн улсын ядарсан эдийн засагт мөн олон сая төгрөгийг цааш харуулах нээ.

Тэгэхээр би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр, зүйл зүйлээр ярья. Ингэвэл хүн бухний хэлэх юм тодорхой болно гэж бодож байна. Ийм юм оруулж өгөх нь зүйтэй. Энэ дээр тухайлсан заах хэрэгтүй.

Ж.Уртиасан: -Учлаарай, эрхэм депутатууд аа.
Цагаа барья, одоо та бидний завсарлах цаг боллоо. Орж ирээд 10 дугаар микрофонд уг хэлээрэй.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.ОЮУНЧИМЭГ

64
1991.II.12

Кассет № 46

II.23-II.35

Уртнасан-Бид 4-ийн "Г" заалтыг ярьж байгаа.Одоо депутат Мөнхдорж.

21 дүгээр тойргийн депутат Мөнхдорж -"Г" заалтыг батлагдахаас өмнө "В" заалтыг баталсан үеийн цөөнхийн төлөө бас нэг санал хэлмээр байна.Энэ дээр "В"-гийн дараа зүхт өгүүлбэр оруулмаар байна.Асуулт хариултын үед төрийн бэлэгдлүүдийн теслийг тавьж түүнийг тайлбарлах уран бүтээлчдийг байлцуулна гэж оруулмаар байна.Энэ саналаар бас санал хураалгамаар байна.Тэгэхгүй бол дэгд ороогүй бол хурлын явцад неге юмыг хэлэлцэхэд энэ улсуудыг байлгах байлгахгүйн тухайд бас асуудал гарч магадгүй гэсэн нэг ийм санаа байна.Хоёрдугаарт "В"-гийн талаар Их цаазын төслийг зүйлчлэн хэлэлцэнэ.Тэгэхдээ анхны хэлэлцүүлгээр зарчмын зүйлгүүдээ тохирч авна.Эцсийн хэлэлцүүлгээр нэг бүрчлэн мөн зүйлчлэн ярьж нарийн тунгааж ариутган цэвэрлэнэ гэдэг юмуу ийм анхны эцсийн хоёр дээр хүрэх зорилтоо бас тодорхой энэ "В" дээр зааж өгвөл яссан юм бэ гэсэн ийм санал хэлэх гэсэн юм. Эцэст нь хэлэхэд байн байн ерөнхий хэлэлцүүлэг рүү ороод байгааг болимоор байна.Шууд заалт заалтайгаа холбогдсон тодорхой зүйл дээр ормоор байна.Ерөнхийгээс тодорхой руугаа шилжихгүй бол бид энийгээ барахгүй нь байна шуу.

12 дугаар тойргийн депутат Очирабат -Түрүүн миний хэлсэн саналын талаар санал хураалгахад би жаахан үл ойлголцох юм гарч уу гэж ойлгогдлоо л доо.Би бол ерөнхийлөгч илтгэлээ тавина,ундсэн хуулийн төслийн тухай,тэрний дараагаар асуулт хариулт явагдана,тэрний дараагаар ерөнхий санал шүүмжлэл явна гэсэн ийм санал хэлсэн юм.Гэтэл хурлын дарга маань илтгэлээс өмнө ерөнхий санал шүүмжлэл явахаараа ойлгогдохоор санал хураалгачихна лээ. Тэгэхлээр яг тэгсэн л дээ,илтгэлийн агуулга гэдгийн өмнө талд санал хураалгачихна лээ.Тэр бол тийм биш.Давтаж хэлэхэд илтгэлээ сонсоно,асуулт хариултаа сонсоно,ерөнхий санал шүүмжлэл.Ерөнхий санал шүүмжлэл гэдэг бол нэгдүгээр хэлэлцүүлэг дотроо л.Нэгдүгээр хэлэлцүүлэг гэдэг нь хоёр хэсгээс ерөнхий санал шүүмжлэл явуулаад тэрэн дээр бас зарчмын юмаа хэлэлцүүлж тохироод тохиролцох ийм л хоёр шаттай байх байх. Түүнээс биш тийм биеэ даасан тийм зүйл бишээ.Хоёрдугаарт,420 хэдэн депутат цөмөөрөө яалаа гэж уг

хэлэх вээдээ. Бид нар анх удаа хуралдаж байгаа биш, нилээд хэсэг нь саналаа хэлээд тэгээд юмны зураг төрх гаралц ирэхлээр санал шүүмжлэлээ тасалдаг ёстой шүү дээ. Хүн болгон албан журмаар 420 хүн хэлэх вэ дээ. Тэрийг би зүгээр тодотгоод хэлчих гэсэн юм.

360 дугаар тойргийн депутат Нийлан -Манай энэ үндсэн хуулийн хэлэлцүүлгийн дэгийг хэлэлцэх явцад бид нар бас нэг харамлах зүйлээ харамлахгүй, харамлахгүй зүйлээ харамлаад, хардах зүйлээ хардахгүй, хардахгүй зүйлээ хардаад байна уу гэж бодогдоод байх юм. Хэлэлцэж байгаа асуудлын дотроос зарим нь байх ёстой зүйлийг хасчихаад дараачийхад нь шургуулах ийм ажилд орж байна бид нар. "Г" дээр байгаа саналыг сая хурлын дарга туруучийн хассан зүйлийг энд найруулаад оруулж гэсэн ийм санал гаргалаа. Тэр саналыг би дэмжиж байна. Ерөнхий санал шүүмжлэл явуулах асуудал хоёр талын ач холбогдолтой байна. Нэгдүгээрт, бид нарт зарчмын үндсэн хуулийг хэлэлцэж байгаа явцыг Монголын ард түмэн сэтгэл харан хүлээж байгаа, энэ ард түмэнд өгөх ойлголтыг ерөнхий санал шүүмжлэлийн үед их тодорхой гарч ирнэ. Ийм учраас сурталчилгааны ач холбогдолтой, бид ард түмнээсээ тасарчихсан депутатууд биш, ард түмэнтэйгээ хамт байгаа депутатууд учраас депутатуудын хэлж байгаа санал энэ ерөнхий санал шүүмжлэлээр гарч хөдөлмөрчдийн өмнө хир зэрэг үүргээ биелүүлж байна вэ, депутатуудын үзэл бодол, тэмцэл ямар байна вэ зэрэг энэ бухнийг харж ард түмэн ч гэсэн өөрийнхэе саналыг давхардуулж хэвлэл, мэдээллээр ирүүлэх нь давхар ач холбогдолтой юм. Тийм учраас туруун хассан "В"-г "Г"-дээр оруулаад ерөнхий санал шүүмжлэлийг явуулах гэсэн уг хэлэх хүн 10 минут гэдгээр нь редакц хийгээд оруулах нь зүйтэй байна. "Г" дээр санал шүүмжлэлүүд давхардаж байгаа, үндсэндээ гарчихлаа гэж бодож байна. Тэгээд санал хураалгаж өгнө уу гэсэн саналыг хурлын даргад тавьж байна.

153 дугаар тойргийн депутат Чойжамц -Хэлэлцэж байгаа зүйлтэй холбогдуулаад ерөнхий санал шүүмжлэлийн тухай асуудал яриг даж байгаа юм. Тэгэхлээр тэр бол их ач холбогдолтой гэж би хувьдаа ойлгож байна. Тэгэхдээ чухам ямар хэлбэрээр явуулах вэ гэдгийг сайн бодох ёстой гэж. Тэгэхээр илтгэлийн дараагаар саяын

Очирбат гуайн ярьдагаар өрөнхий санал шүүмжлэл яваад байвал бид асар их цаг орно. Ийм учраас миний хувийн бодол юу вэ гэх лээр өнөөдрөөс зарчмын гол асуудлуудаар нэрсээр нь санал авья, бичгээр. Үүнийг ямар нэгэн зохион байгуулалттай хийж саналыг боловсруулаад илтгэлийн дараагаар тэрийг сонсон шууд санал хураах журмаар явуулбал хүн болгон хэдэн угзээ ч оруулж болно, тэрэн дээр тодорхой дүгнэлтууд ч гарч болно гэсэн хувийн бодол байна. Бид уг, усгээр хөөцөлдөж цаг алдлаа. Үүнийг бодохоос арга байхгүй. Энэ байдлаараа ч хурлын дарга наарт бид ихээхэн дарамттай байна гэдгийг депутатууд бас анхаараасай гэж бодож байна.

130 дугаар тойргийн депутат Авиurmэл - Энэ дээр би "г" заалттай холбоотой санал байгаа юм. Энэ дээр өрөнхий санал шүүмжлэл явуултия гэсэн саналыг дэмжиж байгаа юм. Энэ өрөнхий санал шүүмжлэл явуулах шаардлага байна. Энд Улсын бага хурлаас өргөн барьж байгаа Үндсэн хуулийн төсөл бол ард түмний санал бодлыг үл харгалзсан, энэ үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссын бутэн жил хөөцөлдсөн ажилд үзэл бодлоо шургуулсан, хаст хянасан, хянаж засварласан ийм төсөл гэж үзэж байна. Ийм учраас ард түмнээ төлөөлж ирсэн депутат бид энд санал бодлоо чөлөөтэй яриад, эндээс Улсын бага хурлын бодлоготой зэрэгцүүлж тавих тийм хувилбар төсөл санал гарч ирнэ гэж үзэж байгаа учраас өрөнхий санал шүүмжлэл явуултия гэсэн ийм саналыг тавьж байна. Үүнийг дээд биш гуравдугаар заалтад орчихвол болохоор, анхны хэлэлцүүлэг гэдгээ үндсэндээ тодруулчихвал болмоор байна. Үүнтэй холбогдуулаад хэлэхэд бид уг үсэг хэтэрхий их хөөцөлдсөнөөс өмнөх батлаад өнгөрсөн юман дотор чинь анхаармаар зарчмын юмнууд байгаа. Тухайлбал Улсын бага хурлын бодлого, үндсэн хуулийн төслийн талаар Бага хурлын бодлого орж ирж байгаа нөхцөлд зарчмын зерүүтэй саналаа депутат хэлэхдээ энд байгаа нийт депутатуудын 50-иас дээш хувийн санал авч байж сая хэлэлцүүлэгт оруулахаар зүйлийг баталчихсан байж байгаа. Гэтэл нэгдүгээр булэгтээ цөөнхийн санал гээд өөрөөр хэлбэл энэ хэлэлцэж байгаа асуудлын эсрэг утгатай нэг хүн санал тавихад л цөөнхийн саналыг хүндэтгэнэ гээд л санал хураагаад байхаар орчихсон байна. Бид энэ юмнуудыг өргөж хармаар байгаа шүү. Үндсэн анхаарч өгөөч гэж хүсч байна.

315 дугаар тойргийн депутат Бат-Эрдэнэ -Тэгэхлээр энэ 4 дүгээр зүйлийн "г", "д", "е" гурван заалт бол зайлшгүй уялдаатайгаар авч үзэх ёстой зүйл байна гэж ойлгож байна. Бид нар анх ны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг гэдгээ тохирсон. Анхны хэлэлцүүлэг бол "г" дүгээр зүйлийн эаалтын асуулт хариулт тасалсны дараа гээд үүний дараа ерөнхий хэлэлцүүлэг явуулж санал зөрүүтэй зарчмын асуудлаар санал хурааж олонхийн саналаар шийдвэр гэсэн "е" заалтын суулийн хэсэгтэй аваачиж холбомоор юм шиг санагдаад байна. Ер нь нэгдүгээр хэлэлцүүлгийн гол ач холбогдол нь юу байх вэ гэхлээр зэрэг бид үндсэн хууль дотор бол 12, 13 төрлийн зарчмын тохирох ёстой зүйл байгаа гэж ойлгож байгаа. Үүн дээрээ өргөн хэлэлцүүлэг явуулаад л санал хураагаад тохирчих юм бол хоёрдугаар хэлэлцүүлэгт жинхэнэ зүйлчилж яриад батлахад ихээхэн ач холбогдолтой байх аа гэсэн ийм л саналтай байна.

407 дугаар тойргийн депутат Нуурээ -Энэ 4-ийн "г" дотор асуулт хариулт явагдсаны дараа Их цаазын төслийг АИХ-ын депутатууд ерөнхий санал шуумжлэл явуулсны эцэст зүйл бүлэг тус бүр дээр үг хэлж санал гаргана гэсэн ийм редакцийн найруулга оруулж санал хураалтуулах саналтай байна.

96 дугаар тойргийн депутат Сэндэнжав -Санал шуумжлэл их давтагдаж байна. 4 дүгээр зүйлтэй холбогдоод. Тийм учраас ерөнхий санал шуумжлэл явуулах нь зүйтэй байх гэдэг депутатуудын саналыг дэмжээд үг асуудлыг энэ "г" заалтанц тусгаж оруулах саналтай байна. Хэрвээ та зөвшөөрвөл тэр тусгаж оруулах саналыг өөрийнхөө редакцийн хэмжээнд уншиж сонсгож болж байна депутатуудад.

Уртнасан -Өөрийнхөө хувилбарыг та депутатуудад сонсгоно уу.

Сэндэнжав -"г" заалт асуулт хариултыг тасалсны дараа АИХ-ын депутатууд Их цаазын төсөл, түүний эуйл, бүлэг тус бүрээр үг хэлэх санал гаргана. Тэгээд 10 минут гэхгүй заасан хугацаанд нь багтааж Их цаазын төслөөр ерөнхий шуумжлэл санал гаргах хүн гаргая. Зүйл тус бүрээр гаргах улсууд нь гаргая. Тийм учраас аль аль нехцэлийг нь энд хадгалагдсан заалт хийвэл ямар вэ гэсэн санал тавьж байна.

Уртнасан -Баярлалаа. Энэ "г" заалт дээр эрхэм депутатуудын санал төвлөрлөө гэж ойлгож байна. Энэ дээр 5 депутат, Сэндэнжав гуай, Гунгаадорж дарга гээд. Энэ зарчмын гол асуудлууд дээр ерөнхий санал солицно гэсэн нэр томъёолол гарч ирж байх шиг байна. Асуулт хариулт явуулсны дараа зарчмын гол асуудлууд дээр ерөнхий санал солицож Их цаазын төслийн талаар АИХ-ын депутатууд зүйл тус бүр дээр уг хэлж санал гаргана гэж. Ийм томъёолол дээр депутатууд санал нэгдэж байх шиг байна. Энэ томъёоллыг редакцийн комисст шилжүүлэх ўу.

Уртнасан -Тэгвэл редакцийн комисст энэ заалтыг засамжлан редакци хийгээд оруулж ирэхийг даалгаад "г" заалтыг хлдээхээр санал хураалт явуулъя. Санал хураалтанц бэлтгээ депутатууд. Одоо байгаа дээр нь редакц хийгээд. "г" заалт дээр депутатуудын гаргасны дагуу засамжлан редакц хийгээд хлдээ гэж. За санал хураалт явуулъя.

За баярлалаа. Санал өгсөн депутатуудын 93 хувь нь буюу 391 депутат зөвшөөрлөө, 24 хүн татгалзаж байна, 3 хүн түдгэлзлээ.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАХ

НИЙЛСЭН

ж.аанолыг

/БАЯНДҮҮРЭН/

БИЧЭЭЧ

/Д.ЭНЭБИШ/

69
1991-XI-12
Кассет № 47
II.35-II.50

Д - заалт дээр Очирбат депутатын санал байгаа. Зарим зарчмын шинжтэй асуудал бүр дээр санал хураалт явуулж депутатын гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ гэдгийг хасна, гэсэн санал бий.

За гарим депутатууд энэ заалтыг бүрэн хасчихаж болох юм гэсэн санал ируулсэн. Д -заалтын талаар.

Д - заалтыг хэвээр үлдээе гэдэг дээр санал хураалт явуулж байна.

Санал хураахад бэлтгээрэй.

За баярлалаа. Санал өгсөн депутатуудаас 353 хүн буюу 86 хувь нь зөвшөөрмөө, 44 хүн татгалзаж, 9 хүн түдгэлзлээ.

Е - заалт. Энэ заалтыг дээдэхтэй нь уялдуулж редакци хийе гэсэн санал бий. Хоёрдугаар өгүүлбэрийг нь хасъя.

234 дүгээр тойргийн депутат Л.Лэмбэрэл: Тэгэхлээр энэ Е заалт болбол З-тэй их төсөөтэй, холбоотой юмуу гэж ойлгогдоод байна. Энэ саналын зөрүүтэй асуудлыг шийдвэрлэхтэй холбогдоод байна. Ер нь энэ З заалтан дотор байгаа энэ хороо зарчмын хувьд өөрчлөх, найруулах засах үүрэг бүхий гээд байгаа ийм хороо байгуульяа гэж. Ерөөсөө зарчмын хувьд өөрчлөх тухай саналыг энэ 420 гаруй депутатууд нүүр нүүрээ харж байж шийдмээр байна. Зарчмын хувьд өөрчлөх саналыг ямар нэгэн хороо, ажлын группт өгмөөргүй байна. Ийм учраас Е заалтанд байгаа саналын зөрүүтэй асуудлыг энэ хороотой нэгтгэн авч үзээд Ардын Их Хурлын Их цаазын төслийг бүхэлд нь зөвшөөрсөн нөхцөлд зохих саналын дагуу түүний гарим гол асуудлуудад дүгнэлт өгөх буюу найруулах ийм үүрэг бүхий хороо байгуулна гэсэн санал оруулж байна.

Уртнасан:

Зарчмын асуудлаар редакци хийх хороо саналын зөрүүтэй гарим асуудлыг.

За өөр ямар санал байна депутатуудаа.

191 дүгээр тойргийн депутатат Б.Лханаасүрэн: Тэгэхдээр хэлэлцүүлэг маань үндсэндээ гурван үе шаттай болчихож байгаа юм л даа.Өчигдөр ерөнхий санал шүүмжлэлийн дараа санал гаргасны дараа Чимид гуай хэрэггүй юм гэж ярьсан.Өнөөдөр бол депутатат бол шийдлээ.Тэгэхдээр энэ дээр эхлээд нэг ерөнхий санал шүүмжлэл гаргаж үг хэлнэ.Дараа нь депутатууд булэг, зүйл бүрээр нь хэлэлцэж өхлэнэ шүү дээ.Ерөнхий санал шүүмжлэл гарсны дараа.Тэгэхдээр өнийгээ оруулахын тулд энэ Е-г ингээд найруулчихвал болмоор санагдаад байна.Депутатууд үг хэлж санал гаргасны дараа энэ бол ерөнхий санал шүүмжлэл гэсэн үг.Дараа булэг, зүйл бүрээр хэлэлцэж гэдэг үгийг "дараа" гэдгийн дараа оруулаад булэг, зүйл бүрээр хэлэлцэж саналын зөрүүтэй зарчмын асуудал бүрээр санал хураана.гэж.Тэгэхдээ ерөнхий санал шүүмжлэл явагдаад дараа нь булэг, зүйл бүрээр хэлэлцэж өхлэнэ.Ингэхэд мэдээжийн хэргэг зарчмын саналуудаараа санал хурааж таарна.Тэгэхдээр өнийгээ энд оруулахгүй болбол энэ ерөнхий санал шүүмжлэлийн дараа хэлэлцэх асуудал маань алдагдчихаад байна.Булэг, зүйл бүрээр хэлэлцэх асуудал маань энд алга болчихоод байна л даа.Тэгээд булэг, зүйл бүрээр хэлэлцсэний дараа зарчмын зөрүүтэй асуудлаар санал хураагаад тэгээд редакцид найруулахаар депутатын негее байгуулсан хороодод шилжүүлэх ёстой.Эцсийн редакци маягаар өцсийн хэлэлцүүлэгт оруулахаар ингэж найруулбал ясан юм бэ гэсэн ийм ганц санал байна.

Уртнасан:

За өөр санал алга шиг байна.

Санал хураалт явуулъя.Энэ дээр энэ булэг үлдэх юм байна.За тэгэхдээ редакци хийх хэрэгтэй юм шиг байна.Депутат Лханаасүрэнгийн саналаар тэр дараа гэдэг үгийн ард булэг, зүйл бүрээр хэлэлцэж гэдэг үг нэмэгдэж байна.Хоёрдахь өгүүлбэрт депутат Дэмбэрэлийн саналаар хороо байгуулах тухай асуудал тусгах шаардлагатай юм шиг байна.Түүнээс биш саналыг хэн тусгаж, хэн гүйцээж боловсруулах нь өзөнгүйдээд байна гэсэн ийм санаа гарч байна.Ийм редакци хийгээд энэ булгийг үлдээх үү.Энэ заалтыг

За баярлалаа.Редакци хийх асуудлыг комисстоо даатгаад Е заалт дээр санал хураалт явуулъя.

За баярлалаа. Санал өгсөн депутатуудын 375 хүн буюу 93 хувь нь зөвшөөрч байна. Татгалзсан 16 хүн, түдгэлзсэн 12 хүн байна.

З - заалтыг хэлэлцье.

Из дугаар тойргийн депутат Цог: Хороо байгуулах санал байж болох байх л даа. Ажлын хэсэг юмуу групп нь нэг л байх ёстой гэж бодож байна. Тэгэхгүй бол гарч байгаа хуулийн технологи асуудал янз бүр болж хувирна шүү дээ. Ингэж санал хураасан уу, хороо болгон өөрийнхэе гэсэн ажлын хэсэгтэй гэж ингэж тохирв уу. Энийг тодруулж асуумаар байна. Миний бодлоор тэр ажлын хэсэг юмуу, ажлын групп нэг л байх ёстой. Нэг л гарцаараа бух хуулийн томъёонд орохгүй сүүлдээ янз бүр болчихно гэсэн ийм оруулалт байна.

Уртнасан:

Хороо бэлтгэж, ажлын хэсэг гэдгээрээ байж гэжүү.

Цог:

Хороо болгон өөрийн гэсэн тусдаа ажлын хэсэгтэй байхаар болов уу. Ажлын хэсэг нь нэг байгаад хороо нь тусдаа байх болов уу.

Уртнасан:

Хороонууд ажлын хэсэг нэгтэй л байж таарах байх л даа. Тэгэхгүй бол олон тийшээ задраад явчихана шүү дээ. Саялын саналаа ахиж давтахгүй юу. Асуудал хураалгасан саналаа, томъёоллоо.

Уртнасан:

Депутатууд уг хэлж, санал гаргасны дараа, санал шүүмжлэлийг гаргаж дууссаны дараа бүлэг, зүйл тус бүрээр хэлэлцэж саналын зөргүйтэй зарчмын асуудал бүрээр санал хураана. Энэ заалт байгаа. Тэгэхдээ саналын зөргүйтэй зарчмын асуудлыг ямар хувилбараар шийдвэрлэх саналтай байгаа, эсвэл уг асуудлаар төслийн заалтыг хороогоор хэлэлцэж дахин гүйцээн боловсруулж саналын олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн ийм л томъёолол байх нь байна шүү дээ. Хороогоор хэлэлцэнэ гэдэг маань ажлын группууд дотроо нэг байна гэсэн уг биз дээ.

Депутат Цог:

Ер нь ажлын хэсэг нь нэг юмуу олон байна гэсэн тийм юм байхгүй юм байна шүү дээ.

Уртнасан:

Тийм. Тийм заалт байхгүй.

4.

За одоо И зaalтыг хэлэлцье. Энэ дээр депутатуудаас тодорхой санал гараагүй байна. Ийм учраас хэвээр үлдээхээр санал хураалгая.

Санал байна уу?

Депутат Очирбат: Энэтэй холбогдуулаад хэлэхэд энд хурлын аппарат их олон хүн сууж байна. Энэ улсуудын хэлээд, томъёолоод бичсэн юмыг тэр дор нь одоо бичиж аваад хурлын даргад өгч байвал их сайн байна. Тэгэхгүйгээр хурлын дарга суулчийн хоёр хүний саналаар л ингэсэн гэж ярьчихаад байна шүү дээ. Ингэж бол би болохгүй болов уу гэж бодож байна.

Е бол ингээ гэсэн. Депутатууд уг хэлж, санал хурааж дууссаны дараа тэр санал шүүмжлэлийг тасалсны дараа гээд хаалтан дотор бичсэн байгаа юм саналын зөрүүтэй зарчмын асуудал бүрээр санал хураана гээд. Энэ зүйтэй. Энэ дээр надад санал байхгүй. Тэгэхдээ саналын зөрүүтэй зарчмын асуудлыг депутатуудын гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ гээд энэ хоёрын дунд байгаа тэр нэг хэдэн, хоёр мөрийг дарчихъя. Энэ хоёр бол өрөөсөө би ач холбогдолгүй мөрөө гэж бодож байгаа юм. Тэр зарчмын асуудлыг депутатуудын гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ гэж. Энэ бол Үндсэн хуулийн нэмэлтийн хуультай яг нийцэж байгаа. Үндсэн хуулийн зарчмын асуудлыг бид олонхийнхоор биш, гуравны хоёрын саналаар шийдэх ёстой байхaa. За энэний дараа би цоо шинэ өгүүлбэр уншсан. Хэрвээ уул асуудлаар дахин санал хураах шаардлага гарвал 24 цагийн дараа дахин санал хураалт явуулна гэж. Тэр дор нь тулгаад за одоо энүүгээр хураачихъя гэхгүй. Ингэж тодотгож өгье гэдгийг ингэж хэлсэн.

Энэ бол одоо Е-гийнх.

З-гийнхийг одоо хэлэх уу.

Уртнасан:

Энийгээ дуусгая. Баярлалаа.

Тэгэхээр депутат нэхдүүлийн анхааралд депутат Очирбат гуайн саналыг ахин толилуулж байна. Энэ нэмэлтийг редакцийн чанартайгаар нэмэх уу, угүй ю гэдэг дээр санал хураалт явуулъя.

5.

Очирбат гуайн саналыг энэ заалтанд тусгах уу, тусгана, тусгахгүй гэдэг маань энэ дээр гарчихна.

Ийм учраас Очирбат гуайн саналын талаар санал хураалт явуулья.

Санал хураалтанд бэлтгэнэ уу.

За санал өгсөн депутатуудын 333 хүн буюу 82 хувь нь санал өглөө. Тэгэхээр энийг Очирбат гуайн хувилбарыг, өөрийнхөө хувилбарыг манай редакцийн комисст өгөхийг хүсч байна. Депутатуудад анхааруулахад энд нэг өгзэгтэй юм орж байх шиг санагдаж байна. Энэ зарим асуудлын талаар дахиж ярилцаад 24 цагийн дараа дахин санал хураана гэдэг маань урьд өдрийн хэлэлцсэн асуудал маргааш нь задраад байх нэг ийм аюул гарах вий гэж болгоомжилж байгаа юм. Нэг ийм юм орлоо. Энийг бид дараа хэлэлцэхдээ анхаарвал зохих юм.

За одоо И заалт. И заалтын талаар санал байна уу.

За тэгвэл И заалтын талаар санал хураалт явуулья.

За баярлалаа. И заалт санал өгсөн депутатуудын 94 хувийн саналаар үлдэж байна. 384 депутат, татгалзсан 15, түдгэлзсэн 6 хүн байна.

З заалтыг хэлэлцэе. Энэ заалт дээр зарим депутатууд суулчийн өгүүлбэрийг хасах санал иргүүлсэн. Өөр ямар санал байна вэ?

Соронзон хальстай
тулгах нийлсэн

Б.Муна

ЭНХТУЯА

Бичээч

В.Оюун

1991-II-12

Кассет № 48

II.50-II.05

Очирбат /депутат/

-Би түрүү-

чиин саналаа жаахан тодотгоод хэлчихье. Энэн дээр би ингээд байна л даа. Хороог зөвшөөрч байна. Энэ заалтыг жаахан найруулж засъя. Зарчмын хувьд өөрчлөх асуудлыг хороонд өгөхөө больё гэж би хэлээд байгаа юм. Тэгэхлээр энд бидний саналын дагуу дүгнэлт гаргаад зарим асуудлаар бидэнд санал тавих байдлаар энэ хороо, угүй бол тэр найруулан засах гэсэн юмаа аваад ингээд ажиллаж болж байна гэж, би бол ингэж ойлгож байна. Ерөөсөө зарчмын дүгнэлт өгөх, зарчмын хувьд тохирох юмыг л депутатууд бид шийдэж байя. Энийгээ бүр зарчим болгоод авчихъя гэж ингэж хэлээд байгаа юм л даа.

Хоёрдугаарт тэр нэг Их цаазын төсөл боловсруулах комиссын гишүүдээс заавал оролцуулна гэдгийн заавал гэдгийг больчихвол яласан юм бэ? Комиссын гишүүдээс оролцуулна гэхэд заавалтайгаа ялгаа алга байна шүү дээ.

Я.Хурлээ /75 дугаар тойргийн депутат/ -Тэр хоёрдугаар өгүүлбэрийн хувьд депутатуудын хороо болон гэдгийг хасчихаад ажлын хэсэгт Их цаазын тесөл боловсруулах комиссын гишүүдээс оруулж болно гээд санал хураалгах саналтай байна. Хороо яагаад хасах гэж байна гэдэг асуудал ярьж байна л даа. Тэгэхээр энэ хороонд депутат бус хүмүүсийг оруулж байх шаардлагагүй байгаа учраас ажлын хэсэгт нь л төсөл боловсруулах комиссын гишүүдээс байж болох юм гэсэн саналтай, хороо бол цэвэр депутататаас бурдэж байх ёстой гэж би ойлгож байгаа юм.

Ж.Уртнасан -Таны санал депутатуудын хороо гэдгийг хасъя гэж байна уу?

Б.Дашзэвэг /328 дугаар тойргийн депутат/ -Энэн дээр нэг ийм зарим зүйлийг засаж залруулах нь зүйтэй юм уу гэж бодлоо. Энд Ардын Их Хурлын Их цаазын төслийг бухэлд нь зөвшөөрсөн нех-

цөлд зохих саналын дагуу түүнийг зарчмын хувьд өөрчлөх, найруулан засах уурэг бүхий депутатын хороог хороо гэж оруулаад, ажлын хэсгийг ажиллуулна гэж оруулмаар байна. Энд хороо, ажлын хэсгийг байгуулж ажиллуулна гэж байгаа юм. Бид хороо, ажлын хэсгийг түрүүн байгуулчихсан шүү дээ. Тийм учраас энийг хасмаар байна.

Негеө талаар депутатын хороо болон ажлын хэсэг, Их цаазын төсөл боловсруулах комиссын гишүүдээс заавал оруулна гэдгийг бүр хасчихмаар байна. Тэртээ тэргүй бүх гишүүд, комиссууд энд ажилд орж байгаа учраас, ийм санал байна.

Ж.Уртнасан -Комиссын гишүүд ороод ажлын группт байгаа учраас ач холбогдол багатай гэж та үзэж байна уу?

Б.Дашээвэг -Үгүй ээ, би тэр депутатын хороо, ажлын хэсгийг байгуулж ажиллуулна гэж байгаа шүү дээ наадах дээр чинь, тэрийг хороо, ажлын хэсгийг ажиллуулна гэдгийг засмаар байна, ажиллуулна гэж, байгуулж гэдгийг нь хасаад. Дараа нь тэр депутатуудын хороо болон, ажлын хэсэг, Их цаазын төсөл боловсруулах комиссын гишүүдээс заавал оруулна гэж байна. Энэ тэртээ тэргүй орж байгаа учраас энэ байх шаардлагагүй юм уу гэж би өөрөө бодож байна.

Ж.Уртнасан -Энэ зүйл дээр зарчмын санал гарагчий, зүгээр редакцийн чанартай, засварын чанартай саналууд гарлаа гэж ойлгож байна. Редакции хийхийг редакцийн групптээ даалгаад "з" заалтаар санал хураая.

Б.Мижил /163 дугаар тойргийн депутат/ -Энэ нэгэнт бүхэлд нь төслийг зөвшөөрснийхөө дараа дахин эргээд зарчмын өөрчлөлт гарах асуудал байж таарахгүй. Ийм учраас зүгээр найрлагын юм байвал байж болох юм. Найруулан засах уурэг байж болох юм. Эргээд бүхэлд нь зарчмын хувьд өөрчилнө гэдэг чинь болохгүй л дээ. Тийм учраас энэ депутатын хороо энэ тэр гэдгийг хасчих-

3.

маар байна. Зөвхөн найрлагын хувьд засах ийм юм үлдээгээд тэгээд тавын "а"-д байж байгаа шуу дээ, депутатын хороо, ажлын хэсэг энэ тэр чинь. Тэрэн дээрээ энийгээ хэлэлцмээр байна.

Ж.Уртнасан - Зарчмын хувьд өөрчлөх гэдгийг та байж болохгүй гэж үзэж байнаа?

Р.Хатанбаатар /24 дүгээр тойргийн депутат/ - Би түрүүний тэр зарчмын асуудлыг 24 цагийн дараа эргэж задалж ярина гэдгээс тун их болгоомжилж байна. Энэ чинь одоо бид 24 цагийн дараа дахиад л энэ бүх асуудлаа зарчмын гээд задлаад байх юм бол энэ чинь Их цааз дотор нь өөрт нь зарчмын бус асуудал бараг байхгүй үндсэндээ. Бүгд зарчмын асуудал. Ингэхээр чинь бид бүх асуудлаа 24 цагийн дараа дахин дахин ингээд задлаад яриад байх юм бол хэзээ ч дуусашгүй юм болно, хэзээ ч бид нар үр дүнд хурч чадахгүй ийм аюулд хүрнэ. Энийг бид нар хаахан бодолцмоор байна. Зарчмын асуудлыг бид нар дараа нь хэлэлцсэн дордо бол тэртээ тэргүй цөөнх гэж дахин хэлэлцэж байгаа шуу дээ. Гэтэл энэн дээр бид нар дахиад 24 цагийн дараа хэлэлцэнэ гэдэг чинь бүр эцэс төгсгөлгүй ийм процесс болгоход хүргээд байна. Би энэн дээр санал хураалгахыг хүсч байгаа шуу.

Л.Болд /277 дугаар тойргийн депутат/ - Тэгэхээр сая "з"-д нэг ийм асуудал орох гээд байна шуу дээ. Их цаазын төслийг бүхэлд нь зөвшөөрсөн нөхцөлд гэж. Бүхэлд нь зөвшөөрөхгүй, хэсэгчилсэн, хэсэгчлэн зөвшөөрсөн нөхцөл бас гарна. Зарчмын хувьд өөрчлөх юмнууд заавал гарна. Тэгэхээр энийг чинь аль аль нь байхгүй бол болохгүй байна. Угүй бол ерөөсөө Их цаазаа батлахгүй гэсэн санаа энэний цаад талд байна, угүй бол бугдээрээ дуугүйхэн шиг гарнаа өргөнө гэсэн санаа орчихоод байна шуу дээ. Ийм учраас "з"-г өөрөөр найруулахгүй бол болохгүй. Энийг бүр дахин боловсруулж, дахин санал хураамаар байна. Энэ "з" дээр.

Ж.Уртнасан - Таны өөрийн хувилбар байна уу?

Л.Болд - Миний хувилбар бол ингэж л оруулмаар байна.

Ардын Их Хурал Их цаазын төслийн тухай зарчмын хувьд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл зарим нэгэн зүйл дээр, бүхэлд нь гэж үгийг авч хэрэглэж болохгүй байна. Зүйл зүйл дээрээ зарчмын өөрчлөлт гарна шүү дээ. Энэ чинь нэгдүгээр хэлэлцүүлэг явж байгаа шүү дээ. Нэгийн эцэст л ярж байгаа.

Ж.Уртнасан - Тэгээд Ардын Их Хурал Их цаазын төслийг та бүхэлд нь гэдгийн оронд зарчмын хувьд гэдэг уг оруулах гээд байна уу?

Л.Болд - Угүй ээ, бүхэлд нь гэдэг уг энд оруулж болохгүй байна. Хэсэгчлэн зөвшөөрөхөөс өөр аргагүй юмнууд зөндөө байгаа шүү дээ. Тиймээ.

Зарчмын зөрөөтэй санал зөрсөн асуудал 10 байна гэхэд 9-ийг нь зөвшөөрөөд нэгийг нь зөвшөөрөхгүй байж болно шүү дээ. Тийм учраас бүхэлд нь гэдэг уг энд хэрэглэж болохгүй байна гэж.

С.Баяр /I дүгээр тойргийн депутат/ - Тэгэхээр би, яг наадад редакцийн хэсэгт гээд хаяглаад олон санал ирж байна л даа. Тэгэхлээр редакцийн хэсэг гэдэг маань Ардын Их Хурал нийтээрээ л шийдээд, олонх дийлэнхээрээ авсан саналыг л редакцидаа оруулахаас биш, ингээд шууд хаяглаад ирж байгаа юмыг надад оруулчих тийм эрх хэмжээ байхгүй юм л даа нөхөд өө, тэрийг бас ойлгож үзнэ биз дээ. Янз янзын санал орж ирж байна. Тэрнийг бид харгалзаж үзнэ. Оруулах эрх мэдэл бидэнд байхгүй. Ардын Их Хурал санал хураагаад, аль нь олонхийг авсан байна, тэрнийг л бид оруулна гэдэг энэ чиглэлээ барьж байгаа гэдгийгээ бас хэлэхгүй бол болохгүй нь ээ. Маш олон юм орж ирж байна.

Баярлалаа.

Т.Яламсүрэн /II дүгээр тойргийн депутат/ - Энэ "з" дээр депутатуудын хороог ажлын хэсэгтэй байгуулж ажиллуулна гэж байна. Тэгэхээр энэн дээр би энийг жаахан тодотгож хэлмээр байна. Депутатуудын ажлын хэсгийг бол өр нь илт байгуулах хэрэгтэй юм. Энийг байгуулахдаа бол илтгэл яваад, асуулт хариулт

5.

дүүссаны дараа энийг байгуулах нь зүйтэй. Байгуулахдаа нэлээн өргөн хүрээтэй, өөрөөр хэлбэл одоо орон нутгаас, аймгуудаас, энэ Улаанбаатараас, энэ комиссоос оруулсан ийм бурэлдэхүүнтэй 5 бүлэг дээр нь хороогоо байгуулбал зүйтэй юм уу гэж нэг бодож байна.

Хоёрдугаарт энэ комиссыг байгуулсны дараа комиссыг ажиллах тийм боломжийг бодож үзэх хэрэгтэй. Тэгэхээр дандаа хуралдаан хийгээд байгаа үед комисс ажиллах боломжгүй болчихно. Ямар үед комиссыг ажиллуулах вэ? Комисс бол ач холбогдолтой. Энэ хуулийн талаар гарч байгаа олон саналыг нэгтгэж нэг цэгцэд оруулах энэ талаар бол цэгцтэй юм оруулж ирж болно байх гэж ингэж бодож байна. Нэг талаар Хоёр талаар, бүх хүн уг хэлэх боломжгүй байгаа учраас тэр бүгдийг нэгтгэх ийм дөт юм үзүүлэх болов уу гэж бодож байна. Ийм учраас энэ хороог бол яж байгуулах вэ? Энэний илт байгуулах юм бол тэр гарч байгаа санал, хусэлт, энэ юмнуудыг харгалзаж үзэх ажилд эртнээсээ комисс орж ажиллах боломж, нөхцөлийг бурдуулнэ гэж үзэж байна. Энийг нэг анхааралдаа аваачээ гэсэн санал байна.

Ш.Шагдарсүрэн /283 дугаар тойргийн депутат/ -Миний санал горимын шинжтэй гэх юм уу даа нэг зүйл хэлэх гэсэн юм. Юу вэ гэхээр, асуудлыг тодорхой болгохын тулд тодорхой саналаар хурааж баймаар байна гэж хэлэх гэж байна. Жишээлбэл, зарим асуудал дээр хоёр санал гараад байхад нэг санал хураалтаар шийдвичийг ийм маягтай яваад байна. Тэгэхээр энэ чинь болж өгөхгүй байна л даа, эцэстээ будлиантуулах ийм маягтай болоод байна. Жишээлбэл, тэр 24 цагийн дараа хэлэлцүүлэх, гуравны хоёроор хэлэлцүүлэх гэсэн энийг бол хамтад нь хураалгаж болохгүй л байсан гэж би ойлгож байна. Тэгээд ингээд будлиан гараад байгаа учраас энийг санал хураалгахдаа дарга анхаарч үзэхгүй юу гэж хүсэх байна. Асуудал тус бүр дээр хураавал илүү тодорхой, дараа нь шийдвээрд бас дөхөмтэй болох юм, асуудал бурийг.

Ш.Гунгаадорж /258 дугаар тойргийн депутат/ -Сая Шагдар-

6.

сүрэн ч хэлчихлээ дээ. Энэ бид бас зарим юман дээр нь жаахан анхааралгүй яваад, тэгээд түрүүчийнхээ заалтанд хучигдаад зарчмын юм зарим нь батлагдчихаад байна. Би бол зүгээр тэр 24 цагийн хувьд Очирбат гуайтай санал нэг биш байгаа юм. Энэ бол зарчмын асуудал. Эрхэм депутатууд энийг нэг эргэж анхаараачээ гэж бодож байна. Хэрэв бид одоо ийм уут гаргачих юм бол энэ хурлыг, аятуй бол Үндсэн хуулиа бид баталж чадахаа байна шүү. Ерөөсөө л 24 цагийн дотор гээд л санал гарч ирээд, ингээд эцэс төгсгөлгүй юм болно. 24 цаг гэдгийг оруулмааргүй байна. Энэн дээр тусад нь санал хураалгаж өгөөч.

Ж.Уртнасан - Щөнхийн саналыг анхааран үзье. Үнэхээр Очирбат гуайн хувилбарыг дахин уншаад сүүлчийн өгүүлбэрийн талаар санал хураалт явуулах боломжтой гэж бодож байна. Очирбат гуай "е" заалтыг депутатууд уг хэлж, санал гаргаж дууссаны дараа санал зоруутэй зарчмын асуудал бүрээр санал хураана. Тэгэхдээ саналын зоруутэй зарчмын асуудлыг депутатуудын гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ гэсэн энэ өгүүлбэр дээр тогтоё гэж бодож байна. Тэгэхдээ би уул асуудлаар дахин санал хураах шаардлага гарвал 24 цагийн дараа дахин санал хураалт явуулъя гэдгийг бид зарчмын хувьд энэ ер нь эргэж задрах, ихээхэн цаг алдах, нэлээн замбараагүй болох ийм үүд хаалга нээгдэж магадгүй гэж болгоомжилж байна. Тэгэхээр энэ 24 цагийн дараа гэдгийн талаар санал хураалт явуулъя. Хасах санал оруулж байна. Энэ бол ер нь бидэнд зарчмын хувьд алдаа болж мэдмээр юм байна. 24 цагийн дараа дахин санал хураалт явуулна гэдгийг хасах санал оруулж байна. Хасъя гэдэг маань зөвшөөрье гэдгээ дарчихвал тэгээд л хасагдана. За санал хураалт явуулъя.

За баярлалаа. 340 депутат буюу 84 хувь нь 24 цагийн дараа гэдгийг хасахаар шийдвэрлэлээ. Татгалзсан 54, 13 хувь, тудгэлзсан 9 хүн байна. 24 цагийн дараа дахин санал хураалт явуулна гэдэг энэ өгүүлбэр хасагдаж байна.

Отгон /180 дугаар тойргийн депутат/ - Би түрүүн нэг санал

гаргасан юм. Энэ "з" заалтыг гуравдугаар заалтын урд хоёрдугаар заалт болгон оруулбал ямар вэ гэсэн. Өөрөөр хэлбэл Монгол улсын Их цаазын төслийг хянан хэлэлцэх гэдгийн урьд депутатуудынхаа хороо ажлын хэсгээ байгуулаад авбал энд орсон улсууд маань эхнээс нь авахуулаад ажил, асуудалдаа орж бодож санаах нь дээр юм уу гэсэн энэ санал ч гарч байх шиг байна. Энийг бас нэг санал хурааж, олон түмний саналыг хэлэлцүүлбэл ямар байна вэ гэж дахиад хүсье. Өөр зүйлгүй.

Соронзон хальстай тулгаж
НИЙЛСЭН

Д. Алтанцэцэг

Д. АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Т.УРАНЧИМЭГ

81

1991. II. 12.
Кассет № 49
12.05 - 12.20

422 дугаар тойргийн депутат Н.Төмөртогоо:

Энэ Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлд БНМАУ-ын Үндсэн хуулийг хэлэлцэх, нэмэлт өөрчлөлт оруудах асуудлыг бүх депутатын гуравны хоёроор шийднэ гэсэн ийм заалт байгаа учраас энэ дэгдээ заримд нь оруулаад, заримд нь оруулахгүй ингээд байх хэрэг байна уу?.

Ерөөсөө энэ дэгдээ гуравны хоёроор гэсэн үгийг оруулахаа боливол ясан юм бэ? Нэгэнт л Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйл энд чинь бичээстэй байгаа учраас тэгэхээр өнөөдөр ингээд харахад чинь заримыг нь гуравны хоёроор шийдэхээр оруулчихаад, заримд нь олонхийн саналаар ч юм шиг ингэж байна.

Тэгэхээр бид одоо Үндсэн хууль /Их цааз/-ийн төслийг хэлэлцэхэд тэр Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийг баримталж явах байхаа, ийм учраас үүнийг анхаарч үзнэ үү гэж эрхэм хүндэт депутатуудаас хүсч байна.

284 дүгээр тойргийн депутат Ш.Бадам:

Энэ дээр бид "з" заалтыг л ярьж байгаа шүү дээ. Бид түрүүн "е"-г баталчихсан. Эргэж дахин давтан яриад байнаа. Тэгэхээр түүнийг батлахад энэ "г", "е" заалт хоёроо эргэж хармаар байна. "з" дээр ирэхийн тулд бид "г"-г батлахдаа асуулт, хариулт явуулсны дараагаар, ерөнхий санал шүүмжлэлээ явуулчихаад, дараа нь булэг тус бүрээр ярьчихаад, ингээд саналаа хураанаа гэдгийг баталчихсан.

Тэгээд "е" дээр ирэхэд, ингэж санал гаргахад зарчмын зөрөөтэй асуудал байвал бид гуравны хоёрын саналаар шийднэ гээд баталчихсан. Одоо "з" дээр ирэхэд зарчмын зөрөөтэй асуудлуудаа нэгэнт шийдчихсэн яваад ирж байгаа энэ нөхцөлд "з"-г зарчмын хувьд

өөрчлөх гэдгийг хасчихаад л 2 дугаар өгүүлбэрийг хасчихаад шууд баталбал болмоор юм шиг санагдаж байх юм.

33 дугаар тойргийн депутат П.Мөнхөө:

"з" заалтын хувьд миний санал бараг бүхэлд нь хасчихсан ч болмоор юм шиг санагдаж байна. Яагаад гэхээр нэгдүгээрт, "и" заалтанц саналын зөрүүтэй зарчмын асуудлаар санал хураасны дараа төслийг бүхэлд нь зөвшөөрөх, эсэхээ тогтоож, зөвшөөрөгдсөн бол эцсийн хэлэлцүүлэгт орно гэж. Зарчмын асуудлаа нэгэнт зөвшөөрөлцөх юм дараа нь бүхэл бүтэн олон хороо байгуулж үүнийг хэлэлцүүлэх хэрэг байна уу гэсэн нэг асуулт байна.

Хоёрдугаарт, энэ нийт дэгийн ерөнхий зүйлийн I дүгээр зүйлийн 10-ын I дүгээр зүйлд, шаардлагатай бол хороод байгуулаад асуудлыг хэлэлцүүлж болно гээд нэгэнт орчихсон юм бол. Их цаазын төслийг хэлэлцэх явц дунд шаардлага гарвал тэр юугаа дагаад хороо байгуулаад л хэлэлцье, гаражгүй бол одоо заавал нэг хороо байлгах гээд, түүнийгээ яах гэж цаг үрэхгүй байвал яласан юм бэ гэсэн саналтай байна. Баярлалаа.

133 дугаар тойргийн депутат Ц.Нанзаддорж:

Тэр бүхэлд нь гэдэг уг их чухал хасагдвал зохих уг байна гэж ойлгоод байгаа юм. Яагаад вэ гэвэл түруүний депутатын хэлдгээр, хэрэв тэр бүхэлд нь зөвшөөрөөгүй бол зөвшөөрөхгүй гэж хэлээд, зарим ֆункцийг аваад явчих гээд байна. Ийм учраас түүн дээр найруулгын редакци хийх шаардлагатай гэж үзэж байна.

Хоёрдугаар асуудал бол, энэ зарчмын гэдэг угнээс бид аль болохоор зайлсхиймээр байна. Эрхэм депутатууд ч үүнийг мэдэж байгаа байх. Яагаад вэ гэвэл, энэ зарчмын гэдэг угэнд чинь чиний энэ асуудал чинь зарчмын юм биш байна гээд өрөөсөө авч хэлэлцэхгүй нь шиг байна. Энэ түруүний Хатанбаатарын хэлдгээр энэ зарчмын асуудал бол үндсэн хуулийг бүх заалт, түүнийг зарчмын биш заалт гэж Үндсэн хуулинд өрөөсөө байхгүй байх, их цаазын төсөлд байхгүй байх гэж би ингэж ойлгож байна.

Үүнийг эрхэм депутатууд анхаарч үзээрэй гэж би үзэж байна.

Гуравдугаарт, "з" заалтыг хасч өрөөсөө болохгүй. Харин тэр хурлынхаа явц дунд хороогоо тэр санал шумжлэлийнхээ дараа байгуулчихаад, тэгээд хэлэлцээд явах нь зүйтэй. Хороо ажиллахгүйгээр санал шумжлэл гараад, депутатуудын санал шумжлэл тусахгүй байна.

Дөрөвдүгээр нэг асуудал бол энд сууж байгаа урд талын хэсэгт сууж байгаа Бага Хурлын зарим нөхдөөс Их Хурлын даргад утсаар яриад байх юм. Энэ ямар нөлөө байдаг юм бэ? үүнийг нэг тайлбарлаж өгөхгүй ю?

261 дугээр тойргийн депутат Л.Пүрэв:

Тэгэхээр энэ "з" заалт бол байх ёстой. Байхдаа байршилын хувьд 4-д биш 5 дугаар зүйл дээр байх ёстой гэж үзэж байна. Их цаазын төслийг бид анхны хэлэлцүүлэгт оруулж хэлэлцүүлэг дууссаны дараагаар үүнд зарчмын өөрчлөлт хийх, найруулгын засвар хийх энэ хороо, ажлын хэсэг бол Их цаазын төслийг хоёрдугаар хэлэлцүүлэгт бэлтгэх, энэ шатны ажил юм гэж ойлгож байна. Ийм учраас "з" заалтаа 5-ын "а"-д зөөх ийм саналтай байна.

56 дугаар тойргийн депутат Р.Гончигдорж:

Энд бид нар анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг гэсэн хоёр хэсэгтэй явуулъя гэж үндсэндээ тохиирлоо. Тэгэхээр анхны хэлэлцүүлгээ явуулах журмаа л бид нар ярьжбайна шүү дээ. Ингээд анхны хэлэлцүүлгээ тийм, тийм журмаар явчихаад, ингээд ерөнхийдөө санал зөрүүтэй зарчмын асуудлаараа санал хураагаад, төслөө бүхэлд нь зөвшөөрөх эсэхээ тогтоосны дараагаар энэ дээр нэг хороо ажиллах учиртай юм.

Энэ хороо бол ямар зарчмын асуудлаар ямар ямар өөрчлөлт оруулахаар болов, тэр бүх өөрчлөлтуүдийг оруулаад та бүхний өмнө, -за одоо энэ эхний хэлэлцүүлгээс гарсан, эцсийн төсөл.

Дараа нь энэ төслөө барьж байгаад хоёр дахь хэлэлцүүлгээ ярихдаа шууд зүйл, зүйл дээрээ батлаад, ингээд батлах шатанд даа орчих ийм шат учраас энд арга байхгүй, саналын дагуу түүнийг зарчмын хувьд өөрчлөх, найруулан засах гэдэг маань бол та бүхний зарчмын хувьд зас гэсэн юмыг, гүйцэтгэх үүргийн үүднээс ажиллаж байгаа болохоос, өөрсдөө зарчмын асуудлын өөрчлөлт оруулахгүй шүү дээ. Энэ бол ажлын хэсэг. Үүнийгээ хоёр хэсэгтэй гэж бодож байна.

Нэг нь бол Хороо. Хороо нь дан депутатуудаас бүрэлдэнэ.

Ажлын хэсэг нь бол депутат биш улсуудаас орно. Энэ утгаараа бол одоо Их Хурлын хороо, нэг л хорооны тухай ярьж байна. Харин Их цаазын төсөл боловсруулах комиссын гишүүдийг заавал оруулна гэдэг бол нийт эд нар шийдэх эрхгүй ийм улсууд байна шүү дээ. Тийм учраас өмнө нь үүнийг боловсруулаад явсан, үүнийг найруулга, хууль зүйн нэр томъёоны хувьд оролцоод, энэ туршид нь явсан улсууд учраас эд нар орж байж, депутат нь хороо руу, депутат биш нь ажлын хэсэг руу нь ороод ингээд хамтарч ажиллах л ийм л агуулгын хувьд эрхэм депутатуудад би тайлбарлах гэсэн юм.

Ж.Уртнасан: Санал хураалтанд бэлэн болж байх шиг байна. Депутат Мөнхөөгийн 10-ын I дээр хороо байгуулах хэсэг гэдэг чинь тэр өгүүлбэр бутнээрээ хасан ^{дээрээс} шүү дээ. Тийм учраас энэ бол давхардахгүй. Ер нь энэ заалт бичихдээ их зөрчилтэй бичигдсэн байна. Нагант бүхэлд нь зөвшөөрчихсөн юм бол зарчмын засвар хийнэ гэж баймааргүй ийм зөрчилтэй заалт болчихоод байгаа юм. Тэгэхээр үүнийг депутатуудын олонхийн санал ийм найруулга дээр тохигох болов уу гэж бодож байна.

Ардын Их Хурал, Их цаазын төслийг зарчмын асуудлаар санал солилцсон нэхцэлд төслийг найруулах засах үүрэг бүхий депутатуудын хороог, ажлын хэсэгтэй байгуулж ажиллуулна. Энэ редакци дээр санал хураалт явуулах уу?

5.

Санал хураалтанд бэлтгэе. Санал хураалт явж байна.

Цөөнх санаалаа хэлж болно.

За баярлалаа. Санал өгсөн дөпүтатуудын 91 хувь нь буюу 376 хүн зөвшөөрлөө. 20 хүн татгалзаж, 13 хүн түдгэлзлээ.

"и" заалт. 10 дугаар хуудасны эхний өгүүлбэр "ж" заалт. Түрүүчийн "и" заалт маань, "ж", энэ нь "и" байвал зохих юм шиг байна. Энэ техникийн алдаа байна, уучлаарай.

Энэ заалт дээр зарчмын санал гараагүй учраас хэвээр үлдээх санал хураалт явуулъя. Санал байна уу?

168 дугаар тойргийн депутат Г.Вандагва:

Анхны хэлэлцүүлгийн явцад Их цаазын төслийн талаар саналын зөрүү, зарчмын асуудлаар саналын зөрүү гараагүй бөгөөд төслийг бухэлд нь сайшаасан бол эцсийн хэлэлцүүлэгт оруулахгүйгээр Их цаазыг хэлэлцсэнд тооцож батална гэсэн зүйлд анхаармаар юм байна.

Энэ дээр бол ийм юм байна. Бид сая анхны хэлэлцүүлгээ явуулаад, үүнээс зарчмын өөрчлөлтөө тусгаад, найруулаад, ингээд эцсийн хэлэлцүүлэгт, бүх юугаа оруулах гэж байна. Тэгэхээр энэ эхний хэлэлцүүлгийн явцад хөндөгдөөгүй, үүнийг бид нар эцсийнхээ хэлэлцүүлэгт оруулахаар үлдээнэ гэж ойлгогдож байхаар энэ дээр найруулах хэрэгтэй байна. Түүнээс биш баталчихлаа гэсэн ийм ойлголт байж болохгүй энэ дээр.

315 дугаар тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ:

Тэгэхээр бид нар өрөөсөө анхны ба эцсийн хэлэлцүүлэг гэдгээ зарчмын хувьд тохироод батлаад явж байгаа. Ийм учраас "и" заалтыг бухэлд нь хасах л саналтай байна.

§354 дүгээр тойргийн депутат Бороодай:

Би энэ "и" заалтыг бол өрөөсөө үндсээр нь хасах саналтай байна. Энд санал гаргахгүй, сайшаах, алга ташиж үүнийг бүхлээр нь батлах гэсэн гол ийм өгүүлбэр санаа байна гэж ойлгож байна

Ийм учраас энэ удаа ийм явдал тохиолдохгүй байхаа. Уүнийг бүхлээр нь хасъя. Ингээд давхардуулаад хэлэхэд 5 дугаар төслийн "а"-гийн өгүүлбэр тийм байгаа. Уүнийг бас хасах нь зүйтэй гэсэн саналтай байна.

Ж.Уртнасан: Саналыг хүлээж авлаа.

Хоёр депутат хасъя гэсэн санал гаргаж байна. Санал хураалт явуулъя. Энэ заалтыг хасъя гэсэн санал хураалт явуулж байна. Санал хураалтанд бэлтгэнэ ѿ.

За баярлалаа. 328 депутат хасъя гэсэн санал ирүүлж байна, 80 хувь нь 63 хүн татгалзаж байна, 15 хүн түдгэлзлээ. Энэ заалтыг хаслаа, олонхийн саналаар.

5 дугаар заалтыг хэлэлцэж өхэлье. Эцсийн хэлэлцүүлгийн тухай. Бид анхны хэлэлцүүлгээ дуусгалаа. Одоо 5 дугаар заалт буюу эцсийн хэлэлцүүлгийн тухай санал, депутатуудын санал солилцье. 5-ын "а"

Зарчмын санал гарагчий бол санал хураалт явуулъя. Учлаарай, депутат Очирбат ийм томъёолол ирүүлж байна. 5-ын "а", "анхны хэлэлцүүлгээр сайшаасан төслийг депутатуудын хороонд эцэслэн гүйцээж боловсруулна. Депутатуудын хороо нь Ардын Их Хурлаас анхны хэлэлцүүлгээр тогтоон, зарчмын тохиролцоог нэгбүрчлэн хянан үзэж, төслийг эцэслэн найруулж засварлаад, товч тайлбар, санал лавлаганаа бэлтгэнэ" гэсэн өөрийн хувилбар ирүүлж байна.

Энэ бол найруулгын чанартай болохоос биш, зарчмын хувьд адил юм. 5-ын "а" заалт дээр санал хураалт явуулъя. Санал хураалтанд бэлтгээрэй.


Зарчмын гэж үзэх ганц л юм байна. Ажлын хэсэг гэдгийг депутатын хороо болгоё гэдэг санал ирүүлж байна. Ийм найруулгын редакц хийгээд хэвээр анхныхаа энэ тесэл дээрээ байгааг санал хураалт явуулъя. Үлдээхээр.

7.

Ажлын хэсэг гэдгийг депутатын хороо болгож найруулан засаад тесел дээр байгаа хэвээр үлдээс гэсэн санал хураалт явуулж байна.

Санал хураалтанд бэлтгээрэй. Саналсгэсэн депутатуудын 93 хувь нь буюу 381 хүн зөвшөөрч байна. I6 хүн татгалзаж, II хүн түдгэлзлээ. "а" заалт үлдлээ. "б"- заалтыг хэлэлцье.

Соронзон бичлэгтэй тулгаж
нийлсэн


Д.ЧУЛУУНЦЭГ

Бичээч Д.Цэндсүрэн

1991.II.
Кассет № 50
12.20-12.35

Х.Уртнасан -"б" заалт дээр түрүүчийн санал гаргасан депутатуудаас хоёр хүн хасая гэсэн санал ирүүлсэн. Мөн эсрэг утга ч санал хураалтанд гардаг. "б" заалтыг хэвээр үлдээе гасэн санал хураалт явуулж байна. Санал хураалтандaa бэлтгэе.

-Баярлалаа, депутатууд анхаарлаа төвлөрүүлье. "б" заалтыг хасья гэсэн санал хураалт явуулж байна. Хасая гэсэн энэ заалтыг 339 депутат буюу 82 хувь нь зөвшөөрч байна. 62 хүн татгалзаж, 10 хүн түдгэлзлээ. Энэ заалтыг хасч байна.

"в" хэсгийг хэлэлцэх шууд санал хураалт явуулж. Нэгэнт "б" хэсэг хасагдсан учраас "в" хэсгийг мөн хасая гэсэн санал ирүүлж байгаа учраас хасахаар санал хураалт явуулж.

-Баярлалаа, 80 хувь буюу 328 депутат хасах санал ирүүллээ. 57 хүн татгалзаж, 20 хүн түдгэлзэж байгаа учраас энэ заалтыг хаслаа.

"г" заалтыг хэлэлцье. 9-р микрофоноос депутат Х.Пүрэвдагва саналаа хэлье.

Х.Пүрэвдагва /63-р тойргийн депутат/ -Саяны "б", "в" хоёр дээр цөөнх болчихлоо. "а" дээр ч мөн адиликан. Депутатууд ийм зүйлийг анхаармаар байна. "а" дээр бүх техник ажлыг депутатын хороо хийхээр боллоо шүү. Ажлын хэсэг биш энэ хороо нь өөрсдөө техник хийхээр батлаачихлаа. Үүнийг эргэж харах уу, угүй юу. Сая ажлын хэсэг гэдгийг хасаад хаясан шүү дээ.

Дараа нь депутатын хороо ажлын хэсгээс боловсруулж гаргасан тэр зүйлийг экспертиз хийхгүйгээр Их Хуралд шууд орж ирэхээр боллоо шүү хэрэв "д"-г хасвал. Үүнийг ойлгосон бол түүгээрээ явахаас биш ээ. Комисс, бүлгүүдийн хурал дээр эргэж хэлэлцээд, экспертиз, дүгнэлтээ гаргаад, Их Хуралдаа

2.

орж ирсэн бол өөр байх байсан.

III. Гурбазар/167-р тойрог/

—Би саяны санал хураалтан дээр цөөнх болж байгаа юм. Олонхийн саналаар нэгэнт ийм болсон учраас миний саналыг санал хураа гэж хэлэхгүй, миний бодоход энэ нь байх ёстой л зүйл байсан. Бид нэг зуийлийг анхаарвал ясан юм бэ? 500 хүний идэвх, чармайлтаар гардаг баримт бичиг бил уу, эсвэл түүхийн онолын баримт бичиг байдаг болов уу гэдгээ ч бодсон.

Хоёрдугаарт бид өөрсдөө баталсан хууль эрхтэй парламентын намуудаа хундлэх үүднээс ч бодсон, эцсийн эцэст эдний санал, онолыг оруулах талаас нь ч бодсон энд юм байсан болов уу гэж би бодож байна.

Гуравдугаарт энэ нь ардчиллаас зөрчигдөхөд хүрэхийг үүнийг бодох байсан юм биш биз дээ. Бид нам гэхээр ухасхийгээд, эсвэл Бага Хурал гэхээр ухасхийгээд байгаа явдал нь суулдээ асуудлаа яригад хундрэх вий дээ. Ухас хийх зүйл дээрээ ухасхийе, тохирох зүйл дээрээ тохиръё. Үүн дээр бид төрийнхээ өмнөөс ярыцгааж байгаа учраас зарим зүйл дээр бид тэнд ч утас, тэнд ч Бага Хурал, нам ингээд гээд яриад байна гэх юм. Бид Монгол орны хувь заяны тухай ярьж байгаа шүү дээ. Гурван талаас цугларсан З хүн ярьж байгаа юм шиг яриад байна. Эмзэглэх зүйл дээрээ л эмзэглээ.

В.Лханаасүрэн/191-р тойргийн депутат/ —зарчмын асуудал дээр уг хэлэхгүй бол болохгүй нээ. Бид дэндүү яраад байна. Үүнийг Их Хурлын даргад анхааруулмаар байна. Жишээ нь саяны "з" заалт дээр хэлэлцэж байгаад та өөрийнхээ саналаар уг хэлээд шууд саналаа хурааж байна шүү дээ. Энэ нь болохгүй юм. Үнд бүхэлд нь гэсэн уг байх уу, зарчмын хувьд гэсэн угээ хасах уу, яах вэ гэдгээ яриад шийдэж байхад та тэндээс санал солилцсоны эцэст гэж байна. Санал солилцоод гэж үүнийг оруулж

3.

боловгуй шүү дээ. Үүнийг санал солилцсоны эцэст шийдэхгүй. Үүнийг санал хураагаад зарчмын асуудлаарх зөрөөг арилгаж байж энэ асуудлыг хороонд шилжүүлж эцсийн хэлэлцүүлэгт оруулна шүү дээ. Тэхээр та хоёр, гурван ч удаа тэндээсээ шууд наиртуулаад санал хураах нь болохгүй. Таны саналыг ч гэсэн бид хэлэлцаж байж, мөн санал хурааж шийдвэрлэж байж бид юмандаа оруулах ёстой шүү дээ.

Саяны "б", "в" хоёрыг хасаж байгаа асуудал нь өнөөдөр зарчмын алдаа гаргаж байна. Яагаад гэвэл хоёрдугаар хэлэлцүүлэгт экспертиз гаргах хүн байхгүй байх нь. Үндсэн хуулийн төслийг боловсруулах нэхдүүдээс үүнд оролцохгүй юм байна.

Хоёрдугаарт намуудын булгийн төлөөлөгч өрх биш бодсон, санасан зүйлээ эцэслэн зөвшөөрсөн төсөл дээр угээ хэлэх ёстой болов уу гэж бодож байна. Тэхээр эцсийн хэлэлцүүлэг нь хорооны саналаар Үндсэн хуулийн асуудлыг шийдэх нээ. Их Хуралд эцэслэн боловсруулж оруулах юм байна.

Зүй ёсондоо бид Үндсэн хуулийг боловсруулах комиссын дүгнэлтийг бодолцоод эцсийн то ѿон дээр бид үүнийг бодолцох ёстой байсан. Хэт яараад, сэтгэлийн хөөрлөөр болоод депутатуудын зарим хумуусийн ярж байгаагаар саналаа шууд хураагаад байгаа нь өнөөдрийн хурлын ажиллагааг хариуцлагагүй байдалд чиглуулж байна уу гэж би сэтгэл түгшиж амзэглэж байна.

Ж.Уртнасан -Депутатууд аа! учлаарай, "а" хэсгийг дахин сайн уншвал энэ нь тодорхой шүү дээ.

I-р микрофон -Хурлын даргаа, надад "а" заалт дээр санал байна. Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг...

Ж.Уртнасан -Учлаарай, ингэж задлаад баймааргүй байна. Цөөнх нь олонхоо хүндэтгэмээр байна шүү дээ.

Бид олонхийн саналаар батлаж байгаа шүү дээ. Түүнээс нэг хүний саналаар батлаагүй.

Д.Лхагвасүрэн/ I70 -р тойрог/ -Тодотгож ойлгомоор юм байна. Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын томъёолж өгсөн саналыг гэж байна. Тэхээр үүнийг анхны хэлэлцүүлэгт оруулж байгаа энэ төслөөр нь бид ойлгох юм уу, үүнийг хэлэлцэх үед Үндсэн хуулийг боловсруулах Очирбат даргын комиссоос бас томъёолол гаргаж ирэх юм уу, үүнийг бид юу гэж ойлговол болох вэ? Комиссын томъёолж өгсөн саналыг хэлэлцэнэ гэж байна шүү дээ. Үүнийг бид анхны хэлэлцүүлэгт оруулсан тэр санал гэж ойлгох юм уу, эсвэл дахин хэлэлцэх явцад Үндсэн хууль боловсруулах комисс нь томъёолол гаргаж ирэх юм уу?

Ж.Уртнасан -Комиссын томъёолж өгсөн саналыг гэдгийг та өөрийн хувилбараар яж өөрчлөө гэж бодож байна.

Лхагвасүрэн -Энэ угийг хасах саналтай байна. Өөрөөр хэлбэл анхны хэлэлцүүлгийн дүн өцэстээ яваад, дахин Үндсэн хууль боловсруулах комиссоос тэр саналтай холбогдсон шинэ томъёолол гаргаж өгөх тухай асуудал болох гээд байна шүү дээ. Би түүнийг шаардлагыгүй гэж бодож байна.

Ж.Уртнасан -Депутат Лхагвасүрэнгийн саналын талаар санал хураах уу?

Л.Эрэнцэннацаг/429-р тойргийн депутат/ -Би "б" заалтыг хасмааргүй байна. Энэ заалтанд нэлээд жинтэй уг, өгүүлбэр тусгагдсан байна. Хуулийн төслийг хороо, ажлын хэсэг, намын бүлэг, төслийн комисс нь хамтарч сайн хэлэлцэж авах нь зүйтэй байх гэсэн санал байна. Хэрэв тэгэхгүй бол депутатуудад шууд оруулна гэдэг нь нэлээд маргаан үүсэх, эвгүй байдалд орж болзошгүй явдал төрөөд байна. Тийм учраас үүнийг эргэж харвал яласан юм бэ гэсэн бодол байна. Үүнтэй холбогдуулж ярихад

5.

хурлын даргаас авахуулаад бид шуурхайлаад, цайны цаг нь дэхээд байгаа юм уу, зөвшөөрсөн дээр бүгд дарчих гээд байх шиг байна. Тийм учраас үүнийгээ эргэж харж, нухацтай дармаар байна шүү дээ кнопкнуудаа гэдгийг хэлмээр байна.

Р.Барсболл/З-р тойргийн депутат/ -Уучлаарай депутатын нэрийг тогтоосонгуй, та сая санал хурааля гэж хэллээ шүү дээ. 5-ын "а" дээр комиссын томъёолж өгснийг хасая гэсэн санал гарав уу даа. Гэхдээ үүнийгээ манай депутатууд сайн уншаач ээ. Үүнийгээ сайн уншихгүй, анхааргүй байна уу даа. Үүнийг комисс барьж аваад, шинээр томъёолох биш шүү дээ. Сайн боловсруулаагүй байж болох учраас та өмнөх өгүүлбэрийг нь сайн унш л даа.

Ардын Их Хурлаас анхны хэлэлцүүлгээр тогтоосон зарчмын тохиролцоог үндэслэн гэж байгаа шүү дээ. Үүнийг комисс нь хэндлэнгөөс ороод өөрчлөх биш, бид хэлэлцэж, тогтчихоод, юмаа өгчихсөн байхад комисс нь боловсруулж оруулна шүү дээ. Энэ нь яагаад болдоггүй юм бэ, үүнийгээ сайн анхааралтай уншаач ээ гэдгийг би хүсмээр байна.

Хурлын горимын, явцтай холбогдуулж нэг зүйлийг хэлэх гэсэн юм. Бид олон саналууд хэлэх гээд байна л даа. Гэхдээ давтаж байна. Би нэг их сурхий юм мэддэг хүний хувьд биш, хэрэв нэгэнт саналыг дэмжих байгаад, давтуулахгүй нь тулд шинэ нотолгоо л гарахгүй бол жишээ нь депутат тэр хүний саналыг дэмжих байна гээд суучихвал боллоо шүү дээ. Тэгэхгүйгээр гарсан саналыг гараагүй юм шиг бие, биенээ хундэтгэхгүй байна шүү дээ. Тэгээд нотлох гээд оролдоод байх юм. Гэхдээ нотлох гэж оролцж болно, хэрэв шинэ нотолгоо, үндэс байвал түүнийгээ хэльье. Хэрэв гаргасан саналыг дэмжих байгаа бол олон угээр хэлээд хэрэггүй шүү дээ, тэр хүнийг дэмжих байна гээд суучихад л боллоо шүү дээ.

А.Далхжав/50-р тойрог/ -Бид 5-ын "б" дээр шуурхай санал давах шиг боллоо. Анхны боловсруулсан төсөл маань юу болсон гэдгийг намын булгууд ч эргэж дүгнэлт, экспертиз хиймээр

93

6.

байна. Мөн Үндсэн хуулийн төсөл боловсруулсан комисс ч эргэж дүгнэлт хиймээр байна. Үүнийг цөөнхийн боловч эргэж санал хурааж эргэж бодолдохгүй юу гэсэн нэхдийн саналыг дэмжиж байна.

Ч.Бат-Эрдэнэ/ЗИ5-р тойргийн депутат/ -Тэхээр Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын томъёолсон саналыг нэгбүрчлэн хянана гэдэг нь бидний түрүүнд байгуулсан хороо, ажлын хэсэг, депутатуудаас гаргасан саналыг нэгдүгээр хэлэлцүүлэгийн үндсэн баримтанд тусгах механизм байна гэж ойлгож байна. Гэтэл үүнийг хасах гээд байгаа учрыг би сайн ойлгохгүй байна. Хэрэв үүнийг хасчихвал бидний оруулсан дүгнэлт, санал, үндсэн баримт бичигт орох механизмыг болох гээд байна. Үүнийг депутатууд ойлгох байх гэж бодож байна.

Хоёрдугаарт бид анхны, хоёр дахь хэлэлцүүлэг гэж тохирсон. Хороо, хэсэг байгуулсан дүгнэлт гаргах, гэтэл "б", "в" заалтыг оруулчихвал хороо, хэсэг ажилссны ур дун гарахгүй болох гээд байна. Эсвэл гурав дахь хэлэлцүүлгийн хувилбар гарчих гээд байна. Тийм учраас үүнийг хэвээр нь байлгах ямар ч үндэсгүй гэж үзэж байна. Үүнийг хасах нь зүйтэй.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Д.БАЯРМАА

/Д.БАЯРМАА/

Бичээч

С.ТУУЛ

1991-XI-12.
Кассета № 51
12.35-12.50.

-Санал хураалт, ер нь санал жигдрэх шиг боллоо.

3-р микрофон: 273-р тойргийн депутат Н.Жанцан: -Б заалтыг бүхэлд нь хассан дээр бол бас нэлэн анхаарч узэх зүйл байна гэж узэж байна. Б зүйлийн 2 дахь хэсгийг хассаны талаар бол би санал нэгдэж байна, нэг дэх хэсгийг хасахдаа бол нэлэн болгоомжтой хандах ёстой. Энд бол намуудын булэг, парламентын намын булэг, энэ парламентынхаа их хуралд ямар шиг байр суурьтай байх вэ гэдгийг бид бодолдох ёстой. Негэе талаар энэ комисс үндсэн дүгнэлтээ бас одоо сүхлд нь дүгнэлт гаргана гэдэг асуудал дээр бид шууд угүйсгэж хэлж болохгүй юм. Ийм учраас энэ дүгнэлт гаргаж болно. Түүнийгээ Их хуралд танилцуулж болно гээд ингээд томъёо-лоод энийг заавал нэг тийм албадлагын шинжтэй биш тэгэхдээ болно гэдэг ийм томъёололыг өгөхөд бол болохгүй зүйл байхгүй. Б зүйлийг бүхэлд нь хасдаг бол бас нэлэн агуулга муутай болж байна. Б зүйлийг хасчихаар зэрэг хэлэлцүүлгээ юу үндэслэж явуулах вэ гэдэг чинь байхгүй болчихоод байна шуу дээ. Нөхдүүд минь. Тэгэхээр энэ чинь юуг үндэслэж явуулах вэ гэхдээр зэрэг засвар хийсэн теслээ үндэслэн явуулах ёстой гэж би бодож байна. Төслийг үндэслэнэ гэдэгтээ бол санал нийлэхгүй байна. Тэгэхлээр Б зүйлийн чинь номонд хасаад бас нэг томъёолол хийж өгөхгүй зугээр цулгуй хасчих юм бол чухамдаа эцсийн хэлэлцүүлгээр юуг үндэслэж явуулах вэ гэдэг нь байхгүй болчихоод байна. Энийг депутатууд анхааралдаа авна байх гэж бодож байна.

1-р микрофон,

Хурлын дарга аа, бяцхан тайлбар өгөх уу.

Энэ депутатууд буруу ойлгочих шиг би бол тэр томъёолж өгсөн гэсэн үгийг эргэлзээд байгаа юм. Тэгэхээр эцсийн хэлэлцүүлгийн явцад Үндсэн хуулийг боловсруулах комисс томъёолол тусдаа гаргаж өгөх юм уу яах юм бэ гэдгийг ойлгох гээд байгаа хэрэг шуу дээ. Энийг л ойлгож авах гэсэн санаа байгаа юм.

Уртнасан:

Дээр нэг дэпутат сайн хэлсэн тодорхой дээ. Энэ эхнийхээ өгүүлбэртэй холбоотой юм.

За санал хураалтад бэлтгэж болж байх шиг байна. Тэгэхээр А хэсэг дээр дахин орооцдолдохoo болж. Депутатууд бид баталчихсан. Харин Б хэсгийг цөөнх дахин харж узэхгүй юу ялан-

2.

гужа энэ бол 2 өгүүлбэртэй юм. I дүгээр өгүү лбэрийг дахин харж үзэх талаар санал хураалт явуулах уу. Олонхийн саналаар бид уг нь Б, В хэсгийг хасчихсан. Тэгэхдээ цөөнх дахин нэг харж үзэхгүй юу номын хэсгийн санал юу болох юм, ажлын группийн санал юу болох юм, энэ өр нь ингээд цулгүй хасчихаж болохгүй байна гээд байх юм. Миний бодоход би зүгээр өөрийнхөө томъёоллыг хэлж байна. Энэ A заалт бол бүгдийг хамраад болж байх шиг санагдах юм. Тэгэхээр дахин санал хураалт явуулах уу, угүй гэдэг санал хураалт явуулаад тогтчих ёё. Энэ 2 хэсгийг дахин хэлэлцэх уу, угүй юу гэдгээр санал хураалт явуулъя. Хэлэлцэхгүй юу. За баярлалаа, тэгвэл санал хураалт явуулъя. Энэ цөөнх санал хураалт явуулахыг шаардаж байх шиг байна. Тэгээд бид олонхийнхоо саналаар санал хураалт явуулъя..

2 дугаар микрофон

-Тэгэхээр өр нь энэ зарчимгүй байдал газар авахуулахгүй байх нь хэрэгтэй. Ухаандaa энэ хэдэн депутат хашгичаад байх юм бол болих барих байх ийм байдлаар явах юм бол цаашдаа их муу үр дагавартай болно. Тийм учраас л одоо дэгээрээ явах нь зүйтэй.

-Баярлалаа, санал хураалт явуулъя.

Депутатууд санал хураалтад бэлтгээрэй. Энэ талаар санал хураалт явуулна, явуулахгүй гэсэн зарчмынхаа юмыг бид шийдэх гэж байна шуу дээ. Явуулахгүй л гэвэл бид туруучийн олонхийн хэлснээр энэ 2 заалтыг хасаад /кассетад яриа давхардсан/

-Уртнасан дарга аа, нэг үг хэлмээр байна.

69-р тойргийн депутат Ж.Яламсүрэн: -Энэ Б, В заалтыг хасах нь зөв байгаа юмаа. Ягаад гэвэл энэ анхны хэлэлцүүлгээр бид энд хэлэлцээд тэгж өөрчлөх ёстой юм гэж тогтчихсон юмыг депутатын хороонд боловсруулж оруулж ирээд, тэр депутатын хороо дахин хэлэлцүүлж өөр газруудаар нелөөлөл авах гээд байдаг ямар учир байна аа. Тийм учраас энд хасах хэрэгтэй юм. Нэгэнт тогтоод өмнө нь тогтчихсон юмаа боловсруулж өөрснээ оруулж ирэх

гээд байна шүү дээ.Дахин энэ чинь.Тийм учраас энд өрөөсөө хэрэггүй юм.Энийг ойлгох хэрэгтэй байх.Тэрнээс анхны хэлэлцүүлэг дээр ийм юм байж болно.Депутатын хороо бол ажлынхаа хэсгийг яаж ч байгуулна, ямар ч лавлагаагаа олуулна энэ бол тэр хороонд нь байх өрх нь мөн.Тийм учраас энд өрөөсөө хэрэггүй юм байгаа юм.

-За санал хураалт явуулъя.Депутат Ламзавын сануулга, анхааруулыг хүлээж авч байна.Б,В хэсгийн талаар санал хураалт явуулъя.Эрхэм депутаттаа, таныг энэ цөөнхтэй санал нэг байгаа болов уу гэж томъёолж байна,эсвэл та угээ хэлэх уу.

-5 дугаар микрофон -тэгэхээр бид дэг журман дээрээ анхаармаар байна.Гэж хэлэх гэж байна ахиад, их хашгиралдмааргүй байна.Ер нь дэгтэй явыя гэвэл энэнээсээ эхлэх ёстой гэж саян хэлсэн депутаттай санал бүрэн нийлж байна.Тэгэхээр бид бас бие биенийгээ сонсох учиртай, тэгж ч түрүүнд нь оруулсан.Цөөнхөө сонсно гэж, тэгээд сая жишээлэх юм бол эарим нэг асуудал дээр болонгүүт санал хураах уу угүй гэж хэлчихээд, зарим нэг дээр шууд хурааж байна.Энийг нэг мөр байж байх ёстой жишээлбэл, гэхмэтчилэнгийн ийм горимын саналтай юмнууд бол байна.Энийг дарга дахиад анхаарахгүй юу.Ер нь намын булэг гэдэг юм уу, Бага Хурал гэж хэлэнгүүт нь учиргүй цочоод байдаг нь их сонин байгаа гэдэг нь түрүүчийн хэлсэн депутаттай бас санал нэг байна.Бид бүгдээрээ ярыж байж шийдэх учиртай бүгдээрээ хэлэлцэж байж шийдэх ёстой.Энд тэгж л бүгдээрээ ирсэн байх гэж би бодож байна.Тэгэхлээр уг хэлэх лээр хамжуунаас хашгиралдаад, бахиралдаад ингээд байж байгаа явдалыг бол би өрдөө хүлээж авч чадахгүй. Ер нь эцсийн эцэст бол Үндсэн хуулийг боловсруулах комисс маань анхнаасаа.Ерөнхийлэгч, намуудын төлөөлөгчид бүгд ингэж орж явж ирсэн.Энэ бүгд байдлыг харах ёстой.Бид өнөөдрийн тогтолцоогоо ч бодож ёстой.Энэ нь үүднээсээ нэг шатаанд нь авч хаях гээд байгаа явдалыг би бас хувьдаа нэг сайн дэмжиж чадахгүй байна.Ийм учраас энэ угийг би зориуд халье гэж боссон юм.Яагаад зарим дээр нь санал хураагаад, цөөнх боллоо гэж цөөнх хэлэхлээр санал хураагаад сая бол цөөнх гэхдээ I хун босож хэлээгүй, их олон хүн хэлсэн, жишээлэхийн бол 7,8 хүн хэлсэн.

Энэ саналыг дахин хурааж өгөөч гэж. Тэгэхэд жишээлжэд санал хураахгүй, хураах уу угүй гэж асуучихаад тэгээд дараагаар нь хураахгүй гэж ингэж авч байна. Энэ бол буруу. Тэгэхдээ би юун дээр нь хэлж байна гэхлээр энэ саналаар санал хураах уу угүй юу гэдэг дээр санал хураах гэж байгаа дээр л би гайхаад байгаа байхгүй юу. Цөөнх хэллээ, саналы нь хураая гэх ёстой байтал, цөөнх уг хэллээ, энэний саналыг хураах уу, угүй юу гэдгээр санал хураах гээд байгаад л би өргөлзээд байна шуу дээ.

Уртнасан:

-Тэгэхээр ийм томъёололоор санал хураалт явуулж гэж бодож байна. Цөөнх буюу хэд хэдэн хүн босож уг хэллээ. Ер нь санал цөөнхийг харгалзан узэх ёстой гэдэг зарчмын асуудлыг та бидэнд анхааруулж байна. Цөөнхийн саналыг харгалзан узье гэсэн ийм томъёоллоор санал хураалт явуулж. Хэрэв цөөнхийн саналыг харгалзан узье гэвэл бид дахиад Б, В заалтын талаар өргэж ярилцах болно, Цөөнхийн саналыг харгалзац узэхгүй гэвэл олонхийн саналаар энэ 2 заалтыг хасаад зөвхөн Г заалтаа хэлэлцэнэ, одоо санал хураалт явуулж. Цөөнхийн саналыг харгалзан узье гэдэг дээр санал хураалт явуулж байна. Анхаараарай.

За санал өгсөн депутатуудын 26 % нь буюу 108 хүн олонхийн саналыг харгалзан узье гэж байна. 70 % нь буюу олонхи нь 285 депутат энэ саналыг харгалзан узэхгүй, Б, В заалтыг хасъя гэсэн саналтай үлдлээ.

Одоо Г заалтыг хэлэлцье.

272 дугаар тойргийн депутат С.Лунаа: -Энэ зүгээр найруулгын засвар хийе гэж бодож байна.

Эцсийн хэлэлцуулэгт Их цаазын төслийг зүйл бурзэр хэлэлцэх ба хэрэв саналын зөрүүгүй бол тэгэхгүй бол энэ чинь утгагүй өгүүлбэр болчихоод байна шуу дээ. Булэг, дэд булгээр нь хэлэлцэж батална гэж, бол гэж хэлэлцэх ба гэдэг ийм уг нэмж.

309 дугаар тойргийн депутат Д.Батбаяр: -В заалтыг хассан нехцэлд Г заалт дээр ийм тодотгол хиймээр байна. Депутатын хороо ажлын хэсгийн эцэслэн боловсруулсан төслийг үндэслэн эцсийн

хэлэлцүүлэгт Их цаазын төслийг зүйл бүрээр нь хэлэлчэнэ гэдэг тодотгол оруулъя гэж бодож байна. Тэгэхгүй бол юуг үндэслэж одоо эцсийн хэлэлцүүлэг хийх вэ гэдгийг гэдэг нь В заалтандaa хасагдчихаад байгаа юм.

Уртнасан:

-Депутатын хорооноос оруулсан гэдэг томъёоллыг урд нь оруулъя гэж бодож байна. Тодотгол. Депутат Зуунай зүйл бүрээр хэлэлцэж гэдэг угийг нэмье гэж байна. Хэрэв санал зөрөөгүй бол тоо гэдгээр нь тогтох байж болох л юм л даа. Энэ 2 депутатын саналыг энэ зүйл дээр найруулгын чанартай /кассетын дуу давхардаж хураагдсан/

-Яг энд байгаа өгүүлбэр чинь их найруулга муутай, ойлгомжгүй өгүүлбэр байгаа шуу дээ. /танхимаас/

-Ойлгож байна, найруулгын засвар оруулах хэрэгтэй юм. За Батбаярын саналыг энд тусгах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Бид нэгэнт 2 заалты нь хасчихсан юм. Нэг тодотгол өгүүлбэр урд нь оруулж өгөх нь зүйтэй болов уу. Депутат Батбаяр манай ~~редакции~~ комисст өөрийнхөө хувилбарыг өгөхийг хүсч байна.

2 дугаар микрофон 39 дүгээр тойргийн депутат Д.Ламжав:
 -Харамсалтай нь би саяны санал хураалт дээр зарчмын юм хэлэхгүй бол болохгүй болчихлоо. Тэгэхээр энэ цөөнхийгээ хүндэтгэхгүй гэж одоо тийм угзэр санал хурааж цаашдаа хэрхэвч флохгүй. Би зүгээр цаашдаа хурлын юу их горимтой байхгүй бол хэцүү хэцүү юм их тохиолддог юм үнэхээр, тийм учраас юу гэхээр тэр З хуртэл санал хураалгах асуудал чинь байгаа юм чинь тэрнийг бол шууд хэнээс ч зөвшөөрөл авахгүй санал хураалгаад тэр битгий хэл тэрнээс цааш хураалгах уу угийг гэд юу гэлэгт даргад эрх олгосон байгаа шуу дээ. Ийм учраас энэ дээрээ яаж байгаасай гэж бодож байна. Түүнээс гадна энэ дээр дахиад ч санал хураах резерв байгаа шуу дээ. Тэгэхээр юуг гэхээр энэ асуудал энд туссан төсөлд байгаа тэр Б, В гээд байгаа тесөлд байгаа зүйл юу гэхээр маш их хүнд маргаантай

асуудал гараад аль болохоор улс төрийн тохиролцоод хүрэх тэр бүх зам шугамыг л үлдээсэн байгаа юм. Бид нар одоо энэ мэтийг бүх боломжтой зүйлийг хэрчиж хаягад байх юм бол сүүлдээ одоо хурал бол аль болох хурал түгжигдмэл байдалд орох ийм зам руу явж болох юм шүү, тийм учраас энэ дээр дахин нэг санал хураахыг одоо өмнө баталсан дэгийг баримтлан дэгийн хэсгийг баримтлан хүсч байна.

283-р тойргийн депутат Ш. Шагдарсүрэн:

-Тэгэхээр бид бас эхнээсээ өхлээд жаахан учиртай явах л гэж оролдох байгаа юм л даа, миний санаа бол тийм, миний санааг зөв ойлгоно биз. Тэгэхээр эхнээсээ I дүгээр зүйл дээр бид цөөнхийг хундэтгэнээ гээд оруулчихсан байгаа байхгүй юу, тэгсэн мөртөө дараагаар нь болонгутуут асуудал болгон дээр цөөнх босч ирээд, яхав асуудал болгон дээр биш өр нь тодорхой асуудлууд дээр цөөнх босч ирээд уг хэлэнгүүт бид нарын юуг санал хураах уу угүй юу гэдгээр хураалгаад явчих гээд байгаа юм л б даа. Энэ маань тэгж ойлгогдож байна уу, аль эсвэл би буруу ойлгоод байна уу, Эсвэл дүрэм горимоо зерчигдэж эхлэх гээд байна уу. Эхнээсээ батлагдаагүй байж, гэсэн ийм л байдалд хүрээд байгаа юм. Ер нь цаашдаа бол аль болохоор юмыг бололцоотой хэрээр нээлттэй явахыг зорих нь чухал гэж үзэж байна. Яагаад гэвэл их олон асуудлууд гарна энэ дээр, маргаантай юмууд гарнаа энийг бид ойлгож байгаа байх гэж бодож байна. Энэбүүгдийг л харгалзаж үзээсэй гэдэг үүднээс энэ ийм эвгүй тийм проце турийн юм оруулчих вий гэж бодож байна. Жишээлэхэд бүх санал цөөнх уг хэлэхад л хураах уу угүй юу гэдэг дээр л санал хураагаад хаячих юм бол угүй гээд л ингээд тараад ирж байдаг, ингэхээр чинь аргагүй болчихож байгаа шүү дээ, ямар юмаа цөөнхөө хундэтгэх байдалд хүрэх вэ дээ энэ чинь хүрэхгүй шүү дээ.

-Депутатууд үүнийг бүгдээрээ анхаарах ёстой гэж бодож байна. Ер нь бид цөөнхийг хундэтгэж сонсоно. Шийдвэр олонхиор гардаг өрөнхий зарчим хэвээрээ үлдэх болов уу гэж бодож байна.

-За Г заалтыг
энэ дээр өөр санал байна уу.

-За тэгвэл депутатуудын гаргасан редакцийн засварыг хийгээд
редакцийн группт даатгая. Г заалтын талаар санал хураалт явуулжь.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

 Ш.БУРМАА

101

1991.XI.12
Кассет №52
12.50 - 13.06

288 дугаар тойргийн депутат С.Баярцогт:

-1 дүгээр бүлгийн 10 дугаар зүйлийн "е" дээр бол өөрчлөлт ороогүй батлагдсан учраас өчигдрийн тавьсан саналаа энэ дээр оруулах нь зүйтэй гэж узэж байна. Тэгээд найруулгын чанартайгаар Их цаазын төслийг зүйл бүрээр, хэрэв саналын зөрүүгүй бол бүлэг, дэд бүлгээр нь хэлэлцэж, нэрсээр санал хурааж батална. "Нэрсээр санал хурааж" гэдэг уг нэмээд энд бол ач холбогдол өгч байгаа. Нэрсээр санал хураасны дараа бол энийг бүгдийг нэрсийн жагсаалттай хэвлэж, ард түмэнд танилцуулах нь зүйтэй. Энэ бол эцсийн эцэст монголын ард түмэн, монголын дахиж урагшaa явах 10, 20 жилийн ар замыг зааж байх баталгаа учраас энэ дээр хүн болгон хариуцлагатай хандах утгаар нь нэрсийн жагсаалт гэдгийг заавал оруулж өгөх нь зүйтэй. 10-ын "е" дээр энэ заалт ~~хягдаад~~ байгаа юм.

Х.Уртнасан: -депутат Баярцогт энэ заалт дээр нэрсээр санал хураана гэдэг ийм томъёолол нэмж байна. Баярцогтын саналын талаар санал хураалт явуулж. Нэрсээр санал хураана гэдгийг энэ заалтад нэмж оруулах талаар санал хураалт явуулж. "г" заалт дээр нэмж байна шуу дээ. "г" заалт дээр Баярцогтын саналыг харгалзан узэх талаар санал хураалт явуулж байна.

Санал өгсөн депутатын 61 хувь нь Баярцогтын саналыг зөвшөөрч байна. 250 хүн. Татгалзсан 133, түдгэлэсэн 21. Редакцийн групп энэ формулировкийг оруулж өгье.

1 дүгээр тойргийн депутат С.Баяр: -Энийг оруулж болно л доо. дэг маань жаахан утга муутай юм болно. Шаардлагатай бол тэртээ тэргүй нэрсээр хураана гэдэг юм маань түрүүчийн юманд маань байгаа шуу дээ. Энийг дахиж оруулж гэвэл редакц найруулаад оруулж болж байна. Тийм давхар давхар юмнууд шаардлага байна уу, угүй юу.

Энэ дээр депутатууд маань, депутатат Баярцогт тэр юугаа

оруулсан шүү дээ. Одоо энэ дээр дахиж оруулж ингэж баталгаажуулах, давхар баталгаа хийж байгаа юм шиг, тийм юм хэрэггүй байх л даа. Дэг маань ч гэсэн тийм цэгцтэй баримт бичиг. Энэ бас түүхэнд үлдэх юм шүү дээ. Бидний хамтын уран бүтээл юм. Тэгээд бие биендээ хардсан, сэргсэн тийм уур амьсгал байгаад байх шиг байна.

Түргүний ажлын хэсэг дээр депутат Шүрэвдагын хэлсэн үнэн. Үнэндээ хэцүү юм. Жишээ нь: хороод болоод суулд нь ажиллах юм бол энэ дотор хуралдах депутат үлдэх уу, угүй юу? Жишээ нь: би редакцийн комисст орсон, санал онолоо хэлмээр байдал. Санал онолоо бодох тийм зав алга л даа. Янзян хэлж байгаа томъёоллуудыг энд оруулах гэж бодоод нааш цааш нь болгоод байна. Ухаандаа ингэх юм бол редакцийн комиссын бусад гишүүд бас л тийм байдалтай байгаа байх, идэвхтэй хил ажиллагаанаас салчихжээ.

Хороонд бол депутатууд оролцох ёстой. Гэтэл зөндөө зүйлүүд байгаа шүү дээ. 5-ын "а" дээр. Тэгээд ажлын хэсэг гэдгийг хасаад депутатын хороо гэдгээрээ яваад орсон. Эцсийн дунд бид энэ танхимдаа биш, энд тэндэхийн нэг мухар буланд суучихсан, нэг томъёолол бариад төвч тайлан, санал лавлагaa бэлтгэнэ, найруулгын талаас нягтална гээд ингээд нэг буланд суучихсан улсууд болж хоцрох гээд байна. Депутат бол энэ дэгээ хэлэлцэхдээ уг нь болбол өнөөдөр үдээс өмнө дуусгаад үдийн завсарлагаанаар редакц нягтлаад 15 цагаас дараагийн ажиллагаандаа ормоор байлаа л даа. Бид ингээд нэг юман дээрээ дахиж эргээд, нэг хураасан юман дээрээ ингээд байх юм.

Шаардлагатай зарчмын юман дээр хэд ч хурааж болно. Бид урьд нь тогтсон, гурван удаа хураагаад суулд нь даргын шийдвэрээр нэг удаа яаж болно гэсэн. Гэтэл бид тэгэхгүй бид урагшилж байна уу гэхээр эргэж очоод энд бичих зай ч үлдээхээ болилоо, нөхөд өө. Тэр талаас нь бодвол ясан юм бэ? Ажлаа тургэлбэл ясан юм бэ? Дахиж энэ дээр санал хурааж өгнө уу. Дэг маань түүхэнд үлдэх бичиг баримт шүү дээ, 11 хуралдааны дэг гэсэн учраас. Тэр нэрсийн

3.

жагсаалтаар хураах гэдэг тэртээ тэргүй байж байгаа.

Ж.Уртнасан: -Баярлалаа. Цөөнхийн саналыг соанслоо. Тэгэхээр түрүүчийн заалт бол шаардлагатай үед нэрсээр санал хураана гэсэн ийм өгүүлбэр орсон гэдгийг анзаарах хөрөгтэй байна. Дахин санал хураалт явуулья.

288 дугаар тойргийн депутат С.Баярцогт: -10-ын "е"-д орсон тэр заалт бол нэлээн, маш өндөр хаалттай, олонхийн саналаар гэсэн. Би тэр утгаар нь яриад байгаа юм. Үндсэн хууль гэдэг маань 20, 30 жилд нэг л батлах байх. Магадгүй, 50, 60 жилд, 100 жилд ч юмуу, тэр утгаараа хариуцлагыг бусад асуудалтай холбож өрөөсөө үзэхгүйгээр Үндсэн хууль дээрээ хариуцлагыг ярья гэсэн ийм санаагаар хэлж байгаа юм. Тэрнээс дахиж орсон юмыг дахиж бие биендээ итгэхгүй хандах гэсэн тэр утгаараа ойлголцохгүй байх гэж бодож байна.

Тэрэн дээр маш өндөр зааг тавьсан байгаа юм. 210-аас дээш санал авч байж тухайн тухайн заалтыг нэрээр батална гэж байгаа.

340 дүгээр тойргийн депутат Б.Сумъяа: -Энэ дээр депутат нөхөр Пүрэвдагва, Баяр нарын хэлж байгаа саналыг эргэж харалгүй болохгүй тал байна. Бид нэгэнт ажил ярьж байгаа учраас хэдийгээр яриад өнгөрсөн ч гэсэн үнэндээ энэ депутатууд чинь бүх л техник ажил, дахиж томъёоллыг боловсруулна гээд суух юм бол үнэхээр бэрхшээлтэй болно. Тэгэхээр ажлын хэсэг гэдэг чинь бид бас л зохих үүрэг хариуцлага хүлээсэн Их цаазыг аятайхан болгоё гэсэн ийм л улс байгаа шүү дээ. Тэгэхээр эдэндээ ямар нэгэн хэмжээгээр итгэл найдвар хүлээлгээд хэрвээ гурван удаа санал хураахдаа хурчкээгүй бол дахиж наг авч яривал яана вэ? Энэ бол ажлын талөө юм.

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж: -Өчигдөр санал хураалтан дээр санал хураахад хязгаар тогтоохгүйгээр тохирсон. Гурав хураачихаад нэг удаа даргын зөвшөөрөлтэйгээр хураана гэсэн байдлаар тогтоогүй шүү. Сая зарим

депутатууд ийм асуудал гаргаж ирж байна. Хязгаар тогтоохгүй гэдгээр л байгаа. Даргын мэдрэмжийн асуудал гэж тэрэн дээр бид нар орхисон, хэд хураалгах нь.

Дараачийн асуудал бол Баярцогтын хэлээд байгаа. Би ойлгоогүй байгаа. И дүгээр бүлэг ярж байхад ИО-ны "е" дүгээр заалт нээлттэй үлдсэн. Энэ бүлгээ ч батлагчийгээр энэ "е" дүгээр заалтаа дахин баталгаажуулалгүйгээр бид нар цаашаа яваад байна. Өчигдөр хурал таraphад би хэлж байсан, ерөөсөө хүлээж аваагүй. Депутатуудын ердийн олонхийн саналаар гэж байгаа. Энэ ерөөсөө биелэхгүй зүйл. Бид нар нэгээнт хариуцлага хүлээж, ард түмэн гэж энд ирж их олон удаа ярж байгаа депутатууд. Тэгэж ярж байгаа бол яагаад энэ үндсэн зарчмын асуудлуудаар нэрээр санал хураахад татгалздаг юм бэ? Депутатуудын ердийн олонхийн саналаар гэдгийг хасаагүй. Баяр хэд дахин босч "хассан" гэж хэллээ. Хасаагүй байгаа.

Хойно нь баталгаажуулах гэлээ гэж байна. Хойно нь тэгэж хийж болно. Урьд талд нь хасаагүйгээр саяны Баярцогтын саналаар хийж болох байсан. Их цаазын зарчмын асуудлуудаар гээд хойно нь хийж болохоор байсан. Гэтэл редакцийн комисс руу шийдэж өгсөн асуудал бишшу дээ, энэ. Би энд депутатынхаа шугамаар оролцож байна. Бас л сонгогчид тэгэж л ярина. Миний асуудал бол ерөөсөө ингэж санал хураагдахгүй юм бол би энд яах гэж сууж байгаа юм бэ? Өчигдөр би хоёр удаа тавьсан, өглөө ирээд нэг удаа тавьсан. Одоо дахиад тавьж байна. Хэд хэдэн депутатууд энэ дээр хурааж өгөхийг санал болгосон байгаа. Энэ дээр нэг хураалгаж өгөөч ээ. Ердийн олонхийн саналаар гэдгийг өчигдөр олонх нь хассан юм байгаа, эхлээд хураахад. Дараагаар нь гар өргөж нэр авах нээ гэдэг асуудал дээр депутатууд тээршаасан юмуу, буцаад олонх болсон, тэгээд нээлттэй орхисон. Хурлын протоколд байж байгаа байх, хальсанд, дахиж сонсох юм бол. Энийг нээлттэй орхилоо, жаахан бодьё гээд цааш явсан байгаа.

94 дүгээр тойргийн депутат Б. Сандуйжав: - Ийм хувилбар байх юм. Энийг эсэргүүцээд байх асуудал биш байх гэж бодож байна. Ерөөсөө энэ компьютерийн санах байгууламжид,

тэр дороо хэн ямар асуудлын төлөө за гэв, угүй гэв гэдэг чинь бичигдэж байгаа шүү дээ. Тухайн үед протоколд тэмдэглээд тэрийг хуулаад авбал ясан юм бэ? Ийм л заалт оруулбал ясан юм бэ гэж бодож байна.

Ж.Уртиасан: -Нэр гарч байгаа л даа, бид түрүүн ярьсан шүү дээ. Энэ цахим техник маань бугдийн нэрийн санал бичиж байгаа гэж. Энэ бол тодорхой юм.

депутат Элбэгдоржийн саналыг бас харгалзан үзэх хэрэгтэй байх. Депутат Элбэгдорж хоёр саналыг гурав дахь удаагаа тавьж байна. Бид уг нь дахин хэлэлцэхэд энийг нээлттэй орхиё гэж санал болгосон. Депутатуудын ердийн олонхийн санаалаар гэдгийг эхлээд хаслаа гэж санал хураалт хийсэн. Хоёр дахь дээр хэвээр үлдсэнээр явж байгаа. Депутатуудын ердийн олонхийн санаалаар хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзаж депутатын нэрийн жагсаалтаар авч болно гэж. Энэ дээр Баярцогт, Элбэгдорж нарын санал нэг байх шиг байна, дахин санал хураалгаж болох юм.

I дүгээр бүлгийг нийтэд нь батлаагий гэдэг маань бид еглөө ярж тохирсон. I, 2 дугаар бүлгээ хэлэлцэж дуусаад редакцийн группийг ажилд нь оруулья гэж. Тэгхэээр I дүгээр бүлгээ баталъя, 2 дугаар бүлгээ баталъя гэх бол нэг их төвөгтэй хойшдох асуудал биш болов уу гэж ойлгож байгаа. Дахин санал хураалт явуулья.

Ц.Элбэгдорж: -Дарга аа, энэ санал хураах онцгой хэлбэр шүү дээ. Энэ хүн нэрээр санал хураалгаж байна гэдгээ, цаана нь нэрээр гарч байгаа гэдэг нь ойлгомжтой. Би нэрээр санал хураалгаж байна гэдгээ ойлгох юм бол энэ хүн асуудалд илхүү ханддаг. Энэ бол санал хураалгах онцгой хэлбэр, зүгээр кнон дарж байгаа асуудал биш.

Ж.Уртиасан: -Депутатууд түүнийг эсэргүүцээгүй шүү дээ, Элбэгдорж депутат аа. Нэрээр санал хурааж болно гэдгийг хэвээр үлдээж байгаа шүү дээ.

Одоо энэ дээр би дахиад санал хураалгах гэж байна. Баярцогтын саналыг редакцийн групп тайлбарлалаа. Баярцогт

өөрөө дахин тайлбарлаа. Нэмэлт тайлбарыг депутат Элбэгдорж өглөө. Тэгэхээр дахин санал хураалт явуулъя. Депутат Баярцогтын саналын дагуу Баярцогтын саналыг тусгаж, нэрээр санал хураана гэдгийг энэ заалтад нэмэх үү гэдэг дээр санал хураалт явуулъя. Дахин хураая, энэ гурав дахь санал хураалт боллоо. Санал хураалтад бэлтгэнэ үү.

Оруулна гэвэл нэрсээр санал хураалт явуулна гэсэн ийм уг бичигдэнэ. Татгалзвал энэ бүлэг энэ хэвээрээ үлдэнэ. Баярцогтын саналын талаар дахин санал хураалт явуулъя.

46 хувь нь зөвшөөрсөн байна, 50 хувь нь татгалзаж байна, 3 хувь нь түдгэлзлээ. Олонх болж чадсангуй. Ийм учраас энэ дээр нэрээр санал хураана гэдэг энэ өгүүлбэр орохгүй боллоо шүү.

Ц.Элбэгдорж: -10-ын "е" дээр би асуудал тавьсан шүү дээ, хурлын дарга аа. Ямар нэгэн Баярцогтын саналтай холбоотой биш. 10-ын "е" дээр. Нээлттэй үлдсэн энэ асуудлаа эргэж хаая гэдэг асуудлыг тавиад байгаа. Депутатын ердийн олонхийн саналаар гэдгийг хасъя гэдэг энэ саналыг тавьсан. Маш тодорхой санал хэлсэн шиг бодогдоод байх юм. Депутатын ердийн олонхийн саналаар гэдэг энэ 4 үгийг хасаад бусдыг үлдээе. 10-ын "е" онгорхой үлдсэн, өчигдөр. Хойшид эргээд бодьё, дахиж эргэж хэлэлцье гэдгийг. 10-ын 2-ын "е".

Ж.Уртнасан: -Депутат Элбэгдоржийн саналыг харгалzan үзэх хүсэлтэй байна. 10-ын 2-ын "е"-гээр бид нэг удаа санал хураалт явуулж, бид нээлттэй үлдээсэн. Гэтэл шийдвэр зайлшгүй гаргах хэрэгтэй гэж депутат шаардах байна. 6 дугаар хуудасны хамгийн сүүлчийн өгүүлбэр байгаа шүү дээ.

Ц.Элбэгдорж: -30-аас дээш депутатын дэмжлэг авсан тохиолдолд гэдэг тийм хязгаарлалт хийхийг үгүйсгэхгүй байгаа, тэрэн дээр хийж өгч болно.

Ж.Уртнасан: - "Депутатуудын ердийн олонхийн саналаар" гэдгийг депутат Элбэгдорж хасна гэж байгаа.

Тэгэхээр яг энэ томъёоллоор хураалгаа. Элбэгдоржийн саналыг харгалзан үзээд депутатуудын ердийн олонхийн саналаар гэдэг энэ дөрвөн үгийг хасъя гэдэг дээр санал хураалт явуулж байна.

10-ын "е" заалт. Депутатуудын ердийн олонхийн саналаар хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзаж саналыг депутатуудын нэрийн жагсаалтаар авна гэсэн томъёолол байгаа шуу дээ. Түүнээс эхний дөрвөн үг буюу "депутатуудын ердийн олонхийн саналаар" гэдгийт хасъя гэсэн санал хураалт явуулж байна. Санал хураалтад бэлтгэнэ шуу.

С.Баярпогт: -Энэ тоог арилахаас өмнө нэг юм хэлье. Миний санал бол сая өхлээд олонх авсан, одоо бол негеөх нь олонх болж чадахгүй байгаа юм. Тэгэхээр негеө санал чинь хэвээрээ үлдэж байгаа биз дээ. Уг нь тийм зарчим үйлчилж байгаа шуу дээ. Энэ бол 50 хувь болж байгаа, татгалзсан. Гэхдээ 10-ын "е"-г зассан тохиолдолд энэ саналаа дахиж ярихгүй л дээ.

Ж.Уртнасан: -Санал хураалтад бэлтгэнэ шуу, депутатууд аа. Анхаарал төвлөрүүлэхийн тулд Элбэгдоржийн хүсэлтээр 10-ын "е" заалтын эхний 4 өгүүлбэрийг хасъя гэсэн санал хураалт явуулж байна. Санал хураалтад бэлтгэнэ шуу.

Зөвшөөрсөн 24 хувь буюу 98 хүн, 295 депутат буюу 72 хувь нь татгалзаж байна. Түдгэлзсэн 14 хүн байна. Ийм учраас энэ хувилбар хэвээр үлдлээ.

Ц.Элбэгдорж: -30-аас дээш хүний дэмжлэг авбал гээд дахиад нэг хураагаад өгнө шуу. Энэ хоёр өөр асуудал.


Ж.Уртнасан: -Уучлаарай, Элбэгдорж оо, үдийн хоолны дараа таны саналыг дахин сонсъё. Одоо дэгийнхээ дагуу үдийн их завсарлага болж байна. Та бүхнийг үдийн зоогоо тавтай барихыг хүсч байна.

128

8.

С.Баяр: -Редакцийн комисс I4 цагт 2II номе-
рийн өрөөнд цуглавал ясан юм бэ?

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.ОЮУНЧИМЭГ

109

Кассет № 53
1991-XI-12
15.03-15.15

Ж.Уртнасан:- Эрхэм депутатуудын өдрийн амгаланг айлтгая.
Хуралдаанаа ургэлжлүүлье. Өнөөдөр манай чуулганы нэр дээр ирсэн зарим мэдээ, захидал, цахилгааныг танилцуулья.

Өнөөдөр манай Ардын Их Хурлын чуулганц ируулсэн захидал, цахилгааныг бид нар түүвэрлэж, Ардын Их Хурлын депутатуудын хамарагдах буюу өглөөний ярьсан зарчмаараа Засгийн газартай холбогдсон асуудлыг Засгийн газрын үед, Бага Хуралтай холбогдсон асуудлыг нь Бага Хурлын үед сонордуулья гэсэн зарчмаа бариад дараахъ зүйлийг сонордуулья.

Барилга, төхөөрөмжийн үйлдвэрийн мастер Доржготов, Найрамдлын районы I6 дугаар хорооны иргэн Дугаржав нар утсаар: Ардын Их Хурлын хуралдааны эхлэлт бидний сэтгэлд нийцээгүй өвгүй байдалтай болсныг цаашид анхаарах, тухайлбал хуралдаан хов жив хөөцөлдсөн байдалтай, депутат Цээн-ойдовын тухай хэлэлцэх шаардлагагүй байлаа.

Сүхбаатарын I дүгээр дүүрэг, I дүгээр хорооны иргэн, өндөр настан Гүнж, Найрамдлын районы I6 дугаар хорооны иргэн Дүгэржав нар: хуралдааны ажиллагаанд амжилт хүсч байна.

Дархан хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны хэлтсийн дарга Баяраа утсаар: хуралдааны ажиллагаанд амжилт хүсээд, дараахъ зүйлийг анхаарахыг хүслээ. Депутатууд мэдээжийн зүйл дээр хэт маргаад хуралдааныг сунжуулж байгааг анхаарах, мөн депутатууд нам, улс, төржих хандлага хэт их гаргаад ард түмний сонгосон төлөөлөгч гэдгээ бага анхаарч байгааг бодолзох, зарим депутатын сонгуулийн хуулийн мэдлэг хангалтгүй байгааг анхаарах.

Сүхбаатарын дүүргийн 9 дүгээр хорооны иргэн, өндөр настан Намжил утсаар: манай тойргоос сонгогдсон Ардын Их Хурлын депутат Зардыхан болон, бусад шатны депутатууд сонгогчид тойгоо уулзахгүй, санал хүсэлтийг нь сонсохгүй байна.

2.

Ахмад хүмүүс бидний үгийг сонсохгүй, амьдрал ахуй судлахгүй байна. Би 74 настай, өөрийн үр хүүхэдгүй, ганц бие өвгөн хүн, амьдрал хүнд байна.

Сүхбаатарын районы 28 дугаар хорооны иргэн Жамсранжав, Найрамдын районы иргэн Дүгэргэжав нар: Монголын ард түмний хувь заяа ойрын хугацаанд Ардын Их Хурлын гарч байна гэдгийг анхаарах хэрэгтэй. Иймд тус хуралдаанаас монголын ард түмэн их зүйл хүлээж байна. Өнөөдөр ард түмний бухимдал их байна. Зөвхөн өнөөдөр гэхэд энэ II дүгээр сарын 10-нд гадуур талх олдохгүй байна.

Октябрыйн районы 26 дугаар хорооны иргэн Цэрэндорж: Ардын Их Хурлын царга, орлогч дарга нарт ямар намынх нь хамаагүй чадвартай хүмүүсийг сонгож байх талаар дараачийн хуралдаанд анхаарах, Ганболд, Бат-үүл нарын тайланг Ардын Их Хурлын хуралдаанаар хэлэлцэх.

Октябрыйн районы 26 дугаар хорооны иргэн Долгор утсаар: шинээр байгуулагдсан хоршооллуудыг төр застийн зүгээс анхаарч эмх цэгцтэй болгож, дэмжлэг туслалцаа үзүүлэх.

Сүхбаатарын районы 6 дугаар хорооны өндөр настан Дэмбэрэл: улс орны байдал замбараагүйтэж байгаа нь төр застийн удирдлагаас шалтгаалж байгааг анхаарах, өмч хувьчлал зохион байгуулалт муутай явагдаж байна. Дунд доод шатны хүмүүс ажиллахгүй байгаагаас төр застийн шийдвэр хэрэгжихгүй байгааг анхаарах.

Дархан хотын Найрамдал хорооны өндөр настан Загдсүрэн утсаар: Арван нэгдүгээр сарын 10-ны өдөр Улаанбаатар хотод болсон цуглаанд оролцогчдоос Засгийн газарт тавьсан шаардлагыг эсэргүүцэж байна. Энэ Засгийн газрыг бүрэлдэхүүнээр огцруулах гэсэн тэдний шаардлагыг депутатууд хүлээж авахгүй байх. Хэрэв Засгийн газар огцорвол нэгдүгээрт, манай улсыг тэтгэх донор улсуудын итгэлийг алдана. Хоёрдугаарт, шинээр гарч ирэх хүмүүс одоогийнхоос дээрдүүлж чадахгүй, улам дордоно. Зас-

3.

гийн газарт алдаа бий нь мэдээж.

Сүхбаатарын районы I дүгээр хорооны иргэн Дашдондог: залуу боловсон хүчнийг удирдах ажилд дэвшүүлж байгаа нь зүйтэй. Гэхдээ залуу хумуусээс зөв сонгож дэвшүүлэхэд анхаарах.

Найрамдлын районы өндөр настан Мягмар: барааны унэ, юм нэмэгдсэнээс тэтгэврийн хумуусийн амьдрал эрс муудлаа. Энэ талаар яаралтай арга хэмжээ авна уу. За ийм л зүйлүүд ирсэн байна.

Ж.Уртнасан:-За өдрийн хуралдаанаа эхэлье. Хуралдааны дэг ёсоор ирцээ бүртгээ. Ирцээ бүртгэхэд бэлтгэнэ уу. Ирцийг бүртгэлээ. Ирвэл зохих 427 депутатас 398 депутат буюу 93 хувийн ирцтэй байна. Биеийн эруул мэндийн байдлаас, ар гэрийн гачиглаас хоёр депутат чөлөөтэй байгаа. Депутат Балдан-очир, депутат Дашням нар. Энд Их Хурлын даргац нэг хүсэлт ирсэн байна. Эмзэглэж. Би 359 дүгээр тойргийн депутат Баасанхүү байна. Өчигдрийн хуралдаанд би огт хоцроогүй, адил нэртэй депутат олон байж болзошгүй учраас заавал тойргийн нь дугаарыг хэлж байна уу. Үг хэлсэн нь дугаар, тойргийг залгуулж хэлвэл их сайн байна. гэж 359 дүгээр тойргийн депутат Д.Баасанхүү бичсэн байна. Заалийн зохион байгуулагч хоцорсон депутат бол 227 дугаар тойргийн депутат Б.Баасанхүү юм байна гэсэн залруулга ируулжээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын I дугаар тойргийн депутат Дашибалбар гомдол ирүүлсэн байна. Үүнийг уншиж сонсгоё. Ардын Их Хурлын II хуралдааны дэгийн I дугаар зүйлийн "д"-д депутат хүн үг хэлэхдээ бусдыг доромжлох буюу гутгэх, өөрийн саналыг тулгахаар хүч хэрэглэхийг, бусдац уриалахыг хориглоно гэсэн заалтыг зөрчиж, II дүгээр сарын II-ний өдрийн хуралдаан дээр нийт депутатуудын өмнө намайг хэл амаар доромжлон гутгэж I дугаар цуглаан хийсэн олон холбоодыг харгис, фашист хэмээн, фашист маягийн союз булэг, хунт маягийн хэмээн дайрч давшилсан депутат Хоржаубайг шүүхэд шилжүүлэхийг хүсч байна.

4.

Энэ нь Эрүүгийн хуульд бусдыг хэл амаар цоромжилж гутгэвэл эрүүгийн хариуцлага хүлээх ёстой заалтаад ч нийцэж буй. Хэрвээ депутат Хоржаубай буруугаа хүлээж уучлал түүнийг заавал шүүхээр шийдвэрлэхийг хүсэхгүй. Учир нь бид энэрэнгүй хүнлэг ёсоо ямар ч тохиолдолд дээдэлдэг юм шүү. Эс чингэвээс Ардын Их Хурлын 10 дугаар тойргийн депутатын нэр тэр, бүрэн эрхэд халдаж, мөн цугларсан олон түмнийг харгис хунт маягийн союз хэмээсний учир бид хуулийн байгууллагад шилжүүлэхээс үл буцна гэж депутат Дашбалбар болон мөн өдөр цугларсан олон түмэн харгис хүч эсэхийг ч хуулийн дагуу шалтгаалж тогтоож өгөхийг хүсье. БНМАУ-ын Ардын Их Хурлын 10 дугаар тойргийн депутат О.Дашбалбар гэсэн байна. Нэгэнт нэр зааж хандаж байгаа учраас депутат Хоржаубайнсэтгэгдэг сонсоё гэж бодож байна.

Ардын Их Хурлын 396 дугаар тойргийн депутат Б.Чимил: -Депутатын бүрэн эрхийн асуудлаар бид нэгдсэн ойлголттой баймаар байна. Депутатууд ямар нэг намын байгууллагын гишүүн шиг бие биенийгээ шүүмжлэх, эрхийг нь тудгэлзүүлэх гэсэн ийм ойлголт байхгүй. Шүүмжилж л болно. Депутатыг эрхийг нь тудгэлзүүлэх буюу дуусгавар болгох гуравхан үндэс бий. Нэгдүгээрт сонгогчид огцруулж болно. Хоёрдугаарт өөрөө гарч болно. Гуравдугаарт ертөнцийн жам ёсоор гарч болдог. Ийм турван юм бий. Энц жаахан буруу ойлголт яваад байна. Тэгэхээр өчигдөр 119 дүгээр тойргийн депутат Цээн-ойдовыг тудгэлзүүлсэн ийм санал хураахад бид санал өгөөгүй. Одоо тогтоол гарах эсэх нь сайн мэдэгдэхгүй байна. Булганы депутатуудаас авсан тооноос үзэхэд 12 сонгогч илээр сонгуулийн биш хэлбэрээр санал өгсөн учраас тэр бол 12 хунийкээ тухайд оролцсон, оролцуулсан аль алин нь Сонгуулийн дагуу болоогүй байна. Гэхдээ сонгогчдын 90 гаруй хувь нь сонгуульд оролцсон шиг байна. Тэгэхлээр хууль бусаар санал өгөгдсөн буюу авагдсанаас, авагдсан тоог нь хасаад гаргавал 50 жаахан өнгиймөөр ийм сураг байна. Ийм учраас хоёрхон асуулт байна. Нэгдүгээрт нэр дэвшигч олонхийн санал авч чадсан уу үгүй юу гэдгийг энэ Их Хурлаас хэдэн хүн гаргаж дахиж авч үзмээр байна. Тэр болтол Цээн-ойдовыг Их Хуралд нь суулгамаар байна. Хэрэв авч чадаагүй бол эрхийг нь тудгэлзүүлэх тухай асуу-

5.

дал ч байхгүй, харин Их Хурлаас өмнө гаргасан тогтоолыг тэр тухайд нь хүчингүй болгох ёстай.Хууль зүйн ийм үндэс байна.Ийм лугаа адил бусад депутатын хувьд ч ийм асуудал гарч магадгүй байна.Нэг буруу нух гарвал тэргүүгээр бас буруу юм хичнээн их цувдаг гэдгийг практик харуулсан шүү ийм байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ

НИЙЛСЭН

Д.Баяндуурэн

Д.БАЯНДҮҮРЭН

БИЧЭЭЧ Л.ХОРЛОО

1991-XI-12
Кассет № 54
15.15-15.31

Уртнасан:
За баярлалаа.

Депутат Жаргал гуай байна уу.

Орон нутгийн хэсгээс танд ямар бичиг баримт өгсөн бэ?

Жаргал:

Бид нэхэр Цээн-ойдов депутатын асуудлыг байнгын комисс хөнгөн дэх тавиагүй. Үнэхээр Ардын Их Хурлын II9 дүгээр тойрог дээр сонгууль будлиантай, хууль зэрчиж явсан тухай асуудлыг байнгын комисс хянаад, шалгаад бүрэн эрхийнхээ дагуу хуралд оруулсан, хэлэлцүүлсэн. Миний ойлгож байгаагаар болбол энэ хуралдаанд оролцож байгаа депутатуудын ихэнхийн санаалаар энэ одоо сонгууль будлиантай болсон учраас депутатын бүрэн эрхийг тудгэлзүүлсэн. Гэхдээ нутаг дэвсгэрийн группээс өчигдөр намайг илтгэл тавих гээд байж байхын өмнөхөн талд зурvas өгсөн. Тэр зурvasан дээр болбол Цээн-ойдовын эрхийг тудгэлзүүлэхгүй байгаачээ гэж хүсэлт тавьсан. Бид нэгэнт байнгын комисс шалгаад хамт олныхоо хурлаар хэлэлцээд, нэхэр Цээн-ойдовыг өөрий нь байлгаж байгаад хэлэлцсэн, дараагаар нь энийг Их Хурлын хуралдаанд албан ёсоор оруулсан учраас нутаг дэвсгэрийн булгийн тавьсан хүсэлтийг юу шуны тухандгүй авч үзэж эргэж буцаж ингэх бололцоо ч байгаагүй, тийм боломж ч бидэнд оддоогүй, тэгэх ч ёсгүй байх гэж бодож байгаа. Сая надад завсарлагаагаар тийм хүсэлт тавьж байна лээ. Их Хурлын даргад манай булгийн өгсөн зурvasыг дамжуулж өгөөч гэж. Хэрвээ үнэхээр энэ асуудал хөндөгдж гарч ирэх юм бол юм зарчим журмаараа л явцгаая. Түүнээс нэг нь очоод нэгийгээ гүйгаад, негеедэх нь албан тушаалаа ашиглаад негеедэхийгээ дуудаад, ингээд байх юм бол энэ хурлын үйл ажиллагаа хууль эрхийн юманд болбол төдийлэн тохиромжгүй байх гэж бодож байна.

Уртнасан:

II9 дүгээр тойргийн депутатат Цээн-ойдовын талаар Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг тудгэлзүүлэх тухай тогтоолын төслийг хийж бидэнд ирүүлсэн байгаа.

БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын бүрэн эрхийн асуудал эрхлэх байнгын комиссын илтгэлийг хэлэлцээд БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь: БНМАУ-ын Ардын Их Хурлын I2 дахь удаагийн

Сонгуулийн II9 дүгээр тойротг явагдсан сонгууль БНМАУ-ын Ардын Хурлын депутатуудын сонгуулийн хуулийг зөрчсөн тул тус тойротг депутататаар сонгогдсон Дамдинсүрэнгийн Цээн-оидовын БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг тудгэлзүүлсүгэй гэсэн ийм тогтоолын тесөл байгаа юм. Уүнийг хамт олноос, орон нутгийн хэсгээс билээнд өнөөдөр шийдвэрлэж өгөөч гэсэн ийм хүснэгтэй бий. Сая манай орлогч дарга та бүхэнд уншиж сонсголоо.

Булган аймгийн Тэшигийн хөдөлмөрчдөөс орон нутгийн захиргаагаар дамжуулж манай депутатын эрхийг зөвшөөрч өгнө үү гэсэн ийм хүснэгтийг утсаар ирүүлснийг та бүхэн сонссон. Тэгэхээр энэ дээр бид санал солилцож энэ асуудлыг нэг мөр болгоод хурлаа ургэлжлүүлэх нь зүйтэй гэж бодож байна.

Нэр тойргийн дугаараа хэлээгүй:

Уртнасан даргаа зөвшөөрөл өгөхгүй юу. Энэ Жаргал дарга нэг л тоо хэлэхгүй байна. I2 депутатын яахав тэрийг хүчингүйд тооцоод үлдэж байгаа нийт сонгогчдын хэдэн хувь нь одоо сонгуульд оролцов гэдгийг яагаад тоогоор хэлэхгүй байгаа юм бэ. Цээн-оидов тэгээд хэдэн хувийн санал авав гэдэг энэ хоёр тоог л хэлээд өгмөөр байгаа юм. 50 аравны гурав гэсэн тэр нь үнэн юм болбол энэ тогтоолыг бид авч ярихын ч хэрэг байхгүй юм шиг санагдаад байх юм. Тоо нь болбол яг баталгаатай хэлэгдэхгүй байгаа юм л даа. I2-ыг оруулж хэлээд байгаа юм. Хасаад л хэлэхээр хэд болохнов гэдгийг тоогоор нэг хэлээд өгмөөр байгаа юм.

II6 дугаар тойргийн депутат Н.Нямсүрэн: Сонгуулийн нэрсийн жагсаалтанц бичигдсэн I498 сонгогч байгаа, энэ нээс санал өгсөн I496 сонгогч саналаа өгсөн байгаа юм. Цээн-оидовын төлөө 754 сонгогч саналаа өгсөн, Болдбаатарын төлөө 727 өгсөн, 5 хуудас дарагдсан, 10 хуудас хүчингүй болсон ийм байгаа юм. Ер нь Ардын Их Хурлын сонгууль явуулах I990 оны 5 дугаар сарын I0-нд Ардын Их Хурлын сонгууль явуулах энэ хуулианд өөрчлөлт оруулсан. Энүүгээр 37-гийн 2-т байгаа бүх сонгогчдын гуравны хоёроос доошгүй нь энэ сонгуульд саналаа өгсөн байх энүүнийг авч үзэхэд энэ дээрх

тоонуудыг авч үзэхэд Цээн-ойдовын төлөө энэ I2 хунийг хасаад үзэхэд 50 хувь байгаа юм. Ингэхлээр энэ зүйл бол зөрчигдээгүй, Цээн-ойдовын энэ эрх бол депутатын эрх бүрэн хадгалагдах юм гэсэн ийм одоо.

Ер нь энэ I2 хуудсыг хасахад л 50 хувь байгаа шуу дээ.

46-р тойрог Харгал: Би түрүүчийн асуултанд хариулах уу их хурлын даргаа.

Нямсүрэн: Тэгэхлээр энэ хүн чинь дээд талд нь сонгуулийн хуулийн 37-гийн 2-т гуравны хоёр бух сонгогчдын гуравны хоёр нь сонгуульд орсон байна гэсэн ийм өөрчлөлт орсон байгаа юм. Тэгээд энгүүнийг хасаад үзэхээр хүчин төгөлдөр л байгаа юм.

Харгал:

Би түрүүчийн депутатын тавьсан асуултанд хариульяа.

Нямсүрэн: Негээ хүн дээр нэмэгдсэн ч гэлээ хүрэхгүй байгаа шуу дээ.

Харгал: Тэгэхээр ийм байгаа. II9 дүгээр тойрог дээр бух сонгогчид I498 байсан. Би өчигдөр ч бас хэлсэн. Үүнээс яг саналаа өгсөн сонгогч I496 байгаа юм. Өөреөр хэлбэл бух сонгогчдын 99,09 хувь нь бол сонгуульд оролцсон. Хүчингүй хуудас I0 байгаа, ингээд хүчинтэй гэж тооцсон хуудас I486 байгаа. Дамдинсүрэнгийн Цээн-ойдовын төлөө 754 хүн санал өгч, 732 хүн сонгохгүй гэж санал өгсөн. Эсрэг санал өгсөн.

Жижидийн Бодбаатарын төлөө 727 хүн сонгохоор санал өгч, эсрэг санал 759 байгаа. Энэ хоёрын хоёуланг дарсан саналын тоо 5 байгаа юм. Ингээд сонгуулийн өнгөрсөн онд явсан сонгуулийн дунг гаргахдаа кандидатын төлөө өгсөн саналын тоог саналаа өгсөн бух хүмүүст хуваагаад тэгээд тэргүүгээр процентыг гаргаж байгаа. Ингээд гаргахаар Цээн-ойдовын төлөө 754 хүн санал өгсөн, саналаа өгсөн нийт сонгогчид I496 байсан, ингээд 50,4 хувь эзэлсэн байгаа юм. Бодбаатарын төлөө 727 хүн санал өгсөн, нийт сонгогчид I496, ингээд 48, 5 хувь нь өгсөн байгаа юм.

Дээр дурдсан сонгуулийн урьд өдөр авсан I2 хуний нэг нь

сонгуулийн дүрэм, журам зөрчих авсан учраас хүчингүйд тооцох юм болбол шалгалтын материалаас, прокурорын тодорхойлолтоос үнэхээр энэ I2 хүн бол I2-уулаа саналаа ил өгсөн учраас Цээн-ойдовын төлөө өгсөн гэдэг нь мэдэгдэж байгаа юм.

Цээн-ойдовын төлөө өгсөн энэ I2 саналыг хасчих юм бол 744 хүн Цээн-ойдовын төлөө санал өгч, саналаа өгсөн нийт I496 хүнтэй харьцуулах юм бол энэ нь 49,6 хувь болж байгаа юм. 49,6 хувь болж байгаа учраас сонгуулийг хүчинтэй гэж үзэх үндэс байхгүй болчихоод байгаа юм. Өөрөөр хэлбэл кандидатын төлөө ийм олонхийн саналыг авч чадахгүй болчихоод байгаа юм. Бид ингэж асуудал тавиагүй. Бид өрөөсөө сонгууль будлиантсан гэдгийг бид албан ёсоор шалгаж оруулж ирсэн учраас депутатын эрхийг түдгэлзүүлье гэдэг ийм санал тавьсан.

39 дүгээр тойргийн депутат Д.Ламжав: Тэгэхээр энэ I2 хүнээс очиж 28-ны өдөр очиж авсан энэ зөрчлөөс болоод тэр бүх сонгуулийн ажиллагаа хүчингүй болсон гэж тооцохоор байгаа юмуу гэдэг дээр эргэлзээ байгаа юм. За яахав хамгийн муугаар бодоод энэ I2 хүн одоо сая Жаргал депутатат хэллээ. Депутатын эрхийн комиссын дарга. Ил авсан учраас Цээн-ойдовын төлөө өгсөн байна гэдгийг би андуурч байж магадгүй, би анх удаа сонсож байх шиг байна. Тэр хир зэрэг баталгаатай зүйл юм бэ? сая тийм сэтгэгдэл төрлөө. Ямар ч байсан I2 хүнийг саналаа урд өдөр нь өгчихсөн энэ явдал бол тэр сонгогчдын буруугаасаа илүү тэр комиссын буруу юм. Энэхээс болоод тэр бүхэл бүтэн сонгуулийг хүчингүй болгох ямар үндэс байна вэ гэдэг дээр нэлээд бодмоор байгаа юм. Зүгээр би арифметикийн талаас нь хэлэх юм бол энэ I2 хүнийг сонгуульд оролцоогүй гээд үзчих юм бол нийт 50 хувийн санал авсан уу. Сонгуулийн хуулийн дагуу, яг 50 хувь. Ямарваа нэгэн ойролцоо байхгүй.

50,3 хувь.

Мэдэхгүй би бодоод яг 50 гэж гаргасан шүү. Тэрэн дээр шалгах явдал гарч магадгүй. Тэгээд би ийм аргумент хэлж байна. Тэр I2 хүн чинь хэнээс болоод хуурагдаад саналаа өгөөгүй юм бэ

гэхээр асуудал байгаа юм. Магадгүй нэг хүн л Цээн-ойдовын төлөө санаалаа өгсөн бол тэр хүн депутат болох байсан байна. Бид нар энүүнд бид нар сонгуулийн туршлага бага учраас язь бурийн юмнууд гарч байсан. Би өчигдөр хэлсэн. Энийг үнэндээ бас нэг хармаар юм шиг байгаа юм шүү.

Өчигдөр би энэ талаар санал тавых хайхрагдаагүй өнгөрсөн.

399 дүгээр тойргийн депутат Д.Чилхаажав: Бид нар өчигдөр тогтоолоо ч баталсан, түдгэлзүүлэх тухай ч баталсан. Одоо хэлэлцэх юм бол тогтоолоо эргэж харж хүчингүй болгох асуудал ярих болов уу гэж би бодох юм. Тогтоолыг 215 хүн зөвшөөрч 51,19 хувиар тогтоолоо баталсан байна. Түдгэлзүүлэх асуудлыг эхэлж шийдсэн. Ийм учраас энэ асуудлыг үнэхээр асуудал бол маргаантай асуудал нь мэдэгдэж байна л даа. Ингээд орох юм бол энэ тогтоолоо хүчингүй болгох орох юм биш уу гэсэн ийм санал тавимаар байна.

III дүгээр тойргийн депутат Г.Бадарч: Сая Чилхаажав депутат ярыж байна. Өчигдөр бид нар нэгдүгээрт тогтоолоо албан ёсоор батлаагүй. Би энд нэг тайлбар хэлмээр байна. Ерөөсөө ноднингийн сонгуулиар ингэж явагдсан шүү дээ. Оюутан сурагчдын хөдөлгөөн их байсан учраас зарим сонгогчид нар бол ердөө урд өдөр нь ч биш арван хэд хоногийн өмнө явсан сонгогч нар ч гэсэн өөрсдийнхэе саналыг өгөөд битүүмжлээд сонгуулийн комисстoo орхиод явж байсан шүү. Энийг эргэж харахгүй юмуу. Ийм л санал байна.

264 дүгээр тойргийн депутат Б.Банди: Бадарч депутатын саналтай ойролцоо юм. Ер нь сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх заавраар бидэнд орон нутагт болбол урьдчилж санал авахыг зөвшөөрсөн юм. Энэ бол язь бурийн шилжилт хөдөлгөөн, онцлон узэх хүндэтгэх шалтгаанаар тухайн сонгуулийн өдөр өгч чадахааргүй болбол конвертонд нууцалж аваад лацдаж хадгалаад, тэр сонгуулийн өдөр задалж дунгийн гаргах ийм чиглэлтэй байсан юм. Тийм ч учраас одоо зөвхөн 2,3 өдрийн урд төдийгүй, сая урьдаас энэ ажил эхэлж явагдаж байсан шүү орон нутагт. Энийг зөвшөөрч байсан юм. Би бас Тэшиг сумын тэр нутгийг мэдэж байна. Тэр болболж үнэхээр тухайн өдөр очиж

авахад бэрхшээлтэй, алс хол тойруу байгаа, алсын отор хийж байгаа малчдын саналыг түргүн өдөр нь авсан байна. Энэ авсан тохиолдыг заавал сонгуулийн хууль зөрчиж, урд өдөр нь авсан гэж хэлэхийн үндэс байхгүй. Зүгээр тэр хүмүүсийн ярьж байгаагаар болбол Цээн-ойдов депутат ч гэсэн өчигдөр, уржигдар ярьж байсан. Яг одоо үнэхээр нууц байдалд авсан юмуу, аваагүй юмуу гэдгийг үнэхээр тогтоосон юм бол хараахан бид нарт мэдээлэлгэхгүй байна. Депутат өөрөө ярихдаа хайрцаг хүрсэн, тэр байтугай ардчилсан хүчний хүмүүс хүртэл дагаж яваад авч байсан гэж өчигдөр ярьж байсан. Энэбиш депутатын ярианд баталсан, нотолсон юм, Жаргал депутатын юманд яг тодорхой одоо хэлэхгүй байна. Тэгэхдээр энэ бол урьдчилж авах ёстой байсан, авч болох ч байсан гэдэг ийм үндэслэл байна. Негээ талаар болбол энэ батлагдаж, нотлогдохгүй ийм юм байна. Нууц авсан юмуу, ил авсан юмуу, Ийм учраас ерөнхийдөө авч үзэхэд энэ хүнийг бид зөв зүйтэй шийдэж өгөхгүй болбол энд хэлмэгдуулж магадгүй байна шуу. Ер нь энэ, негээ талаар Чимид депутатын яриад байгаагаар бол бид энэ асуудлыг энд авч үзэх үндэслгүй, ер нь энэ тогтоолыг энд батлах шаардлагагүй байх гэж үзэж байна. Тэр сонгогчид нь тэндээ шийдэх юм байгаа биз. Ер нь депутатынх нь бүрэн эрхийг үлдээх нь зүйтэй юм гэсэн ийм саналтай байна.

55 лугаар тойргийн депутат Ц.Альяасурэн: Энд бид нар Цээн-ойдов гуайн хувьд нь авч яриагүй шуу. Хамгийн гол нь Цээн-ойдов гуайг бид нар шүүх гэж ярьж байгаа юм биш. Хамгийн гол асуудал юу вэ гэхээр цаад сонгууль нь будлиантай, хууль зөрчсөнд байгаа юм байхгүй юу. Бид нар нэгэнт төрийн хуулийг хэрэгжүүлэх ёстой байгууллага чинь өөрсдөө энэ төрийн хууль зөрчиж байгаа байдлыг зөвшөөрөөд байвал юу болох юм бэ. Тэгвэл өрөөсөө хууль гэж гаргаж байхын хэрэггүй, хууль байхын хэрэг байхгүй болно. Хэрэв хуулийг зөрчөөд орон нутаг өөрөө урьдчиллаад урд нь журам дэглэм гаргаад, урд өдөр нь сонгууль аваад байвал энэ ер нь юу болох вэ. Цааш, цаашлынхаа байдалд энэ чинь нэлээлнэ шуу дээ. Тийм учраас тэр хууль зөрчсөн сонгууль хийсэн

учраас энэ сонгуулийнх нь энэ асуудлыг, будлианыг хуртэл энэ хүний эрхийг түдгэлзүүлж байгаа биз гэж би ойлгож байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт бид энэ түдгэлзүүлсэн тогтоолоо өчигдөр баталсан шүү дээ. Энийгээ мартчихаад байх шиг байна. Тэгээд одоо дахиж ийм юм эргэж ярьж байдаг. Чимид гуай ч гэсэн дээ. Хуралдааныг сунжуулж ийм юм хийж байдаг. Энийгээ өрөөсөө болимоор байна. Харин дэгэндээ орьё.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Б.Мурда

ЭНХТУНА

Бичээч

В.Оюун

1991-II-12

Кассет № 55

15.31-15.45

Ж.Гомбожав /326 дугаар тойргийн депутат/ -Би депутат Чилхаажав, Адъяасүрэн нартай санал нэг байна. Тэгэхээр өчигдөр өглөөний хуралдааны бичлэгийг эргэж сонсохгүй юу. Энэ тогтоолыг, би тэр хуралдааныг удирдаж байхдаа тогтоолыг батлуулсан, нэгдүгээрт. Хоёрдугаарт сонгуулийн хууль зерчсөн тухай л ярьж байгаа шуу дээ. Хэрэв ингээд хууль зерчсөн тухайгаа эргэж задлах юм бол ер нь Монгол улсад хууль гэж биелүүлэх юу, угүй юу. Ийм зарчмын асуудлыг тавимаар байна. Урьдчилж бол санал авч болохоор сонгуулийн хуулинд орсон, гэхдээ хувь хүн бүр өөрөө биттуумжилж өгөх ёстой. Тэرنийг сонгуулийн өдөр задлах ёстой, тэрнээс биш түрүү өдөр нь бөөнөөр нь авах ёстгүй. Манай хуулинд тийм байгаа шуу дээ.

С.Баяр /I дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр тавьж байгаа асуудал бол хуулиа л дагая гэж тавьж байгаа л даа. Сая депутат Гомбожав, Адъяасүрэн нарын хэлсний дараа бол үнэхээр дуутгуй сууж болсонгүй. Хуулиа л барьж байгаа юм бол бид хуулийнхаа л дагуу ажиллах ёстой. Асуудлын гол нь юундаа байна вэ гэхээр бид тогтоол гаргахдаа депутатын бурэн эрхийг тудгэлзүүлж байгаа. Депутатын бурэн эрхийг тудгэлзүүлнэ гэж байхгүй. Аль ч хуулинд тийм юм байхгүй. Тудгэлзсэн бурэн эрхтэй депутат гэж байхгүй. Эсвэл тэр хүн депутат, эсвэл тэр хүн депутат биш. Сонгууль нь хүчингүй болно гэдэг бол бид ноднин бурэн эрхийг нь зөвшөөреөд гаргачихсан тогтоолынхoo тухайн хэсгийг хүчингүй болгох тухай л байхаас биш. Тэр нь хүчингүй болсон учраас тэр депутатын бурэн эрхийг тудгэлзүүлж байгаа юм бишээ.

Сонгууль нь хүчин төгөлдөр биш, хуулиа зерчсөн бол тэр хүн депутат болоогүй. Бид ноднин гаргасан тогтоолдоо алдаад, тэр хүнийг депутат гээд тооцчихож. Тэр гаргасан тогтоолынхoo тэр хэсгийг хүчингүй болгох тухай асуудал болохоос биш, болжихсон хүний бурэн эрхийг тудгэлзүүлнэ гэдэг бол тухайн хүнтэй ч холбоотой, өөрөө нэг хуураад мэхлээд болжихсон, янз янзын юм нь илэрчихсэн хүнийг огцруулаад л татаад

авахаас биш бүрэн эрхийг нь түдгэлзүүлнэ гэж байхгүй. Тийм учраас хууль зүйн дагуу хийе гэдэг үүднээсээ л энэ тогтоолыг дахин ярьж байгаа байх. Тийм ч үүднээс бид Ардын Их Хурлаасаа хууль тогтоох гол байгууллага, энэн дотроосоо бид хуулинд зохицсон шийдвэр гаргах учиртай. Шаардлагатай бол наад тогтоолын шинэ төслийг хийгээд дахиж оруулж болох юм. Одоо бол дэгээ хэлэлцээд явъя. Сүүлд нь шинэчилсэн тогтоолыг өргөн барьсны дараа дарга танилцуулаад батлуулчихаж болох юм. Хуулийн дагуу л хийх юм. Тэрнээс биш тэр 12 хүн тэгсэн ингэсэн гэдэг бол Ардын Их Хурал нийт бурэлдэхүүнээрээ хэлэлцээд сууж байдаг асуудал арайхан биш байх л даа. Тэр сонгуулийн комиссын л шийдэх асуудал байх. Тогтоолоо л зөв гаргая, хуулийн дагуу л гаргая гэсэн уг. Депутатын бүрэн эрхийг түдгэлзүүлнэ гэж өрөөсөө байхгүй.

Ч.Тэрбийш /406 дугаар тойргийн депутат/-Тэгэхээр энэ байнгын комиссоос ч тэр, очигдэр хурал удирдаж байсан хурлын дарга, орлогч ч тэр түдгэлзүүлэх асуудлыг батлуулахын тулд аливаа гох дэгээ хийгээд байна гэж ойлгож байна. Хэрэв Жаргал даргад яг үнэн тооцвол очигдэр депутат Баяндалай хэлсэн. 12 хуудсыг хүчингүй гээд Цэн-Ойдовоос хасах юм бол 1486 гэдэг тооноосоо бас 12-ыг хасах ёстой шүү дээ. Яг ингээд хасаад харьцуулаад үзэхээр 50,3 байгаа юм. Тэгэхээр 50-иас дээш байгаа юм. Тэгэхээр энэ нь эвдрээд байгаа учраас л 1496-даа аваачиж хуваагаад зөрөөд яриад байх юм.

Нэгэнт боссон дээр би бас нэг санал хэлэхгүй бол болохгүй байна, хурлын даргад хандаж. Энэ микрофон дээр депутатууд очерлож уг хэлж байна. Таны хувьд бидэнд арай ялгавартай хандаад байх шиг санагдаж байна. Нэг, хоёр, гурав, дерев... гээд яг дугаараар нь яриулахын оронд аль нэгэн одоо эвсэл, холбооны дарга юм уу, эсвэл жаахан мэдэл, танил ихтэй хүн гарч ирвэл тэр хүн урьтаж уг хэлээд, бид орхигдоод байна. Жишээлбэл, одоо манайд депутат Ганбаяр /408 дугаар тойргийн депутат/ уг хэлэх гэсэн, та санал авах гэж байна гээд таслаад зогссон, удийн өмнөх хуралдаанд, тэгсэн дараа нь Очирбат дарга босож

3.

ирээд маш удаан уг хэлсэн, хөдөөний бараг IО-аад депутат байж байхад ерөнхий зүйл хэлэхгүй, зүйл нэг бүр дээр санал хэлнэ гээд санал халуулэлгүй бүгдийг нь суулгасан та. Тэгсэн дараа нь Очирбат дарга II дүгээр зүйлийн дөрвийг бүрэн дуусгаад тавд нь орж хуртэл санал хэлсэн. Мөн хоёрын "е" гэдэг саналаар Элбэгдорж бараг IО-аад удаа бослоо. Гэтэл бидний баталсан дэгд бол нэг зүйл дээр гурван л удаа босно гэж байгаа. Ийм илүү дархан эрхтэй зарим депутатууд байгаад байгаа нь харамсалтай байна.

Ж.Уртнасан -Баярлалаа. Таны шүүмжлэлийг анхааралдаа авъя.

Ч.Цэрэндагва /257 дугаар тойргийн депутат/ -Миний хувьд өчигдрийн гаргасан шийдвэрийг хуульд нийцээгүй шийдвэр гарлаа гэж үзэж байгаа депутатын нэг байгаа юм. Ямар учраас тэр вэ гэхээр сая хэллээ. Уул хэлэлцэн гол асуудал бол депутатын бүрэн эрхийн тухай асуудал биш, сонгууль хүчинтэй, хүчингүй тухай асуудал байсан. Тэгэхээр хоёр тохиолдолд сонгуулийг хүчингүй гэж үзэж болох байна.

Нэгдүгээр тохиолдол сонгууль явуулсан хувь нь зохих сонгуулийг хүчинтэйд тооцох хувьдаа хүрэхгүй бол, хоёр дахь тохиолдол нь сонгуульд оролцсон хоёр хүний аль аль нь 50 хувь хуртэл санал авч чадаагүй, энэ хоёр тохиолдолд л сонгуулийг хүчингүй гэж үзэх ийм боломжтой байгаа юм. Гэтэл сонгуулийг явуулсан байдлаас үзэхэд тэр I2 хүнийг хаслаа гэхэд, сонгуульд оролцсон сонгогчдын тоо бол сонгуулийг хүчинтэй гэж үзэх тоондоо хувьдаа хурч байгаа.

Хоёр дахь шалтгаан нь аль аль нь 50 хувь авч уу угүй юу гэдэг дээр маргаантай байх шиг байгаа юм. Хэрэв тэр I2 хүнийг хүчингүй хуудас гэж үзэх үндэс байхгүй. Яагаад гэвэл хуудас нь хүчинтэй, цаана нь саналаа өгсөн сонгогч байгаа. Бүрэн эрхийнхээ дагуу саналаа өгсөн сонгогч байгаа. Тэр сонгогчийн хуудас бол сонгуулийн хуулинд зааснаар хүчинтэй байгаа.

Зүгээр харин урьдчилж саналаа илээр өгсөн, урьдчилж өгсөн байна, энэ нь дурмэнд нийцэхгүй гэж узэж байгаа бол санал өгсөн хүний тооноос энэ 12 хүнийг хасаж тооцож болно. Сонгуульд оролцогчдын тооноос хасаж узэж болно. Энэ тохиолдолд хувь нь хурч байгаа юм. Тэгэхлээр би энийг өчигдөр арай яараад, жаахан хуульд нийцэхгүй шийдвэр гаргачихав уу даа гэсэн энэ талд нь байгаа учраас энийг бас дахин тайлбарлаж хэлэхийг хүсч байна.

С.Зориг /9 дүгээр тойргийн депутат/ -Яахав энэ удаан маргалдаж байгаа явдал бол гол нь юунд оршиж байна вэ гэхээр хуулинд зохицуулагдаагүй тийм узэгдэл гарсан байна л даа. Жишээ нь юу вэ гэхээр, өнгөрсөн жилийн Их Хурлын чуулганаар, хуралдаанаар бүрэн эрхийг нь баталгаажуулсан хүн төрний дараачийн сонгуулийн хувьд ийм маргаантай асуудал гарч ирэхэд тэрийг яж шийдвэрлэх вэ гэдгийг хуулинд өрөөсөө заагаагүй байгаа юм. Тийм учраас ийм маргаан гараг нь мэдээжийн асуудал. Тэгэхээр энэн дээр энийг зохицуулах ганц арга юу вэ гэхээр энэнтэй холбогдуулж тусад нь нэг удаа үйлчлэх тийм нэг хууль гаргадаг юм уу, тэгж байж засна гэхээс, хуулинд заагаагүй юмыг өөр аргаар заах арга байхгүй.

Хоёрдугаарт, энэ юуг харуулж байна вэ гэхээр манай сонгуулийн хууль маань түрүүчийн их боловсронгуй бус байгаа байдлыг харуулж байна. Жишээ нь нэг хүний сонгуулийг би ингээд сүйтгэхийн тулд одоо аль нэг аймагт очоод, бур холын нэг оторт явж байсан хэдэн малчинд очоод за та нар энэ бол миний дайсан юм байгаа юм, та нар одоо жилийн өмнө сонгуулийг бид нараас ил авсан гээд хэлчих гэж ятгачихаад тэд нар гаргачих юм бол одоо энд суугаа депутатын алийг нь ч огцруулж болж байна. Саяын заалтаар, бүрэн эрхийг нь татгалзуулах бол тийм бололцоо бол амархан шүү дээ. Ялангуяа жишээ нь жаахан сахилга муутай хүмүүст би мянга мянган төгрөг өгөөд энэ нөхрийн эсрэг ингээд хэлчих тиймээ тэр үед. Тэгвэл одоо энэ 427 депутат бүгдээрээ огцорч болно. Тийм учраас энэ чинь хууль боловсронгуй бусаас болж байгаа юмнаас биш, тэгээд ч тодорхой энд 12 хүн зөв уу буруу юу гэдэгдээ биш байхгүй юу.

Ц.Энхбат /23 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр энэн дээр сая Зориг депутат ярилаа. Тэгэхдээ энэн дээр би санал нийлэхгүй байна. Энэ зүгээр нэг 12 хүний тавьж байгаа асуудал биш. Энэний мөрөөр өчигдөр Жаргал дарга тодорхой ярьсан. Прокурорын шалгалт хийлгэсэн байгаа. Бид нар хуулийнхаа байгууллагад итгэхгүй тийм үндэслэл байхгүй. Бид нар дахиад эндээс комиссоос хүн явуулсан. Оchoод уулзалт хийсэн, ярьсан. Гэтэл тэрэнд бас адилхан дүн гараад байгаа. Тэгэхээр бид нар нэгэнт хуулийн байгууллагаар шалгасан энэ дүнг өнөөдөр одоо буруу юм ч гэдэг юм уу, нэг хэдэн хүний асуудал ч юм уу, энийг яримааргүй байна. Тэгэхээр энэ хуулийн байгууллагаар тогтоогдсон асуудал. Хуулийг зөрчсөн байна. БНМАУ-ын сонгуулийн тухай хуулийг төд, төддүгээр заалтаар нь зөрчсөн байна гэдэг хуулийн нотолгоо байж байгаа. Одоо Жаргал дарга дээр прокурорын гаргасан мэдэгдэл, бүх материал нь бий. Ер нь танилцуулах хэрэггүй гэсэн үүднээс манай комисс оруулаагүй юм. Зүгээр энэнд шалгалт хийгдсэн гээд ингээд өнгөрсөн. Тэгэхээр хэрэгцээтэй гэж үзэж байгаа, энэн дээр одоо эргэлзэж байгаа хүмүүс байвал тэр прокурорын шалгалтын материалтай танилцааж болно. Танилцаад, тэрэн дээр дүгнэлт хийгээд тэгээд дараа нь энэ асуудлыг яримаар байна.

Ж.Уртнасан -За одоо ганцхан хүн үлдсэн байна, дерөвдүгээр микрофоныг сонсоод энэ асуудлыг тасалъя.

Л.Болд /49 дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр энэн дээр хуулиа дээдэлье гэдэг санааг дэмжиж байна. Тэгэхдээ энд бол сонгуулийн хуулийг зөрчсөн мэт харагдаж байгаа боловч цаана нь эцсийн эцэст бид бухний дээдлэн мөрдөх ёстой Үндсэн хуулийг зөрчсөн тохиолдол байхгүй юм шиг харагдаж байна. Өөрөөр хэлбэл тухайн сонгогчдын сонгох эрхийг хангажээ. Ингэхээр нэгэнт Үндсэн хуулийн заалтыг мөрдүүлэхийн тулд тодорхой нэг хуулийг зөрчих тохиолдол хүртэл гардаг. Тийм зөрчил бий болоход. Тэгэхээр энэний цаана эцсийн эцэст Үндсэн хуулийн дагуу явагдсан байна гэдэг үндсэн дээр бол дахин авч үзэх тийм бүрэн үндэстэй юм гэж бодогдож байна.

Ш.Гурбазар /167 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр энэ бол бас нэгэн талын цаг сунжирсан асуудал үүссэн хэрэг мэт боловч нэгэн талын би эргээд бодохоор их чухал зүйл юм. Үнэхээр бид зөв шийдвэр хийсэн үү, буруу шийдвэр гаргасан уу? Ардын Их Хурал ямар мэргэнээр энэ хуралдаанаа эхлэх гэж байна вэ гэдгээ хоёр сая ард түмэнд өчигдөр өглөө харуулсан. Тэгэхээр энийг ард түмэн энэ хэдийгээр хүнлэг талаасаа ч шуугиж л байгаа, зарим нь зөв гэж байгаа байх, зарим нь буруу гэж байгаа байх. Яг энэ танхимд болж байгаа шиг болж байгаа. Харин би түрүүн Баяр депутатын хэлсэнтэй санал нийлж байна. Би авах авахгүй, тэр хуулийн эсрэг эсрэггүйгий нь би мэдэхгүй байна. Хамгийн гол нь ноднин бид нар бүрэн эрхийг нь Ардын Их Хурлаараа баталчихсан бол хуулийн тэр факт баримт нь тэryүгээрээ л үүдэж гарах ёстой байдаг болов уу. Энд бол их эмзэг юм байна.

Тэгэхээр ямарваа нэгэн үнэнийг тодруулахад бид нар 0,1-ийн нарийвчлалтай ярьж эхэллээ. Энэ бол энэ удаагийн Ардын Их Хурлын чуулганы маш их амжилт эхэллээ гэж бодож байна. Бусад юмыг ч гэсэн ийм л нарийвчлалаар бид ярилцах болно.

Ж.Уртнасан -Баярлалаа. Тэгэхээр одоо дэгэндээ орохын тулд бид саналаа нэг солилцоод энэ асуудлыг нээлттэй үлдээе гэдэг ийм бодол байна. Яагаад вэ гэхээр хууль зөрчсөн гэдэг хууль эрхийн акт нэгдүгээрт бас бүрэн бүрэлдлээ гэж узэхэд учир дутагдалтай юм. Хоёрдугаарт, бид очигдөр 51, I хувийн санал хураалтаар энэ тогтоолыг баталсан. Тэгэхдээ энэ маань бас өөрөө хууль зөрчиж байна. Үнэхээр сая Баяр депутат хэллээ. Депутатын бүрэн эрхийг Ардын Их Хурлын хуралдаанаас түдгэлзуулдэг тийм хууль бидэнд байхгүй гэж. Тэгэхээр бид бас хуулиас гадуур юм хийчихээд байна. Ийм учраас манай хуулийн зөвлөхүүд дахин авч узье. Нээлттэй үлдээе гэдэг ийм санал бидэнд тавьсан юм. Ингээд өөрөөр хэлбэл цөөнхийн саналаар гэхүү, бид хууль зөрчиж тогтоол гаргах гээд байгаа учраас дахин та бүгдийн сонорт хургэсэн юм. Тэгэхээр өнөөдөр бид энийг бас шийдэхэд учир дутагдалтай байна. Хуулийн зөвлөхүүдэд энэн дээр дахин ажиллах хугацаа олгоё. Үүнийг өнөөдөртөө нээлттэй орхиод дэгээ хэлэлцэх асуудалд

оръё.

За бид II дугээр зүйлийн тавдугаар заалтын "г" хэсгийг ярилцаж байсан. Тэгэхээр энэн дээр бид дахин сануулж. Депутат Элбэгдорж, депутат Баярцогт нарын санал бол зарчмын ач холбогдолтой гэж бид бас узэж байгаа юм. Бид цөөнхийн саналыг харгалзаад нэрсээр санал хураана гэдгийг энэ заалт дээр оруулах уу угий юу гэдэг дээр дахин санал хураалт явуулах болов уу гэж бодож байна.

Ц.Альясурэн /55 дугаар тойргийн депутат/ -Би түрүүний тэр, сая бид нарыг их завсарлага болох үед тэр хураалгасан саналд цөөнх нь болоод хоцорчихсон хүн юм байгаа юм. Ийм учраас цөөнх болохоороо саналаа хэлье гэж бодож байна. Энэ 10 дугаар зүйлийн "е" заалт их ач холбогдолтой юм байгаа юм. Энийг бид нар бас жаахан ойлгомоор байгаа юм. Яагаад гэвэл бид нар тэр тойргийнхоо хичнээн мянга ч байдаг юм хөдөлмөрчдийн өмнө түүхэн хариуцлага хулээж байгаа хүмүүс, тийм учраас энэн дээр бид нар буруудсан ч зөвдсөн ч гэсэн тэрэн дээр нэрээ ямар нэгэн хэмжээгээр улдээх ёстой. Түүхийн өмнө бид нар буруудвал буруудж, зөвдвел зөвдье, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энд депутатын асуудалд хандах хариуцлага ч бас дээшлэх ёстой юм байгаа юм. Ийм учраас тэр депутатын ердийн олонхийн саналаар гэдгийг түрүүн яагаад дийлсэнгүй, ийм учраас энэн дээр ердийн олонхиор мэдээж хурч чадахгүй юм шиг байна. Ийм болохоор тодорхой тоо байх нь зүйтэй юм байна. Ингээд 40 депутатын саналаар хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалzan саналыг депутатын нэрийн жагсаалтаар авч болно гэсэн санал оруулж. 40-ees доошгүй депутатын саналаар гэж оруулмаар байна. Яагаад вэ гэхээр бид нар энэнээс олон депутатын санал авч чадахгүй байж магадгүй л дээ. Энд бол их ач холбогдолтой юм, энийг бас та бүхэн болгоож узээд дахин энэн дээр санал хурааж өгнө уу гэсэн ийм саналтай байна.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Д.Алтанцэцэл

Д.АЛТАНЦЭЦЭЛ

Бичээч Уранчимэг

1991.II.12

Кассет-56

15.45-16.00

387 дугаар тойргийн депутат Энхсайхан:

Энэ II дүгээр зүйлийг хэлэлцэж байхад энэ дараалал давхардсан санаа хоёр дээр бид толгой эргээд сүүлдээ ер нь хэрэгтэй юмаа хасч, хэрэггүйгий нь үлдээчихэж болмоор болов уу бодож байна. Ингээд энэ дээр зарчмын З санал байна.

II дүгээр зүйл ер нь З дугаар зүйлд байгаа анхны буюу эцсийн гэсэн энэ хоёр дээрээс 3,4,5,6 дугаар зүйлүүд үүнтэйгээ холбогдсон ийм зүйл байж. Анхны гэдэг нь бол энэ үйл ажиллагааг 4 дүгээр зүйлд хэлэхээр байж, эцсийнх гэдгийг 5,6 дугаар зүйлд заагдсан зүйл байж. Энэ нь санаа давхардаад, толгой эргэлээ. Энэ дээр II дүгээр зүйлийнхээ З-аас эхлээд, энэ зарим дарааллыг солих юм бол үлдсэн санаа бол, зарчмын санаа байхгүй, зарим дарааллуудыг ийш тийш нь оруулчих юм бол их эвтэйхэн болох юм биш байгаа гэсэн ийм саналтай байна.

Тухайлбал, З дугаар зүйлийн "а"-д анхны гэж байна. Үүнд зарчмын гол гол асуудлуудыг ярилцаж шийдэх гэсэн. Үнэндээ 4-ийн "б"-г авчирч оруулмаар байна. "в" заалтанц бол уг өгүүлбэр, найруулгын зүйл тус бүрээр, найруулгыг зүйл тус бүрээр хэлэлцэх, үүнд 5-ын "г"-г авчирч оруулмаар байна. Үүнд "в" заалттай болгомоор байна. "в" заалтанц нь юу байна вэ гэвэл депутатын санал дүгнэлтийг нам, хороод, ажлын хэсэг хамтран боловсруулж, мэдээллийг хийж боловсруулах гэсэн. Энэ бол 5-ын "д" байгаа. Ийм З зүйлийг нэргэснээр оруулж өгөөд хойшдоо хэлэлцээд явах юм бол болох юм биш байгаа. Би өөрийнхөө хувилбарыг ажлын хэсэгт өгсөн. Ингээд байрлалыг нь солиод явчих юм бол зарим зүйлүүд хасагдмааргүй юм шиг байна.

4 дүгээр зүйл дээр ерөөсөө хэлэлцүүлгийг дээрхи хэлэлцүүлэг бол I, 2, 3 дугаар зүйлийг өрөнхий хэлэлцэх зарчим бол ижил шүүдээ, бух юманд. Анхны ч байсан, сүүлийнх ч байсан, дундах ч байсан тийм өөр зарчмаар хэлэлцэнэ гэсэн юм байхгүй.

Ийм учраас 4 дүгээр зүйл дээр дээрх З зүйлийг хэлэлцэж ерөнхий зарчмаа, 5 дугаар зүйлд бол санал зөрөлдсөн асуудлыг яаж шийдэх вэ гэдэг зүйлүүдийг 5 дугаар зүйл дээр авчраад, 5-д 6-г оруулмаар байна. Тэгээд 6 дугаар зүйлийг бур хасчихмаар байна. Ингээд эцэст нь 7 дугаар зүйлийг 6 дугаар зүйл болгоод, ярилцаж байгаад редакций нийт өрхээ өгөөд II дүгээр зүйлийг дунгээр нь баталбал яадаг юм бэ? Үүн дээр цөмөөрөө хамтарч үзмээр байна л даа. Хэлж яриад байхад энэ бүгдийг ажлын хэсэг бол бидний энэ хэлж байгааг толгойдоо багтааж бидэнд эргээд юм болгоно гэхэд хүнд юм уу гэсэн ийм санал байна.

Эцэст нь нэг санал байна. Энэ дээр депутат хүн бол хэлсэн уг, хийсэн хэргийнхээ төлөө хариуцлага хулээхэд хаана ч бэлэн байдаг байх. Ер нь бид энэ төрийн төлөөлөгч болчихоод, бага ангийн хүүхэд ч шиг, тэр депутат суудал дээрээ суухгүй байна, түүнийг оруулж ирээч гээд хурлын дарга товлоод, ийм юмаар хөөцөлдөөд ингэж байдгийг болимоор юм. Гэсэн санал байна.

54 дүгээр тойргийн депутат Б.Гомборагчаа:

Энд дандаа түрүүчийнхээ хэлэлцэж ярьсан юмыг буцаж эргээд байна. Тэгэхээр энэ дээр энэ төслийг боловсруулсан энэ дэг дээр ингэж байгаа юм чинь Үндсэн хууль дээр ингэх юм бол бур хэдүү. Энэ саяал хэлж байгаа, үүнийг боловсруулах, тухайлбал түрүүн тэр хэлэлцээд, санал хураасны дараа нь саналаа гаргаж хэлээд байх юм. Энэ боловсруулсан юмыг чинь бид бол боловсруулсан хүний хэмжээг мэдэхгүй. Тийм учраас л ийм зөрүү, зөрүү санал гараад байна. Ийм маргаантай юман дээр боловсруулсан юм уу? Үүнийг биднээс илүү мэдэж байгаа нь тайлбараа хэлчихмээр байгаа юм. Жишээ нь Баяр эхлээд тэнд хэлэлцээн бол тэр ажлын хэсэг гэдэг дээр ямар санал гарах байсан ухаан нь. Ийм учраас энэ болоод өнгөрсөн юм уу, санал хураалтын дараа гараад, эргэж буцаж явсаар байтал энэ чинь аль ч биш болмоор байна.

Тийм учраас юу гэж хэлэх гэж байна вэ гэвэл боловсруулсан улсуудын саналыг энэ маргаантай юман дээр эхлээд агуулгыг нь сонсмоор байна. Түүнээс биш энэ өгүүлбэр нэг бурийг тэр болгон

мэдэхгүй байна шүү дээ. Ийм маягаар Үндсэн хууль явах юм бол бас эргэж буцсан юм болоод байна. Энэ чинь дахиад түрүүчийн-хээ хэлэлцэн юм руу дахиад эргээд орчихлоо шүү дээ. Ийм л санал байна.

Ж.Уртнасан: Бид ер нь зарчмын хувьд эргэж буцахгүй гэдэг зарчмаа барьж байгаа шүү дээ. Тийм учраас заалт бүрээрээ авч хэлэлцье, зүйл дотроо заалт заалтаараа авч яръя гээд явж байгаа шүү дээ.

107 дугаар тойргийн депутат Л.Баяндалай:

Тэгэхээр бид өчигдөр хамгийн эхний заалтан дээрбаталсан. Бух асуудлыг чөлөөтэй хэлэлцээд, олонхийн саналаар шийднэ гээд. Энэ чинь ерөөсөө ардчилсан, хамтын гол удирдлагын зарчим байх байх. Гэтэл өнөөдөр үүнээсээ эргэж няцсан янз бурийн юм гаргаж ирж ярьж байна. 40 депутат л санал хэлчихвэл зарим асуудал шийдэгдэж байх бололтой. Ингэж болохгүй байхаа. Бид хуралдааны дэг гээд гол нь яриад байгаа ганц дэг маань л тэр байх болов уу? Түүнээс наана ийм олон асуудлаар бид нарыг дэглэх гээд яах юм бэ? Яах вэ дэггүйчүүд олон байна гэж үзээд дэглэх гээд байгаа байх. Ноднин бид дэг баталж үзсэн. Баталж гэж хэлэлцэж үзсэн. Баталж чадаагүй шүү дээ. Хоёрын хооронд хагас дутуу дэгтэй ороод түүнийгээ баталж чадаагүй, баталж чадаагүй байж байгаад тарсан. Тэгэхээр аливаа асуудлыг урьдчилж ингэж нарийн дэглэнэ гээд байгаа чинь нөгөө ардчиллаа эргэж зөрчих гээд байна. Их Хурлын депутатын хувьд би энэ хурал дээр ямар ч асуудлыг гаргаад, хэлэлцүүлэх эрхтэй, хэлэлцэх, санал хураахыг шаардах эрхтэй гэж ойлгож байгаа. Сонгогчдынхoo нэрийн өмнөөс.

Өнгөрсөн жилийн сургамж бидэнд байна. Дэгээ батлах гэж их цаг иддэг. Тэр дэг баталчихаараа суулдээ явцын дундуур уян хатан хандмаар янз бурийн асуудал гараад ирдэг. Гэтэл нөгөө дэгэн дээр тийм байгаа шүү дээ гээд, ерөөсөө асуудлыг сайхан уян хатан бололцоотой үед нь, тухайн үед авч үзмээр байна.

Хоёрдугаарт, энэ дэгийг баталлаа ч гэсэн явцын дундуур бид өөрчилж чадна. Бид ямар ч хуулийн заалтыг аваад өөрчилж чадах эрхтэй сууж байгаа улс чинь, өөрсдийнхөө баталсан нэг дэгийг өөрчлөх эрхтэй шүү дээ. Тэгэхээр энэ дэг дээр эцсийн эцэст би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр энэ дээр ингэж их цаг идэж их нарийвчилж ярилщаад яах юм бэ? одоо асуудлын гол нь тодорхой гарчихлаа, үлдэж байгаа хэсгий нь бөөнөөр нь баталчихаад, дараагийнхаа ажилд оръё. Энэ дээр зарчмын бус асуудал дээр маргалдмааргүй байна.

Ж.Уртнасан: Бид дэгтэй, журамтай байхын тулд дэгээ хэлэлцэж байгаа гэж би ойлгож байгаа.

407 дугаар тойргийн депутат Б.Нүүрэй:

Тэгэхээр би энэ санал гэдэг энэ техникийн системийн талаар үүний программын талаар яримаар байна. Нэгэнт хумуусууд асуудал бүрээр санал хурааж байгаа юм чинь энэ компьютер дээр хатуу дискэн дээр нь юм уу, эсвэл зеэлэн дискэн дээр нь дээр нь бүх саналын зөвшөөрсөн, татгалзсан, тудгэлзсан тэгээд санал өгөөгүй хумуусууд бичигдэж байх ёстой, нэrsийн дэс дараагаар.

Ж.Уртнасан: Байгаа, бичигдэж байгаа.

Нүүрэй: Тийм учраас тэр нэrsийн жагсаалтаар авна гэдэг заалтыг тэртэй, тэргүй энд байх шаардлага байхгүй. Яагаад гэвэл түүнийг дахин эргээд хэдий чед нь ч гэсэн эргүүлээд түүнийг хэвлээд принтер дээр гаргаад үзүүлэх, харах үзэх тийм боломж байх ёстой.

Тийм учраас тэр IО дугаар зүйлийн нэrsийн жагсаалтаар гэдэг заалтан дээр санал хурааж авна гээд үлдээчих хэрэгтэй. Саяны тэр II дүгээр зүйлийг ч гэсэн нэrsийн жагсаалтаар авна гэж заавал тодруулж оруулах шаардлагагүй.

Харин II дүгээр зүйлийн "г" дээр хугацааг, депутатуудын олонхийн саналаар батална гэж суулд нь тийм, иймэрхүү хэлбэрээр өрөөсөө дэгийнхээ санал хураалтын асуудлыг ингэж тогтох шийдвэр байна.

Харин тэр программын талаар тэнд программыг өөрчилж болно, хүн дураараа тэнд үзэж харж болно, түүний баталгааг, нууцыг хадгалсан баталгааг хянасан, баталгааг найдвартай болгосон тийм хамгаалалт байх ёстой, программын хувьд Техникийн системийн хувьд ч гэсэн гадны ямар нэгэн томъёолол, сигнал орж ирж саналын хураалтыг будилцантуулдаггүй тийм хамгаалалт байх ёстой. Уүнийг харин Их Хурлын депутатууд системийн талын ажилчдад танилцуулж өгөх ёстой юм.

II дүгээр тойргийн депутат Ж.Бямбаа:

Их Хурлын дарга ч гэсэн, депутат бид нар ч гэсэн, цөмөөрөө ийм юм бодоцгооё. Нэг нь босч ирээд урьд нь ялангуяа тэр саяны яриад байгаа 10 дугаар зүйлийн тэр хэсгийг чинь бид 2-3 дахиад санал хурааж байж баталсан шуу дээ. Тэгээд баталж, хэлэлцээд өнгөрсөн юмаа эргээд нэг нь босч ирээд ярихаар, дарга ч түүнийг нь яриулаад байгаад байдаг, хэлэлцээд баталсан юмыг баталсан шуу дээ гэдгийгээ хэлээд дараагийнхаа асуудал руу орж явмаар байна. Бид ч гэсэн энэ хэлэлцэж байгаа юмаа анхаарч цөмөөрөө сууж байгаа юм бол хэлэлцээд, батлаад, санал өгөөд, олонхийн саналаар шийдвичихсэн юмаа эргэж ярьж байх хэрэг алга.

Ингээд мөн ноднингийнх шиг 2-3 хоног нэг дэгтэйгээ ноцдолдох болж байна шуу дээ. Бид бол хоолны өмнө 5 дугаар зүйлийг хэлэлцээд, "г" дээр зогсчихсон байгаа. Ингээд "г"-гээсээ өхлээд цаашаа явах байтал урьд нь шийдвичихсэн юмуудаа эргэж яриад байгаа нь ингэж бантан хутгаад байх юм бол энэ хурал чинь хичнээн өдөр үргэлжлэх юм бэ? тэр сонгогчид чинь биднийг юу гэж үзэх юм бэ? Ийм учраас би 5 дугаар зүйлийн "г" дээр саналаа хэлмээр байна.

урьдах нь бол ойлгомжтой, бид нар "б,в"-г бас санал хураагаад хасчихсан шүү дээ."г" дээр, энэ "г" бол өрөөсөө их ойлгомжгүй болсон байна. Эцсийн хэлэлцүүлэгт Их цаазын төслийг зүйл бүрээр, хэрэв саналын зөрүүгүй бүлэг, дэд булгээр нь хэлэлцэж гээд, өрөөсөө энэ ойлгомжгүй өгүүлбэр болчихсон байна. Үүнийг ингэж найруулбал ясан юм бэ өгсэн саналтай байна

"Их цаазын төслийг эцсийн боловсруулалтаар хэлэлцэхдээ бүлэг, дэд бүлэг, зүйл ангиар нь хэлэлцэн батална" гээд зөрүүгүй гэвэл зөрүүтэй юм тэртэй, тэргүй гарч ирнэ шүү дээ, ийм учраас тэр санал хураалтаараа явуулаад, хурлын дарга удирдаад явуулчина биз.

Дараагийн зүйл дээр гэхээр тэр "д"-г хасах нь зүйтэй юм уу гэж бодож байна. Яагаад гэвэл нэгэнт тэр төслийг чинь ингээд төдийд оруулаад ир гээд хэлчих учраас үүнийг заавал дэг дотор маргааш оруул, негеөдөр оруул, өнөөдөр оруул гэж байх нь юу байна вэ? Бид чинь юмаа шуурхайлах л учраас аль болохоор л хурдан хийгээд оруулах бол, маргааш оруулж хэлэлцүүлнэ гээд шийдсэн ч, өнөөдөр боловсруулаад, дуусчихвал бид өнөө орой л хэлэлцэх ёстой шүү дээ. Ийм юм байх юм.


Харин тэр 6 дугаар хэсэг нь байна. 6-д бол тэгвэл зургаагаа болих уу?

52 дугаар тойргийн депутат Э.Бат-Уул: Нэрсийн жагсаалтаар санал авах тухай асуудал бол депутатуудын түүхийн өмнө хүлээх хариуцлагатай холбож яригдаж байгаа гэж түрүүн нэг депутат хэлсэн. Тэгэхээр бид нарын түүхийн өмнө хүлээх хариуцлага гэдэг чинь түүхсээд байх ч юм байхгүй, бид нар энэ удаагийн Ардын Их Хурлын чуулганаар болчимгүй алхам хийх юм бол З сард мэдэгднэ. Ер нь ямар тэнэт алхам хийснээ. Тийм юм хийгдэх ч янзтай байгаа. Тэгэхээр энэ дээр яг ийм хариуцлагын асуудал ярьж байхад, хурлын дарга, сая бас нэг депутат ч яриадах лаа, бас нэг хариуцлагагүй юм ярьсан.

Юу вэ гэхээр принтерт байгаа нэрийг чинь л гаргачихна шүү дээ. Тийм биш шүү. Түүхийн хариуцлагын асуудал бол тэгж принтерт байгаа нэрээр явагддаггүй. Тэгээд ч ардын Их Хурал дээр депутатын өгсөн саналыг нууцлах нэг асуудал бий, ^{ил} гаргах, албан ёсоор зарлах нэг асуудал байгаа юм. Тэгэхээр нэrsийн жагсаалтаар гэдэг нь бол тэр албан ёсоор, ил ард ^{тумэнд} зарлахыг хэлж байгаа байхаа. Хамгийн гол нь. Уүнийгээ ойлгооч ээ. Тэгээд би бас дараа нь 4 сард сонгогчдынхоо өмнө ямар хариуцлагагүй алхам хийснээ бас мэдэрмээр байна. Манай сонгогчид түүнийг маань хармаар байна. Үнэхээр энэ чинь ямар хариуцлагагүй алхам хийсэн юм бэ гэдгийг, тийм асуудал энэ удаагийн Ардын Их Хурлын чуулганыар дэндуу их хэлэлцэгдэх учраас, нэрсээр гэдэг бол зарчмын асуудал шүү. Энэ бол цэвэр улс төрийн шинжтэй асуудал гэдгийг уртнасан дарга анхаарах байх. Тэгээд одоо таны хэлснээс болоод энэ чинь нууцаар санал хураасан юмны, нууц нь баталгаатай хадгалагдах уу? үгүй юу гэдэг баталгаа байхгүй болчихлоо шүү дээ. Узэмжээрээ принтерээс гаргаад ирж болох нь байна шүү дээ, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нэгтэй депутат чинь 4 сард би тэр суудалд чинь байгаагүй юмаа, тэр машин чинь худлаа ярьчихаж гээд залаад байж мэднэ шүү дээ, тийм учраас энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн



Д.ЧУЛУУНШИРЭГ

1991.XI.12
Кассет № 57
16.00-16.15

135

С.Лхагвасүрэн/14-р тойргийн депутат/ -Үндсэндээ
Бат-Үүл депутатын хэлсэнтэй санал нэг байна. Нэрсээр санал
хураах гэдгийг би албан ёсоор бичгээр санал авахыг хэлж
байна гэж бодож байна. Тийм учраас принтер дээр гарсан
зүйлийг нууцлах юмыг нь нууцлана. Үүнтэй холбогдуулж нэг
зүйлийг хэлэхэд бид үдээс хойш хуралдаад нэг ч өгүүлбэр
баталсангүй. Хэрэв энэ маягаар байвал маргааш дэгийн асуудал
дуусахгүй нээ. Түргэхэн шиг дэгийнхээ асуудлыг батлаад
явмаар байна.

Б.Лханаасүрэн/191-р тойргийн депутат/ -Бид зарчмын
асуудлаа тогтох хэрэгтэй. Үүн дээр мэдээж Үндсэн хуулиа
бид нэрсээр хураана. Энэ нь зайлшгүй асуудал учраас үүн
бурийн түүхийн өмнө хүлээлгэх хариуцлага гэдэг нь үнэн
юм. Гэхдээ үүн дээрээ тохирж авья. Нэrsийн жагсаалтаар
хураана гэдгээ цахим тоолуураар бичиж гаргах дунг тооцох
уу, эсвэл бүгдээрээ Үндсэн хууль гэдэг юм уу, Их цааз ч
юм уу гэдгээ бичээд, түүнийг зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй гэсэн
бичигтэй хуудсаар хураах уу? Энэ нь зарчмын асуудал юм.
Цахим тоолуураар бичээд гаргаад ирнэ. Тэрийг тооцох уу гэд-
гээ тогтох авахгүй бол бид нэрсээр хурааж батлана гэж яриад
байна.

Зүйл, булэг бүрээр хэлэлцэх нь зайлшгүй. Гэхдээ
үүн дээр бичигдсэнээр өцсийн хэлэлцүүлэгт Их цаазын төслийг
зүйл бүрээр гэдгийг зүйл, булэг бүрээр хэлэлцэж батлана гэж
оруулах саналтай байна.

Зүйл, булэг бүрээр хэлэлцэж батлахихдад дараа нь бухэлд
нь хэлэлцэж батлана. Энэ нь зайлшгүй учраас үүнийг мөн оруу-
лах хэрэгтэй. Хэсэг бүрээр батлаад, дуусчихлаар заангээд
баталчихлаа гэж хэлж таарахгүй байх. Тийм учраас нийт
депутатуудын нэrsийн жагсаалттай хуудас өгөөд, түүнийгээ
зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй гэдгээр албан ёсоор хураагаад,
тэр хуудас нь түүхийн баримт болж үлдэх юм. Үүнийг нэrsийн

жагсаалтаар хураана гэж нэрлэнэ. Түүнээс биш хүмүүсуудийн ярж байгаагаар үүнийг хэзээ ч гаргаж болно гэдгийг би хувьдаа зөвшөөрөхгүй. Энэ нь маш чухал асуудал юм.

Хүмүүсууд ярж байна л даа. 40 депутатын саналаар, нууцаар гэж байна. Тэхээр мэдээж Үндсэн хуулиа нэrsийн жагсаалтаар хурааж батлана гэдгийг эрхбиш депутатууд ойлгож байгаа биз дээ. Тиймээс ердийн олонхийн гэдгийг хасаад хэрэггүй. Хэрэв шаардлагатай бол бид санал хураагаад, ердийн олонхийн нэрсээр хураая гэж байгаа бол хураана шүү дээ. Үндсэн хуулийг нэрсээр хураана гэдэг нь ойлгомжтой юм.

Ж.Уртнасан -Саналуудыг анхааралдаа авч байна.

Редакцийн комисс ч та бүхний саналыг нэлээд нягт тэмдэглэж байгаа байх. Бид "Г" заалтын уг, өгүүлбэрийн найрлага учир дутагдалтай бичигдсэн гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Тийм учраас депутатын саналаар эцсийн хэлэлцүүлэгт. Их цаазын төслийг зүйл бүрээр хэлэлцэж гэдгээс хэлэлцэж гэсэн уг нэмсэн. Бидний нэлээд будлиж байгаа зүйл гэвэл Баатарцогт депутатын нэрээр санал хураана гэдгийг нэмж оруулах хэсэг байгаа юм. Тэхээр нэрээр санал хураая гэдгийг нэмж оруулья гэдэг дээр санал хураалт явуулмаар байна. Депутатуудаас сая саналууд гарч байна. 50 хувьтай байгаа шүү дээ. Тиймээс бид найдвартай болгохын тулд "Г" заалтаар дахин санал хураалт явуулъя гэж бодож байна.

Манай депутатууд "нууцаар"; "нэрээр" санал хураана, мөн ил санал хураалт явуулж ердийн олонхийн саналаар батлана гэдгийг сайн ойлгож байгаа байх гэж бодож байна. Энэ нь зарчмын ялгаатай зүйлүүд шүү дээ. Бид принтрийн асуудлыг энгийн санал хураалтын хэлбэр гэж бодож байна. Гэхдээ төхник ашиглаж байгаа л хэлбэр шүү дээ. Энэ нь ил санал хураалтын далд хэлбэр юм.

Санал хураалтандаа бэлтгэе. "Г" заалт дээр түрүүчийн депутатуудын хэлсэн... найруулгын хувьд манай редакцийн

3.

грушийг залруулж болох байх гэж бодож байна. Зарчмын санал нь нэрээр санал хураана гэдгийг нэмэх асуудал юм.

Нэрээр санал хураана гэдэг дээр санал хураалт явуулж. Нэрээр гэдэг нь түүхийн ач холбогдолтой гэдгийг депутатууд онцлох хэлээд байна. Ялангуяа Баярцогтын гаргасан санал нь зарчмын ач холбогдолтой юм гэдэг дээр бид тогтох байна. Тийм учраас "г" заалт дээр нэрээр санал хураана гэдгийг дэмжих байгаа депутатууд зөвшөөрсөн гэдгээ дарах болно. Одоо санал хураалт явуулах гэж байгаа учраас үүндээ бэлтгэе.

Баярлалаа, 219 депутат буюу 53 хувь нь нэрээр санал авна гэдгийг зөвшөөрч байна. 166 хүн буюу 40 хувь нь татгалзлаа. 21 хүн буюу 5 хувь тудгэлзэж байна.

Цааш нь II-р хуудасны "д" заалтын хэлэлчье. Энэ заалт дээр зарчмын санал Гараагүй. 3-р микрофоноос ярья.

Г.Дэндэв/20-р тойрог/ -"д" заалт дэгдээ анхны боловсруулсан төслөөр орох нь зүйтэй юм. Найрууллагын чанартай зүйл нэмж оруулвал зүгээр юм. Үүн дээр хороо, ажлын хэсгийн эцэслэх боловсруулсан Их цаазын төслийг хэлэлцүүлэхээр оруулах хугацаа гэж найруулвал зүгээр юм. Үүнийг хэн оруулах нь мэдэхдэхгүй, эзэнгүй байгаа юм. Тэхээр хороо, ажлын хэсэг эцэслэн боловсруулаад өгүүлбэрийг нь хэвээр нь үлдээх нь зүйтэй болов уу гэсэн саналтай байна.

Ж.Уртнасан -"д" заалтын эхний хэсгийн Их цаазын гэсэн үгийн өмнө хороо, ажлын хэсэг гэсэн үгийг нэмье гэж байгаа юм уу? Эзэнтэй болгож тодотгол хийе гэж тийм уу?

Ж.Даргахүү/271-р тойргийн депутат/ -Үүн дээр ганцхан санал байна. Их цаазын төслийг эцэслэн боловсруулж хэлэлцүүлэхээр оруулах хугацааг дарга тогтооно гэж байгаа дээр миний санал хамтын журмаар байх нь зүйтэй гэсэн бодлын үүднээс

хэлэлцэж тогтоох нь зүйтэй болов уу гэсэн санал байна.

Ж.Уртнасан -Бид "г" заалтын талаар санал хураалт явуулсан. Гэхдээ томъёоллыг редакцийн комисс хүндрэлтэй болж байна, гэж үзэж байгаа учраас депутат Баярын хэлэх угийг сонсъё.

С.Баяр/I-р тойргийн депутат/ -"г" заалт дээр нэрээр хурааж болно. Нэрээр хураахын эсрэг байгаа юм биш ээ. Гэхдээ Баярцогтын хэлснээр даргын санал хураасанаар Их цаазын төслийн зүйл бүрээр нэрээр хураах болчихлоо шүү дээ. Ингэж байх ач холбогдол, цаг завь нааана байна. Мөн цаас, боломж хаана байна. Хэрэв шаардлагатай гэж байгаа бол томъёоллоо өгөхгүй байж болохгүй шүү дээ. Тодорхой томъёолол юу байна. Түүнийгээ тодорхой томъёоллоор Ардын Их Хурлын даргаа, та тодорхой санал хураалгах гүй бол редакцийн комисст маш хүндрэлтэй болно. Нэн ялангуяа "г" заалт дээр. Нэрээр хураахыг эсэргүүцэж байгаа юм биш ээ. Бид ажиллагаагаа өөрсдөө, механикаар хүндрүүлэх үү, угүй юу гэдэг дээр байгаа юм.

Дахин давтан хэлэхэд би зарчмыг нь эсэргүүцээгүй. Үүн дээр хэрэв шаардлагатай гэж үзвэл тодорхой томъёолол баймаар байна. Депутатын төчнөөн хувийн зөвшөөрснөөр ч гэдэг юмуу, тийм зүйлийг наана нь шийдвэр гаргах механизмыг нь оруулж өгөхгүйгээр бух зүйлийг хэлэлцээд, нэрээр хураахаар орчихлоо шүү дээ.

Ж.Уртнасан -Баярын саналаар шаардлагатай гэж үзвэл гэсэн үг нэмвэл болох юм биш үү.

Ж.Бямбаа /II-р тойргийн депутат: -Ийм найруулага хиймээр байна. Би түрүүнд найрууллага хэлж байсан шүү дээ. Баярын саналтай энэ нь таарж байна. Их цаазын төслийг эцсийн боловсруулалтаар хэлэлцахдээ булэг, зүйл бүрээр хэлэлцэж, өрдийн, олонхийн саналаар буюу онцлог зүйл дээр нэрээр санал хурааж батлана гэж "г"-г найруульяа.

5.

Ж.Уртнасан - Онцлог гэдэг уг нь оносон уг биш юм. Хэрэв шаардлагатай гэж узвэл нэрээр санал хураана гэж яриад, редакц хийе.

"д" заалт дээр зарчмын өөр санал байна уу. Нэг депутат хороо, ажлын хэсэг гэсэн уг нэмж оруулж гэсэн. Ийм редакц хийгээд энэ заалтыг хэвээр үлдээх уу. Санал хураалт явуулахад бэлтгэе.

Баярлалаа, 89 хувь буюу санал өгсөн депутатуудын 339 хүн зөвшөөрч байна. 26 хүн татгалзлаа, 13 хүн түүгэлзэж байна.

Гүйцэтгэх

6-р зүйл дээрээ ярья. Бид "г" заалтыг батлачихсан шүү дээ. Гэхдээ шаардлагатай гэж узвэл гэсэн найрууллагын засвар хийхийг редакцдаа даалгасан гэж бодож байна. Хэрэв шаардлагатай гэж узвэл нэрээр хураана.

Л. Болд/ 49 -р тойргийн депутат/-Хурлын даргаа, бид шаардлагатай гэж узсэн булэг, зүйлээ тодорхойлох хэрэгтэй шүү дээ. Надад шаардлагагүй байж болно, танд шаардлагатай байж болно шүү дээ. Шаардлагатай, шаардлагагүй гэдгээ олонхийн саналаар тогтоох юм уу? Үүнийг таслах нэг хэмжигдэхүүн байх хэрэгтэй шүү дээ.

Ж.Уртнасан - Эрхэм депутат Болдоо, үүнийг бид ойлгож байна. Үнэхээр тийм юм. Түрүүнд нэг депутат санал гаргаж байсан. Бид 40 хүн гэдгийг ямар үндэслэлтэй, үндэслэл нь юу байна гэдэг дээр байгаа юм. Нэг депутат 40 хүн гэж хэлсэн шүү дээ. Тэхээр энэ нь хууль зүйн үндэслэлээр авч узехэд хэцүү байгаа юм. Хэрэв 30, 40 гэвэл ямар үндэслэл байгаа юм. Мөн 50 гэвэл ямар үндэслэл байгаа юм гэдэг дээр. Ердийн олонхийн гэсэн саналаар болох юм.

Ц.Элбэгдорж/427-р тойрог/ - Ямар нэгэн шалгуур байх ёстой шүү дээ. 10-ны I юм уу, аль эсвэл 30 хүн юм уу? 10-ны I гэвэл илхүү боломжтой болно. Хэрэв 300 хүн оролцож

байвал 30 хүн, 400 хүн оролцож байвал 40 хүн гэх.

Танхимаас: -Уүнийгээ тодруулж байж цааш нь явахгүй бол хэлэлцэж байх үед бид будлих байх.

Ж.Уртнасан - "г" заалт дээр санал хураалт дахин явуулъя. Гэхдээ нэг зүйлийг тодотгомоор байна. Хувиар, тоогоор заах уу гэсэн хоёр хувилбар байна. Эсвэл өрдийн олонхийн гэсэн бидний түгээмэл хэллэг байгаа.

? -Их хурлын дарга, депутат нөхөд өө! Уүн дээр ганцхан зүйл байгаа шүү дээ. Өчигдээр Элбэгдоржийн маргаад байсан дөрвөн үгийг хасна, хасахгүй гэж байсан. Тэр заалт дээр ерөнхий томъёолол нь байгаа шүү дээ. Депутатын өрдийн олонхийн саналаар хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан саналыг депутатын нэрийн жагсаалтаар авч болно гэсэн заалтыг бид батлахихсан. Дөрвөн үгийг хасаад өг гэсэн бид хасаагүй батлахихсан. Ердөө л ерөнхий зарчим энэ шүү дээ. Асуудлын шинж байдлыг харгалаана гэдэг нь Үндсэн 柙 цаазын энэ асуудал, зүйлийг олонхийн саналаар хэлэлцэх ёстой гээд бүлэг биш, би ганцаар санал гараад Их Хурлын депутатууддаа хэлэлцүүлж болно шүү дээ. Депутатуудын олонх нь Уүнийг нэrsийн жагсаалтаар хураах ёстой гэвэл хураагаад явна шүү дээ. Бид ийм асуудал дээр маргаад цаг алдаад байна.

Ц.Элбэгдорж - Тэр санал нь өрдийн олонх авсан нөхцөлд нэrsийн жагсаалалтаар хураахад гол нь байгаа шүү дээ. Та ганцаараа санал тавьж болно, тэр нь өрдийн олонх авахгүй байвал яах вэ? Тийм өндөр иворум байгаа юм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ц.Баярмаа Ц.БАЯРМАА

Бичээч

С.ТУУЛ

1991-XI-12
Кассета № 58
16.15-16-30

З дугаар микрофон 25-р тойргийн депутат Л.Энэбийш: -Тэгэхээр ер нь байна шүү дээ 10 %-иар тогтчихвол ясан юм бэ? 40 хүн гэсэн уг шүү дээ. Тэгээд тийм хүмүүс нэрээр санал хураах санал тавибал ер нь болбол энд нэрээр санал хураахад татгалзаад байх зүйл байхгүй юм шиг санагдаж байна. Энэ үнэхээр л нэрээрээ үлдэх л хэрэгтэй юм байвал үлдэнэ. 10 % буюу 40 хүн гэдэг юм уу тийм үндэслэл байна л даа. Тэрэн дээр санал хураагаад шийдвичвэл одоо энэ асуудал цаашаа явчихна.

235-р тойргийн депутат Ц.Өөлд:

Эрхэм депутат Энэбийшийн саналыг хүндэтгэж байна. Гэхдээ огт санал нийлэхгүй байна. Энэөдөр 10 %, 20 %, 30 % гээд тавихад энэ хувиудыг тавихад ямар ч шинжлэх ухааны үндэслэл байхгүй. Тийм учраас ямар нэгэн хувь тавилаа гэж үзээд үзэхийн хэрэг байхгүй. Хэрвээ нэрээр хураалгах шаардлага гарвал тэр хүн нэрээр хураалгая гэсэн шаардлагатай зарчмынхаа асуудлыг саналаа гаргаад тэр хүн 420 депутатaa сэнхруулж чадвал өөрийнхөө саналыг нэрээр хураалгах саналаа аваг аа. Тийм учраас тэр одоо Е заалтын дагуу тэр чинь нэрээр хураах бололцоонд байж байгаа, энүүнтэй холбогдуулаад энэ 5-ын Г заалтан дээр нэрээр хураалгах гэдэг заавал оруулаад давхардуулж оруулаад байхын шаардлагагүй гэж үзэж байна. Тийм учраас хүндэт депутат Баярцогт бараг энэ саналаа буцааж аваасай гэж хүсч байна.

2-р микрофон I63 дугаар тойргийн депутат Б.Мижид: -Бид нэг зарчмын юман дээрээ тохирмоор юм шиг санагдаад байна. Ерөөсөө асуудлыг Их Хурлын чуулган хийлгэхдээ олонхийн саналаар шийдвэх юм уу, цөөнхийн саналаар шийдвэх юм уу, бид дэгнийхээ эхнээс эхлээд асуудлыг шийдвэхдээ олонхийн саналаар шийдье. Зарим зүйл дээр дийлэнх олонхийн саналаар шийдье гэж ингэж явж байгаа. Ямар нэгэн тэрнээс доод хувь 40 хүн, 20 хүн, 5 хувь, 10 хувь гэвэл энэтэй харшилна. Тийм учраас энийг шийдье.

2.

I дүгээр тойргийн депутат С.Баяр: - Надад ийм санал байна. Депутат Баярцогт, Элбэгдорж нарын хэлээд байгаа саналыг би үнэхээр хүндэтгэж үзэх байна. Тийм ч учраас би хэлсэн. Нэрээр хураах санал дээр эсэргүүцээд байх юм алга. Гэхдээ давхар давхар оруулах хэрэгтүй юм. Бид I0-ынхаа Е-д өрөнхий зарчмаа оруулаад өгсөн, депутатын ердийн олонхийн саналаар хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзаад гээд ийм, Үнэхээр энэ болбол сая Мижид туйяа ярилаа л даа. Асуудлыг АИХ дээр шийдэхдээ үнэхээр олонхоор шийднэ. Ердийн олонхоор шийдэх уу, дийлэнх олонхиор шийдэх уу гэж тухайн асуудал дээр, энэ бол шийдвэр гаргаж байгаа юм биш. Гарсан шийдвэрийг санал хураах хэлбэр нь бол нэрийн жагсаалтын юмаар гэж, энэ бол гаргаж байгаа шийдвэр биш. Зүгээр гаргасан шийдвэрийг гаргах хэлбэр нь бол нэрийн жагсаалтаар юм. За энэ тэгээд ард талдаа түүхийн өмнө хулээх хариуцлага сонгогчидтойгоо тавих тайлан майлантай холбоотой ийм зүйл байгаа юм л даа. Тэгхэлээр аргагүй энэ бол ардчиллын гол зарчим маань олонхийн шийдвэрээр гэхдээ цөөнхөө хүндэтгэнэ гэдэг энэ ардчиллын гол зарчим гэж байгаа, энийгээ хүндэтгэж үзэх юм бол энэ I0-ын Е-т доорхи байдлаар найруулчих юм бол боломжтой, тэгэх юм бол 5-ын Г-д элдэв хангайн юм оруулаад байх шаардлагагүй юм шиг санаглаж байна. Миний санал юу вэ гэхлээр I0-Е хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзаж, хуралд оролцсон депутатын I0-ны I-ийн саналаар нэрийн жагсаалтаар авч болно. Ингээд тавих юм бол одоо юу гэсэн уг вэ, аливаа асуудлыг шийдэхэд нэг 40 хун, энэ асуудлыг санал хураая, гэхдээ санал хураахдаа нэрээр хураана шуу, тэгэх юм бол тэр эсрэг өгсөн, татгалзсан тудгэлзсэн гэдэг нь хүнийхээ нэртэй гараад ирнэ. Энэ дээр би нэг тайлбар хэлмээр байгаа юм. Депутатуудад би зүгээр компьютерийн энэ хангамжийн нөхдүүдийг бас нэг тайлбар өгвэл зүгээр байх гэж бодож байна л даа. Миний ойлгож байгаагаар бидний энэ өгөөд байгаа юм цаанаа бол санах төхөөрөмждээ нэргүйгээ байгаа. Одоохондоо зөвхөн тоогоор явж байгаа, шаардлагатай гэж үзвэл давхар программ өгөөд тэрэн дээр нэрээр гаргаж болно. Тийм учраас бидний өгч байгаа саналын нууц байдал бол хадгалагдаж байгаа гэж би хувьдаа ойлгож байгаа, тэгж ч найдаж байгаа, депутатын хувьд. Шаардлагатай гэж үзээд нэрээр хураая гэж ингэж тийм 40 хун юм уу, I0-ны I нь ингээд хүснэгтээ тавиад ингэх юм бол нэрээр гаргадаг программы нь өгөөд

тэр нь нэрээрээ гараад ирдэг ийм л юм байгаасай билээ гэж бодож байна, ийм л байх нь зүйтэй. Бидний энэ хуралдааны зарчимд ч нийцнэ, 10-ын Е-г тэгээд найруулчих юм бол 5-ын Г дээр дахиж илүү дутуу асуудал, бид өрөнхий зарчим дээрээ тохирсон юмаа нарийвчилсан юман дээрээ дахин дахин ярих болбол энэ одоо утга учир багатай юм. л даа. Тийм учраас 10-ны I-ийн саналаар саналыг нэрсийн жагсаалтаар авч болно. гээд найруулчихаж болно. Энэ дээр бол ер нь айгаад байх юм уу, болгоомжлоод байх зүйл огтхон ч байхгүй. Шийдвэр гаргаж байгаа юм биш, шийдвэрийг гаргаж байгаа хэлбэрийн тухай асуудал.

4-р микрофон

-Тэгэхээр ийм байна, энэ асуудал эцэс тэгсгөлгүй маргаан болох нь. Шийдэх өрөөсөө I-хан арга зам байна. Бид нар нэрээр авахыгаа үндсэндээ шийдчихлээ шүү дээ. Шалгуураа олох гээд байна шүү дээ. Ямар шалгуур байх вэ гэхлээр хэн ч хэлсэнгүй, би л одоо хэлэхээс. Бид нарыг булгүүд гээд нэг юм зөвшөөрчихсөн шүү дээ, намын булэг, өөр булэг гээд, булгийн учир холбогдол энд гарч ирэх нь ээ. Аль нэг булэг хэрэв нэрээр авах санал тавибал нэрээр санал хураая л гэж. Тэрнээс одоо 10-ны нэг гэдэг юм уу, 40 хүн гэдэг юм уу ямар нэгэн үндэслэл байхгүй болчиноод байна л даа. Тэгээд аль нэг намын булэг ч байдаг юмуу эсвэл депутатын ямар нэгэн булэг байдаг юмуу, мэргэжлийн булэг байдаг юм уу, аль нэг нь л санал гаргавал нэрээр санал хураая. Өөр ямар ч арга алга. Энийг өөрөөр шийдэх ямар ч арга алга. Нэг хүн гэхлээр арай болохгүй оргиод байна. 10 хүн гэхлээр арай л болохгүй оргиод байна. Ер нь үндэстэй юм биш уу гэж энийг та нар болгоогоочээ гэж. Ийм хүсэлт байна.

Уртнасан:

-2 зүйл дээр санал хураалт явуулах боломж байна бидэнд. I-рт депутат Баярын саналаар /яриа давхардсан/ редакци хийчихвэл I гарч болохоор байна, 2-рт нь шаардлагатай гэж узвэл аль нэг булгийн хүсэлтээр нэрээр санал хурааж болно гэсэн хүндэт депутат Гунджалбын редакци байж болж байна. Ийм 2 хувилбар байна.

105-р тойргийн депутат Б.Чойжилсүрэн: -Тэгэхээр энд

их цаг барж байна л даа. Ер нь нэрээр санал хураахаас депутатууд татгалзахгүй, яагаад гэвэл бид энэ Үндсэн хуулийг баталж улс орноо урагш нь хөгжүүлж ахиулахын төлөө цуглараад ард түмнээ төлөөлөөд байж байгаа хүмүүс шүү дээ. Тэгэхээр зэрэг тэр нэг 10 хувь, 40 хүн гээд байдаг одоо энэ ямар учиртай ямар үндэслэлтэйгээр энд оруулах гээд байгаа юм, тэрнийг нэг сонсмоор байна. Тэнд нэг учир байх шиг байна. Ер нь энэ Үндсэн хуулийг батлахад зүйл, булэг тус буреэр нэрээр санал хураах тийм хүчин чадал байгаа юм болов уу даа. Компьютерын ой тоонд бол бичигдчихсэн байж байгаа. Эцэстээ энийг нэг Монгол улс гээд нэрлэсэн хүмүүс нь энэ энэ байсан юм, БНМАУ гэж нэрлэх гэж байсан нь энэ энэ байсан юм, ингээд ухаандаа депутатуудыг бурэн эрхт байдал нь дууссаны дараагаар ер нь ухаандаа ийм юм руу тулхэж аваачих гэж байгаа хэрэглүүр болгож одоо энэ нэг зүйл тус бур дээр ингэх гэж байгаа юм биш биз дээ. Ерөнхийдөө бол булгээр юм уу, шаардлагатай асуудал дээр аль эсвэл Их цаазыг нийтэд нь батлахад нэрээр санал хураалгахад бэлэн байна. Гэвч ямар нэг асуудал болгон дээр нэрээр санал ухураалгаж эцэстээ ухаандаа түүхийн өмнө тэр буруутай шийдсэн, тэр тэр буруутай шийдсэн, гэж энд сууж байгаа 400 гаруй депутатуудыг хэдэн жилийн өмнө ялгаж узэх гэж байгаа бол энэ дайсан имуу, аль эсвэл ямар нэг одоо түүхийн өмнө буруутан этгээдийг бий болгохыг урьдаас эрмэлзсэн ийм их будуулэг уйл явдал болно шүү. Тийм учраас энэ 10-ын Е дугаар зүйлд заасан зарчмаа баримтлаад явахад болмоор байна.

72-р тойргийн депутат А.Болат: -Тэгэхээр бидний түүхийн хариуцлагын хувьд ч магадгүй нэрээр санал хураах энэ шаардлага байх байх. Тэгэхдээ шнийг бид Парламентынхаа ардчиллын дагуу шийдэх ёстой. Ийм санал гарч ч болно. Хэн ч гаргаж болно, гэхдээ заавал тэр хүн 40 хунд хүрсэн утгаар нь биш, гарсан саналыг ардчиллынхаа дагуу өөрөөр хэлбэл нэрээр хураах уу угүй юу гэдгийг санал хурааж олонхиин санал авсан тохиолдолд нэрээр хурааж байхаар тогтоох нь зүйтэй.

215-р тойргийн депутат Ж.Чунагсүрэн: -Нэрээр хураана, Ердийн олонхиор авна гэсэн юман дээр маргаад нэр лүү заавал санал авах л ийм л юм руу яриад байна л даа өчигдөөс хойш.

Нэрээр өгч болно, сүүлд нь тэр нэрийг ях гэж байгаа юм бэ, одоо Чойжилсурэн ярьж л байна л даа, тэр нэр, санал 2-ыг ях гаж байгаа юм. Энүүн дээр эмзэглэж байна. Хэрвээ нэг эрлийзүүд нэг 40, юм уу, 10 хувийн эрлийзүүд гаралт тэр АИХ-ын эрхийг гартаа аваад бутгийг шийдэх юм бол бид энд сууж байх хэрэг алга. Тэр эрлийзүүдээ энд нь ялгаж үлдээчээд бид тардаг цаана нь ажилгүй биш дээ. Ажлаа хийе. Энэ дээр олон түмнээ хүндэтгэж явбал ясан юм бэ, цөөнхийн эрх ашиг гэдгээр одоо энэ 2 өдөр л энэ дээр олонхи нь тулгалт хийж байна шуу дээ. Уучлаарай цөөнх нь. Хурлын дарга ингэж эргэж буцалгүй, бидний хэлэлцэж байгаа дэгээ дуусгачаад тэгээд зарим зүйлээ түүх буцвал болж байна. Одоо ер нь дуусаагүй байхад эргэж явсаар байгаад бид нэг 2 өдөр ингээд барах нь байна шуу дээ. Цаашдаа Их цаазын төслийг ийм маягаар хэлэлцвэл одоо бид энэ жил тарахгүй байх аа. Тийм учраас тэр нэрээр авна гэдгийн учрыг сайн эйл-гуулж өгмөөр байна депутатуудад. 2 дугаарт энэ самбарын цаана бидний дарсан кнопкны цаана нэр бичээд байгаа юм уу угүй юу, Энэ сүүлд ял, гавьяа 2-ыг тэр нэртэй холбож үзэх гээд байна уу угүй юу, сэтгэл эмзэглээд байна шуу дээ.

7-р микрофон, ЗИ5-р тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ:

-Тэгэхлээр бид нар өрөөсөө ганц хүний тоглоомонд зрителээрээ орчихож болмооргүй байна. Бид чинь 10 дугаар зүйлийнхээ Е-д бол тодорхой заагаад баталчихсан. Депутатуудын ердийн олонхийн саналаар хэлэлцэж байгаа асуудлынхаа шинж байдлаас шалтгаалаад нэрээр санал хураанаа гэдгийг бид бол баталчихсан. Тухайн хүн одоо утгыг заавал нэрээр хураалгах шаардлагатай гэж үзэх юм бол, өөрөө депутатынхаа бүрэн эрхийн дагуу энэ асуудлаа хажуугийн санал болгоод хэлэлцүүлж болно. Тэгээд бид энэ Е зүйлээ үндэслээд тэр хүний санал нь ердийн олонхийн санал авч байх юм бол тэр асуудлыг нэрээр хураагаад явж болно шуу дээ. Тэгэхлээр ер нь одоо нэг шийдчихсэн юмаа ингээд эргэлдээд ингээд баймааргүй байна. Цаашаа энэ асуудлаа шуурхайлж явбал ясан юм. Бид одоо ер нь ингээд телевиз энэ тэрээр үзэж байх даа ярьдаг шуу дээ. Улсын Бага Хурлынхан иймэрхүү байдлаар хандаж байхад бид ямархуу байдлаар шүүмжилж ярьдаг билээ. Өөрсдөө одоо энэ байдал руугаа гулсаж орчихоод бид нарыг ард түмэн шүүмжилж байгаа шуу дээ.

6.

Ингэж сахилгагүй баймааргүй байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



М.БУРМАА

147
1991.XI.12. 9

Кассет № 59

I6.30-I6.45

15 дугаар тойргийн депутат Д.Лундээжанлан:

-Бид асуудал болгон дээр нэрээр санал өгөхэд айх юм алга. Түүхийн өмнө ч гэдэг юмуу, юу ч гэдэг юм. Гэлээ гэхдээ энд эцэс төгсгөлгүй, дуусахгүй юм болно. Хэн нэг дуртай хүн гарч ирээд энийг нэрээр өгье гээд өөрийнхөө санал болгоныг. Ингээд Их цаазын эхний хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг энэ олон эзил ангийг яаж бараг юм бэ?

Хоёрдугаарт, нэг хүн саналаа нэрээр гаргалаа. Гэтэл тэр нь ор дэмжлэг авахгүй, ердийн олонхийн дэмжлэг авахгүй байя. Ихэнх тохиолдолд бас болзошгүй, бас нэг юм байж болох юм. Тийм учраас би ийм санал тавьж байна. Харилцан ийм юманд хурч болохгүй юу. Дөрөвний нэг, нийт бүрэлдэхүүний дөрөвний нэг буюу 100 гаруй депутат байгаа, дөрөвний нэг гэсэн тоо, хэрвээ тоо хэлдэг юм бол. Энэ нь бас нэг үндэс байгаа юм. Өөреөр хэлбэл, энэ бол аливаа асуудлыг шийдэхдээ бид голцуу ердийн олонхийн болон дийлэнх олонхийн байгаа. Гэтэл энэ бол хараахан асуудал шийдэх биш санал хураахдаа яаж хураах вэ гэдэг горимын шинжтэй асуудал учраас тэрий тал нь гэж үзээд 25 хувь гэдэг нь өчүүхэн ч гэсэн шинжлэх ухааны үнэр байх болов уу гэж бодож байна. Ийм учраас энд байрлаж байгаа нийт бүрэлдэхүүний дөрөвний нэг гэдэг бол ямарваа нэгэн санаа бодлыг илэрхийлэх байх гэж бодоод энэ тоон дээр хураагаад өгнө уу гэсэн саналтай байна.

27 дугаар тойргийн депутат Л.Пүрэвдорж: -Их Хурлын депутат Чойжилсурэн, Чунагсурэн нар энэ дээр саналаа хэллээ, улс төрийн утгатай үг хэллээ. Тэгэхээр нэгэнт депутатууд ингэж хэлсэн учраас энэ хэлж байгаа саналын талаар би бас саналаа хэлж өрхтэй гэж бодож байна.

Нэгдүгээрт, улс төрийн хариуцлагын тухай хэрэв ярж байгаа бол Ардын Их Хурлын депутататаар нэр дэвшээд бид зөвшийрэл өгөхдөө Монголын ард түмний өмнө улс төрийн хариуцлага

хүлээсэн. Одоо тэрнээсээ айх юм бол бид депутатуудын тухай асуудлыг тийм хүн байвал өргөж ярих хэрэгтэй болох байх, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хэмэгдүүлгийн тухай ярьж байгаа бол яахаараа олон намын тогтолцоо үүсчихсэн, ардчилсан сонгууль яваад ард түмэн сонгочихсон Их Хурлыг хэмэгдүүлэх гэж байна гэж Их Хурлыг бүхэлд нь сэжиглэж байна вэ?

Гуравдугаарт, энэ танхимд болж байгаа санал хураах бүх асуудал сонгуулиас бусад нь, сонгуулийн санал хураалтаас бусад нь Монголын ард түмэнд ил байх ёстой гэж бодож байна, миний хувьд бол. Дуртай сэтгүүлч ирээд сонгуулиас бусад бүх саналыг энэ санах аппарат, ажлын аппаратаас аваад нийтэлсэн байхад тэр сониньг, тэр сэтгүүлчийг буруутгах арга байхгүй гэж би бодож байна. Тийм учраас нэрээр санал хураах асуудал гэдэг маань үнэн, эцсийн эцэст түүхийн хариуцлага хүлээхийн тухай асуудал мөн. Энэ цаанаа сахилгажуулах бас учир холбогдолтой. Хүн гэдэг чинь хүн юм болохоор зэрэг бас л хувийн бодол байгаа, өөрийн эрх ашиг байгаа. Ийм юманд ороод ирэхээр том хариуцлагаа ухамсарлахаар зэрэг улс орныхоо эрх ашиг, Монголын ард түмний эрх ашигийг илүүд үзэх ийм хариуцлагын ч юм бий. Хүн гэдэг сэтгэхүйн онцлогтой болохоор зэрэг. Тийм учраас депутатуудын хэн нь ч гэсэн ямар саналтай байна, энийгээ нэрээр хураалгаад түүгээр ч барахгүй тодорхой хугацааны дараа мэдээлэхийг шаардах эрхтэй байх ёстой гэж бодож байна. Жишээлбэл, би нэг асуудлын талаар нэрээр хураалгах санал тавина, ухаандаа Их цаазын тесэл хэлэлцэхэд. Тийм учраас бид уур амьсгалаа хордуулахгүй явах юмсан. Бунд энд улс төрийн хэмэгдүүлгийн тухай ярина вэ? Энийг больё.

178 дугаар тойргийн депутат д.Энхбаатар: -Хүмүүс асуугаад байна, дараа нь энэ нэрсээр яах гэж байгаа юм бэ гэж. Нэрсээр санал хураагаад энэ нэрсийг дараа нь яах гэж байгаа юм бэ гэж, хариуцлага хүлээлгэх гэж байгаа юмуу гэж. Энд бол хариуцлага хүлээлгэх гэж байгаа юм. Хариуцлага бол, би ямар хариуцлага ярьж байна вэ гэхээр сонгогчдынхоо өмнө хүлээх хариуцлага, түүхий өмнө хүлээх хариуцлага. Тэрнээс ямар нэгэн эрүүгийн хариуцлага байж болохгүй.

Ардын Их Хурлын депутат чуулган дээрээ хэлсэн үгнийхээ төлөө ямар ч хариуцлага хүлээх ёсгүй, зөвхөн сонгогчдынхоо өмнө, захиа даалгавар ийм юман дээр ийм санал гаргаарай гэснийг би үнэхээр та нарын захиа даалгаврыг биелүүлсэн шуу гэж хэлэх өөрийнхөө үgtэй байх ёстой. Тэгээд бид бол энэ хариуцлагаас айх ёсгүй. Үнэхээр чухал эгзэг мөчид бид ирээд байгаа. Улсын хувь занатай холбогдолтой асуудал шийдэх гэж байна, жирийн хууль биш, Үндсэн хууль.

Тэгэхээр бид нар нэг төрийн тогтолцооноос, нэгөө цоо шинэ төрийн тогтолцоо руу орох гэж байна. Хоёр дахь бүгд найрамдах улсыг байгуулах гэж байна. Энэ бол түүхийн өмнө үнэхээр бид нар хариуцлага хүлээж байгаа улсууд. Тэгээд нэгөө талаас бид бол өгч байгаа санал, гаргаж байгаа шийдвэрээ өөрөө ухамсарлаад тэнд саналаа өгч байгаа. Нэгэнт өөрөө ухамсарлаад саналаа өгч байгаа юм чинь яагаад би энэний төлөө эсрэг санал өгсөн юм, энэний төлөө санал өгсөн юм гаж хэлж чадахгүй, төрийгээ нууцлах гээд байгаа юм. Хун бүр ухамсарлаж байгаа учраас тэр юугаа ил тодор хэлж байх ёстой. Бүгд ойлгож саналаа өгч байгаа. Тэрнээс биш, хэрвээ энэ санал батлагдахгүй бол дараа нь яг энэтэй холбогдож өөр санал хэлмээр байх юм.

I дүгээр тойргийн депутат С.Баяр: - Тэгэхээр бид асуудлыг нэлээн улс төрийн талаас нь яриад эхэллээ. Тийм ч учраас би дахиж энэ дээр саналаа хэлмээр санагдлаа. Бид турүүн депутатын бүрэн эрхийн тухай ярьж байсан. Үнэхээр Ардын Их Хурлын депутат гэдэг бол сонгогчид нь огцруулчихгүй, өөрөө хорвоогийн мөнх бусыг үзчихгүй, эсвэл өргөдлөө өгөөд татгалзахгүй юм бол хэнд ч бидэнд халдчих тийм эрхгүй юм байна л дээ. Үнэхээр том улсууд.

Үнэхээр тийм том эрхийнх нь хажууд тийм том үүрэг дагалдаж ирэх ёстой. Тэр үүргийн тухайд бид ярьж байгаа. Ямар санал яаж өгсөн гэдгийгээ бид сонгогчдынхоо ч өмнө, түүхийн ч өмнө бүрэн хариуцах учиртай. Бид парламентат ёсны тухай ярьдаг. Үнэхээр боломжтой, бололцоотой, том экрантай ийм дэлгэцтэй газар бол бидний өгч байгаа санал бол депутатын нэрээр гарч байдаг юм байна лээ. Бидэнд тийм боломж бололцоо алга. Тийм

учраас тоогоороо гаргаж байгаа юм. Зохион байгуулалтын асуудал, саналаа нууцаар өгдөд тийм зориудын асуудлаар бол тэд нар тоогоор өгдөг. Ийм л ёстой. Энэ дээр эмзэглээд байх юм алга. Боломжтуй учраас бид ингээд байгаа юм.

Хоёрдугаар асуудал, энэ нэрээр хураах асуудал гэдэг бол парламентат ёсны нэг том арга хэлбэр юм л даа. Парламентыг бүх байгуулахдаа олон намын тогтолцоон дээр үндэслэж байгуулсан. Энд олонхийн суудал авсан нам байна, цөөнхийн суудал авсан нам байна. Тэгэхээр парламент бий болсны утга учир маань бид энэ дотор ороод хэл амаа ололцох л гол зорилгоор энд цуглаад байж байгаа. Бүх юмыг олонхоор хийнэ гэх юм бол нөгөө нэг цөөнхийн ашиг сонирхол гэдэг юм чинь цаана хөсөрдөнө. Хөсөрдснөөс болоод бухимдал үүснэ, бухимдал үүссэнээс болоод нийгэм төдийчинээ бухимдах болов уу. Тэгэхээр энэ нэрээр хураана гэдэг юм бол бас л үнэхээр цөөнхийн хувьд бол энийг зайлшгүй оруулах ёстай юм гэж хэлээд байгаагий нь би хувьдаа хүндэтгэж ойлгож байна. Тийм ч учраас шийдвэр гаргахдаа 40 хүнээр гаргая гэж хэлээгүй шуу дээ. Гаргасан шийдвэрээ, хэн ямар, юуны төлөө өгч байна вэ гэдгийг мэдэх тэр эрхийг цөөнхөд олгож болмоор юм шиг санагдаж байна. Энэ аль ч парламентат ёсонд байдаг. Магадгүй энэ тогтоогоод байгаа аравны нэг гэдэг юмуу тэр нь шинжлэх ухааны үндэслэлийн хувьд бага байж болох юм. Би өнөөдөр яг тийм шинжлэх ухааны үндэслэлтэй тоо хэлчих боломжтуй байна.

Гэхдээ аравны нэг бол 40 хувь. Бидний байгуулагдаж байгаа бүлгүүдийн хувьд 40-ийн тоо яригдаж байсан. Энд байгуулагдсан, байгуулагдах, цаашид уил ажиллагаагаа явуулах булгийн талаас нь бодох юм бол аравны нэг гэдэг бол үндэслэлтэй хувь юм. Энэ дээр ингээд шийдсэн байхад бидэнд, олонхийн хувьд ч, цөөнхийн хувьд ч алдаад байх юм байхгүй. Энэ уг нь ийм асуудал дээр нэг их удмааргүй байна. Зарим депутатууд, ялангуяа депутат Чунагсүрэн энэ асуудлыг налээн улс төржүүлж тавьж байгаа учраас энэ уур амьсгал битгий цаашаа яваасай билээ гэдэг үүднээс би энэ тайлбарыг хэлж, өөрийгөө ойлгуулахыг бодож байна.

288 дугаар тойргийн С.Баярлогт: -Би бол энэ саналаа авахгүй. Гэхдээ би хүний тоогоор хязгаарлах гээгүй. Яг асуудал шийдэгдэж байхад депутат Баяр хумуусийг нэлээн төөрөгдүүллээ. Цаас, юм болохгүй гээд. Болно, энэ. Би энэ дээр ямар нэгэн тоо тавихгүйгээр би 10-ын "е" заалтыг хундэлж байна. Тухайн тухайн асуудал дээр тэрийт дийлэх олонхийн саналаар шийдээд явж болно.

Үндсэн хууль буюу Их цааз маань маш өөр зүйл. Энийг яагаад тусгайлж, энд зориулж дэг гэж байгаа юм. Энэ чинь хэлэлцэх асуудал нь онцгой учраас тусгайлж дэг гэж байгаа юм, тэр утгаараа.

Энд сууж байгаа бүх хумуус бол улс төрийн бодлоготонгууд. Монголд улс төрийн талаар бодлого явуулж чадах чадвартай хумуус гэж ард түмэн төлөөлж сонгосон хумуус байгаа. Энэ хумуус бол өөрсдөө тэр хариуцлагаа ухамсарлаж чаддаг байх ёстой. Энэ утгаараа би ямар нэг, 40, хагас нь юмуу, 10 хувь нь юмуу гэж ерөөсөө хэлэхгүй. Энийг бол бугд л эцсийн, учлаарай, депутат Мундээжанцан нар бол гүйвуулж байгаа шүү дээ. Хоёр хэлэлцүүлийг хоёулангий нь нэрээр хураана гэж огт хэлээгүй байна. Эцсийн хэлэлцүүлэг, энэ дээр унших юм бол маш ойлгомжтой хэлбэр байгаа шүү дээ. Тохиролцсон байвал булгуудээр гэж байгаа. Санал зөрөлдөөнтэй асуудал байхгүй бол булгуудээр нь.

Бүгдийг би ямар нэгэн тоо юмуу хязгаарлалт тавихгүйгээр эцсийн хэлэлцүүлийн зүйл бурийг нэрээр хураая. Ард түмэн үнэхээр ойлгог. Энэ чинь улс төрийн бодлого, түүхийн өмнө хүлээх хариуцлага, тэгэж л ойлгох байна. Энэ хуулинаас болж монгол улсын дараагийн 100 жилийн асуудал яригдана. Энийг л бид ойлгох ёстой байх. Энэ утгаараа би залуучуудыг төлөөлж сууж байгаагийн хувьд хатуу энийг хамгаалж хэлж байна. Би энэ асуудлаа эргэж татаж авахгүй.

154 дүгээр тойргийн депутат Е.Моголлог: -Их Хурлын даргад би гурван санал тавъя. Хамгийн нэгдүгээр санал. Саяян яриад байгаа нэрсээр санал хураахаас айгаад байх юм байхгүй. Ямар нэг юмыг бидэнд оссорлуулж байгаа юм биш ээ. Тийм учраас эрхэм хундэт депутатууд энээс айх явдалгүй. Тийм учраас

Энийг би нэрээр нь хураалгахыг дэмжих байна.

Хоёрдугаарт, өнөөдөр их төвөгтэй байна, эргэж буцаад явж өгөхгүй байна. Их Хурлын дарга жаахан урагшaa явуулмаар байна. Бид аль хэзээнээ баталсан асуудлаа хэдэн минутын дараа, цагийн дараа буцаад байна. Энийг болиоч ээ. Хэрэв санал тасалсан юм бол тасаллаа гээд дараачийн асуудалдаа шилжээд орж баймаар байна.

Энэ редакцийн комисс учраас ингэж яриад байна. Энэний чинь нэг уг, усэг жаахан юмаар хөөцөлдөөд байх хэрэгтгүй байна. Энийг редакцийн комисс засаад янзлаад та нар дахиад хэлэлцээд батлуулахад таны санал ороогүй байсан тэр нөхцөлд эргэж лавлаж болох юм. Ийм хоёр дахь саналыг би хэлмээр байна.

Гурав дахь миний хэлэх гэж байгаа санал юу байна вэ гэхээр бид өнөөдөр 2 дахь өдрөө бүтэн хуралцаж байна шуу дээ, ажлаа бодъё, цагаа бодъё, эдийн засгаа бодъё, ард түмнээ бодъё, жаахан цэгцтэй, хурдан явъя. Цөөнх нь олонхдоо заавал хүлээлгэх гээд олон олон дахин буцаад байдаг энэ маань нэг олигтой биш. Ард түмэн энийг сайн хүлээж авахгүй байх болов уу. Энэ бас маргалдааны шинж чанарыг хумууст төрүүлэх гээд байна. Ийм учраас Их Хурлын дарга энэ чуулганыг хатуу дэгээр удирдах хэрэгтэй. Бид дэгээ жаахан дэг муутай хэлэлцээд байна. Дэгэн дээр ерөөсөө урагшaa явж өгөхгүй байна шуу дээ. Ерөөсөө хальтиргаатай зам өөд халван дугуйтын машинаар даваад өгсч байгаа юм шиг ухраад байна. Энэ хумуусийг бухимдуулж байна. Энэ комиссыг бас хунд байдалд оруулж байна. Дахин дахин яриад байдаг, эргэж яриад байдаг. Тэр ч байтугай очигдрийн ярьсан депутатын эрхийн асуудлыг өнөөдөр ярих ямар хэрэг байдаг юм бэ?

Чимид даргаар ингэж дэг алдуулж байхад хурлын дарга яагаад чимээгүй суугаад байдаг юм бэ? Бас жаахан журманц орьё. дэгээ яримаар байна. Тэрний дараа дараачийн асуудлыг яръя.

Ж.Уртнасан: -Таны саналыг таашааж хүлээж авч байна. Бид дэгтэй болчихвол жаахан хатуухан гараар цаашаа явж болох байх аа.

427 лугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж: -Энэ дээр үндэслэл шаардаж байна. Ийм учраас хоёр, гурван зүйлийг хэлэхгүй бол болохгүй нээ.

Нэгд, бид бол хийх ёстой ажлаа л хийж байна. Энд бид нар ярилцаж байж л ерөнхий тохиролцоонд хүрэх ёстой. Ерөөсөө энэ бол бидний хийх ёстой ажил гэж ойлгож байна.

Дараачийн асуудал бол Чойжилсүрэн, Чунагсүрэн нар бол ерөөсөө асуудлыг санаагүй байхад нэлээн улс төржүүллээ. Ийм учраас би энэ дээр тайлбар хийе гэж бодсон юм. Ямар нэгэн бодол байхгүй. Нэгдүгээрт, энэ асуудлыг тавьсны учир бол та бидний ард талд та биднийг сонгосон сонгогчид мэдэж байх ёстой. Миний сонгоод явуулсан, итгээд явуулсан энэ депутат ямар байр суурин дээр байдаг юм бэ гэдгийг.

Дараагаар нь энэ хүмүүст, тэр сонгогчдод хэрэгтэй байна. Энэ ардчиллын хамгийн гол зарчим юм. Тэрийт сонгогчид мэдэж байх ёстой. Үнэхээр миний төлөө явж байсан депутатууд би энийг дараагийн сонгуульд дахиад сонгоно, үнэхээр хүний төлөө явдаг бол . Үнэхээр зарчмын асуудал дээрээ зогсч чадлаггүй бол энэ депутат дараагийн сонгуульд олонхийн санал авч чадлаггүй. Энэ л байдлаар асуудлыг хардаг. Нэгдүгээрт энэ асуудал байгаа юм.

Дараачийн асуудал бол аливаа парламентад парламентын гишүүн хэлсэн угнийхээ төлөө хариуцлага хүлээдэггүй. Чи энд тийм уг хэлж байсан, энэ Их Хурал мөн парламент гэж би ойлгож байгаа. Энд чи тийм уг хэлж байсан гээд гараад ямар нэгэн байдлаар надад ял тулгах ийм ёс байдаггүй. Энэ бол хуулиар олгогдсон бидний ганц эдлэх ёстой дархан эрх. Бид энд хэлэх ёстой угээ хэлдэг. Энэнийхээ төлөө гадагшaa ямар нэгэн хуулийн хариуцлага хүлээдэггүй. Ийм учраас энээс айх шаардлагагүй гэж бодож байгаа. Энэний үндэслэлийг би хэлэж байна.

Түрүүчийн эрхэм гишүүн Баярын хэлээд байгаа тэр IО-ын I, аравны нэг хувиас дээш гэсэн энэ санал дээр тогтвол ядаг юм бэ? Энэ бол хамгийн боломжтой санал байх аа. Энийн шинжлэх ухааны үндэслэл гээд байх юм. Энэ дээр ерөөсөө шинжлэх ухаансаад байх юм байхгүй. Зүгээр дуртай нэг депутат нь босч ирээд нэрээр санал хураалгаад байя гэхгүй асуудлыг наана нь хааж өгч байгаа юм. Наад зах нь 40 хүн энийг дэмжсэн байх ёстой, наад зах нь 40 хүний дэмжлэг, наад зах нь IО, I хувийн дэмжлэг хүлээсэн байх ёстой гэдэг асуудал байгаа. Энэ дээр ямар нэгэн шинжлэх ухаан хэрэггүй гэж бодож байна.

84 дүгээр тойргийн депутат Н.Самат: -Би нэг юманд гайхаад байгаа юм. Би маш товчон хоёрхон уг хэлье. Нэгдүгээрт, бид нар яагаад өөрийнхөө саналаас айдаг депутат энд сууж байгаа юм бэ, ойлгохгүй байна. Энэ чинь улсын хувь заяа шийдэх гэж суучихаад өөрийнхөө саналаас айдаг юм бэ?

Харин одоо эмзэглэж байгаа, өөрийнхөө саналаа нууцлах гээд байгаа, нэрээ нууцлах гээд байгаа тэр юмнаас харин айх хэрэгтэй. Тийм учраас манай Ардын Их Хурлын хуралдаан бол маш ил тод, ардчиллын журмаар явагдах ёстой. Тэгэхээр зөвхөн маргааш түүхийн өмнө хариуцлага хүлээж, зөвхөн ёс суртахууны хариуцлага хүлээнэ. Тэрнээс нэрийг жагсааж байгаад ямар нэгэн эрүүгийн хариуцлагад татах тухай асуудал энэ дээр байхгүй.

Негээ талаас би нэг горимын санал хэлье. Бид нар жаахан ажил хэрэгч баймаар байна. Ерөөсөө бид нар хүүхэд зан гаргаад байна шүү дээ. Өөрийнхөө сэтгэл санаандаа тохирохгүй юм хэлсэн хүнийг бараг узэн ядаад байна. Бараг л олонхиорое ингэх гээд байдаг. Тийм учраас энд цөөнхийн асуудал тавигдаад байгаа шүү дээ. Сая би гайхсан юм бол бид нар алга ташаад байна. Бид нар хууль тогтоох гэж байгаа, бид нар баярын цуглаанд сууж байгаа юм биш. Хэзээ ч ташиж болохгүй, хэзээ ч алга ташиж олонх нь цөөнхөө алга ташилтынхаа дуугаараа тэгэж дарж болохгүй. Энэ бол ерөөсөө болохгүй зүйл. Хууль тогтоох байгууллагад энэ хэзээ ч байж болохгүй.

9.

Энэ дээр миний тодорхой хэлэх санал бол ингэвэл яасан юм бэ? Ямар нэгэн үндэслэл эрэхээр бол энэ дээр хоёр үндэслэл байна, надад.

Нэгдүгээрт, эрх зүйн үндэслэл байна. Юу гэвэл, шаардлагатай гэж үзвэл Их Хурлын дарга нь өөрөө, үзэмжээрээ нэрээр санал хураалгаж болно. Манай хуралдааны уур амьсгал жаахан улс төржөөд юмуу, сэтгэл хөөрөлд автагдаад жаахан ийм болоод ирэхээр хариуцлагаа дээшлүүлэх, цэргтэй болгохын тулд Их Хурлын дарга өөрөө санаачилж нэрээр хураалгаж болно, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ийм нэг үндэслэл байж болох юм. Бид нар энэ хурал 75 хувиар хүчин төгөлдөр болж байгаа шүү дээ. Тийм учраас бид нар 25 хувь гэж авч үзэж болох юм. 25 хувийн дэмжлэг авч байж нэрээр санал хураана гэж.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:

М. НАРАНТУЯА

Бичээч

Ө. ОЮУНЧИМЭГ

1991.II.12
Кассет-60
16.45-17.05

Ж.Уртнасан: Одоо ер нь санал гарчихлаа гэж ойлгож байна.

168 дугаар тойргийн депутат Г.Ванданлагва

Ж.Уртнасан: Уучлаарай, өөрөөс чинь урд зогсож байгаа улсууд байгаад байна, 5 дугаар микрофон Жамсран депутат үгээ хэлэхгүй юу.

379 дүгээр тойргийн депутат Ц.Жамсран: Энэ хэлэлцэж байгаа манай депутатуудад хандаж нэг юм хэлмээр санагдах юм. Энэ дээр бид маш их анхааралтай ажил хэрэгч, ингэж ормоор байна. Жишээлбэл, энэ бидний маргаад байгаа энэ асуудал байна шүү дээ, энэ бол их чухал асуудал. Тэгэхдээ бид энэ 10-ын "е" заалтаар З удаа санал авсан. Нэг удаад 78 хувьтай, нэгөө нь 93 хувьтай, нэг 72 хувьтай, тэгээд олонхийн саналаар бид юу гэж үлдээсэн бэ гэхээр хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзаж саналыг депутатын нэрийн жагсаалтаар авч болно гэсэн ийм юм үлдээсэн байгаа ердийн олонхи гэдэг дээр маргаж байгаад, түүнийг зассан шүү дээ. Тэгээд энүүгээр чинь бид нар, ямар ч байсан тэр нэrsийн жагсаалт гэдгээр үлдсэн шүү дээ. Тэгээд энэ дээрээ бид маргаад байх шиг байх юм.

Тэгэхээр энэ дээр ийм санал байна. Ер нь ердийн, тэр нэrsийн жагсаалтаар байж болно гэж би саналаа хэлмээр байна. Энэ дээр ер нь бид хариуцлагатай байхын тулд энд ирсэн. Тэгэхээр хэр зэрэг хариуцлагатай байсан юм бэ гэдэг нь ил тод үлдэг. Тэгэхээр тэр дөрөвний нэг гэдэг байж болох юм. Тэгэхээр нэг хүний саналаар биш дөрөвний нэг орчим хувь нь санал гаргаад, түүнийг нь үндэслээд нэrsийн жагсаалтаар авч болох юм гэж энэ саналыг дэмжиж байна.

396 дугаар тойргийн депутат Б.Чимиц: Нэгдүгээрт, шийдвичүүсэн юмаа дахин хэлэлцмээргүй байна. Тэгэхээр энэ дэг бол З хэсэгтэй. Толгой нь хөлөө захирч явдгийн адил өрөнхий зүйл нь тусгайгаа захирч явдаг хуулийн логик бий.

Ерөнхий зүйл аливаа асуудлаар саналыг нэрээр ба нэргүйгээр хураах хоёуланг нь баталсан байгаа. Нэрээр батлахын хувьд бид олонхийн гэдгийг хасаагүй, ердийн олонхийг гэдгийг хасаагүй, одоо хасчихсан гээд ярьж байна. Ерөнхий зүйлд тэгээд орчихсон байхад, хойш нь асуудал бүр дээр тийм юм яриад баймааргүй байна. Тэгвэл депутатын асуудлыг яах вэ? шүүхийн асуудлыг яах вэ? Застгийн газрыг яах вэ гээд, бүгдийг бичих болж байна. Ийм юман дээр маргамааргүй байна, нэгэнт шийдвичихсэн асуудал.

Хоёрдугаарт, ийм ойлголт байна. Ердийн олонхи шийдвичихсэн, харин шийдвэргүй хассан гэдэг ойлголттой депутатууд байгааг Их Хурал удирдаж байгаа хүмүүсүүд ойлгуулж өгмөөр байна.

Гуравдугаарт ийм асуудал байдаг. Депутатуудын Их Хуралд санал оруулах хүчин төгөлдөр нөхцөлийн тухай асуудал. Энэ манай хуульд байхгүй зүйл. Чигдээр цухалзаж байгаад, тэгээд ерөнхийдөө шийдвэгдлээ. Жишээ нь, бүлэг байгуулах дээр. Одоо хоёр ч байсан бүлэг, гурав ч байсан бүлэг. Тэгэхээр депутатууд чинь нэг бүхэл бүтэн байгууллагын эс учраас ганцаараа бүхэнд тулгаж болдоггүй, тийм учраас улс орнуудын парламентын практикт бол тодорхой тооны депутат нийлж байж, асуудлаа хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулах хэрэгтэй болдог, ийм ёс бий.

Жишээ нь; Францад 45 байгаа, Италид 60 байгаа, депутатын олон цөөнөөс болдог.

Би Элбэгдоржийг ийм асуудал ярьж байна уу гэж бодоод байсан, өөр өнгөөр яригдаад байна. Ийм юмыг хаяж хэлж баймаар байна. Тэгэхдээ даргын хувьд биш, депутатын хувьд хэлж болох байх гэж бодож байна. Ноднин тийм асуудал гараад байсан. Ажил хөөцөлдэж яваад энэ яваад байна ч гэдэг юм уу? Ярихаар энэ хүн яриад байна гэдэг юм уу? депутатууд адилхан ярих эрхтэй байгаа гэдгээрээ хүндэтгэмээр байна. Энд гомдол ирж, юм санах юм алга. Зарим үед хэлэхгүй олон юм хонгорч байна шүү. Чигдрийн депутатын тогтоолыг уншиж батлуулаагүй. Чимээгүй хаячихсан, санал хураагаад орчихисон. Сүүлд нь яваад үзсэн чинь түдгэлзүүлсэн байна. Тийм хууль байхгүй. Хуулинд З үндсийг нь заачихсан, депутатын хууль байна.

3.

Тийм учраас бол өчигдөр өөрөө хэлсэн бол бас л үүн шиг зэмлүүлэх байсан байх л даа. Өнөөдөр нэгмөсөн зэмлүүлчихье.

Ж.Уртнасан: Бид их дэлгэрэнгүй санал хураалт явууллаа.

Б.Чимид: Тэгээд хүүхэд шиг битгий загнаад байгаарай.

Ж.Уртнасан: Одоо бид нэгдсэн ойлголтой болсон гэж бодож байна. Асуудлыг, уур амьсгалыг, сэтгэлийн хөөрлөөр, улс төржүүлж болмооргүй байна. Бид хариуцлагаа мэдэрч байгаа. Түүхийн хариуцлагын өмнө сууж байгаа гэдгээ ч бид мэдэж байгаа. Сонгогчдынхоо өмнө хариуцлага хулээнэ гэдгийг ч мэдэж байгаа.

Тийм учраас хэт нэг тийш нь туйлшуулж, үзэл бодлын зөрөлдөөн хийхгүй байхыг депутат нөхдөөс хүсч байна. Энэ бол тулгалт биш, хүсэлт юмаа.

Республиканский парламент

Ерөөсөө энэ санал хураах, нэрсээр хураах шалгуурыг юу болгоё гэвэл нэгдүгээрт, бидний хэлэлцэж байгаа дэг дотор саналын зөрөөтэй зарчмын асуудал гэж байгаа. Үнийг анхны хэлэлцүүлгийн явцад, ямар ямар асуудлыг саналын зөрөөтэй зарчмын асуудал гэж үзэх вэ гэдгийг манай Их Хурлын дарга, орлогч нар шийдэж эцсийн хэлэлцүүлэгт, энэ зарчмын саналын зөрөөтэй зарчмын асуудлууд дээр нэrsийн жагсаалтаар санал хураая гэсэн ийм байдлаар дэгэндээ оруулаад, ингээд хэлэлцээд зохицьё гэж бодож байна. Бусад 10-ын "е" бол бусад бүх төрлийн асуудалд хамарагдана гэж үзвэл ямар байна вэ?

Ж.Уртнасан: Бас нэг хувилбар гарч ирж байна. Их Хурлын удирдлага гэсэн. Ингээд бид саналаа тасалбал ямар вэ?

5 дугаар микрофон.

ТӨХИРСОН САЛБАРЫН ТОЛХОО

Би нэг уг хэлчихсэн. Айхтар эмзэглэж байх шиг байна. Би хариуцлагаас бултсандаа бишээ. Асуудлын соёлыг бодож ярьсан юм. Бид нар өчигдөр яриад тохирсон зүйлээ өнөөдөр дахиад л эргээд буцаад байна, тэр үүднээс. Яагаад зориуд ингэж нэrsийн жагсаалт руу шахаад байгаа юм бэ? цаанаа даралт үзүүлээд байгаатал байна уу? гэдэг үүднээс ярьсан юм.

Ер нь бол депутатын эрх баталгаатай биш байна шүү. Бидний дотроос өнөөдөр хуулинд байхгүй аргаар бид нар нэгийнхээ эрхийг түдгэлзүүлчихээд байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр иймэрхүү юм ч бас гарахгүй гэх үндэс алга байна шүү дээ.

Ж.уртнасан : З хувилбар байна, эрхэм депутатууд аа.

З46 дугаар тойргийн депутат Ч.Лэмбэрэлням:

Би нэг санал хэлье гэж бодож байна. Тэгэхээр энэ саналыг нэrsийн жагсалтаар хураах нь зарчмын хувьд зөв гэж бодож байна. Тэгэхээр энэ асуудлыг бид өнөөдөр одоо ингээд гар өргөөд баталлаа гэхэд энэ дэгийнхээ I дүгээр зүйлийг дахиад эргээд өөрчлөх шаардлагатай болж байна. Дэгийн I дүгээр зүйл чинь хуульд тусгайлсан заагаагүй бол олонхийн саналаар асуудлыг шийднэ гэчихсэн. Тэгэхээр үүнийгээ дахиад л буцаад, бид өрөөсөө

5.

өчигдрээс хойш түрүүчийн баталсан юмаа дахин ярьсаар байтал хамаг цаг өнгөрч байгаа. Ийм учраас уүнийг бид, хэрэв энэ асуудлыг ингэж шийдэх юм бол 10-ны нэгээр ч гэдэг юм уу, дөрөвний нэгээр ч гэдэг юм уу саналаар ингэж шийднэ гэвэл тэр 1 дүгээр зүйлээ дахин өргөж авч үзэх хэрэгтэй болж байна.

Тэгэхээр энэ дэгд бол бас депутат тодорхой асуудлаар өөрийн бодол саналаа илэрхийлж, хэлэлцүүлэг явуулж, санал хураалгах эрхтэй гэсэн ийм заалт дэг дотор бас орчихсон байж байгаа. Тэгэхээр уүнийг заавал ингэж тусгайлан оруулах шаардлага байна уу үгүй юу гэдэг нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Их цаазын төслийг хэлэлцүүлэх явцад нэрсээр санал хураах асуудал, миний бодож байгаагаар цөөхөн асуудал гарах байх. Ер нь 10 орчим асуудал гарах байх. Тэгэхээр түүнийг нийт депутаттууд энэ цөөнхийн тавьсан санал гэж үлдээхгүйгээр нийтээрээ энд нэрсийн жагсаалтаар 10-ын "е"-д заасны дагуу санал хураалгах ийм бололцоотой, үндэслэлтэй, зүйл гэж бодож байна. Тэгэхээр одоо бид энэ ярьж байгаа асуудлаараа санал хураагаад хэрэв, энэ хүмүүсийн тавьж байгаа хүсэлтийн дагуу асуудлыг шийдэх юм бол дэгийнхээ нэгдүгээр зүйлээс бусдыг өргөж ярих л хэрэгтэй болох нь байна. Ийм байдлаар асуудал чинь улам цаашаа сунаад яваад байна.

Ж.Уртнасан:- Саналыг тасалъя. Тэгэхлээр бидэнд дөрвөн хувилбар байна. Ер нь зарчмын хувьд авч үзвэл бид нэрээр хураана гэдгээс татгалзаагүй. Хоёр зүйл дээр аль алин дээр нь нэрээр хураана гэдэг энэ заалт хэлэлцээд баталсан. Тэгэхдээ ганцхан нэрээр хураана гэдэг нь "г" заалт дээр шалгуурын хувьд бид нар нэлээн будиллаа. Гурван хувилбар гаргаж ирж байна. Нэг хэсэг нь аравны нэг дөрөвний нэг буюу дөчин хүн гэдэг ийм хувилбар гаргаж байна. Хоёр дахь хувилбар нь Их Хурлын удирдлага шаардлагатай гэж үзвэл гэсэн ийм хувилбар гаргаж ирж байна. Гурав дахь нь аль нэгэн, шаардлагатай гэж үзвэл аль нэгэн

булгийн шаардлагаар нэрээр санал хураана гэсэн ийм гурван хувилбар байна. Энэ гурван хувилбар дээр санал хураагаад цаашаа явах уу? Дөрөвний нэг, аравны нэг, дөчин хүн гэсэн гурван хувилбар байгаа юм. Нэгдүгээр хувилбар байгаа юм.

— Олонхи нь зөвшөөрсөн тохиолдолд, өрдийн олонхи нь зөвшөөрсөн тохиолдолд.

— Ердийн олонхи гэсэн нэг хувилбар байгаа шүү дээ.

— Ердийн олонхийг чинь өчигдөр уг нь баталчихсан санал шүү дээ. Зөвшөөрсөн санал.

— Тэрийг баталчихсан шүү дээ. Яагаад тэрийг задлах гээд байна вэ? Өчигдөр тэрийг баталчихаад тэрэн дээр ахиад яриад байгаа шүү дээ бил нар дарга аа.

Ардын Их Хурлын 285 дугаар тойргийн депутат С.Батсүх: Өчигдөр одоо бил өрдийн олонхийн саналаар шаардлагатай болбол нэрээр авья гээд тохирчихсон шүү дээ. Тэгээд баталсан. Тэгээд энэ дээр ахиж өргөж ороод хичнээн их маргалаа л даа. Ингэхээр явахгүй байна аа. Шийдсэн юмаа дахин дахин өргөж яриад баймаартгүй байна.

Ж.Уртнасан: — Өнөөдрийн хувьд цөөнхийг хүндэтгэж сонсоно гэж бутгдээрээ өргөж будлиад байна. Бид ярыж байгаа шүү дээ. Дэгтэй болсон хойно бил арай өөр дэгтэй байх байхаа гэж бодож байгаа шүү дээ. Санал хураалтаа явуулъя. Ардын Их Хурлын удирдлага шаардлагатай гэж үзэвл нэрээр санал хураана гэсэн энэ хувилбар дээр санал хураалт явуулъя.

Бид шалгуур л олж авах гэж байна шүү дээ. Санал хураалтанц бэлтгэнэ уу.

Тодруулж хэльв. Нэгдүгээр хувилбар маань бас потроо гурван

дэд хувилбартай учраас бид зайлсхийж байгаа юм. Хоёр хувилбарыг нь бид эхлээд санал хураалт явуулчихаад хамгийн эгзэгтэй шалгуртай, тэр аравны нэг, дөрөвний нэг, дочин хүн тал хувь гэдгийг дараа нь хэлэлцье гэж бодож байна. Нэг хувилбар нь Их Хурлын удирдлага шаардлагатай гэж узвэл нэрээр санал хураана гэсэн энэ хувилбарыг үлдээх үү гэдэг дээр санал хураалт явуулах гэж байна. Их Хурлын удирдлагад энэ эрхийг олгох гэж байна. Санал хураалт явуулья.

Депутатуудын 54 хувь нь буюу 221 хүн Их Хурлын удирдлага шаардлагатай гэж узвэл нэрээр санал хураах ийм хувилбарыг оруулж байна. Дараагийн хувилбаруудыг зэрэгцүүлэн үзэх үү? Одоо 54 хувь байна. Одоо тодорхой бүлгийн шаардлагаар нэрээр санал хураана гэсэн. Тэгэхлээр энэ бүлгийн гэдгийг би тодотгож хэлмээр байна. Манай нэхдүүд бүлэг гэдгийг 40 хүнтэй байна. 4 хүнтэй байна гээд ✓ маргаад байна. Онөөдөр Их Хурлын удирдлагад ирүүлж байгаа анхны бүлэг эмэгтэйчүүдийн бүлэг байна. Манай энэ хуралд сууж байгаа бүх депутатуудын дотор есхэн эмэгтэй хүн байгаа. Тэгэхдээ энэ хэд маань бүлэг болно гэдэг нэрийн жагсаалтаа, протоколоо ирүүлчихсэн учраас анхны бүлэг 9 хүнтэй байна шүү. Тийм учраас бүлгийн шаардлагаар гэвэл наад талынх нь 9 хүнээс дээш байж таарах нь уу гэж бодож байна. Ингээд аль нэгэн бүлгийн шаардлагаар мэргэжлийн, хүйсийн, эвсэл, холбоодын намын бүлгүүд байж болох юм шиг байна. Аль нэгэн бүлгийн шаардлагаар нэрээр санал хураалт явуулна гэдгийг санал хураалгая. Аль нэгэн бүлгийн хүсэлтээр.

22 хувь нь зөвшөөрч, 71 хувь нь татгалзаж байна.

Гурав дахь хамгийн түвэгтэй хувилбарт орьё. Депутатуудын зарим нь аравны нэгийн хүсэлтээр гэдэг дээр санал хураалт явуулья. Дараа нь дөрөвний нэг 40 хүн гэсэн хоёр дэд хувилбар байгаа. Аравны нэг гэдэг маань тооны хувилбараар бараг 40 орчим хүн л дээ. За аравны нэгийн хүсэлтээр нэрээр санал хурааж болно.

20 хувь нь зөвшөөрч байна.

• 8 •

За 54 хувьтай, 22 хувьтай, 20 хувьтай байна. Одоо сүүлчийн хувилбар бол дөрөвний нэг гэсэн хувилбар буюу хүний тоогоор бол 100-гаас дээш хүн гэсэн ийм хувилбар үлдэж байна. Дөрөвний нэгийн хүсэлтээр нэрээр санал хурааж болно гэдэг хувилбарыг санал авья.

I76 хүн буюу 43 хувь нь энд санал өглөө. За та бүхэн санаж байгаа. Их Хурлын удирдлагын шаардлагаар гэдэг 54 хувьтай, Булгийн гэдгээр 22 хувь, аравин нэгээр 20 хувь, дөрөвний нэгээр 43 хувийн санал авлаа. Ингээд...

Уучлаарай бас нэг хувилбар үлдэж байгаа юм байна. Хуучин өчигдөр санал авсан хувилбар. Зарим депутатууд ердийн олонхийн гэдэг энэ хувилбарыг дахиж оруулж өгөөч гэж байна. Ердийн олонхийн гэдэг талаар санал хураалт явуулах ёстой юу? Хэрэгтэй юу Арвины "ө"-д байгаа шүү дээ. Арвины "ө"-д ердийн олонхиор гэсэн заалт байгаа. Тийм учраас энэ дээр давхардуулаад хэрэгтгүй байх. Харин энэ дээр нэрээр санал хураана гэдгийг Их Хурлын удирдлагын шаардлага, Их Хурлын удирдлага шаардлагатай гэж үзвэл нэрээр санал хураана гэсэн ийм хэлбэрээр редакц хийхээрүүлдээе.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ
ТУЛГАЖ НИЙЛСЭН

Уваженчийн

Д.БАЯНДҮҮРЭН

БИЧЭЭЧ Л.ХОРЛОО

1991-XI-12
Кассет № 61
I7.25-I7.40

Уртнасан:

Эрхэм депутатууд аа! Хуралдаанаа үргэлжлүүлье.

Хурлын даргаа нэг зарчмын санал байна.

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж:

Уртнасан:

Учлаарай Элбэгдорж оо. Бид ирцээ нэг бүртгээд, хүмүүсээ нэг бүртгээд авья. Тэрний дараа.

Нэгдүгээр микрофоныг уу. Хэлэх зөвшөөрөл өгөхгүй юу. Хурлын даргаа.

Депутатуудаа бид бас илэн далангуй ярьмаар байна. Энэ завсарлагааны дараа нэлээд олон депутатуудын суудал онгойчихлоо. Ийм учраас бид бас дэгтэй, журамтай, ард түмнийхээ өмнө, сонгогчынхоо өмнө хулээсэн хариуцлагатай улс. Тийм учраас ирцээ бүртгэе. Суудал, суудал дээрээ байхыг урьж байна. Яагаад вэ гэвэл онгорхой байгаа суудлуудын нэрийн жагсаалт шууд гарч байгаа. Бид үүнийг мэдээлнэ. За ирц авья бэлтгэнэ уу.

За бэлэн болсон байх. Ирцийг бүртгэж байна. Эхэллээ.

За ирвэл зохих 427 депутатас 404 дэпутат буюу 94 хувь нь ирсэн байна. Одоо энэ 26 депутатын нэр бидэн дээр ирэх байх. Энийг бид шалтгааныг нь тодотгоё. Яагаад хуралд оролцоогүйг бид тодотгоно.

За 6 дугаар микрофон. Элбэгдорж.

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж: Нэг зарчмын санал хэлэхгүй бол болохгүй нээ. Нэгдүгээрт хурлын удирдлагаас, хурал удирдаж байгаа хүнээс нэг зүйлийг хүсэхэд гарсан саналыг гарсан тэр дэс дарааллаар нь хураалгаж баймаар байна. Хоёрдугаарт ямар нэгэн бодлого явуулмааргүй байна. Эхлээд санал хураалгаад, дараачийн саналуудыг өө энэ түвэгтэй хувилбар байна. За нэг хураачихуудаа гэсэн. Ийм байдлаар нэлөөлэхгүй баймаар байна. Түвэгтэй хувилбар байна гэдэг чинь энэ хэрэгтүй хувилбар юмуу даа гэсэн үгийг та тэндээс шууд хэлж байна.

2.

Хурлын удирдлага бол зөвхөн хурал даргалагч. Би тэгж л ойлгосон. Бид бүхэнд ашиглан л үйлчлэх ёстой. Яг л хурал даргалагч. Ямар нэгэн бодлого явуулдаг хүн бишээ гэж ингэж ойлгож байгаа. Дараачийн нэг зүйл бид нар тэр нэрээр санал хураах дээр хурлын удирдлага шийднэ гээд ойлгоочихлоо. Уртнасан гуай ганцаараа шийдэх юмуу, аль эсвэл хурлын удирдлага гээд дөрвөн удирдлага даргатайгаа нийлж байж ярьж байж шийдэх юмуу. Энэ тав дотроо ярилцаад олонхийн санал авахаар нь хураах юмуу. Хурлын удирдлага гэж хэнийг ойлгох юм бэ гэдэг асуудал гарч ирж байна. Хурлын удирдлага нэрээр санал хураах уу, угтуй юу гэдгийг хурлын, удирдлага тодорхойлох ёсгүй гэж би бодож байгаа. Энэ бол ямар нэгэн бодлого явуулдаг биш, тухайн хурлыг л гарсан саналын нь дагуу л тэрнийг л санал хураалгаад тухайн хурлыг л удирдах ёстой. Хэрвээ орлогчид нь оролцно гэж ингэж үзвэл орлогчид нь, хурлын удирдлага гэх юм бол орлогчдыг оролцуулж байна гэж би үзэж байгаа. Орлогчид гэдэг бол зөвхөн бидний өөдөөс индэр дээр гарч сууж, бидэн руу харж суугаагаараа биднээс ялгагддаг байх ёсгүй гэж бодож байна. Ямар нэгэн үүрэг л хүлээсэн байх ёстой. Биднээс ялгагдах юм одоо харагдахгүй л байна. Тэгэхээр энэ хурлын удирдлагад 54 хувь гээд ингээчихлээ. Та бүхэн өөр дээрээ илүү ачаа үүрчихэж байгаа юм биш үү. Нэг л бодлого явуулдаггүй. Тэгээд түвэгтэй санал байна, түвэгтэй хувилбар байна. За энэ дээр гэсэн иймэрхүү байдлаар саналыг ялгамааргүй байна.

Уртнасан: Таны хэлснийг анхааралдаа авлаа. Эрхэм депутат Элбэгдорж оо.

Харин өөрийнхөө хувилбарыг дахиад нэг цөөнх болсны хувьд сонсгохгүй юу. Тэр 54 хувийг дахиад задалж болох л юм.

Болат:

Цөөнхийн санал хэлмээр байна. Нэгдүгээр микрофондоор.

Уртнасан: Олонхийн саналаар бид шийдлээ. Цаашаа явъя гэдэг саналтай байна.

Болат:

Цөөнхийн санал хэлэх учиртай гэж бодож байна. Би энд.

Уртнасан:

Дэг одоохондоо батлагдаагүй л байгаа шүү. Болат депутат. Гэхдээ би таныг сонсоё гэж бодож байна.

Их Баярлалаа танд.

72 дугаар тойргийн депутат А.Болат: Тэгэхээр бид сая нэг ийм юман дээр төөрөгдчихшиг боллоо. Ерөөсөө бид эхэндээ асуудал хэлэлцэх үндсэн очер дээрээ, ерөөсөө толгой дээрээ хийсэн гэсэн энэ утгаар л депутатууд бол ийм санал өгөх шиг боллоо. Бид энүүн дээрээ төөрөгдж болмооргүй байна. Нэгэнт Үндсэн хуулин дээрээ тусгай хэвлэл гаргаж, тэгээд нэрээр цаана нь хураах уу, угүй юу гэдэг асуудлыг ингэж хэлэлцэж байгаа тохиолдолд. Би турүүн эхэнд хэлэлцсэн

гэсэн утгаар саяны олонхийн саналаар шийднэ гэсэн энэ асуудлыг бүрхэгдуулж болохгүй байна. Бид бол депутатуудын 50 хувь нь, магадгүй 60, 70 хувь нь ямарваа нэг зүйл анги дээр нэрээр санал хураая гэж санал гаргаж байхад хурлын дарга л зөвшөөрөөгүй гэдгээр бидний эрх, санал хүсэлтиг хааж болохгүй шүү дээ. Тийм учраас саяны асуудал дээр өргөж узэх хэрэгтэй. Депутатууд ч гэсэн их анхааралтай бодох хэрэгтэй байна. Бид хэрвээ нэрээр хураана гэсэн заалтыг бухэлд нь дээрээ томъёолсон гэдэг утгаар хэлэлцэж байгаа болбол энд энэ тухай ярих хэрэг байхгүй. Үндсэн хуулийн энэ асуудал дээр тухайлж хэлэлцэнэ гэж узэж байгаа болбол дийлэнх олонхи нь заавал өөрийнхөө саналаар, нэрээр санал хураалгах асуудлыг шийдэх ёстой гэж бодож байна. Тийм учраас сая 54 хувь санал өгсөн асуудлаа өргөж санал хураая. Миний энд хэлэх гэж байгаа асуудал болбол аль нэгэн гишүүний санал болгосноор нэрсээр санал хураах асуудлыг олонхийн саналаар шийднэ гэж. Ердийн гэсэн уг нэмж болно өрдийн олонхийн саналаар шийднэ гэж энэ дээр тухайн үед нь тавьж өгөх хэрэгтэй. Үндсэн хуулийн энэ асуудал дээр тухайлж хийж өгөх шаардлагатай гэж бодож байна. Энүүн дээрээ санал хураалгаж өгөхгүй юу.

264 дүгээр тойргийн депутат Б.Банли:

Болат депутатын саналыг ой дэмжиж байна. Тэгэхээр 2 цаг энэ дээрх заалтыгяриад эцсийн эцэст маш буруу шийдэх гээд байна. Өөреөр хэлбэл, ардчилалаа бодсон ч, аль талаас нь бодсон ч тэр чинь олонхийнхоо саналаар шийдэх ёстой энэ асуудлыг ганцхан хүнд даатгаж, тэрний узэл бодлын хэмжээнд, тэр дундаа хурлын даргыг хүнд байдалд оруулж. Мэдээжийн хэрэг хурлын дарга энэ асуудлыг шийдэх юмаа гэж бодоход өргээд бид нараар, депутатуудаар хэлэлцүүлж байж шийдэх энэ асуудал байж таарна. Эсвэл дангаараа шийдэхэд

4.

хуралдааны даргад их бэрхшээл учирна. Ямартай ч байлаа гэсэн 54 хувийн энэ саналаар ингэж хуралдааны даргад үлдээж болмоортуй байна. Яагаад гэвэл бид нар 40 хүнийг цөөдөж байна, 25 хувийг цөөдөж байна гэсэн байдлаар ярьсаар байгаад эцсийн эцэст нэг хүн дээр үлдээж таарахгүй. Тэгэхээр 10-ын Е дээр үндсэн санал байна гэдгийг дээр олон депутатууд ярьсан. Тэнд болбол гол асуудал туссан учраас нэгдүгээр вариант бол Г заалтыг хасаж болох нэг үндэстэй. Хэрвээ Г заалтыг байлгана гэж үзэх юм бол олонхийн саналаар гэдгийг одоо санал хураалт авч шийдэж өгөөчээ. 4 дэх вариант болгодог юмуу, эсвэл I дүгээр вариант болгодог юмуу. Түргүн З вариантаар санал авсан. Дээр нь нэмээд ердийн олонхийн саналаар гэдэг асуудлаар санал хураалгах ийм саналтай байна. Энэ Г дээр байна гэвэл. Г-г хасна гэвэл урд байж байгаа шүү дээ. Бэлхэн. Энийг олон талаас нь ярихгүй . Шийдэж санал хураалгаж өгөөчээ. Олонхийн санал байх нь арай ардчилалын үед нийцэж байгаа юмуу гэж бодож байна.

207 дугаар тойргийн депутат М.Моёор: Тэгэхээр би нэг зарчмын зүйл дээр анхаармаар байна гэдгийг өрхэм депутатуудад хандаж хэлмээр байна. Бид ер нь зарчмын нэг зүйлийг анхаармаар байна. Бид өнөөдөр улс орныхоо, ард түмнийхээ хувь занаг шийдэх үүрэг, эрхийг бурэн авчихаад өнөөдөр бидний гарг байж байна. Тэгэхээр бид энэ асуудалд туйлын хариуцлагатай хандах ёстой. Би 4 өдөр энэ хуралд сууж байна. Албан ёсоор хуралдаан эхлээд хоёрдахь өдрөө явж байна. За аливаа зүйлд буйр суурьтай, ухаалаг хандмаар байна. Тийм хандлага гарахгүй байна гэдгийг би шүүмжлэлтэй хэлж байна.

Тухайлбал гарч байгаа асуудлыг шинжилгээ хийж хамгийн оновчтой зөв вариантуудыг барьж бид шийдмээр байна. Сүүлийн хоёр едрийн хуралдаанаас харахад ерөөсөө асуудалд их хөнгөн хандаг, туйлшрах явдал элбэг байна. Жишээ нь одоо депутат нөхөр Г.Очирбат 24 цагийн дараа эргэж хэлэлцэе гээд нэг асуудал хэлэхэд тэгье гээд батлаад хаячихдаг. Тэгээд буцаад больё л гэдэг. Элбэгдорж зарчмын юм хэллээд байсан. Энэ одоо сенсац шүслээ шүү дээ. Энэ нэрээр хураах асуудал дээр эмзэглэж байсан. Зарим улсууд сая. Эмзэглэж байсан. Ер нь бол нэрээр хураах асуудалд эмзэглэх ёсгүй юм.

Ерөөсөө үнэний төлөө явж байгаа. Бидний шийдвэр бол 100 хувь тийм сайн юм гарч чадахгүй л дээ. 80 хувь нь онож сайн юм байж болно, 20 хувь нь алдаж болно. Энэ жил бид нар Монголын сая гаруй ард түмний саналыг авчихаад ирсэн. Ийм л депутатууд энд өнөөдөр төрийнхөө асуудлыг шийдэх гэж байгаа учраас энд ихээхэн бууртай сууж хандмаар байна. Бас нэг эвгүй үнэр байна. За энэ бага хурлынхан босоод ирлээ. Энэ л их өгзэгтэй улсууд ирлээ. За тэр эвсэл холбоодынхон босоод ирлээ. Тэр Элбэгдорж олон босоод байна, тэр өгзэгтэй гэдэг тэр хуучин До яамны үзэл бодлоор бие биенээ хардмааргүй байна. Бас зарим нь хэт хуучинсаг үзэл гаргаад дараа нь та нар намайг ях гээд байна вэ? Энэ шинэ хүчнийхэн Бат-үүл эд нар ях гээд байна вэ? гэж Чунагсүрэн гуай сая тэгж яриад байсан. Тэгэхээр биенээ хардаж мөрдөлгүйгээр биднийг хүрэх л нэг замруугаа явж байгаа учраас энд биенээ хардлаг хуучин сэтгэлгээнээс салаад зөв замаараа явахын төлөө тэмцмээр байна. Тэгэхээр асуудалд хэн тавьж байгаа депутатыг ялгамааргүй байна. Тийм учраас бидний тавьж байгаа энэ асуудал чинь бол депутат хүнийг улс төрийн үзэл бодлоор нь ялгах гэсэн хуучин үнэр ханхалж байна. Энэ бол их эвгүй байна гэдгийг хэлмээр байна.

Тэгээд би цөөнхийн хувьд хэлж байна. Сая олон депутатууд нэрээр санал хураах гээд байсан. Тэгээд сүүлд нь явсаар байгаад аль ч үгүй жинхэнэ хурлын даргад өгөөд ингээд хаячихаж байна шүү дээ. Энэ бол ерөөсөө таарахгүй. Тийм учраас нэрээр хураана гэдэг асуудал дээр зоригтой хэлчихээд яг энэ дээр нууц санал хураахаад тарчихаж байна. Ийм учраас өсвэл энийг Үндсэн хуулийн гол төслийг нэрээр хураая гэсэн энэ саналыг тийм тийм депутат бол олонхийн саналаар зөвшөөрсөнгүй. Ингээд нэрээр хураахаа болилоо гэдгийг маргааш төвийн хэвлэл, сонинуудаар тавьж өгмөөр байна. Тэгэхгүй бол дахин санал хүсэлт оруулж байна.

23-р тойргийн депутат Ц.Энхбат:

Саяны депутатын саналтай нэг байна. Дахиад санал хураалт явуулахыг хүсч байна. За хураахдаа сая цөөнх болсон депутатын булгуудээс гарсан саналаар, өсвээс депутатын аравны нэг нь санал болгосноор нэрээр санал хураах явдал дээр санал ався гэсэн

ийм тодотголоор оруулаад санал дахиж хураахыг хүсч байна. Хэрэв энд олонхийн санал аваагүй нөхцөлд одоо энэ явуулах гэж байгаа санал хураалтыг компьютерт нэрээр нь гаргаад тэргүүнийг ёстой танилцуулах хэрэгтэй байна. Хэд нь татгалзаж байгаа, хэн хэн татгалзаж байгааг үзмээр байна.

157 дугаар тойргийн депутат Л.Одончимэд: Бид нар өнгөрсөн жил гурав хоног хуралдаад дэгээ баталж чадаагүй. Сүүлдээ дэггүй баахан хурал хийснээ бүгдээрээ санаж байгаа байх. Говьд нэг шене төөрөхөд давхиж давхиж нэг төөрсөн газраа эргэж ирээд дахиад нэг өвгөнөөр эзлгаж аваад дахиад нөгөө газраа эргэж ирээд байдаг шиг бид нар, ингэж эргэж ирсээр байгаад эцсийн эцэст ихэнх асуудлыг дэмий баахан маргаж цаг аваад, түрүүчийн боловсруулж оруулсан дэгийн дагуу асуудлаа шийдэж байна шүү дээ. Тэгээд Уртиасан даргаас хүсэхэд бид нар өчигдөр шийдсэн шүү дээ. Ерөөсөө дэгийнхээ дагуу хэлэлцээд яваад байя. Тэгж байтал нэг хөндлөнгийн асуудал орж ирээд бүх асуудлыг бүр ар руу ч явуулаад, бүр урагш нь нэг явуулаад ингээд баймааргүй байна. Өчигдрийнхээ шийдсэнээр явсан бол өдийд бид нар дэгээ баталчихсан байх ёстой. Тэгээд даргаас хүсэхэд нэгэнт тогтсон зарчмынхаа дагуу явуулаачээ. Битгий өргөж, хургаад байгаа чээ гэж ингэж хүсмээр байна.

Хоёрдугаарт ажиглаад байхад энэ хөндлөнгийн асуудал оруулж ирээд байгаа улсууд өчигдөр ярьж байсан юмыг өнөөдөр гаргаж ирээд байгаа асуудлыг би бодохдоо хурлыг зориуд сунжуулах гэсэн хүчин байгаа юмуу гэж ойлгогдож байна. Тухайлбал би Чимид гуайг шүүмжилмээр байна. Өчигдөр ярьж ярьж Цээн-ойдовын асуудлыг шийллээ гэж тохирсон. Тэгсэн өнөөдөр үзээс хойши завсарлагаан дээр орж ирээд Чимид гуай баахан юм яриад энүүнийг болиулсан. Дахиад будилуулсан. Тэгэхээр миний хувьд Цээн-ойдов гуай нэгэнт боссоных өчигдреес хойш бидэнд голын улсуудад микрофон олдохгүй хэцүү юм байна. Харин далиманд нь голын улсуудыг микрофоноор хэлдэг, ярьдаг механизм бий болгож өгөөч гэж даргаас хүсмээр байна.

Цээн-ойдов гуайн хувьд бол энэ чинь жилийн дараа яагаад энэ ийм асуудлыг гаргаж ирж байгаа юм бэ. Ноднин ярьдгаа яриад

энэ хүнийхээ юмыг баталсан шүү дээ. Ийм учраас Цээн-ойдов гуайн асуудлыг депутат чигээрээ байг гэсэн ийм саналыг дахиж яриач гэж ингэж бодож байна.

Одоо яахав нэгэнт асуудлыг тавьсан учраас би энэ асуудлыг дахиж ярихгүй гэж бодож байна. Энийг Чимид гуай өөрөө гаргаж ирсэн. Ийм учраас би ярихаас өөр аргагүй болсон.

Өөр нэг асуудал бол нэрээр авахын тухай ярьж байна. Бид нэрээр авна уу, юугаар авна уу, бидэнд ерөөсөө ялгаа алга. Бид өгдөг саналаа л өгнө, тэр ар талд хэдэн хүн байдаг юм. Зарим нь 10000 гэх байх, зарим нь 3000 гэх байх. Тэр саналаараа сонгогчдынхоо захия даалгаврыг бид биелүүлнэ. Өөрөө толгойтой, бөндгертэй учраас депутатынхаа хувьд хэлдэг угээ хэлэх байх гэж бодож байна.

Тэрнээс биш бид нар нэрээр авахаас айгаад байх юм алга. Зүгээр ерөнхий саналд нэрээ оруулаад явахаас хулчийгаад байх юм алга. Ийм байна.

Өөр хамгийн суулийн санал ийм саналтай байна. Бид одоо дэгээ баталж чадахгүй гурав хонох нь байна шүү дээ. Өнөөдөр аягүй бол дусахгүй нь. Энэ гадна, дотны улсуудыг суулгах юм бол ерөөсөө энэ дэгээ баталтлаа энэ хурлаа хаалттай хийе. Ийм будилсан хачин улсууд байдаг юм байна гэж энэ олон түмэн чинь ойлгоно биз дээ.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

З.Мурда

ЭНХТУЯА

Бичээч

В.Оюун

1991-II-I2
Кассет № 62
I7.40-I7.55

Д.Баттулга /Т48 дугаар тойргийн депутат/ -Би энэн дээр өөр санал гаргамаар байна. Зүгээр турүүн бид нар хурлын даргад эрх өгөх шиг боллоо.. Би хувьдаа юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр энд удирдаж байгаа хурлын дарга нар бол энэ хурлыг зохицуулагч болохоос биш тодорхой шийд гаргадаг хүмүүс биш гэж би бодож байгаа. Тийм учраас аливаа хурлын даргатай холбогдсон эрхийн асуудал дээр депутат нөхөд бас бодолтой хандахгүй бол болохгүй, нэгд.

Хоёрдугаарт, энэ нэрээр хураах асуудал, бид нар ийм зарчим барьж байгаа шүү дээ. Нэрээр хураах асуудлыг юуны төлөө саналаа өгөөд, тэр өгсөн саналаа ил хэлэх хэсэг нь тэр депутатын бүрэн эрхийн асуудал. Энийг депутатууд ойлгож байгаа байх. Нэрээр хураана гэдгийг шаардаад байгаагийн учир нь тэр аливаа депутат юуны төлөө саналаа өгөв гэдгийг тэр депутатас үл асууж, шууд олон түмэнд мэдээлэх энэ асуудлыг л тавьж байгаа. Энэ утгаар л тавьж байгаа. Зүгээр би энэн дээр асуудал яхын тулд, зүгээр олон хүмүүс, олон вариантаар хэлж байгаа. Энэн дээр би турүүн манай техникийн нөхдүүд энэн дээр баталгаа гаргаад өгчихвөл болмоор юм шиг санагдаж байгаа юм. Бидний энэ машинаар хураагаад байгаа энэ санал хураалт бол ил санал хураалт. Энийгээ бид нар тогтох хэрэгтэй. Нэрээр санал хураана гэдэг чинь ил уу, далд уу гэдгээс үл хамаараад зөвхөн нэрийг зарлах асуудал. Бид нар бол саналаа ил хураая. Нэрээр яхад тэр компьютер дээр суудлаар гардагсан уу, нэрээр гардагсан уу тэрэн дээр манай техникийн нөхдүүд бол нэрээр хураахад, эндээс кнопк даравад тэнд тэр хүний нэр гарч байгаа гэсэн тийм баталгааг энэ хуралдаа гаргаж өгөөд ингээд асуудал шийдчихмээр байгаа юм. Энэн дээр ямарваа нэгэн цаас, ямарваа нэгэн тийм цаг хугацаа зарсан тийм асуудлыг бол би байхгүй гэж бодож байна. Тийм учраас би ямар асуудал хэлэх гэж байна вэ гэхээр Үндсэн хуулийн хоёр дахь хэлэлцүүлгийг зүйл бүрээр нь нэрээр нь хураах л гэж, бид нар зөвхөн энэ кнопк даравад л суучихна шүү дээ. Түүнээс тэрэн дээр нэг их цаг хугацаа алдаад байх юм байхгүй. Цаг хугацааны фактор өрөөсөө байхгүй.

Тэгээд энэн дээрээ бол зөвхөн нэрээрээ өгч байна гэдгийг тохирчихвол энэн дээр нэг их маргалдаад бариад байсан юм бол байхгүй л гэж би бодож байна. Тийм учраас тэр 10 хувийн саналаар, 20 хувийн, 25 хувийн саналаар ч гэдэг юм уу, даргад эрх өгөх ч гэдэг юм уу, энэ асуудлуудыг ер нь болиод, нэгэнт бид нар ийм төхникийн боломж байгаа учраас энэ боломжоо ашиглаад, тэгээд бүх юм нь болж байгаа учраас би зөвхөн анхных гээгүй, хоёр дахь хэлэлцүүлгийн зүйл ангиудаар нь нэрээр хураагаад ингээд явчихна гэж болно гэсэн ийм л саналтай байна.

Ж.Уртнасан - Ердийн олонхийн саналаар гэдэг саналтай байх шив дээ Баттулга депутат.

Л.Баттулга - Угүй ээ, би зүгээр байна шүү дээ. Энэн дээр ямарваа нэгэн санал хураахад түүнийг авч узэх шалгуурыг тогтоомооргуй байгаа юм. Ерөөсөө энэн дээр зүйл болгон дээр бид нар санал өгнө шүү дээ. Тэрэн дээр л кнопоо дараад л өнгөрчихнө. Тэгээд тэр техникийн нөхцүүд хэн юун дээр гарсан бэ гэдэг нь тэр дисплей дээр гараад ирнэ. Тэрийг нь яхав болж өгвөл хaa нэгтээ газар нь зарладаг юм уу яадаг юм, тэр эрхийг нь бид нар энд нь нээлттэй өгчихье л дее тодорхой хүнд, зарлах эрхийг нь. Энэн дээр шалгуур байхгүй бүх зүйл дээрээ л нэрээр өгчихье.

Д.Лундээжанцан /15 дугаар тойргийн депутат/ - Тэгэхээр ийм байна л даа. Хэрэв аравны нэг буюу булэг, ингээд хэрэв санал хураалгая гэж цөөнхийн санал болж хураалгавал би ч гэсэн дөрөвний нэг гэсэн энэ санал дээрээ дахин санал хураалгахыг хүсч байна. Өөрөөр хэлбэл тэр зүйл болгон дээр санал хураана гэдэг чинь бид нэг зүйл дунджаар тав байна. Өөрөөр хэлбэл өнөөдөр бидний хэлэлцэх гэж байгаа Их цаазын төсөл эцэслэн ороход 70 зүйлтэй, дотроо тав таван дэд хэсэгтэй, дэд хэсэг болгоноор нь хураахаас аргагүй. Нэг зүйлийн нэг дэд хэсэг дээр нь хэд хэдэн янзын, доторхи нэг, хоёр, гурав, дөрөв гээд голдуу дөрөв байгаа. Энэ болгон дээр санал нэгтэй

3.

нь таарч байхад негөө хоёртой нь таараахгүй хүмүүс гарч болно. Ийм учраас 350 удаагийн саналыг заавал ингэж нэрээр хураах шаардлага байна уу? Бид түүхийн өмнө хүлээх тодорхой хариуллагат, тодорхой сонгогчдынхоо санаа бодлыг илэрхийлэх юман дээр нэрээр хураах ёстой. Энээнээс бид айх, эмээх, янз бурийн нуух, хаах тийм зүйл байхгүй. Ганцхан Их Хурлаа, соёлоо, парламентынхаа соёлыг хүндэлж узвэл яласан юм бэ? Ийм учраас бид заавал ердийн олонхи гээд байхгүй, заавал аравны нэг гээд байхгүй, дэрөвний нэг буюу аливаа асуудлыг шийдвэхийн талын тал хувь болох тэр хорин таван хувиар тэр асуудлыг шийдвэл хaa хаанаа арай зохимжтой хувилбар юм болов уу гэж би энэ санал гаргаад байгаа юм. Ийм учраас ор юм тавихгүй байх, эсвэл аль нэг тийш нь туйлшуруулахгүй байвал яласан юм бэ? Ингээд нэг хорин таван хувь буюу дэрөвний нэгээс доошгүй гэсэн саналаар дахин санал хураалгаж өгөхийг хүсч байна.

Ш.Лхагва /39I дүгээр тойргийн депутат/ -Хурлын даргаас, удирдлагаас хоёр зүйл хүсэх байна. Одоо ингээд надаас өөр энэ микрофоны ард зогсож байгаа хүн алга байна. Дахиад энэ урд өмнө ярилцсан зүйлээрээ өөр хүн яриулмааргүй байна. Энэн дээр нэг дүгээрт юу гэж хүсэх гэж байна вэ гэвэл, одоо урьд нь шийдсэн нэг асуудлаа дахин битгий хэлэлцүүлээчээ, одоо өрөөсөө эцэслээ, дахин босохгүй, дахин ярилцахгүй шүү энийгээ гэсэн ийм санал хураалгаж өгөөч гэсэн ийм хүсэлт байна.

Хоёрдугаарт, нэг асуудал дээр нэг хүн гурваас илүү босохгүй гэсэн бидэнд тогтсон юу бий. Гэтэл зарим хүн өрөөсөө 4-5 удаа, миний хажууд сууж байгаа Элбэгдоржоос авахуулаад, тэгээд Чимид гуай, бусад хэд хэдэн депутатууд зөвхөн энэ асуудал дээр 5-6 удаа бослоо. Тэгэхээр зэрэг энэ одоо бидний ярьдаг, негөө хуц, ухна тавьчихсан биш, энд бүгдээрээ ярилцвал бүгдээрээ ярилцъя. Тэгдэггүй юм бол энэ гурав гэдэг асуудлаа хатуу тогтох, буртгэж мэдээлж байгаачээ бидэнд. Тийм хүн тэдэн удаа босож байна гээд, тэгэхгүй бол энэ өрөөсөө энэ жил таarahгүй нь ээ. Энийг одоо анхааралдаа авч узмээр байна. Ийм хоёр санал байна. Ингээд нэгдүгээр саналыг одоо хэлэлцүүлээд, өмнө нь шийдсэн

асуудлаа дахин ярилцахгүй гэсэн ийм юмыг санал хурааж узмээр байна.

Хоёрдугаарт, өөрөө ч гэсэн одоо олонхийн санал гэж олонхийн саналаар шийлчихээд, тэгээд шийдвэртэй юмаа дахиад нэг хүн бороод ирэхээр дахиад задлаад ингээд хэлэлцүүлээд байгаа явдал чинь одоо энэ удирдаж байгаа арга барилд чинь ийм дутагдал байна гэдгийг бас анхааруулмаар байна.

Г.Сосорбарам /ЗІ6 дугаар тойргийн депутат/ -Нэг асуулт байна хурлын дарга, орлогч дарга нараас. Энэ дэгийн нэгдүгээр булгийн I0-ын "е" заалтыг өчигдөр шийдвэртэй. Өөрөөр хэлбэл 1991 оны II дүгээр сарын II-ний өдөр шийдвэртэй, хажуугийн санал гээд гурван удаа санал хураагаад, энэ заалтыг "е" заалтыг байхаар тохирлоо гээд бид өчигдөр тарсан. Энийг яагаад дахин өнөөдөр хэлэлцэх болсон юм бэ? Энэний хариуг өгнө үү?

Ж.Уртнасан -Сосорбарам депутатын асуултад хариулъя. Өнөөдөртөө бид дэгээ хэлэлцэж л байна. Дэг арайхан батлагдаагүй байна. Хоёрдугаарт, бид бас зарим зүйл дээр алдаа гаргасан байж болох юм гэж жаахан хойш нь татаад, ухраад ингээд байгаа явдал бидний алдаа болж байна, олон депутатууд сануулж байна. Ийм учраас та бүгдийг хүсвэл, та бүгдийн саналын дагуу одоо эргэж ярихаа түр азнаад, ер нь жаахан урагшаа явбал ясан юм бэ? Нэгэнт баталсан зүйлээ дахиж хэлэлцэхээ больё. Энэн дээр санал нэгдэх байх гэж бодож байна. Буруу шийдвэр гарлаа гэж узвэл бид бас арайхан баталчихаагүй байгаа дээрээ эргэж буцах нь зүйтэй ч юм болов уу гэж нэг хоёрдмөл санаа байсан юм. Та бүгдийн хүсэлтээр үүнийг цэглээ.

Одоо суулчийн хэлэлцуулэг дээр, бид бол ер нь асуудлуудыг ингээд батлаад, зарчмын хувьд батлаад яваа ч гэсэн, редакци хийсний дараа дахин нэг удаа шүүн тунгаана шүү дээ. Энэн дээр бид эцсийн шийдвэр дээр энэ санал бодлоо суулчийн удаа эцэслэн шийдвэрлэж болох болов уу гэж бодож байна.

5.

Энэ хүн тус бурийн саналыг компьютерээр нэгтгэн гаргах программ бий юу гэж байна. Байгаа. Энэ хүн бүгдийн санал дотор өгсөн санал, зөвшөөрсөн, татгалзсан, тудгэлзсэн гэдэг энд та бидний нэрээр, суудлаар гарчихаж байгаа. Тийм учраас энийг бид хэрэв шаардлагатай гэж үзвэл аль суудал дээрээс хэн зөвшөөрөв, хэн татгалзав, хэн тудгэлзэв гэдгийг амархан бид гаргачихаж болно. Энэ байгаа, тийм программ бий.

II дүгээр хуудас буюу 5 дугаар заалтыг яривал яана вэ? "д" заалт, "г" заалтыг зарчмын хувьд баталсан, дахин оролдохoo больё гэж бодож байна, нээлттэй үлдээж байна. Одоо "д" заалт дээр энд нэг хороо, ажлын хэсэг гэдэг үгийг урд талд нь нэмж оруулъя гэсэн ийм санал гарсан. Хороо, ажлын хэсэг Их цаазын төслийг эцэслэн боловсруулж гэж. Өөр зарчмын санал гарахгүй байна. Өөр саналтай депутат байна уу? За тэгвэл редакцийн чанартай найруулгын засвар хийгээд, энэ заалтыг үлдээе гэсэн санал хураалт, энэ заалтын талаар санал хураалт явуулах гэж байна. За баярлалаа, бид 89 хувиар баталсан юм байна.

Одоо 6 дугаар заалтыг хэлэлцье. Зарчмын санал гаргах депутатууд байхгүй байх шиг байна. 6 дугаар заалтын талаар санал хураалт явуулахад бэлтгэнэ уу?

Н.Пүрэвдорж - Тэгэхээр энэ 6 дээр зарчмын санал байна.
741 дүгээр тойргийн депутат/

За энэн дээр Үндсэн хуулийн нэмэлтийн хуулийн төслийг энэхүү дэгд заасан журмын дагуу хянан хэлэлцэж батална. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлтийн төсөл гэдэг чинь өөрөө автоматаар хүчингүй болчихоод байгаа шүү дээ. Нөгөө юун дээр тиймээ. Энэ Их цааз батлагдангуут. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн хяналт, хуулийн нэмэлтийн хууль юм уу, эсвэл Их цаазын хуулийн нэмэлт юм уу одоо энэ.

II-ийн 6 мөн. Тэгэхээр энийгээ тайлбарлаж өгөөчээ. Энэ дурэм боловсруулсан хүн. Тэр чинь юу юм бэ? Их цаазын нэмэл-

6.

тийн хууль юм уу, эсвэл Үндсэн хуулийн нэмэлт юм уу? Хэрэв Үндсэн хуулийн нэмэлт юм бол Их цааз батлагдангуут энэ хууль чинь автоматаар хүчингүй болчихож байгаа. Тэрийг дахиж хэлэлцээд байх шаардлага байна уу үгүй ю?

Ж.Уртнасан -За энэ хуулийн зөвлөхөөс бид асуулаа. Энэ бол зүгээр техникийн алдаа юм шиг байна. Энэ Үндсэн хуулийн гэсэн ойлголт биш, Их цаазын хавсралт хууль гэсэн ийм ойлголтоор явах юм байна. Үүнийг бид техникийн, найруулгын засвар хийгээд ингээд үлдээе. Найруулгын засвар юм, техникийн алдаа байна.

Ч.Бат-Эрдэнэ /ЗІ5 дугаар тойргийн депутат/ -Тэгэхлээр дээд талын Үндсэн хуулийн нэмэлт гэдэг нь жинхэнэ Үндсэн хуулийнхаа нэмэлтийг энэ тавын хоёрыг ёсоор гуравны хоёрын саналаар гэдгийг урьд батлагдсан хуулиа ярьж байна. Дараагийнх нь Үндсэн хуулийн нэмэлт гэдгийг энэ Их цаазынхаа хавсралт хуулийг ярьж байна гэж ингэж ойлгож байна. Тийм учраас долоо дээр бол ухаандаа ингэж байна л даа. Шилжилтийн тухай Үндсэн хуулийн нэмэлт хуулийг мөн журмын дагуу хэлэлцэн батална гэж. Энэ санаа бол дээрээ энэхүү дэгд заасан журмын дагуу хянаж, хэлэлцэж батална гээд байж байгаа учраас, долоог хасчихаад дээш нь нийлүүлчихмээр байна. Энэ бол яг нэг юман дээр яригдаж байна гэж ойлгогдож байна.

Соронзон хальстай тулгаж

НИЙЛСЭН

Алтанцэцэг

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.II.12
Кассет № 63
17.55-18.10

Ж.Уртнасан: Санал хураалт явуулъя. 6 дугаар зүйл дээр. Бид техникийн засвар хийж найруулъя. Санал хураалт явуулахад бэлтгэнэ үү? депутатуудаа. Санал хураалт явуулж өхэллээ. 6 дээрээ ярьж байна, заалт тус бүрээр. 7-д ороогүй байна. 7-гийн тухай бид яриагүй байна.

Санал өгсөн депутатуудын 91 хувь буюу 307 депутат энэ заалтыг зөвшөөрч байна, 18 хүн татгалзаж, 10 хүн түдгэлзлээ. 6 дугаар заалтыг бид баталлаа.

7 дугаар заалтыг депутат Бат-Эрдэнэ үүнийг хасъя гэсэн санал оруулж байна. Өөр саналтай депутат байна уу?

. 406 дугаар тойргийн депутат Ч.Тэрбиш: Самбарын юун дээр нэг юм лавлахгүй бол болохгүй байнаа. Тэр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гурав нийлээд 100 хувь болох ёстой. Би нэлээн олон тоо  харлаа, даандаа 98,99 болоод болж өгөхгүй юм.

Гэтэл бид чинь цаашаа хэлэлцэхээр түрүүнд депутат Гурбазар хэлсэн 0,3, 1 хувиар нарийвчлалтай болох нь ээ, их сайхан боллоо гэж ярьсан. Гэтэл энэ маань нарийвчилж чадахгүй юм бол бид хувшиа өөр машинаар давхар шалгахгүй бол зарим нь болох байх нь ээ.

Ж.Уртнасан: Цепутат Тэрбишийн асуултанд хариулъя. Манай техникийн ажлын хэсэг хариулж байна. Энэ цахим тоолуур дээр нарийвчлалын бутархай орныг оруулаагүй, энд 0,5-аас дээш байвал 1 рүү, бүхэл рүү шилжүүлээд, 0,5-аас доош бол 0 руу шилжүүлж байгаа, энд алдаа байхгүй гэдэг хариулт ирж байна. 0,5-аас бага хувийд нийлсээр байгаад л 2 болж байна л даа. Хэрэв депутатуудыг хүсвэл техникийн хэсгийн саналыг сонсьё.

**Н.Батбаяр:-Ардын Их Хурлын
орлогч дарга**

-Зарим улсууд ийм асуулт асуугаад байх шиг байна л даа. Нийт гэдэг дээр 78 хувь гарчихаад байдаг, гэтэл дээд тал нь 100 хувь болчихоод байдаг ямар учиртай юм бэ гэж байна. Тэр бол ойлгогдох байгаа биз дээ. Тэгвэл маргаантай зүйл байхгүй.

**Депутат /Нэр, тойргоо
хэлээгүй/** -91,5 байсан бол 5-аас дээш бол 91,92 болно, 5-аас доош бол 91 болно, 5,8 байсан бол 6 болох ийм байх ёстой. Тэгэхээр одоо энэ чинь 97,98 болчихсон байна. Энэ гурав чинь бол хэрэв доош байсан бол доошлоод, 1,5-д дарагдана уу гэхээс биш, 2 хувиар дарагдах ёсгүй шүү дээ. Түдгэлзсэн дээр тийм болчихоод байна л даа.

Хэт шүүсийн инженер Эрдэнээ: Энэ хувь дээр өчиглөр хувь зарим үед 101 байгаа, өөрөөр хэлбэл бутархай орныг дандаа дээш нь авсан чинь 101 болсноосолж, үүнийг өөрөөр хэлбэл бодитойгоор 0,5-аас бага байвал доош нь ав, сүүлийн орныг үнэн чанартай хаяад явж, илүүдүүлэхгүй гэж.

407 дугаар тойргийн депутат Б.Нүүрэй: Энэ чинь дэвшүүлж чадахгүй байна шүү дээ. 307: 335 =,91,6 байна. 0,5-аас дээш гэвэл 92 болох ёстой шүү дээ.

Хэт шүүсийн инженер Эрдэнээ: Маргаашийн хуралд өөрөөр хэлбэл нарийвчиллыг бүгдийг яг нийлбэр нь яг 100 хувь байдгаар болгочихоод байж байя.

Б.Нүүрэй: Сүүлчийн орон хаягдаад байна шүү дээ.

Ж.Уртнасан: Депутатууд аа, энэ дээр нэг тайлбар нэмж хэлье. Энэ техникийн нөхдүүд маань энэ бутархайн орныг 0,5-аас доошихыг нь хаячихаад байгаа юм. Тийм учраас түүний нийлбэр нь 1,2-оор хэлбэлзээд байна. Маргааш энэ нөхдүүд 0, бариулах энэ системийг хийг ээ. Бид тэгвэл хар гажиг маань арилах байх. Энэ нөхдүүд програмдаа засвар хийг. 0,5-аас доош орсон бутархайг хаячихаад байгаа юм байна.

3.

Энд л учир нь байна.

7 дугаар зүйлийг, дэгээ дахин хэлэлцэж өхэлье. 7 дугаар зүйлийг хасъя гэсэн санал гаргасан. Өөр саналтай депутат байна уу?

Депутат/нэр, тойргоо хэлээгүй/Хурлын даргаа би энэ самбарын талаар нэг юм яримаар байна. Энэ чинь одоо бол саналаа 400 гэхэд 75 хувь нь байна шүү дээ, тэгэхэд одоо 91 гэж хэлж болох юм уу? Тэтвэл саналаа өгсөн депутатын 91 гэх юм уу? нийт депутатын 91 хувь нь гэх юм уу? Тэр чинь 335 хүн байна шүү дээ. Бусдыг нь яаж тэтгэж үзэх юм бэ?

Ж.Уртнасан: Саналаа өгсөн депутатуудын гэж гарч байгаа шүү дээ, хувь.

/Нэр тойргоо хэлээгүй/-Тэгэхээр бусдыг нь яласан гэж үзэх вэ? энэ байгаа улсуудын чинь.

Ж.Уртнасан: Саналсөгөөгүй буюу, суудал онгорхой байна гэсэн уг. 7 дугаар заалт дээр хасъя гэсэн саналаас өөр санал байхгүй байна. Санал хураалт явуулж. 7 дугаар заалтыг хасъя гэсэн санал хураалт явуулж байна, бэлтгэнэ хү. 7 дугаар заалтыг хасъя.

Саналсөгсөн депутатуудын 78 хувь нь буюу 304 хүн үүнийг, 7 дугаар заалтыг хасъя гэж зөвшөөрч байна. Хасъя гэдэг саналыг 304 депутат өглөө гэж ойлгож байна, зөв биз. За баярлалаа.

12 дугаар зүйл. Илтгэл, мэдээлэл, тайлан хэлэлцэх тухай.

Депутат/нэр тойргоо хэлээгүй/ Энэ саяны бидний хасч байгаа зүйл чинь хасч болохгүй зүйл шиг санагдаад байна. Давхардаж байна гэж ярьж байна. Тийм бишээ. 6 дугаар зүйл чинь бол шилжилтийн хуулийг, их цаазынхаа төслийг хэлэлцэхээд, дараагаар нь шилжилтийн хуулийг хэлэлцэх тухай, батлах тухай асуудлаа одоогийн мөрдөж байгаа үндсэн хуулийн нэмэлтийн 5-ын 2-ыг үндэслэж

шийднэ гэдэг ерөнхий зарчмыг хэлж байна. Шийдвэрээ гаргах. Яг чухам яж хэлэлцэх вэ? тэр нэмэлтийн тухай хууль чинь бол бас төслийг харвал нарийн яригдах юм их байна билээ. Яж хэлэлцэх вэ гэхээрээ саяны урьдны бидний тарчилж, тарчилж баталсан тэр журмуудаа барьж, хэлэлцэнэ гэдгийг хэлж байна. Тэгэхээр энэ нэмэлтийн тухайгий чинь ерөөсөө шууд баталчих юм шиг ойлгогдож байна. Тийм учраас хэлэлцэх тухай юмаа тодруулж үлдээмээр байна.

315 дугаар тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ: Тэгэхээр Үндсэн хуулийн гэж энэ дээр хэл найруулгын алдаа байна гэж бодошд байна л даа. Шилжилтийн тухай Их цаазын хавсралт хууль гэж. Хавсралт хуулийн төслийг энэхүү дэгд заасан журмын дагуу гэж байгаа шуу дээ. Тэгэхээр энэ чинь 7-тойгоо давхардаад байна шуу дээ. Тэгээд дээшээгээ хамт орчихож байгаа юм чине.. Тэр дээр байгаа Үндсэн хуулийн нэмэлт гэдэг чинь бол тэр 5 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгтээ хамаарч байгаа шуу дээ. Доод талынх нь бол ерөөсөө тэр шилжилтийн үеийн их цаазын Хавсралт хууль гэдэг утгаар байгаа учраас давхардаж байна.

Ж.Уртнасан: Бат-Эрдэнэ депутатад тайлбар тавиад энэ ойлгомж-той болох байх гэж бодож байна. Манай хуулийн зөвлөхүүд бидэнд лавлагаа өглөө л дөө. Энэ Хавсралт хууль гаррагүй байхад хийгдсэн дэг учраас яах аргагүй давхардаж байгаа юм. Тэр дээд талын хоёрдугаар өгүүлбэр, Бат-Эрдэнийн уншдаг бол зөв юмаа. Ийм учраас энэ 7 дугаар заалтыг хасаад хаячихад туйлын боломж-той гэж бидэнд зөвлөж байна.

Ингээд цаашаа явъя. 12 дугаар зүйл. Илтгэл, мэдээлэл, тайлан хэлэлцэх тухай, саналаа хэлье. 7 дугаар микрофон.

341 дүгээр тойргийн депутат П.Бямбажав:

Энэ тайланг хэлэлцэхдээ энэхүү дэгийн 10 дугаар зүйлд заасан нийтлэг журмыг баримтална гэжээ. Энэ журмаар хэлэлцэх нь зүйтэй юм. Тэгэхдээ 10 дугаар зүйлд байхгүй 3 жижиг санал байна.

Нэгдүгээрт, Ардын Их Хурлын хуралдаанаар хэлэлцэх илтгэл, тайлан, мэдээллийг депутатуудад өгч, урьдчилан танилцах боломж олгосон байх нь зүйтэй гэсэн ийм санал байна, "а" дугаарт.

"б" дүгээрт, шаардлагатай гэж узсэн зарим онцлог асуудлыг тодруулж, шалгаж Их Хуралд мэдээлэх комисс, ажлын хэсгийг Их Хурлаас байгуулж болох юм. гэсэн заалт баймаар байна. Энэ нь үндсэндээ 10 дугаар зүйл дотор байгаа юм. Тэгэхдээ лавлагаа авч тайлбар өгч болно гэсэн заалтанд хамааруулж болбол болох юм. Тэгэхдээ үүнийг ингэж тодруулмаар байна.

Гуравдугаарт, Их Хуралд оруулсан мэдээллийг мэдээллийн хэмжээнд хэлэлцэхээр төлөвлөгджээ, дээрх утгаар аваад узвэл. Тэгвэл Ардын Их Хурлын хуралдаан асуудлыг арай өргөн дэлгэр хүрээтэй авч хэлэлцэх ёстой гэж би хувьд ойлгож байна. Энэ утгаараа дээрх комисс шаардлагатай бол зайлшгүй байх ёстой болов уу гэсэн саналтай байна.

Ж.Уртнасан: Өөр горимын санал байна уу? Депутат Бямбажавын саналыг бид энэ тайлан илтгэл, энэ хавсралт илтгэлүүдийг танилцах боломжтой 15 хоногийн өмнө өөрөөр хэлбэл авч танилцъя гэсэн ийм санал оруулж байна.

Бид хуулийн зөвлөхтэй ярих хэрэгтэй юм уу, техникийн тийм боломжтой юм уу? Угүй юу гэдгийг. Бүх илтгэлүүдийг тэгж 15 хоногийн өмнө тараах тийм боломж бий юу?

Ардын Их Хурлын 155 дугаар тойргийн депутат Л.Ишдорж:

Нэг санал байна. Энэ Бага Хурлын тухай асуудлыг 15 хоногийн дараа ярина. Гэхдээ баталгаа алга. Маргааш, нөгөөдөр чиг дэг батлаад бид тэр асуудлыг яриад эхэлж байна. Хоёрдугаарт, хэлэлцэх асуудал бүрэн тэгс биш. Улсын Прокурорын мэдээлэл ч гэдэг юм уу, өөр янз бүрийн асуудлыг хэлэлцэх асуудал болгож болно. Тэр болгоныг одоо өнөөдөр бэлэнгүй буку бэлэн болоон 100 хувь тарааж чадах уу, угүй юу гэдгийг бодолцох хэрэгтэй байх шиг байна.

6.

Ж.Уртнасан: Бид сая лавлалаа. Тэгэхээр үнэхээр бэлэн биш байна. Нэгдүгээрт цаасны боломж их хязгаарлагдмал байгаа юм байна. Хоёрдугаарт, зарим илтгэл, тогтоол одоо хүртэл бэлэн болоогүй учраас бид 15 хоногийн өмнө авч танилцана гэдэг ийм шаардлага тавихад үнэхээр учир дутагдалтай юм байна.

Соронзон бичлэгтэй
тулгаж нийлсэн

Д.ЧУЛУУНЦЭГ

I991.XI.I2.

Кассет № 64

I8.IO→I8.25

Ж.Уртнасан -Энд бичигдсэн хэлбэрээр нь оруулья.
I2-р зүйл дээр санал хураалт явуулахад бэлтгэнэ уу.

? -Их хурлын даргаа, надад тайлбар байна. Би материалын I5 хоногийн урд гэж яриагүй. Урьдчилан танилцуулахад шаардлагатай гэсэн утгаар ярьсан. 5 хоног байж болно, нэг хоног байж болно, урьд өдөр нь байж болно. Бид асуудлаа танилцахын өмнө эхээр нь өөрийн нудээр уншиж танилцаад оруулах нь зүйтэй болов уу гэсэн санаагаар уүнийг хэлсэн юм шүү.

Ж.Уртнасан -Урьдчилан танилцуулах боломжгүй гэж бидэнд хариу өгч байна. Цаас байхгүй, мөн техникийн боломж байхгүй учраас та нар сонсож, хэлэлцэх нээ.

Уучлаарай, I2-р зүйл дээр санал хураалт явуулахад бэлтгэнэ уу.

Баярлалаа, нийт санал өгсөн депутатуудын 93 хувь буюу 375 депутат зөвшөөрч байна. I7 хун татгалзаж, I0 хун тудгэлзлээ.

I3-р зүйл. БНМАУ-ын Ардын Их Хурлын байнгын комиссүүн дээр 4 заалттай зүйлийг зүйлээр нь батлая гэсэн санал ирж байна. Заалтыг бүхэлд нь батлая.

Ш.Цэндбаяр/280-р тойрийн депутат/ -I3-р зүйлийн I-д найруулгын чанартай зүйл байгаа юм. Байнгын комиссыг шаардлагатай салбараар гэж байгаа юм. Тэхээр шаардлагатай салбараар гэх уу, ажлын чиглэлээр гэх уу. Салбар гэхийн оронд ажлын чиглэлээр гэвэл ясан юм бэ?

Ж.Уртнасан -Өөр горимын санал байна уу, депутатууд аа! За баярлалаа. Тэгвэл I3-р зүйлээр санал хураалт явуулахад

2.

бэлтгэнэ уу. За, санал хураалт явуулж байна.

Санал өгсөн депутатуудын 97 хувь буюу 392 депутат зөвшөөрч байна. 6 хүн татгалзаж, 2 хүн түдгэлзлээ.

I4-р зүйлийг хэлэлцье.

Ц.Элбэгдорж /427-р тойргийн депутат/ -Саналаа хураа я
гэсэн санал байна.

Д.Баттулга/148-р тойргийн депутат/ -Уртнасан даргаа, танд нэг зүйл хэлье. Хурдан хураалгахгүй бол удаад байгаа юм шиг санагдаж байна. Ингээд сүүлдээ яриад эхлэдэг шүү дээ, шууд хураалгамаар байна.

Ц.Элбэгдорж -Тэгээд тэр хооронд нэг зүйл олоод харчихна шүү дээ.

Д.Гантэмэр /62-р тойргийн депутат/ -Анхдугаар хурал дээр би Бага хурлын гишүүдийг сонгох тооллогын комиссын бүрэлдхүүнд би орж байсан. Ерөнхийдэгч, дэд ерөнхийлөгчтэйнг адилхан оруулсан. ӨХ.50%-ын санал өгөхөд сонгогдож байсан. Ноднин I02 гишүүн санал өгөөгүй, байхад БХ-ын гишүүнээр сонгож байсан. Тэгэхлээр Бага хурлын гишүүдийг сонгох журамд АИХ-ын бух гишүүдийн 90%-с гэхгүй бол, 50% гэх юм бол бух нэр дэвшсэн хүмүүс сонгогдож байсан.

Ц.Элбэгдорж: Энэ жилдээ сонгогдохгүй гэсэн уг.

Ж.Бямбаа/II-р тойрог/-I3-р зүйл дээр зүйл, зүйлээр гэж байгаад нэг дээр санал авахдаа бүгдийг нь батлаачихлаа шүү дээ.

Ж.Уртнасан -Уучлаарай, Бямбаа гуай, бид лавласан шүү дээ. I3-г заалт тус бүрээр биш, зүйлээр нь батлагая гээд бух депутатууд саналаа өгчихлөө. Анхааралтай байхыг хүсч байна.

Ж.Бямбаа -14-р зүйл ч ялгаа байхгүй. 13-ийн 3-ийг тэнд ярих байсан шүү дээ. Байнгын комиссын дарга, гишүүдийн талаар намын бүлэгтэй заавал ярьж байх алба байхгүй шүү дээ. Тийм зүйлийг хасах ёстой байсаар байхад яриулалгүй, 14-рүү оруулаад байна шүү дээ. Ингэж мэдэн будлиад байж болохгүй шүү дээ.

14-р зүйл дээр Бага Хурлын гишүүний гэдгийг гуравны хоёр гэдгээр оруулах нь зүйтэй юм. Түүнээс ердийн олонх гэж болохгүй. Гуравны хоёр гэдэг нь дийлэнх олонх болно шүү дээ. Гантэмэр депутат маш зөв ярьж байна шүү дээ.

Ж.Уртнасан -Горимын ямар өөр санал байна, Бямба гуайн саналыг хүлээж авлаа.

Д.Баяр/ЗИЛ-р тойргийн депутат/ -14-р зүйл дээр Бага Хурлын гишүүний шийдвэрийг, Бага Хурлын гишүүний эрхийг түдгэлзүүлчихсэн байхдаа нөхөөд оронд нь сонгож болдог юм уу, эсвэл зогсоосон хүний оронд сонгодог юм уу? Журмын тухай асуудлыг яриагүй учраас журмын асуудлыг энд дэлгэрүүлж ярих шаардлагагүй юм биш байна.

Б.Мижид/163-р тойргийн депутат/ -Энд ойлгогдохгүй зүйл байна. Өөр ажилд шилжсэн, өөрөөр хэлбэл хурал дээрээс хойш гэж байна шүү дээ, бусад шалтгаанаар Бага Хурлын гишүүний эрхийг түдгэлзүүлсэн гэж байна. Хэн түдгэлзүүлснийг ярьж байгаа юм бэ? Бага Хурал түдгэлзүүлснээс бусад Бага Хуралд оруулах өөрчлөлтийг бид авч хэлэлцэх эрхгүй болох нээ дээ. Тэгсэн ойлголт уу, эсвэл Их Хурал шийднэ гэсэн ойлголт уу?

Д.Лундээжанцан/15-р тойрог/ -Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 7-р зүйлд БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын олонхийн санал авсан хүн БНМАУ-ын Бага Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно гэх. Ингэхээс өөр арга байхгүй.

Түдгэлзүүлснийг Бага Хурлаас чөлөөлөх асуудлыг Ардын Их Хурлаар олонхийн саналаар мөн ялгаагүй шийдчихээд дараа нь нехэн сонгуулийн асуудал ярина.

Б.Лханаасүрэн /191-р тойрог/ -Уүн дээр зарчмын асуудал байгаа юм. Түдгэлзүүлсэн гэхээр Бага Хурлын өөрийн нь түдгэлзүүлсэн гишүүдийг бид хэлэлцэх болчиноод байгаа юм. Хуралдааны явцад магадгүй Бага Хурлын зарим гишүүдийг чөлөөлөх асуудал гарч магадгүй. Тийм учраас уүн дээр түдгэлзүүлсэн буюу чөлөөлсөн гишүүнийг гэж оруулаад, заримыг нь солих, хэрэв ингэвэл Их Хуралдаа үүнийг авч шийдвэрлэнэ шүү дээ. Тэхдээ чөлөөлөх гэсэн үгийг заавал оруулахгүй бол болохгүй. Хэрэв тэгэхгүй бол Бага хурлын түдгэлзүүлсэн хоёр, гурван гишүүн байгаа юм. Өөр ажилд шилжсэн, үүнийг хэлэлцээд л болох гээд байна. Тийм учраас шаардлагатай гэж үзвэл чөлөөлөх гэсэн үгийг шаардлагатай гэж үзвэл ч гэдэг юм уу, ийм зүйлийг заавал оруулахгүй бол болохгүй. Дараа нь 75 хувь гэсэн асуудал байх нь таарахгүй л дээ. Яагаад гэвэл бид 5 гишүүнийг чөлөөллөө гэж бодоход 7 хүний нэр дэвшлээ. Тэр 7 хүнээсээ бид олон санал авсан 5 хүнээ л сонгоно. Магадгүй бүгд 75 хувь авсан байж таарна шүү дээ. Тийм учраас олон санал авсан 5 хүн, чөлөөлвэл тэр 5 гишүүн 7 хүнээс сонгогдоно. Ийм утгаар оруулахгүй бол болохгүй. Ийм хоёр санал байна.

Ж.Уртнасан -Уучлаарай, депутат аа! ийм зүйл байгаа шүү дээ. Сая йүндээжанцан хэлж байсан. БНМАУ-ын Бага Хурлын тухай Үндсэн хуулийн нэмэлтэд ийм зүйл бий. Бага Хурлын тухай хуулийн 7-р зүйл дээр БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын олонхийн санал авсан хүн БНМАУ-ын Бага Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно. Энэ нь мэдээж хэрэг 7 хүнээс олон санал авсан нь шигшигдээд, орно шүү дээ. Тийм учраас уүн дээр заавал... Бага Хурлын гишүүнээс түдгэлзүүлэх тогтоолыг Бага Хурал гаргаж байгаа шүү дээ. Түдгэлзүүлж, чөлөөлж асуудлыг та бид энд өнөөдөр ярьж, шийдэх нь тодорхой юм. Өөр ямар горимын санал байна вэ?

Ш.Бороодой/354-р тойрог/ -14-р зүйл Улсын Бага Хурал, Бага Хурлын гишүүдийн үйл ажиллагаатай холбогдсон хэдэн хүний тухай ярилцаад өрөнхийдээ болох юм байна гэсэн ойлголтоор энэ өгүүлбэр орсон байна гэж нацад ойлгогдож байна. Тийм учраас шаардлагатай гэж үзэл Улсын Бага Хурлын гишүүдийн бүрэлдэхүүний зарим хэсгийг шинэчлэж, өөрчлөлт хийж болно гэсэн утгаар уг, үсэг оруулж найруулж өгөхийг хүсч байна.

Ж.Уртнасан -Депутат Бороодойн асуултанд хуулийн тухай нэмэлтэд байгаа шүү дээ. БНМАУ-ын Бага Хурлын гишүүний бүрэн өрх, түүнийг сонгох, огцруулах журмыг БНМАУ-ын хууль, тогтоомжоор тодорхойлно гэж заасан заалт бий шүү дээ. Үүний дагуу явна шүү дээ. Үүнийг хуулиар шийдвэр шүү дээ.

С.Баяр/1-р тойрог/ -Та сая тайлбар өгчихлөө л даа. Би нэг зүйлд эмзэглээд байна л даа. Бага Хурлын хэсэг нөхдүүд ийм зүйлийг боловсруулж оруулчихаад, өөрсдөө дотроос нь мултаран гарч амиа авч үлдэх зүйл хийж байгаа юм шиг Ардын Их Хурлын хэлж байгаа зүйлд нь би хувьдаа эмзэглэж байна. Шаардлагатай бол ямар ч асуудлыг оруулж хэлэлцүүлэх боломжийг бид өрөнхий дэг дээрээ заачихсан шүү дээ. Заавал тэнд очоод нялдана даа гэсэн сэтгэлээр хандаад, нялдах боломжийг хасах гээд байна. Тэн дээр очоод нялдана шүү гэсэн зүйлийг оруулах гэсэн нь Ардын Их Хурлын хуралдааны ажлын уур амьсгалд муугаар нелөөлж байна гэж бодож байна. Энэ нь бидний улс төр, парламентын соёл гэж ярьдаг. Энэ дотор байгаа зүйлүүдээ бид бүрэн дүүрэн хариуцлагатай баталсан шүү дээ. Хэрэв шаардлагатай бол ямар ч асуудлыг оруулж ярж болно. Ийм зүйл орсноор ямар ч хаалт байхгүй ээ.

Эрхэм Ардын Их Хурлын депутатууд минь, та бүхэн биднийг сонгосон. Сайн, муу ажилласан тухай тайлангаа бид хэлэлцэнэ. Энэ боломж бүрэн нээлттэй байгаа. Иймэрхүү байдлаар битгий яриач ээ гэсэн хүсэлт байна. Ерөөсөө сэжиглэх зүйл байхгүй.

6.

С.Билитсайхан/184-р тойрог/ -I4-р зүйлийг ямар ч тайлбаргуйгээр батламаар байна.

Ж.Уртнасан -Саналыг хүлээж авлаа. Горимын өөр санал байхгүй байна. I4-р зүйлийг батлах санал хураалт явуулах гэж байна. Санал хураалт явуулж байна, анхаараарай эхэллээ.

За баярлалаа, санал өгсөн депутатуудын 89 хувь нь буюу 367 депутат энэ заалтыг хэвээр үлдээе гэсэн санал өглөө. 30 хүн татгалзаж, II хүн түдгэлзлээ. Бид I4-р заалтыг баталлаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ц.БАЯРМАА

Бичээч

С.ТУУЛ

1991-II-12.
Кассета № 65
I8-25-I8.40

-3 дугаар булэг рүү орьё. 2-хон зүйлтэй юм. Нэг тийшээ хараад яахав.

-3 дугаар булгийг булгээр нь яриад, булгээр нь санал хураах санал байна.

7-р микрофон

-Нэг ийм санал болгож байна л даа. 3 дугаар булэг рүү орохын урд талд зүгээр Парламентын булгэмийн асуудлыг энэ дээр тусгах нь зүйтэй юу үгүй юу гэсэн тийм л асуулт байна. Өөр юм алга л даа.

5-р микрофон, I75-р тойргийн депутат Х.Чулуунбаатар:
-I5-р зүйлийг үндсээр нь хасах санал оруулж байна. Энэ II-ын 6-д яг энэ хэвээрэ орчихсон. Бид нар II-ын 6-д чинь 7-гий нь дээш нь оруулчихлаа гээд баталчихсан шүү дээ. Тийм учраас I6-гаа тэгээд булгээр нь батлах санал оруулж байна. I5-р зүйлийг хасъя гэдэг санал оруулж байна уу.

4-р микрофон, 293-р тойргийн депутат Бадарч: -Саяны депутат нарын саналыг дэмжиж байна. I5-ыг хасъя, бусды нь батлахад бэлэн гэдэг санал байна. Нэмэх 2 асуудал байна. Дэгийн зарим заалтыг тухайн үед өөрчилж болно гэсэн ийм үг оруулбал ясан юм бэ, бид бас /кассетанд дуу давхардсан/
2-рт, 2 дугаар санал бид ямарваа нэг булэг ажил хийхийг зөвшөөрсөн. баталчихсан, өчигдөр, энэ зүйтэй. Булэг маань З-аас дээш хүнтэй л байх нь. Зарим нь ес ч байна гэнэ, хэдэн ч хүнтэй байж болно. Энэ булэг хуралдааны асуудлыг их удаашруулж байна. Ер нь тийм учраас энэ завсарлага авахад 30 минут хуртэл тэж хугацаа өгчихсөн. Тэгээд л нэг З хүний булэг л 30 минут аваад байх юм бол энэ чинь тарахаа байчихна шүү дээ. Энэ завсарлага тойм авахын журмын талаар энд бас нэг нарийвчилсан юм авахгүй бол нэг л З хүнтэй булгийн шаардлагаар 30 минут хуртэл аваад байх юм бол энэ хурал чинь дуусахгүй шүү.

2.

4-р микрофон: I80 дугаар тойргийн депутат Х.Зардыхан : -Энэ I5 дугаар зүйлд АИХ Үндсэн хууль дээр оруулах нэмэлт өөрчлөлтийг хуралдаанд орсон депутатуудын гуравны 2-ын гэсэн ийм санааг оруулсан байна л даа. Тэгэхлээр бид эхлээд Их цааз гээд сурхий зутгээд байсан, одоо Үндсэн хууль явчихсан, хэлэлцэж байсан юмаа хаяшихаад өөр юм хэлэлцэх юм болж байна уу, энийгээ нэг жаахан өөрчилж найруулж нэг л юманд оруулмаар юм шиг ингэж санагдаж байна.

3-р микрофон: 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн:
 - Энэ I5-р зүйлийг хасах саналтай бол санал нэг байна. I6-р зүйлийн 2-дээр БНМАУ-ын Их цааз, АИХ-ын бусад баримт бичиг нэрээр хураасан саналыг Ардын эрх сонинд албан ёсоор нийтэлнэ. Нийтэлхээс гадна хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр мэдээлж байна гэсэн юм оруулаад шууд батлах саналтай байна.

4-р микрофон, 32I-р тойргийн депутат С. Батхуягт:

- Энэ хурлын шийдвэр гаргаад I5-р зүйл хасагдаж байх шиг байна. Тэгэхээр нацад нэг тодруулах асуудал байна. Хурал хаявсдыг яах вэ, энд чинь депутатуудын З-ны 2 юм уу, олонхийн саналаар шийднэ гэж байгаа шүү дээ, хурлын асуудал хэлэлцэх явцад хэсэг хумуус хурал хаявал одоо тэрийг юу гэж үзэх вэ гуравны 2-т нь хүрээгүй цөөхөн хүн хаях юм бол хуваарь бүрэлдэж байх юм бол асуудлаа шийдээд явах уу гэдгийг тодруулж хэлж өгөөч э Тийм асуудал гарч магадгүй гэж бодож байна.

Уртнасан:

- Бид ирциийхээ тухай энэ дэгдээ тусгачихсан байгаа шүү дээ. Тэр ирцийн хэмжээ хүрч байвал хуралдаж болно. Тэгвэл хурал хүчинтэй байна.

7-р микрофон, 3I5-р тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ:

- Тэгэхлээр бид дэгээ хэлэлцээд үндсэндээ дуусч байна. Саная авмаар нэг зүйлийг хэлмээр байна. Энэ дэгийг Их хурлын шинээр сонгогдсон дарга боловсруулаагүй нь ойлгомжтой. Тэгэхлээр боловсруулаагүй хүн дэгээ хэлэлцуулэх гэж их ядарч байгааг бид харж байна. Тэгээд цааш цаашдаа иймэрхүү асуудлыг хэлэлцуулэхдээ энэ юмыг хийсэн зохиогчоор нь тайлбар өгч хэлэлцуулээд

3.

хурлаа бол дарга нь удирдаж явах нь зүйтэй байна гэсэн санал байна. Энэ бол цаашдаа асуудлыг шуурхай болгоход их нелөөлөхөөр байна. Нэг санал байна. 16-р зүйлийн I. Энүүн дээр Үндсэн хууль ч бол Их цааз ч бол энийгээ Их Хурал батална. Гэтэл энэ хуулийг Ерөнхийлөгчийн гарын үсэгтэйгээр нийтэлнэ гэж бичжээ. Тэгэхлээр энэ хуулийг Ерөнхийлөгч батламжах уу, эовэл өр нь Ерөнхийлөгчийн гарын үсэгтэй нийтлэгдэг журамтай байдаг юм уу, энэн дээр тайлбар авмаар байна.

Уртнасан:

-Санал хураалт явуулахад бэлэн болж байх шиг байна.

-2 дугаар микрофон, 188 дугаар тойргийн депутат Б.Буяндэлгэр:

-Сая халыт цухалзуулаад орхисон. Энд нэг асуудал байгаа юм. Би бур хуралдааны эхнээс хэлье гээд бодоод яваад байсан юм. Ингээд хаягдсан, ингээд эцэст нь хэлэх нь зүйтэй болов уу гэж бодоод орхисон. Бид хуралдаан эхлээд дэггүй явсаар байгаад сая нэг дэгтэй болох тийшээ хандаж байх шиг байна. Тэгэхээр энэн дээр энэ дэгийн үйлчлэх хугацааг заавал ясан юм гэсэн ийм нэг санал байна. Ерөесөө бид дэггүйгээр олон чухал асуудал шийдсэн л дээ. Жишээ нь Шийдвэр батлах зарчим энэ тэр бол зайлшгүй хэрэгтэй. Энэ дэгийг батлагдчихсан дэг хэрэгтэй. Тэгэхээр энийг ерөесөө бид З дахь удаалаа хэлэлцэж таарахгүй байх, гэж бодох юм. Ерөесөө энэхүү дэгийг БНМАУ-ын АИХ-ын З дугаар хуралдааны дэгийг хэлэлцэж батлах хүртэл хүчин төгөлдөр мөрднө гэсэн заалтыг эхний огт хөндөлгүй орхисон нэг хэсэг байгаа. Энэ дэгийг тодорхойлж байгаа хэсэг. Энд ерөесөө ганцхан өгүүлбэр хэрэгтэй гэж узвэл депутатууд хэлэлцээд оруулна уу гэж би хусч байна аа. Шийдвэрлэл доромжлох, гутгэх энэ тэр асуудлыг бид үнэндээ ерөесөө батлаагүй л өнөө хурлээ шуу дээ. Тэгэхээр энд зайлшгүй дэгээс хэрэглэх З дугаар хуралдаан дээр хэрэглэх зүйлүүд зайлшгүй бий. Тэгэхээр энийг ингэж нэг баталгаажуулж өгвэл болохгүй юу. 2 дугаар хуралдааны дэг гэж яхав гарчигтай байг. Гэхдээ Ш хуралдаанд бол бид л хуралдана шуу дээ. Тэгэхлээр ингээд энэ талаас нь ингээд оруулчихаж болмоор юм шиг санагдах юм. Хэрэгтэй бол та нар хэлэлцэнэ уу.

Уртнасан:

-Та өөрийнхөө хувилбарыг танилцуулахгүй юу.

-Ерөесөө энэхүү тэр дэгийг тодорхойлно гээд эхний хэсэгт байгаа даа.

Тэр тодорхойлж байгаа хэсэг. I дүгээр бүлгийн дээр байгаа. Энэ дэгийг БНМАУ-ын АИХ-ын Ш хуралдааны дэгийг хэлэлцэж батлагдах хүртэл хүчин төгөлдөр мөрдөнө гэсэн нэг л өгүүлбэр баймаар юм шиг санагдаад байна. Тэгвэл дараачийн маань хуралд бас дэгтэй явах болов уу гэж бодогдоод байх юм. Энэ дэгээ хэлэлцэх дуусах хүртлээ.

272 дугаар тойргийн депутат С.Лунаа:- Энэ I5 дугаар зүйлийн I дүгээр зүйлд эргээд бас энийг харчих юм уу АИХ-ын тогтоол, протоколыг АИХ-ын дарга Ерөнхийлөгчийн гарын үсэгтэй нийтлэнэ гэж байгаа. Протокол бол нийтэлдэггүй байх л даа. Тийм учраас тэрнийг яах юм одоо найруулгын засвар хийх юм уу. 2-р санал байна. Туруун Баярцогт хэлээд өнгөрлөө. Энэ Ш бүлгийн өмнө талц Монголын Парламентын булгемийн гүйцэтгэх хорооны тухай асуудлыг Их Хуралг яаж авч хэлэлцэх юм бэ. Тэгээд энд огт байхгүйгээр ходорч байна шуу дээ. Энийг бас нэг эргэж анхаarahгүй юу. Тэр Баярцогтын гаргасан санал,

393-р тойргийн депутат Д.Баасанжав:- Энэ I6-ын 2 дугаар зүйлд нийтлэх юманд бусад баримт бичиг гэж байгаа. Бусад баримт бичиг дотор нийт депутатуудын санал орох болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр өнгөрсөн хэлэлцүүлгийн дунгээс ч узсэн зуны зөвлөлгөөнөөс ч узсэн депутатуудын саналыг Ардын эрх сонин узэмжээрээ гэж хэлэх юм уу, юугаараа юм заримы нь бичээд заримы нь бичихгүй хойш нь дарсан явдал бий. Гэтэл сонгогчид маань та яагаад бидний угийг Ардын эрх сонингоор дамжуулж өгсөнгүй вэ бидэнд гомдолтавьж байгаа. Ийм учраас бусад баримт бичиг гэдэг дотор депутатын саналыг бичих бол бүгдий нь бичээсэй гэж бодож байна. Бичихгүй бол бүгдий нь болиосой гэж бодож байна.

Уртнасан:-

-Ардын эрх сонинь редакцийнхан энд сууж байгаа, энэ хүсэлтийг хүлээж бай авч байгаа байх гэж бодож байна.

I5-р зүйлийг II-ын 6-тай тун төстэй ийм учраас хасъя гэсэн санал ирж байна.

82 дугаар тойргийн депутат А.Сарай: - Дэгээ хэлэлцэж дуусч байна даа үндсэндээ, одоо 15-р зүйл гэдэг маань очиж дэгээрээ явж ирээд Их цаазаа батлах гэж байгаа дун байна шүү дээ. Тийм учраас энэ 15-р зүйл гэдгээ хасахаа боливол ясан юм бэ? Их цаазаа баталж байна. Дэгээ ярьж дуусч байгаа учраас би нэг зүйл нэмж хэлье. Энэ Үнэн сонини Бодлын солбицол гэж II-ний өдөр бүх депутатуудад халдаж Бодлын солбицолд хэлсэн байх юмаа.

АИХ-ын бүх депутатуудын сонорт гэсэн учраас энийг зориуд түрүүн депутатууд ярьсан шүү дээ. Депутатуудыг хооронд нь ялгах барих ийм асуудал байж болохгүй гэж. Энэ уг бол дотор уншихад жаахан эвгүй сэтгэгдэл төрж байна. Анхдугаар Үндсэн хуулийг ясны Монгол хумүүс боловсруулсан. Одоо жинхэнэ Монгол үндэстний хууль байх ёстой юм гэж, одоо казак хүн өр нь ядаг болж байна аа одоо, юу гэсэн уг болж байгаа юм хаашаа юм. Энэ жаахан тиймэрхүү утга амьсгал байна шүү. Тэгэхээр бусад депутатууд зөв ойлгоно биз. Ер нь одоо ясны Монгол хумүүс боловсруулсан гэхдээр Зардыханыг оруулж болохгүй гэсэн ухаантай юм уу, одоо юу хэлэх гээд байгаа юм. бэ. Ерөөсөө Үнэн сонини нөхдүүд нэг бус удаа нийтлэл нийтэлсэн шүү. Тэгэхээр энэ Намын Төв Хорооны дарга нар ч байгаа байх. Энэ үндэстэн ястны хооронд яс хаясан, маягийн ийм юмыг Үнэн сонин цаашид анхаармаар юм, эзэнтэй болмоор юм. Энэ үндэстэн ястны асуудал гэдэг бол их эмзэг асуудал юм. Тэгэхээр ер нь их анхаарах хэрэгтэй энэ бас бодууштай юм хэлж байгаа шүү дээ утга нь. Энийг би депутатуудын сонорт хүргэчихье гэж бодсон юм. Анхаарна биз дээ.

С.Зориг: -Түрүүчийн эрхэм депутат Лунаа, Баярцогт нарын асуултанц хариулаадхая. Тэгэхээр парламентын булгэм бол Их Хурлын салбар байгууллага биш. Депутатуудын олон нийтийн байгууллага, тийм учраас олон нийтийн байгууллагын журмаар Их Хурлын хуралдаан дууссаны дараа өөрийнхөө бие даасан хуралдааныг явуулж өөрийнхөө асуудлыг шийдэх ёстой.

14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн: -Би бол ингэж бодож байна л даа. Их цаазын төслийг бол Ерөнхийлөгч батламжлах ёсгүй гэж бодож байна. Үнтэй холбогдуулж Ерөнхийлөгч гарын үсэг зурна

гэсэн энэ хэсгийг авчихвал таарах юм байна.Хууль зийн хувьд бол нийцмэргүй юм шиг байна.

151-р тойргийн депутат Б.Алгаа: -Хамгийн суулд ийм зүйл оруулмаар санагдаж байна.АИХ-ын дэгийг бүлэг, зүйл нэг бүрээр хэлэлцэн нийт депутатууд санал нэгтэй баталлаа гэж нийт бүх үзүүлэлтийг баталсан санаа оруулж өгмөөр байна.Яагаад гэвэл хурал өхлөхээр тэргүүнд би санал өгөөгүй ,энүүнд санал өгөөгүй, тэр бүлэг дээр санал өгөөгүй гэдэг уг гарч ирж магадгүй өнгө цухалзаж байгаа учраас нийтэд нь батлая гэсэн нэг ийм зүйл оруулъя гэсэн санал байна.

163-р тойргийн депутат Б.Мижид: -Тэгэхээр Ерөнхийлөгчийн хуулинд Ерөнхийлөгч батламжлахаар заасан байна шуу дээ.Бага Хурлаас баталсан Ерөнхийлөгчийн хуулинд Ерөнхийлөгч Үндсэн хуулийг батламжлахаар заачижжээ.Тэгэхээр Бага Хурлын хуулийг бид хүчингүй болгохгүй бол болохгүй.

I-р тойргийн депутат С.Баяр: -III бүлэг дээр саналаа хэлье. 15-р зүйл үнэхээр илүү байна гэдэг дээр санал нэг байна.16-р зүйл дээр бол харин депутатуудын хэлж байгаа санал үнэхээр ортой юм.Урд өмнө нь сайн бодоогүй л юм шиг байна.Би энийг боловсруулахад оролцоогүй л дээ,сая харж байхад үнэхээр Их цаазыг түргүний нэг депутатуудын санал гарч байсан.Энд АИХ-ын 2 дугаар хуралдаанд оролцож, Монгол улсын шинэ үндсэн хуулийг баталсан бүх депутатуудын гарын үсэг зурсан цагт энэ бол хүчин төгөлдөр болж байна гэж үзэхээр хийвэл их зүгээр байгаа юм. Үндсэн хуулиа гаргаад бид дагавар хууль гаргана шуу дээ.Энийг одоо нийтэлсүгэй,тэг^{сүгэй} гээд энэ хуулийг нийтлэнэ.Энэ бол үнэхээр Их цаазын төслөөр Ерөнхийлөгч хууль батламжлахгүй байгаа л даа.Тэр үүднээсээ бол Их цааз хуулийг гэдэг нь бол өрөөсөө буруу болчихж.Тийм учраас АИХ-ын тогтоол, протоколыг АИХ-ын дарга гарын үсэгтэйгээр нийтэлнэ.Их цаазын төсөлийг АИХ-ын нийт депутатуудын гарын үсэгтэйгээр хүчин төгөлдөр болсонд тооцно гэдэг ч юм уу тийм ээ.Түүн дээр нь бас нэг ийм юм байгаа юм. 2 дугаар заалтан дээр бид бол бусад хууль гаргаад түүнийгээ яаж

нийтлэх вэ гэдэг дээр нэлээн ярьж байсан л даа. БНМАУ-ын Их цааз АИХ-ын бусад баримт бичгийг гэхлээр таарахгүй байгаа юм. Бусад баримт бичиг дотор хурлын стенограмм энэ тэр ороод явчихаж байгаа юм. Бусад шийдвэрийг Ардын эрх сонинд нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх сурвалж болгон хэрэглэнэ. Бусад сонин хэвлэл ч болно. Гэхдээ Ардын эрхэд хэвлэгдсэн юунд бол албан ёсны эх сурвалж болно гэсэн ийм хоёр засвартайгаар баталвал ясан юм бэ гэсэн саналтай байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ш.БУРМАА

1991.XI.12

Кассет № 66

18.40-18.55

400 дүгээр тойргийн Л.Ламлинсурэн: -Үндсэн хуулийн нэмэлтийн хууль дээр нэг зарчмын юм байна. 17 дугаар зүйлийн 4-т БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурлаар хэлэлцэж баталсан хуулийг гарын усэг зурж батламжилна гэж байна. Ерөнхийлөгч батламж гаргах ёстой. Тийм учраас манай энэ тесел дээр зүгээр гарын усэг зураад нийтэлнэ гэсэн ийм утга агуулга байна. Тийм учраас 16 дугаар зүйлийн 1 дүгээр заалтыг ингэж найруулбал ямар вэ гэсэн саналтай байна. Ерөнхийлөгчийн батламжилсан, батламжилж гарын усэг зурсны дараа хэвлэлд нийтэлнэ гэсэн ийм утгатайгаар оруулбал ямар вэ?

15 дугаар зүйлийг зарим депутатууд ер нь хасъя гэсэн ийм саналтай байна. Энийг би зөвшөөрөхгүй байна. Ер нь энэ оролцсон депутатуудын гуравны хоёрыг гэсэн бүрэн эрхээрээ байх нь зүйтэй байна гэсэн ийм саналыг оруулж байна.

39 дүгээр тойргийн депутат д.Ламжав: -Сая Баар депутатын хэлсэн санал дээр болгоомжлох бол, зохих ёстой нэг юм байна. Зарим депутатын санаанд нийцээгүйгээс болоод нийтдээ их том процентаар батлагдсан мөртлөө тэр хүний гарын усэг зураагүйгээс болоод Үндсэн хууль батлагдаагүй мэт болох тийм явдал гарах вий. Тийм учраас гарын усэг зурах асуудал бол сайн дурын үндсэн дээр тавигдвал их аятаихан болох болов уу гэж ухаандаа, хүсэхгүй депутатыг заавал зур гэх байдалтай орчихвол эвгүй болох юм гэсэн санал байна.

13 дугаар тойргийн депутат Л.Цог: -Одоогийн төслийн 15-ыг хасах нь зүйтэй гэж бодож байна. Яагаад гэвэл, нэмэлтийн тухай хуулийн 5-д байгаа. Яг тэр дүрмээр тэр чигээрээ байна.

Хоёрдугаарт, 16-гийн 1-ийг бухэлд нь хасах нь зүйтэй гэж бодож байна. Хэн гарын усэг зурах нь огт хамаагүй гэж бодож байна. Харин 16-гийн 1-ийг хасчихаад 16-гийн 2-т "БНМАУ-ын Их цааз, Ардын Их Хурлын шийдвэр болон бусад баримт бичиг" гэсэн ийм уг оруулья.

Ж.Уртнасан: -Бусад баримт бичиг гэдэг чинь нэгээе
стенограмм, бичлэгүүд бүгд орчихоод байгаа юм биш уу, бусад
баримт бичиг гэвэл.

Л.Цог: -Шаардлагатай гэвэл болно шүү дээ,
яагаад болдоггүй юм.Хааж болохгүй шүү дээ.Шийдвэр гэсэн угийг
заавал оруулах нь зүйтэй гэж бодож байна.Тогтоол, бүгд орж
яваа.

ЗТ4 дүгээр тойрог М.Гантэмэр: -I6-гийн I дүгээр
заалтыг хараад байхад хэний гарын үсэгтэй нийтлэх тухай
асуудал байгаа.Тэрнээс хэвлэл мэдээллээр гэдэг нь 2 дээрээ
орсон.Хэний гарын үсэгтэй нийтлэх тухай асуудал бол Их цаазыг
бид яж шийдсэнээс болно.Хэрэв Ерөнхийлөгчийн засаглал тог-
тоно гэж бид шийдэх юм бол Ерөнхийлөгч зурах байх, парламен-
тын засаглал тогтоно гэвэл өөр байх болов уу.Тэгэхээр нийтэлнэ
гээд бичье.Их цааз, Үндсэн хуульд аль засаглал тогтох юм.
Тэр нь тэртээ тэргүй гарын үсэгтэй нийтлэгдэхэд хэнд ч ойлгомж-
той.Тийм учраас нэгийг хасья.

Ж.Уртнасан: -Баярлалаа, санал үндсэндээ нэг
байна.Депутатын сонорт хүргэмээр ийм асуудал байна.Тэгэхээр
энэ санал хураалт явуулъя.Тэрний өмнө тайлбар хэрэгтэй байх.
Энэ үнэхээр 3 дугаар бүлгийн I5, I6 дугаар зүйлийг хассан
байхад буруудах юмгүй болж байна.Яагаад гэвэл, I5 дугаар
зүйл нэмэлтийн тухай хуулийн 5-д байгаа.I6 дугаар зүйлийн
I дүгээр заалт бол Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн
I7 дугаар зүйлийн 4-т байж байгаа.БНМАУ-ын Ардын Их Хурал,
БНМАУ-ын Бага Хурлаар хэлэлцэж баталсан хуулийг гарын үсэг
зурж батламжилна гэж.Ерөнхийлөгчийн тухай заалтанд энд байж
байгаа.Тийм учраас энд давхар орох хэрэггүй юм гэж ойлгож
байна.

ер нь

Харин 2 дугаар заалт дээр, I5-ыг хасья, I6-гийн I-ийг
хасья гэсэн саналдууд олон ирлээ.Энд тайлбар тавъя, тавьчих-
лаа.Одоо санал хураалтад орох уу?

3.

400 дүгээр тойргийн депутат Л.Дамдинсурэн:

-Би дахиад босч хэлэхгүй бол болохгүй нээ. Тэгэхээр энэ дээр ийм шүү дээ. Бид Ерөнхийлөгч энэ хуулийг чинь бас узаж танилцаж, гарын үсэг зурж батламжилна шүү дээ. Хэрэв Ерөнхийлөгч батламжахгүй бол Их Хурал дахин авч узаж хэлэлцээд тэгээд хүлээж аваагүй бол энийг чинь албан ёсоор хүчин төглөдөр боллоо гэж үзнэ. Нэмэлтийн тухай хууль өөрчлөгдөөгүй. Энүүгээр бол Ерөнхийлөгч, Ардын Их Хурал болон Бага Хурлын баталсан хуульд хориг тавих эрхтэй гээд заасан байж байгаа.

Тэгэхээр бид энэ хуулиа хэзээ нийтлэх вэ гэдгээ бас тогтох хэрэгтэй. Ерөнхийлөгч шууд баталсны дараа маргааш нь гарын үсэг зураад нийтлэх юм бол энэ хүн дараа нь дахиад узаж, завсарлаж, саналаа оруулж батламжах эрхгүй болчихно шүү дээ. Энийг эрхбиш харгалзаж узаж эрхэм депутатууд батламжилсны дараа нийтлэх уу, шууд маргааш нь нийтлэх уу гэдэг асуудал байна. Тэгэхээр хэний гарын үсэгтэй яах вэ?

14 дүгээр тойрог С.Лхагвасурэн: -Би ахиад нэг хэлчихмээр байна. Нагаад Ерөнхийлөгч энийг гарын үсэг зурж, батламжахгүй вэ гэдэг талаар би саналаа хэлэх гээд байна. Хууль эрх зүйн хувьд болохгүй байна. Манай Ерөнхийлөгч монголын бүх ард түмний шууд сонгуулиар сонгосон бол энэ Үндсэн хуулийг батална.

Их Хурлаасаа Ерөнхийлөгч сонгосон болохоор энэ бол үнэндээ хууль эрх зүйн хувьд бол үнэхээр таарахгүй асуудал. Тэгэхээр энийг батлах асуудал бол Ардын Их Хурлын II хуралдаанаар батлав гээд хойно нь гарын үсэг байхгүй, автоматаар энэ хууль батлагдах ёстой гэж би ойлгож байгаа шүү.

27 дугаар тойрог Л.Цурэвдорж : -Их цааз бол Бага Хурлын баталж байгаа ердийн хуулиуд шиг хууль биш ээ. Энэ бол Ардын Их Хурал өөрийнхөө бүрэн эрхийн хэмжээнд, бүх депутатууд өөрсдөө бодол саналаа нэгтгэж байж байгаа хамгийн том хууль маань энэ. Тийм учраас энэ Ардын Их Хурлын энэ тогтоол, өөрөөр хэлбэл, хууль баталж байгаа тогтоолд зөвхөн Ардын Их Хурлын дарга ганцаараа гарын үсэг зурж

4.

батламжилна. Ерөнхийлөгч бол энд хамаа байхгүй. Тэгэх ёстой.

Л.Дампинсурэн:

Бага Хурлаас баталсан Ерөнхийлөгчийн хуулин дотор ийм заалт байж байна. Хэрвээ бид хоёр депутатын тавьсан шиг Ерөнхийлөгчөөр батламжуулахгүй гэвэл бид Улсын Бага Хурлын баталсан энэ хуулийн заалтыг хүчингүй болгосон хуулийг гаргаж байж ... Тийм учраас энэ болохгүй юм. Эцсийн цэг тавиад энийг санал хураая. Хэрвээ Ерөнхийлөгч батламжлахаар байгаа юм бол тийм хуультай бол Ерөнхийлөгч батламжилсан зарлигаа дээр нь Ерөнхийлөгчийн гарын үсэгтэй нийтэлнэ. Их цаазын батлагдсан төслийн дор нь Улсын Их Хурлын дарга Уртнасан гээд хэвлэе. Ингээд саналаа хураая.

315 дугаар тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ: -Тэгэхээр бид яармааргүй байна. Бидний энэ З дугаар бүлгийн гарчиг бол ингэж байгаа шүү дээ, Ардын Их Хурлын шийдвэр гаргах, нийтлэх журам. Тэгэхээр шийдвэр гаргах юман дээрээ бид нар хоёрхон өгүүлбэр байж байгаа, энийг хасья гээд улсууд яриад байх юм. Энэ дээр санал зөрүүтэй байна.

Урьд талын гуравны хоёроор шийднэ, явна гээд байсан чинь бол бүлэг, дэд бүлгүүдийн асуудал. Энэ бол ерөөсөө Үндсэн хуулиа юмуу, Их цаазаа бухэлд нь батлах, мөн Үндсэн хууль, Их цаазынхаа хавсралт хуулийг бухэлд нь батлах тухай асуудал энэ бүлэг дээр яригдаж байна шүү дээ. Зарчмын ийм асуудал байна гэж үзэж байна. Түрүүн нэг депутат их хоржоонтой санал гаргасан. Тэрнийг анзаарагүй өнгөрчихлөө. Тийм учраас эцэст нь боловсруулсан бүх юмаа бухэлд нь батлах, "батална" гэсэн энэ өгүүлбэрээ хасмааргүй байна.

427 дугаар тойрог Ц.Элбэгдорж: -Энэ дээр хэлэхгүй бол болохгүй боллоо гэж бодож байна. Бид нар Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулиа барих ёстой. Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 4-т заасан байгаа. БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурлаар хэлэлцэж баталсан хуулийг гарын үсэг зурж батламжилна гэж Ерөнхийлөгчийн тэр хэсэгт заасан байгаа юм. Энийг барих ёстой гэж бодож байна.

Дараачийн нэг зүйл бол Ерөнхийлөгч ард түмнээс сонгогдсонд ч, Их Хурлаас сонгогдсонд ч аль ч тохиолдолд Монгол улсыг төлөөлнө. Аль ч засаглалтай бай, Ерөнхийлөгч л байгаа тохиолдолд энэ хүн Монгол улсыг бухэлд нь төлөөлж байгаа. Монгол улсын энэ их хууль, Их цаазын энэ хүний гарын үсэг байх ёстой. Та бид батлах нь батална. Ардын Их Хурлын депутатууд гарын үсэг зурах тухай асуудал дээр би энэ дээр зөвшөөрч чадахгүй байгаа. Энэ шаардлагагүй гэж бодож байгаа.

15 дугаар тойргийн депутат Д.Лундээжанцан: -Элбэгдоржийн саяын хэлсэнтэй ерөнхийдөө таарч байна. Гэлээ гэхдээ Их Хурлын баталсан хуулийн дор Их Хурлын дарга гарын үсгээ зурна. Дээр нь Ерөнхийлөгч батламжилдгаараа батламжилна. Энэ нь Ерөнхийлөгч хориг тавьж байгаа хэрэг биш ээ. Ерөнхийлөгчийн батламжлах тухай заалт, хориг тавих заалт хоёр бол Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиар хоёр тусдаа заалт байгаа. Ардын Их Хурал, Бага Хурлаас баталсан хуулинд гарын үсэг зурж батламжилна гээд байгаа. Хуулин дотроо Үндсэн хууль, ердийн хууль гэж хоёр хуваагддаг. Энэ бол хуулиңдаа Ардын Их Хурлаас баталж байгаа хуульдаа хамаарна.

Хоёрдугаарт, Ерөнхийлөгч бол манай улсын тусгаар тогтолц, Монголын ард түмний эв нэгдлийн баталгаа, төрийн тэргүүн гээд заасан. Ийм учраас энэ бол манай Үндсэн хуулинд бэлгэ тэмдэг, бэлгэ дэмбэрэлтэй давхар баталгаа болж байгаа юм. Харин тэрнээс биш Ерөнхийлөгч батламжлахдаа хориг тавих эрх байхгүй, зөвхөн символический батламжилж өгнө.

Ц.Элбэгдорж: -Лундээжанцан депутат аа, хууль барьчихаад яагаад худал яриад байна аа. Яг 4-ийн ард талд 5 гээд байгаа шүү дээ. БНМАУ-ын Ардын Их Хурал, Бага Хурлаас баталсан хууль, бусад шийдвэрт хориг тавина гэж байгаа. Ерөнхийлөгч мөн Их цаазад хориг тавьж болно. Нэг асуудлаа эргэж хараач, депутатууд аа гэсэн асуудлыг тавьж болно шүү дээ, баталсны дараа. Хууль барьчихаад ингэж худлаа ярыж болохгүй, олон түмний толгой эргэнэ.

6.

Д.Лүнлээжанцан: -Хориг тавихын хувьд бол ярих асуудал байгаа байх аа. Ардын Их Хурлын баталсан хуулинд хориг тавих асуудал дээр. Үндсэн хуулин дээр хориг тавих асуудал.

280 дугаар тойргийн депутат Ш.Цэнлбаяр: -Энд ийм зүйл бодогдоод байна. Тэгэхээр Үндсэн хуулийг хэн батламжлах вэ гэдэг асуудал бол үнэхээр бусад ердийн хуулиудыг бодвол энэ онцгой чухал зүйл болов уу гэж бодогдох юм. Үүнтэй холбогдуулаад энэ Ардын Их Хурлаас тусгай хууль гаргаж, эсвэл Үндсэн хуулийн нэмэлтийнхээ хуульд өөрчлөлт оруулж энэ асуудлыг шийдвэрлэвэл ямар вэ гэдэг ийм санал байна.

Энэнтэй холбогдож депутат Баярын санааг хуульчийн хувьд тайлбарлаж өгнө уу, өөрөө ч түрүүн энэ саналыг хэлсэн. Ийм саналтай байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:

Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.ОЮУНЧИМЭГ

1991.II.12
Кассет № 67
18.55-19.10

Уртнасан -Ерөнхийлөгчид уг өгье.

П.Очирбат -Эрхэм хүндэт депутатууд энэ үндсэн хуулийг батламжлах эсэх тухай асуудал энэ хуулинд гарын усэг зурах тухай асуудлыг ярьж байна. Энэ үнэхээр ярих ёстой зүйл. Үндсэн хуулийн нэмэлтийн хуулинд БНМАУ-ын Үндсэн хуулийг батламжилна гэсэн уг байхгүй. Ер нь АИХ, Улсын бага хурлын баталж гаргасан хуулийг батламжлана, хориг тавьж болно гэсэн ийм заалт бий. Тэгэхлээр хууль гэдэг утгаар нь Үндсэн хуулийг ч мөн хамааруулж болно. Тэгэхдээ АИХ-ын 400 гаруй депутатуудын баталчихсан тэр улсын үндсэн том хуулийг ерөнхийлөгч батламжлах шаардлага байхгүй гэж бодож байна. Энэ бол арай өөр зүйл. Заавал хамааруулаад одоо хууль л юм чинь энэ хуулиндаа багтаагаад батал гэвэл батламжил гэвэл та бүхний л шийдэх асуудал. Миний хувийн бодол ойлголт юу байна вэ гэвэл энэ үндсэн хуулийг нэг ерөнхийлөгч батламжилж хэрэггүй байх аа, цугаараа 427-уулаа ч гарын усэг зурах хэрэггүй байх. Ер нь одоо Ардын Их Хурал, ээлжит хуралдаанаараа энэ хуулийг олонхийн гэнэ хү, хэд гэнэ вэ заавал 100 хувийн санал авчихсан болбол батлагдсанд тооцно гэсэн юм байхгүй ээ. Тийм учраас тэр л батлах хэмжээндээ л хүрээд батлагдсан л болбол АИХ-ын II хуралдаанаар батлав гэвэл болох юм болов уу гэж бодогдож байна.

Хэрэв Үндсэн хуулийг баталсан тухай хууль гаргавал тусад нь тэгвэл өөр хэрэг ээ. Тэгвэл тэр хуулин дээр хэн гарын усэг зурах вэ гэсэн нэг асуудал байгаа юм шиг байна. Тийм учраас би бол Үндсэн хуулийг та бүхэн, АИХ түүний депутатууд цугаараа батлчихаад тэгээд тэргүүгээр хууль батлагдсан гээд тооцож болох байх аа гэж. Тэр үндсэн хуулийг батлагдсан хуулийг нийтлэхэд дор дээр нь ямар нэгэн гарын усэг байх шаардлага байхгүй. Тэр хэнийг ч төлөөлөхгүй, тэр юны ч тухай ярьж байгаа юм биш байх аа. Нэгэнт энэ удаагийнхаа Их хурлын хуралдаанаар баталчихсан л болбол болох байх гэж би бодож суугаа.

Бат-Үүл- Ерөнхийлөгчийн сая хэлсэн энэ зүйл бол хэтэрхий өөцөггүй юм ярьж байна шүү дээ. Яагаад гэвэл ерөнхийлөгч

маань Үндсэн хуулийн нэмэлтийн хууль ёсоор БНМАУ-ын тусгаар тогтнолын бэлэгдэл, үндэсний эв нэгдлийн бэлэгдэл, одоо ухаан нь төрийн тэргүүн гэж яваа. Тэгээд тусгаар тогтносон БНМАУ өөрийнхэе БНМАУ-ынхаа хуулийг баталж гаргаж ирж байна. Ардын Их Хурал нь. Бид чинь хуулийг баталдаг байгууллага, батламжилдаг эзэн нь өрөнхийлөгч. Тусгаар тогтносон улсынхаа өрөнхийлөгчөөр тусгаар тогтнолын бэлэгдэл гэдэг чинь санамсаргүй уг биш шүү дээ. Тэр зүгээр санамсаргүй хийчихсэн юм бол авч хаях хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр энэ дээр үнэхээр бодмоор байна. Тэгэхээр энэ дээр ийм ээцэггүй юм ярьж боломгүй байна нэгд. Хоёрт, Ардын Их Хурлын хэлэлцэх асуудал дотор Үндсэн хууль гэж байдал. АИХ-ын хэлэлцэх нэг гол асуудал бол үндсэн хууль өөрөө байж байгаа. Тэгэхээр зэрэг АИХ-ын гаргасан хуулинд хориг тавих, батламжлах асуудал өрөнхийлөгч гэж байгаа шүү дээ. АИХ-ын чинь хууль Үндсэн хууль байгаа шүү дээ.

358 дугаар тойргийн депутат Жаншансамбуу-Би нилээн олонхийн саналыг харж суулаа. Ер нь манай дэг баталж гаргахдаа маш их олон зүйл анги, маш их хэмжээний юм хийлгээ энэ хүмүүсээс гэж бодож ийм олон зүйл анги оруулаагүй байх гэж бодож байгаа. нэгд. Хоёрдугаарт, илүү байлаа гэхэд үүнийг хийсэн хүмүүсээс чухам ямар бодолтой, ямар санаатай тухайлбал энэ 15 дугаар зүйлийг хасмааргүй бодогдож байна л даа. Энд бол зохих хэмжээндээ, цаг үедээ таарсан үүрэг гүйцэтгэх учраас үүнийг оруулсан гэж үзэж байгаа. Хэрвээ хасахаар болбол үүнийг хийсэн хүмүүсээс чухам зорилгыг нь сонсож байж хасчихаж болно гэх юм бол хасч болно. Хоёрт, төрийнхөө өрөнхийлөгч байгаа учраас энэ өрөнхийлөгчөө би Их хурлаас батлагдаж гарсан үндсэн хуулийг батламжуулах нь эйтэй гэсэн депутатын хувьд санал оруулж байна.

I дүгээр тойргийн депутат Баяр -Тэгэхлээр сая өрөнхийлөгчийн хэлсэн зүйл дээр бас юм бодогдож байна л даа. Депутат Бат-Үүл ч ярьж байна. Бид хуулийн хүрээн дээр л бодмоор байна. Нэмэлтийн хуулийн 17 дугаар зүйлийн 4 дээр гарын үсэг зурж батламжлана. Ардын Их Хурал, Улсын бага хурлын хэлэлцэж баталсан хуулийг гэж байгаа юм. 5 дээр нь хориг тавина гэж байгаа юм. Тэгэхлээр бид нэгэнт үндсэн хуулиа батламжуулна гэдэг тал дээр нь аваад үндсэн хууль гэдэг маань АИХ-аас баталсан хуулийн хүрээндээ байна аа гэж үзэх юм бол бид 5-ыг заавал авч таарна.

Бидний батламжилж гаргасан үндсэн хуульд нэгэнт л батламжлах юм бол хориг тавих эрх нь ерөнхийлөгчид байна гэдэг талаар нь ойлгомоор байгаа юм л даа. Тийм учраас энэ бол ерөнхийлөгч батламжилж таарахгүй санагдаад байгаа юм. Батламжлах юм бол хориг тавих эрх нь цаана нь үлдэж байгаа учраас. Тийм болохоор I6 дугаар зүйлийн I-ийг АИХ-ын. Энд чинь батлах тухай асуудал биш шүү дээ I6 дугаар зүйл. Нийтлах тухай асуудал яригдаад байгаа юм. Батлах, батламжлах тухай асуудал энд байхгүй байгаа юм. Тэгэхлээр нэгэнт энд нийтлэх тухай асуудал ярьж байгаа учраас нийтлэлийнхээ хүрээнд нь АИХ-ын, БНМАУ-ын Их цааз, АИХ-ын хууль тогтоол, бусад шийдвэрийг АИХ-ын даргын гарын усэгтэйгээр нийтэлнэ. Хоёрдахь хэсэг нь БНМАУ-ын Их цааз АИХ-ын хууль, тогтоол, бусад шийдвэрийг Ардын эрх сонинд нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх сурвалж болгон хэрэглэнэ. Гурав нь хэвээрээ. Ийм байдлаар I6 дугаар зүйлийг баталбал ийм асуудал гарахгүй юм шиг санагдах юмаа.

Түрүүний би депутатын бүх гарын усэг авна барина гэдгийг батламжлах юмуу тэрнийг бүгдээрээ гарын усэг зурчихсаных нь хувьд хууль хүчин төгөлдөр боллоо гэдэг утгаар нь яриагүй юм л даа. Би буруу уг хэрэглэсэн байх. Үүнийг түүхэн дурсгал болгоно үлдээнэ гэдэг юмуу тэр талаар нь найруулж оруулбал депутатууд эевшөөрвөл тэгж хийж болж байгаа юм. Шаардлагагүй гэж узэх юм бол ёслолын чанартай арга хэмжээ юм хууль баталдаг үндсэн хууль баталдаг тэр журмаараа л З-ны 2-оороо л бид батална. Үүнийг батлаагүй учраас би гарын усэг зурахгүй гэдэг ийм тийм гарч магадгүй учраас би саналаа эргүүлж авахад бэлэн байна. Бас ёслол төгөлдөр байх үүднээс ийм юм байвал болмоор юм шиг санагдаж байгаа юм. Тэрнээс батлах, батламжлах утгаар нь бишээ.

I56 дугаар тойргийн депутат Гантөмөр -Тэгэхлээр энэ I6-р зүйлийн талаар шууд санал хураах саналтай байна. Депутатууд ер нь үндсэн асуудлаа ойлголоо гэж узэж байна. Гагихуу чухам энэ Их цаазын доор гарын усэг хэн зурах вэ гэдэг дээр асуудал шийдэхгүй байна гэж узэж байна. Бага хурлын практикаас узэх юм бол Бага хурлаас гаргаж байгаа хуулиуд дээр Бага хурлын дарга,

нарийн бичгийн дарга хоёр баталдаг, гарын үсэг зурдаг. Ерөнхийлөгч батламжилдаг. Ер нь Их цааз дээр бол ерөнхийлөгчийн гарын үсэг заавал хэрэгтэй. Харин дээр нь байх уу, доор нь байх уу гэдгийг шийдвэр ёстой. Заавал энэ хэрэгтэй. Тэгэхлээр миний бодлоор болбол Их цаазын доор гарын үсэг зурахдаа Их хурлын дарга Уртнасан, хуралдааны ерөнхий нарийн бичгийн дарга Моломжамц гэж гарын үсэг зураад дээр нь ерөнхийлөгчөөр батлуулах нэг ийм хувилбар байж болно. Ерөнхийлөгчийн хэлдэг саналаар онцгой хууль гэж үзэх юм бол ердөө л дор нь ерөнхийлөгчөөр гарын үсэг зуруулбал яасан юм бэ гэсэн ийм санал байна.

Т. Очирын - Ерөнхийлөгчийн түруун хэлсэн зүйлийг би гайхаж байна л даа. Ерөнхийлөгч Их хурлын гишүүн, Бага хурлын гишүүн хэн ч байсан өнөөдөр мөрдэж байгаа Үндсэн хууль, Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулиа барих ёстой. Их цаазын төсөл батлагдтал энэ хууль бол хүчин төгөлдөр өө. Сарын дараа хүчинтэй болтол ч гэсэн энэ хуулиа л барих ёстой. Тэр хуулин дотор хоёр зүйл ерөнхийлөгчийн эрхэд байж байгаа тэр нь бол нэгдүгээрт, Их хурал, Бага хурлаар батлагдсан хуульд гарын үсэг зурж батламжлана гэж нэгдүгээрт байж байгаа. Хоёрдугаарт нь хориг тавьж болно гэж байж байгаа. Энэ эрхийг, энэ үндсэн хуулийн нэмэлтийн хүрээнд заасан эрх хэмжээнийхээ дагуу л хийгдэх ёстой гэж үзэж байна. Өнөөдөр бол ерөнхийлөгчийн байх сууринаас уг асуудалд хандахаас биш хувь хүний байр сууринаас хандаж болохгүй ээ. Тэр одоо нэмэлтийн тухай хуулиа бариад л шийдвичих асуудал. Нэгэнтээ уг хэлж байгаатай холбогдуулаад л 15 дугаар зүйл дээр Үндсэн хууль болон түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг З-ны 2-ын саналаар батална гэдгийг авч хаяж болохгүй ээ. Харин зүйл заалтыг олонхийн саналаар эхний хэлэлцүүлгээр батлаад эцсийн хэлэлцүүлэг дээр З-ны хоёроор гэсэн процердурараар явах ёстой. Тийм учраас тэрийг хасах саналыг зөвшөөрөхгүй байна аа.

2 дугаар микрофон. Бямбаа - Энд би нэг юм хэлье. Манайхан ардчилал дээр ардчилал хөгжсөн орнуудын туршилагыг авч хэрэглэж байгаа. Энэ Америкийн үндсэн хууль гэхэд бараг 200 жил засвар ороогүй шахам үндсэн хууль гэдэг.

Энэ үндсэн хуулийг Америкийн өрөнхийлөгч Жорж Вашингтонд доор нь гарын үсэг зурсан байна.Өөрийнхөө өхөн хэлээр байж байгаа хууль нь энэ байж байна.Ингэхээр энэ хамгийн суулийн 1787 оны 9 дүгээр сарын 17-ны нэгдэх едрийн конвенц гэдгээр яагаад өрөнхийлөгч нь гарын үсгээ зураад баталчихжээ.Тэгэхлээр өрөнхийлөгч үндсэн хуулийг батламжилж байгаа явдал бол тэрийг болно, болохгүй гэж баталж байгаа хэрэг биш энэ хуулийг батлаад хүчин төгөлдөр гээд гаргачихсан юм шүү, энэ нь үнэн юм шүү гэдэгт давхар баталгаа өгч байгаа учраас л өрөнхийлөгч батламжлах нь зөв.Өөр хэн ч хэрэггүй.

25 дугаар тойргийн депутат Л.Энэбийш -Тэгэхдээ энэ бол гол нь Бямбаа гуай хэллээ.Ер нь ингэж хэвлэгдэх байх л даа. Үндсэн хуулиа болбол II хуралдаанаар тогтоол гаргаж батална шүү дээ.Тогтолцой байх байх.Тэгэж хэвлэгдэнэ.Дээр нь болбол өрөнхийлөгч бол заавал батламжилна.Энэ бол ард түмэн дараа нь асууна.Яагаад энэ өрөнхийлөгч батламжилсангүй вэ, нэмэлтийн хуулинд байгаа гэж хүн асуувал юу гэх юм бэ, хуулинд байгаа, тийм учраас өрөнхийлөгчөөрөө заавал батламжуулах ёстой.Негээ нэг юм бол өөр нэмэлт гарч ирж магадгүй шүү дээ.Хавсралт, хууль, бас өөр юм.Тэгвэл энэ хуулийг батламжлаагүй, дараа өөр нэмэлт юм ороход батламжлах уу гэж асууна шүү дээ.Тэгэхээр заавал батламжуулах ёстой.

49-р тойрог. Болц -Сая Бямбаа депутат дутуу хэлчихлээ л дээ. АНУ-ын Үндсэн хуульд бол өхлээд өрөнхийлөгч гарын үсэг зураад, тэр хуулийг баталсан бүх депутатууд тэр штатаас гэдгээ заагаад нэрээ заагаад гарын үсгээ зурсан байгаа.Тэгэхлээр энэ дээр бүрнээр нь хэлбэл тэрнийг батламжилсан тогтоол гэх юмуу тэр конвенцид өрөнхийлөгч дангаараа гарын үсэг зурах ёстой байх.Ийм тусдаа хоёр баримт бичиг байна.Манай энэ тохиолдолд болбол шинэ Үндсэн хууль батлана гэдэг бол Монгол улс цоо шинэ замд орох түүхэн том үйл явдал байна шүү дээ.Тэгэхлээр үүнийг бол хуучин хуулиудаа хараад тэрэндээ нийцүүлэх гэж заавал оролдоод байх шаардлага байхгүй.Негээ талаар бид бол, бидний түүхэн үүрэг бол үнэхээр энэ шилжилтийн үе шатыг эхлүүлэх, шинэ Үндсэн хуулийг батлах энэ бол бидний хамгийн гол үүрэг байгаа.Энэ АИХ-ын бүрэлдэхүүний нь.Ингээд үзэх дээр бидний

дотор ямар юм цухалзаад байна вэ гэхлээр зэрэг өрөөсөө энэ үндсэн хуулийг батлахгүй гэдэг юмуу өсвэл тэрэнд чинь би хамаагүй гэх тийм сэтгэлгээтэй хүн байж болзошгүй юм шиг яриад байх юм. Миний бодлоор бол тийм хүн байхгүй байх. Өөрөөр хэлбэл 75 хувиар батлагдлаа гэхэд тэр цаана нь үндсэн 25 хувь хүмүүс бол өрөөсөө хамаагүй гэж хэлэхгүй шүү дээ. Эргээд энэ чинь Үндсэн хууль, бид бүхний дээд болох шүтээн болсон хууль. Тийм учраас тэрэндээ нэгэнт хэлэлцэж байсан, оролцож байсан, түүнийг батлахаад ямар нэгэн саналаар оролцож байсан хүний хувьд бол тэр хуулийн дор гарын үсэг зурахад бол үнэхээр түүхэн үйл явдлынхаа хувьд зайлшгүй юм л даа. Нэгөө талаар эргээд тэр үндсэн хууль маань хэрвээ өрөнхийлөгч, тэгээд манай энэ дарга нар чинь бүгд депутатууд байгаа, тойрог, тойргоороо депутатууд гарын үсэг зурсан тохиолдолд тухайн ард түмнээс сонгогдсон депутат бүрийн нэр байгаа учраас үүний цаана монголын ард түмэн бүхэлдээ хамрагдаж энэ Үндсэн хууль баталгаажиж байна гэсэн ийм баталгаа байх юм байгаа биз. Хэвлэлд нийтлэхдээ ганцхан тэр өрөнхийлөгчийн гарын үсэгтэй нийтэлнэ. Тэрнийг энэ дэгээр зохицуулчихаж болно. Энэнээс хүн болгон айгаад, татгалзаад байх, нэгэнт батлагдсан үндсэн хуулийн тухайд байхгүй байх аа гэсэн саналтай байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

Баянчолц

/БАЯНДҮҮРЭН/

БИЧЭЭЧ

/Д. ЭНЭБИШ/

1991-XI-12
Кассет № 68
19.10-19.30

Уртнасан:

Уучлаарай. Зарлалын чанартай зүйл байна. Санал авмаар байна. Яагаад вэ гэвэл бид 7 цагт 19 цагт завсарлаж байх ёстой. Одоо 15 минут өнгөрч байна. Хэрэв та бүгдийг зөвшөөрвөл энэ дэгээ баталж дуусаад завсарлавал ямар вэ.

За баярлалаа. Завсарлагаа өнөөдөр дэгээ хэлэлцэж дуусаад завсарлай.

Одоо дахиж санал авахаа болж.

Цог:

Би нэг асуудал ойлголоо. Энд сууж байгаа бүх хүн бол Үндсэн хуулиа манай өрөнхийлөгчийг батламжилна гэсэн ийм сайхан санаа гарч байна. Энэ зөв санаа, тэгэхдээ хуулинд байхгүй санаа. Энэ санааг хийж өгье гэвэл энэ дэгэндээ биш хавсралтын тухай хуулиндаа хийж өгье. Тэгэхгүй бол энэ дэг чинь хуулиас илүү болчих гээд байна шүү дээ. Энийг зөв ойлгохгүй, бид энэнд хийж өрөөсөө болохгүй. Энэ саянхaa санааг хавсралтын тухай хуулиндаа хийж өгье. Нэмэлтийн тухай гэж нэрлэж байгаа тэр хуулинд Үндсэн хууль хүчин төгөлдөр болох өдөр сарыг хүртэл заасан байгаа. Тэндээ оруулж өгье. Эндээ биш.

I65-р тойргийн депутат Ч.Гомбосурэн:

За уучлаарай депутатуудаа. Тэгэхээр бид энэ Ардын Их Хурлын жинхэнэ хийх, жинхэнэ хийх ёстой ажлаа ганцхан ноогдсон өрхтэй ийм ажлаа хэлэлцэж байгаа гэдгийг мэдэж байгаа. Үндсэн хууль хэлэлцэх хамгийн гол ганц үүрэгтэй. Тэгэхдээр энэ асуудал дээр ийм санал байна. Энэ саян олон маргаантай асуудал дээр, маргаантай юу байхав, олон талаар яригдсан асуудал дээр Ардын Их Хурлаа Ардын Их Хурлын хуралдаанаар баталсан гэдгийг Үндсэн хуулийн доор нь БНМАУ-ын Ерөнхийлөгч гарын үсэг зурчихаж тийм хууль зүйн аль нэг талаар буруутаад байх зүйлгүй гэж бодож байна. Тийм учраас дээр нь Ардын Их Хурлын хуралдаанаар баталсан, доор нь Ерөнхийлөгчийн гарын үсэгтэйгээр нийтэлвэл яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Хоёрдахь санал бол 15 дугаар зүйлийг хасахгүй, хэвээр нь батлах саналтай байна. Тэр хэвлэлээр нийтэлнэ гэдгийг дээрх өгүүлбэртэйгээ нэгтгэмээр байна.

2.

I48 дугаар тойргийн депутат Д.Баттулга:

Зүгээр эсрэг санал хэлэх гэж байна. Энэ нэмэлтийн тухай хуулийн хоёрдугаар зүйл дээр бол Ардын Их Хурлын эрхэнд Үндсэн хуулийн асуудал байгаа. Батлах асуудал. Батлах батламжлах хоёр өөр л дөө. Гэхдээ.

Нэгөө талаас 5 дугаар зүйл дээр Ардын Их Хурал хэлэлцсэн асуудлаараа хууль тогтоол гаргана гэж байнаа. Энэ бол хоёр өөр ангилаар авч узсэн гэж би, ойлгож байна. Нэгөө талаар энэ үндсэн хуулийн нэмэлтийн хуулийг аваад үзэхэд Үндсэн хууль, бусад хууль гэсэн хэллэг дандаа явж байгаа гэж ойлгож байна. Үндсэн хууль, бусад хууль гээд яваад байгаа. Тийм учраас Ерөнхийлэгчийн Ардын Их Хурлын батламжлах энэ эрх нь тэр бусад хуульдаа, өөрөөр хэлбэл тэр 5 дугаар зүйлд заасан Ардын Их Хурал хэлэлцсэн асуудлаар хууль гаргана гэдэг энэ хуулинд хамаарч байгаа гэж ойлгож байна. Харин хоёрдугаар хуулиар батлах үндсэн хуульд хамаarahгүй байгаа гэж ингэж ойлгож байгаа. Яг энэ хуулийн узэл санааг аваад үзэхэд. Тийм учраас энэ Үндсэн хуулийн асуудлыг батлах нь Бага Хурлын асуудал. Батламжлах тийм эрх Ерөнхийлэгчид байхгүй. Харин эний дагуу гарах тэр хавсралт хууль гэж бид нар гаргах байх. Тэрийг л батламжлах. Тэр бол бусад асуудлаар нэгдсэн тэр бусад хууль гэдэгт хамаарч байгаа учраас.

Яг энэ Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн узэл санааг нэгд нэгэнгүй уншихад нэг ийм л юм хэлэгдэх гээд байх л байна гэж. Ийм санал хэлж болно.

354 дүгээр тойргийн депутат Х.Баянмөнх: Би бодож байна. Энэ Үндсэн хуулийг мэдээжийн хэрэг Ардын Их Хурлын 2 дугаар хуралдааны тогтоол гарна. Тогтоол гарч баталж таарна. Тогтоол дээр Их Хурлын дарга гарын үсэг зурна. Бид бол одоо ямар шаардлагатай байна вэ гэвэл Үндсэн хуулийг, яг Үндсэн хуулийг тийм хүн батална гэсэн тийм хууль алга. Яг уг, угсээр нь. Тийм учраас мэдээжийн хэрэг Үндсэн хуулийг бол Ерөнхийлэгч батална. Энэ Үндсэн хуулийг батлах ажилд бүх саналаа өгч оролцсон бүх депутатууд гарын үсэг зурна. Үнийг батламжилсан хууль гарах ёстой. Хууль гаргаж байж, бүрэн эрхийг баталж байж ингээд Ерөнхийлэгч гарын үсэг зурж, бүх депутатууд гарын үсэг зурсан ийм баталгаа үлдэнэ.

273 дугаар тойргийн депутат Н.Жанцан: Энэ асуудал бол нэг их будлиад байх асуудал биш гэж би үзэж байгаа юм. Энэ хуулийг дээдлэх ёс нэгэнт манай улсад дэлгэрч байгаа учраас Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлтийн хуулинд энэ асуудлыг заасан гэж үзэж болно. Их Хурлын баталсан хуулийг Ерөнхийлөгч батламжилна гээд энэ Үндсэн хуулийн чинь хуулиндаа заачи-хаад байхад, энийг хаанаас батламжилах уу, хэн батламжлах уу, яаж батлах уу гэж хайгаад байх явдалгүй юм. Ийм учраас бол Үндсэн хуулийг Их Хурлын батлах хууль гэдэгт чинь хамгийн эх-лээд Үндсэн хууль, хууль гэдэг агуулгандаа бүх хууль шин-гэнэ. Ийм учраас Их Хурлын баталсан Үндсэн хуулийг бол Ерөнхийлөгч батламжилна. Батламжлаад зогсохгүй энэ батламжлах том ёслолын ажиллагаа явагдах байх гэж би бодож байна. Түүхэнд юу болж үлдэх вэ гэвэл хэрвээ Монгол улс Үндсэн хуулийн баяр гэж тэмдэглэх юм бол тэр батламжилсан өдрийг л тэмдэглэх ёстой.

Ийм учраас энэ асуудлыг Ерөнхийлөгчөөрөө батламжуулах ёстой гэж би үзэж байна. Ерөнхийлөгч хувь хүнийхээ хувьд энд яг Үндсэн хууль гэдэг уг байхгүй байхад би батламжилъя гэж хэлэх нь ёс зүйн хувьд ч сайхан биш, тийм учраас Ерөнхийлөгчийг би батламжилъя гэж хэлсэн гүй гэж зэмлэх зүйл байхгүй болов уу гэж бодож байна. Ийм л зүйл байна.

За санал таслай.

72 дугаар тойргийн депутат А.Болат: Би 15 дугаар зүйл дээр нэг юм хэлмээр байна. Бид энэ 2 дугаар хуралдааны дэг баталж байгаа энэ тохиолдолд 2 дугаар хуралдаан маань өөрөө хэрэг дээрээ Үндсэн хуулийг батлах л үүрэг хүлээж байгаа. Эргээд тэрэн дээрээ нэмэлт өөрчлөлт оруулах тухай санаа байх шаардлагагүй гэж бодож байна. Тийм учраас энэ боловсруулж байгаа комиссын сонорт тавихад түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн нэмэлт санааг хасчих хэрэгтэй байна. Дараа нь батламжлах асуудал санал давхардсан учраас би энд дурдах хэрэггүй гэж үзэж байна.

Уртнасан:

За санал хураалтанд бэлтгээ.

15 дугаар зүйл дээр редакцийн ямар нэгэн засвар хэлээгүй. Депутатуудын нэг хэсэг нь хасая, нэг хэсэг нь хэвээр үлдээе гэсэн ийм саналтай байгаа. Тийм учраас хажуугийн саналыг урьдал болгоод санал хураачихъя. Тэгвэл хэрэв энэ маань шийдэгдчих юмаа.

15 дугаар зүйлийг хасъя гэдэг дээр санал хураалт явуулж байна.

Санал хураалтанд бэлтгэнэ уу.

За Баярлалаа. Энэ заалт үлдэж байна. Яагаад вэ гэвэл хасъя гэдгийг татгалзаж байгаа депутатын тоо 67 хувь буюу 273 хүн байна. Зөвшөөрсөн нь 30 хувь буюу 123 нь зөвшөөрч байна. 273 нь татгалзаж байна. 12 хүн тудгэлзлээ. Энэ заалт хэвээрээ үлдлээ.

За 16 дугаар заалт дээр би депутатуудыг нэгдсэн ойлголт-той болсон гэж бодож байна. Үнэхээр манай Үндсэн хуулийн нэмэлтний тухай хуулийн Ерөнхийлөгчийн хэсэгт 4 дүгээр зүйл дээр байж байгаа. Хуулийг их хурал, бага хурлын баталсан хуулийг Ерөнхийлөгч батламжилна гэж. Энэ бол хүчин төгөлдөр хэвээрээ, Үндсэн хууль бол хууль гэдэгтээ багтана гэдэг депутат Ханцан-гийн саналтай би ч гэсэн санал нэг байна. Тийм учраас Их Хурлын хэлэлцэж баталсан хуулийг тогтоолоор, бид тогтоол гаргах байх. Тогтоол дээр Их Хурлын дарга гарын үсэг зурах байх. Ерөнхийлөгч батламжилна гэдэг асуудал хуулинд баталгаатай хэвээрээ үлдэж байна гэж үзэж байна. Ийм учраас 16 дугаар зүйлийн I дүгээр заалтыг эндээс хасчихъя гэсэн санал депутатууд гаргаж байна. Хориг тавьчихаж болно гэсэн заалт хэвээрээ байгаа шүү дээ.

Даргаа ганцхан уг хэлчихъе.

Уртнасан: Санал хураалт явуулжъя. Санал хураалтын дараа тайлбар тавьж цөөнх болбол саналыг сонсоё.

Цогийн саналыг сонсмоор байх юм.

16 дугаар зүйлийн I дүгээр заалтыг хасъя гэдэг санал хураалт явуулж байна. Санал хураалтанд бэлтгэнэ уу.

За I6 дугаар заалтыг хасъя гэдэг саналыг 40 хувь нь буюу I6I хүн зөвшөөрч, 23I хүн татгалзаж байна, 57 хувь нь Ийм учраас I6-гийн I дүгээр заалт үлдлээ. Түдгэлзсэн хүн I4 байна.

I6 дугаар зүйлийн 2 дугаар заалт. Энэ дээр депутат нэг найруулгын чанартай засвар хийсэн. Бусад баримт бичиг гэдгийн оронд шийдвэрийг гэсэн ийм уг оруулъя гэж. Ийм редакци хийгээд энэ заалтыг үлдээхээр санал хураалт явуулах гэж байна. Санал хураалтанд бэлтгэнэ уу.

БНМАУ-ын Их цааз, Ардын Их Хурлын шийдвэрийг Ардын эрх сонинд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд дамжуулна гэсэн ийм томъёололтой байх юм.

Санал хураалт явуулъя. I6-гийн 2 дээр. Санал хураалтанд бэлтгэнэ уу.

Санал хураалт явуулж байна.

За баярлалаа. Энэ заалтыг санал өгсөн депутатуудын 96 хувь нь зөвшөөрч байна. 392 депутат зөвшөөрлөө. I2 хүн татгалзаж, 5 хүн түдгэлзсэн байна.

I6 дугаар зүйлийн 3 дугаар заалт. Энэ дээр зарчмын бүр техникийн алдаа юм болов уу, найрлага муутайхан хийсэн гэж бодож байгаа юм. Ардын Их Хурлын хуралдааны протоколд гээд протоколд Ардын Их Хурлын дарга, хуралдааны ерөнхий нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна гэж байгаа юм. Тэгэхээр

Уучлаарай. Энэ дээр ийм редакци байх юм шиг байна. Хуралдааны протоколд, тогтоолд Ардын Их Хурлын дарга, аппаратын ерөнхий нарийн бичгийн дарга гарын үсэг зурна гэж байх юм байна. Хуралдааны биш, аппаратын. За ийм уг, үсгийн засвар хийгээд.

За ойлголсоо. Ардын Их Хурлын хуралдааны протоколд Ардын Их Хурлын дарга, аппаратын нарийн бичгийн дарга гарын үсэг зурна гэсэн ийм найруулга байх юм байна.

За ингээд санал хураалтанд бэлтгэнэ уу.

За баярлалаа. Санал өгсөн депутатуудын 93 хувь нь буюу 307 хүн З дугаар заалтыг зөвшөөрч байна. 18 хүн татгалзаж, 8 хүн түдгэлзлээ.

За одоо заржал мэдээллийн чанартай ...

Уучлаарай депутатууд аа.

Даргаа бүхэлд нь баталчих юм биш уу.

Уртнасан: Одоо энэ дэгээ зүйл, зүйлчлэн ярьж дууслаа. Тийм учраас одоо бид батлаад, редакцийн комисст шилжүүлье.

Нэрээр санал хураах дээр асуудал бий шүү.

Уртнасан: Дэгийг одоо бид дэгийг батлаад редакцийн комисст шилжүүлье. Та бидний өгсөн санамж зөвлөлгөөний дагуу редакцийн комисс өнөөдөр эцсийн засвар хийгээд маргааш өглөө бидэнд энэ дэгийг сонсгоё гэж бодож байна.

За ингээд дэгийг зарчмын хувьд батлах санал хураалт явуулъя.

Нэрээр санал хураах дээр бий шүү.

Санал хураалтанд бэлтгэнэ уу.

Цөөнхийг сонсох журамтай шүү дээ.

Санал тавимаар байна. Даргаа

27 дугаар тойргийн депутат Л.Пүрэвдорж: Тэгэхээр бид зүйл ангиар нь баталчихлаа шүү дээ. Одоо бүхэлд нь батлахыг редакци хийсний дараа, нэгмөсөн маргааш батлая. Редакци ямар байгааг ерөөсөө мэдээгүй байж байгаа шүү дээ бид нар. Тэгвэл энэ чинь гурван удаа хэлэлцэх болж байна шүү дээ. Тийм учраас маргааш батлая. Би тийм саналтай. Редакци хийсний дараа нэгмөсөн батлах хэрэгтэй.

Уртнасан:

За саналыг хүлээж авлаа.

Тойрог нэрээ хэлээгүй:

Ийм байна хурлын даргаа. Одоо бид чинь ерөөсөө Пүрэвдорж

депутатын саналыг би хувьдаа зөвшөөрөхгүй байна. Ийм учраас депутатууд дэгээ үндсэндээ хэлэлцүүлээ. Энийгээ өнөөдөр батлах нь зүйтэй. Тэгээд редакци хийгээд саяны хурлын даргын саналыг депутат миний хувьд дэмжих байна.

Хурлын даргаа санал байна.

284 дүгээр тойргийн депутат Ш.Бадам: Энэ хоёр санал гарч байна. Одоо батлахгүй, маргааш батлана гэх юм бол маргааш зуйл зүйлээр нь дахиж уншин сонсож байж, тэгж байж батлах ажил гарна шүү дээ. Тэгэхээр маргааш бүтэн өдрөө авна гэсэн үг. Тийм учраас одоо батлах уу, маргааш батлах уу гэдэг дээр санал хураагаад шийдчихье.

14 дүгээр тойргийн депутат Лхагвасүрэн:

Уртнасан:

Энэ ер нь цаг удаан ургэлжлэх нь байна. Олон санал гарах нь. Хоёр хувилбараар санал хураалт явуулчихъя.

Дэгийг одоого батлая гэсэн санал хураалт эхлээд явуулчихъя.

Үндсэнд нь батлаачихъя л даа зарчмын хувьд.

За санал хураалтанд бэлтгэнэ үү.

Буяндэлгэр:

Би нэг хувилбар хэлсэн, та хүлээж авсан миний бодлоор.

Хурлын даргаа.

Та тэндээ хүлээж авсан шүү дээ. Энийг хэлэлцүүлэхгүй юу. Та хүлээж авсан тиймээ.

Уртнасан: Учлаарай. Тойрог, депутатынхаа нэрийг хэлэхгүй юу.

188 дугаар тойргийн депутат Буяндэлгэр. Би нэг санал өгсөн тэр З дугаар хуралдаан хэрвээ бид хуралдвал энэ дэгээ, бас тэр дараачийн хуралдааныхаа дэгийг баталж дуусахгүй шүү дээ.

Больё, больё.

Энийг мөрдөё. Энэ мөрөөдөл биш. Энэ бол магадгүй бид сарын дараа ч эргээд хуралдах мэднэ. Тэгээд ийм байгаа юм. Тэр саналыг шаардлагатай бол хэлэлцүүлэхгүй.

Хоёрдугаарт Ерөнхийлөгчийн түрүүн хэлдэг бол зөв юмаа. Ерөнхийлөгч Үндсэн хуулийг батламжлах эрх дарх.

Би Цог депутатын саналыг дэмжиж байгаа юм. Үндсэн хууль, хууль хоёр чинь өөр гэж ойлгоод байгаа юм. Учлаарай би нэг гадаад уг хэрэглэхээс болохгүй нь. Конституци закон гэдэг тэр талаас нь аваад үзэх юм бол энэ бол өөр юм гэж би ойлгоод байгаа. Үндсэн хууль, хууль хоёр бол. Энэн дээр бол Үндсэн хуулийн нэмэлтийн хуулинд зайлшгүй Үндсэн хууль гэсэн хоёр уг оруулж өгөхгүй бол ерөөсөө болохгүй гэж би бодоод байна. Тэгэхээр энийг энэ талаас нь эргэж яахгүй бол болохгүй юм шиг байх юм.

Уртнасан:

Учлаарай. Дэг Үндсэндээ батлагдаж байна.

Санал хураалт явуулахад бэлтгэнэ үү. Депутатууд аа.

Хурлын даргаа би нэг зөвшөөрөл авсан байгаа шүү дээ. Түрүүн.

Л.Олончимэд:

Хүндэт депутатууд аа. Та нөхөд байна шүү дээ монголын нэг уг байдаг. Алдын нь аваад дэлэм дээр нь, атгы нь аваад чимх дээр нь гэж.

Өчигдрөөс хойш хоёр хоног энэ дэгийн тухай ярилаа. Хэрэгтэй, хэрэггүй зүйл дээр маш их цаг алдсан. Гэхдээ бид нар редакцид даалгаад орхисон нэлээд ноцтой ноцтой юмнууд байгаа. Энийгээ мартчихаад одоо хоол ундандаа яараад ингэж тэвдэхийн хэрэггүй гэж бодож байна. Маргааш нэгдүгээрт редакцийн хийсний дараагаар батлах саналтай байна. Хоёрдугаарт хурал хаях тухай, хурлаас завсарлага авах тухай, дэгийн хугацааны тухай, саяян Үндсэн хуулийг батламжлах тухай олон асуудлыг бид дутуу, нээлттэй орхиж байна шүү дээ. Тэгэхээр бид өнөөдөр яараад байх хэрэг байхгүй. Тэртэй, тэргүй цаг зарсан юм маргааш бүр сайн хэлэлцэх батлая. Тэгэхгүй бол Цүрэвдорж депутатын хэлдгээр бид гурван удаа хэлэлцэх гэж байна. Ийм учраас маргааш батлах ийм саналтай байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн
Бичээч

ЭНХТУЯА
В.ОЮУН

1991-XI-12
Кассет № 69
19.30-19.46

Д.Энхбаатар / 178-р тойргийн депутат/ -Түрүүн нөгөө санал хураах дээр би ингэж хэлсэн шүү дээ. Хэрэв энэ санал батлагдахгүй бол би нэг санал гаргана шүү. Дараа нь эрхийг нь өгөөрэй гэж хэлээд суусан шүү дээ. Тэрэн дээр бол бугд надад тэр эрхийг нь өгчихсөн гэж би ойлгоод байгаа юм. Тэгэхээр, өгсөн. Хэрэв батлагдахгүй бол би өөр санал гаргана шүү гээд, хэлчихье тэр саналаа. Ер нь нэрээр санал хураагдах асуудал шийдвэгдэхгүй нь. Тэгэхээр нэрээр санал гаргая гэж өөрөө хүсч байгаа депутатууд өөрийнхөө нэрийг өгөөд нэрээр саналаа өгөг. Тэгээд тэд нар нэрээр санал гаргаад өгсөн депутатуудын нэрсийг хэвлэлд нийтлэх эрхтэйгээр, тэгээд нэрээр өгөөгүй депутатууд өөрсдөө тойрог дээрээ очоод сонгогчилдоо тайлангаа тавиг.

Нэрээр санал өгөхийг хүссэн депутатуудыг өөрийнхөө нэрийг өгөөд хэвлэлд нийтлэх эрхийг нь дэг дээрээ өгчихье.

М.Энхсайхан /45 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр ийм юм. Бид нар редакцийн групп байгуулсан. Редакцийн группэд бол аливаа нэгэн асуудлыг шийдвэрлэ гэж өгөөгүй. Бүгд шийдсэн асуудлаа өгсөн. Ганцхан тэрийг зөв томъёолох уу, угүй юу гэдэг асуудал дээр маргаан бий. Тэгэхээр бид өнөөдөр зарчмын хувьд дэгээ батлах хэрэгтэй. Яагаад гэхээр маргааш асуудал яриад эхлэхэд биднийг дэглэх дэг байхгүй. Тийм учраас тэр дэгээ баталчихаад, тэруутгээрээ явж байгаад редакци оруулж ирсний дараа бидний олонхиор баталсан юм зөв болж уу угүй юу гэдэг дээр дахин батална. Тэгэхгүй бол, өнөөдөр дэгээ батлахгүй бол маргааш асуудлыг хэлэлцэж чадахгүй байдалд хүрнэ. Тийм учраас батлах нь зүйтэй гэж бодож байна.

Ж.Уртнасан -Санал хураалт явуулъя. Дэгийг одоо зарчмын хувьд батлах уу угүй юу гэдэг дээр санал хураалт явуулъя. За санал хураалтанд бэлтгээрэй, санал хураалт явуулж байна. Дэгийг зарчмыг хувьд баталъя гэж байгаа нь зөвшөөрснийг дарна

шүү дээ. За баярлалаа. Санал өгсөн депутатуудын 90 хувь нь дэгийт өнөөдөр баталъя гэсэн санал өгч байна, 368 хүн. За одоо дахин санал хураалт явуулъя. Дэгийг баталъя гэсэн санал хураалт явуулах гэж байна. Уучлаарай бид олонхидоо захирагдъя. За санал тогтвортой байгаа юм байна. Санал өгсөн депутатуудын 90 хувь нь буюу 369 хүн дэгийг зарчмын хувьд баталлаа. 28 хүн татгалзаж байна, 12 хүн түдгэлзэж байна. За баярлалаа.

За одоо зарлал, мэдээллийн чанартай асуудлууд байна. Тэгэхээр манай Ардын Их Хурлын II хуралдаанд сонордуулах бичиг ирсэн байна. 1991 оны II дүгээр сарын II № I. Энэ сонордуулах бичгийг үндэсний төрийн зөвлөлийг зохицуулах хороог санаачлагчид гэдэг ийм нэртэй төвөөс ирсэн. Энэ /уучлаарай/ үндэсний төрийн зөвлөлийг зохицуулах хороог санаачлагчид гэж. Тэгэхээр бид хаяг адрес тодорхой байхгүй байна гээд ажлын группэд буцаасан юм. II дүгээр сарын 12-ны 16 цагт Улсын нийгэм хангамжийн газрын автобаазын газрын жолооч Жаргалсайхан гэдэг хүн манай групптэй ирж уулзсан байна. Энэ хороог 10 дугаар хороог 7 хүнийг бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ардын Их Хурлын II хуралдааны шийдвэр гарсан хойно улс төрийн үйл ажиллагаа явуулна. Аймаг, хотод салбар байгуулна. Ардын Их Хурлын даргатай биечлэн уулзаж санал солиццоно гэсэн ийм хусалт тавьж байгаа юм байна. Энэ сонордуулах бичгийг та бухэнд сонсгоё.

Эрхэм хүндэт депутатууд аа! Манай улс орны ард түмэн маань хүнлэг арчилсан нийгэмд хүний ариун сайхан сэтгэлийг хүндэтгэн дээдэлж, дээдсийн ёсыг эрхэмлэн амьдрах нь хүний ёс билээ. Гэтэл улс, эх орон, ард түмэн маань эдийн засгийн хямралын ирмэг дээр байгааг мэдсээр байж улам доройтуулж, хүн ардынхаа итгэл найдварыг ул ойшоон, арчиллын далбаан дор худал хуурмаг угээр хуурч, эдийн засгийн шинэчлэлийг хийхдээ цөөн тооны ашиг хонжоо хайгчдын үүд хаалгыг нээн өгч, нийгмийн бухимдал, хэв журмыг улам гааруулж ирснийг ард түмэн маань хилэгнэн буруушааж, Ардын Их Хурлын II хуралдааныг хийхтэй холбогдуулан Ялалтын талбайд эх оронч үзэл нэгтэй холбоодууд эв нэгдлийг нэгтгэн цуглаан хийсэн билээ. Энэхүү

3.

цуглаан нь анх гарч ирсэн нам, холбоод болон түүний удирдах нөхдийн адил хэсэг булэг хумуусийн зохиомол үйл ажиллагаа болон улс төрийн хоосон цэцэрхэж хийсэн цуглаан биш, харин ч хот, хөдөөгийн хөдөлмөрчдийн чин үнэн, эх орноо дээдлэн хундэтгэх цуглаан болсныг талархан дэмжих, тус хуралдаанд өргөн барьсан мэдэгдлийг өрхэм хундэт депутатууд та бухэн мэргэн оюун ухаандаа соёрхон хулээж авна гэдэгт гүнээ итгэж байна. Улс, эх орон, !^{ард түмэн} ур хүүхдийнхээ төлөө бидний хэсэг хумуус улс төрийн хонжоо наймаа харж тохуурхах биш, эх оронч узлийнхээ үүднээс энэ өдрөөс эхлэн төрийн үндэсний зөвлөлийн зохицуулах хороог санаачлан байгуулж, албан ёсоор зарлан тунхаглаж байна.

Энэхүү үндэсний төрийн зөвлөлийг зохицуулах хороо нь Ардын Их Хурлын II хуралдаанаас гарсан шийдвэрт дүгнэлт хийсний дараагаар улс төрийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэх болно. Ийнхүү үндэсний төрийн зөвлөлийг зохицуулах хороо нь тус хуралдаанд доорх саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Нэгдүгээрт, 1991 оны II дүгээр сарын 10-нд болсон хөдөлмөрчдийн цуглаанаас гаргасан мэдэгдлийг бүрэн өхөөр нь шийдвэрлэж өгөх.

Хоёрдугаарт, Дэд ерөнхийлөгч, Бага Хурлын дарга Гончигдорж тэргүүтэй Бага Хурлын гишүүдийг шинэчлэн өөрчлөх.

Гуравдугаарт, Засгийн газрын Брөнхий сайд Бямбасүрэн, Шадар сайд Дорлигжав нарыг ажлаас нь өөрчлөх.

Дөрөвдүгээрт, Тэргүүн шадар сайд Ганболд, Монголын парламентын булгэмийн дарга Зориг, депутат Элбэгдорж нарыг албан тушаалаас нь өөрчлөх, үүний хамтаар Монгол банкны ерөнхийлөгч Жаргалсайхан, Гадаад тооцооны газрын дарга Сүх-Эрдэнэ нарын хумуусийг үүрэгт ажлаас нь өөрчилж, шуух, прокурорын байгууллагад шилжүүлж, ард түмэнд мэдээлэх.

Тавдугаарт, 1992 оны 3 дугаар сард бүх нийтийн ардчилсан сонгууль явуулах.

Зургадугаарт, Ардын Их Хурлын дарга Гомбожав тантай 1991 оны II дүгээр сарын 12-нд уулзалт хийх зэрэг саналуудыг Ардын Их Хурлын хуралдаанд болон депутат та бүхэнд илэрхийлж байна гэсэн ийм сонордуулах бичиг иржээ.

Д.Баттулга /148 дугаар тойргийн депутат/ -Хурлын даргаа энд ганцхан юм байна. Би наад мэдэгдлийн чинь талаар ярихгүй. Би зүгээр хурлын дарга нарт нэг юм хүсмээр байна. Депутатуудад ч гэсэн хандаж. Юу вэ гэхээр, энэ бол Ардын Их Хурал. Төрийн эрх барих хамгийн дээд байгууллага. Бид анхнаасаа бас учиртай-хан шиг байх хэрэгтэй. Юу вэ гэхээр, энд байгаа мэдээлэл, цахилгаан эд нарыг бол эсвэл монгол улсад албан ёсоор буртгэгдсэн тийм байгууллагынх нь мэдээг сонсмоор байна. Эсвал хөдөлмерчдийн, хувь хүний мэдээг сонсмоор байна. Буртгэсэн нь мэдэгдэхгүй, буртгээгүй нь мэдэгдэхгүй, иймэрхүү юуг эндээс албан ёсоор сонсгох нь энэ бас зүйд нийцэж байна уу угүй юу гэдэг нь бас хурлын удирдлагууд авч үзсэн нь дээр байх. Хэрэв үнэхээр наадах чинь улс төр яах юм бол албан ёсоор буртгүүлээд, зүйл ажиллагаа явуулаад ингэж байгаа бол нэг өөр хэрэг. Чухам ямар нь мэдэгдэхгүй, албан ёсны, угүй нь мэдэгдэхгүй ийм юмыг энд сонсгож ингэж факт болгох нь эвгүй байх гэсэн саналтай байна.

Ц.Элбэгдорж /427 дугаар тойргийн депутат/ -Даргаа энэн дээр нэг зүйл хэлье. Энэ Латвид ард түмнээ аврах фронт гэж гарч ирээд нэг ч хүн олдолгуй алга болж байсан. Латвид улс төрийн байдлыг маш хүчтэй, эвгүй, тогтвортгуй байдалд хургэж байсан. Үндэсний төрийн зөвлөлийг зохицуулах хороо, эхлээд нэргүй ирсэн. Дараа нь та шаардсан, нэг хүн нэрээ тавьж ирүүлсэн юм байна шуу дээ.

Ж.Уртнасан - Тийм. Нэргүй ирсэн. Манай ажлын группийнхэн энэ удирдагч, санаачлагчдыг нь тодотгоё гэдэг утгаар дахин

уулзалт хийсэн. Жаргалсайхан, Улсын нийгэм хангамжийн газрын автобаазын жолооч Жаргалсайхан гэдэг хүн энэ байгууллагыг толгойлж байгаа юм байна.

Ц.Элбэгдорж -Би энэн дээр хариуцлагатай нэг зүйлийг хэлье. Энд сууж байгаа депутатууд бол бүгдээрээ төрийн зутгэлтийн, төрийн бодлоготнууд. Бид бүхэн төрийн нуруунаас л юманд хандах ёстой. Тэгэхдээ ийм зүйлийг харааныхаа гадуур өнгөрөөх ёсгүй шүү. Иймэрхүү юмнууд зарим улс оронд гарч байсан, тэгээд гарч ирээд алга болдог. Аль эсвэл төрийг хямралд хургэдэг. Ард түмнээ аврах фронт ч юм уу, дандаа ийм нэрээр гарч ирдэг. Үндсээ аврах фронт, Улс үндсээ аврах фронт, ийм нэрээр сайхан уг гарч ирж, ард түмний зовлон дээр дөрөөлж, төрийг хямралд хургэдэг шүү.

Р.Доржбат /101-р тойргийн депутат/ -Би Засгийн газарт олон нийтийн байгууллагыг хариуцсан хүн байгаа юм. Тэгэхээр энэ хороо бол ийм хороо манайд ямар ч тийм буртгэл байхгүй. Энэ Жаргалсайханыг 1990 оноос хойш Ажилчны эвсэл бил уу, холбоо билүү ийм нэртэй нэг байгууллага, нэгдсэн холбоо гэдгийг байгуулсан. Тэрнээс хойш олон удаа иймэрхүү юм ирүүлж байсан. Одоо болохоор энэ улс төрийн ямар юм гэнээ, ийм нэг хороо гэдэг юм байгуулчихсан байна. Иймэрхүү юмнуудыг хүлээж авмааргүй байна. Ямар ч баталгаа алга. Засгийн гаэар анхааралдаа авна биз. Өөр энэн дээр авч хэлэлцэх юм байхгүй.

Э.Бат-Үүл /52 дугаар тойргийн депутат/ -Уртнасан даргаа горимын санал байна. Тэгэхээр ингээе. Энэ ажлын хэсэг, саяын тэр, та нар нэрийг нь сонсоорой. Наадах чинь төрийн дэргэдэх төр бий болчихсон ч юм уу, тур засаг байгуулчихсан ч юм уу, нэг ийм хачин юм гараад ирчихсэн байна шүү дээ. Тэгэхээр энийг чинь тодруулах хэрэгтэй шүү дээ. Энэ чинь, тур засаг байгуулчихсан юм уу, ясан юм Жаргалсайханаас асуух хэрэгтэй. Тийм учраас ажлын хэсэг яах вэ гэхээр наадах чинь ямар учиртай байгууллага юм бэ? Олон нийтийн байгууллага юм уу, та нар тур засгийн газар байгуулсан юм уу, тэрийг нь асууж байж энэ чинь асуудлыг тавихгүй бол

боловгүй. Наадах чинь яг нэрнээс нь харахад нэг олон нийтийн байгууллага юм уу, улс төрийн нам ч юм уу, тийм биш, наадах чинь үндэсний төрийн зөвлөлийн үндэсний хороо гэж байгаа юм. Тэгэхээр энд бол нэг ийм, Уртнасан даргаа, яг одоо энэ Ардын Их Хурлын, наадах чинь их чухал асуудал л даа. Ардын Их Хурлын чуулган хуралдаж байхад Ардын Их Хуралд ямар нэгэн байдлаар дарамт үзүүлэх гэсэн нэгт тийм юм гарна. Тэгэхдээ бид тэр асуудлуудыг ажлын хэсэг анхааралтай үзэх бөгөөд яах ёстой вэ гэхээр, хэрэв Шархаднаас арван галзуу хүн ирээд асуудал тавьчихсан байвал яах вэ энийг чинь. Бид хэлэлцээл байх юм уу? яах юм бэ? Тэгэхээр тур засгийн газар байгуулчихсан юм бол, тэр тур засгийн газар асуудлаа хэлмээр байна шүү дээ.

Ж.Уртнасан -Уучлаарай Элбэгдорж депутат аа. Энийг та бүхэнд болгоомжуулж, сэрэмжлуулж сонордуулж байгаа юм. Энэ бол цаад талдаа эзэнтэй юм. Ажлын групп дахин шалгасан. Харин зугээр ер нь ирсэн мэдээлэл бүгдийг бид ингэж мэдээлж байх уу? Эсвэл бид дахин шүүлт хийж байх уу гэдэг дээр санал тогтмоор байгаа юм.

С.Билэгсайхан /184 дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр ийм мэдээлэл егч байгаа нь нэгдүгээрт зөв байна. Тэгэхдээ би зүгээр сурвалжлах хэсэгт хүсэлт тавья. Ийм тийм болчимгүй мэдэгдлийг заавал, сая бол зургийг нь бүгдийг авлаа л даа тиймээ. Тэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулахгүй байхыг хүсье. Мэдээлж байх нь зөв.

Ж.Уртнасан -Энэ зарчмын санал юм. Тэгэхээр бид эндээс сонсож байгаа зүйлийг мэдээллийн хэрэгслээр олон түмэнд, нийтэд түгээх тал дээр болгоомжлох хэрэгтэй юм. Сая манай төлөвизийн нөхдүүд зураг авах шиг боллоо. Бичлэг хийх шиг боллоо. Харин үүнийг ард түмэнд тэгж их яаралтай мэдээлэх шаардлагагүй гэж үзэх байна.

С.Харжаубай /86 дугаар тойргийн депутат/ даргаа тэгэхээр наадах чинь ийм байна шүү дээ. -Хурлын Тэгэхээр юм

болов тодорхой байна. Одоо ерөөсөө бид энд сууж байгаад Засгийн газраа бараг алдчихсан байна шүү дээ. Ерөөсөө ийм байна, төрөө алдчихсан байна шүү дээ бид бол. Яг одоо мэдэгдэл бол тийм байна. Терийг зохицуулах холбоо гэнэ уу ямар юм гэнээ? Үндэсний зөвлөлийн хороо гэж байна. Тэр цуглаан хийгчид бол тодорхой шүү дээ. Жухиг-лээд юу гэх вэ дээ. Жаргалсайхан гээд. Эзэн нь тодорхой байж байна шүү дээ. Тэгэхээр ингээд Их Хурал руу дарамт үзүүлж байгаа, Их Хурал руу, депутатуудад дарамт үзүүлж байгаа ийм улсуудыг хүлээж авахын ямар хэрэг байна. Харин тэр улсуудтай албан ёсоор бид уулзъя Тэр лидруудтэй нь уулзъя. Депутатын хэсэг байгуулаад уулзаад, дахиад иймэрхүү юм хийгээд байх юм бол бид тэр улсуудыг шүүхэд шилжүүлье. Албан ёсны. Энэ улсууд бол албан ёсны бус тэр байгуулсан байна шүү дээ. Өөр зам байхгүй. Ард түмнээс нуутдаад албан ёсны тэр байгуулсан байна шүү дээ энэ улсууд. Тэгэхээр депутатын хэсэг байгуулаад албан ёсоор ярья.

Ж.Уртнасан -Депутатууд аа зарлалын чанартай хоёр турван зүйл байна. Монголын залуучуудын холбооны идэвхтнүүд хуралдааны дараа зааландаа үлдээрэй гэсэн зарлал байна. Бид энэн дээр тогтвортой суугаад шийдчих хэрэгтэй юм. Үнэхээр бид зөвхөн энэ халуун тогоон дотроо асуудлыг сонсоод мэдээд, сонордож байя гэвэл энэ телевизийн нэвтрүүлэгт саяын хийсэн бичлэгийг нийтэд зарлахгүй байх тухай санал хураалт явуулж, энийг албан ёсоор хаах нь зүйтэй юм. Санал хураах шаардлагатай болов уу гэж бодож байна.

О.Пашбалбар /10 дугаар тойргийн депутат/ -Уртнасан даргаа. Энд би зайлшгүй нэг хариу хэлэх ёстой гэж бодож байна. Өчигдөр "281"-ийн холбоо жагсаал, цуглаан хийсэнтэй энэ асуудал ямар ч холбогдолгүй бөгөөд, зарим нэг хүн холбох гээд байх шиг байна.

Хоёрт гэвэл, энэ хариуцлагыг хүлээж чадах улсууд нь албан ёсоор юмаа батлуулаад, цагдаагийн газар, хотын захиргаанаас бүх зөвшөөрлөө аваад, бүх юмыг хуулийн хүрээнд хийгээд, хуулийн хүрээнд ард түмнийхээ дунд мэдээллийн хэрэгслээр явуулсан. Нөгөө талаар гэвэл энэ зүгээр бидний явуулсан уйл ажиллагааг далимдуулж

манай уйл ажиллагааг унагаах, Ардын Их Хуралтай бид бүгдийг сергэлдүүлэх гэсэн тодорхой улс төрийн хүчний зохион байгуулсан ийм ажиллагааг гэж үзэж байна.Хэрэв ийм балмад ажиллагааг та нар өөрсдөө дэвэргэж өгөх юм бол харин энэнээс чинь үүдээс илүү ноцтой юм гарч мэднэ шүү гэдгийг анхааруулъя.Бид аль болохоор тайван, харилцан бие биеэ ойлголцож, хэрэв ийм дээрээ тулах юм бол, Харжаубай ч шүүхэд өгөх биш, би ч шүүхэд өгөх биш, Харжаубай бид хоёр харин нэг зуу зуу тулгаад уулзах хэрэгтэй байх. Утгагуй юм болж байна шүү дээ нээрээ.Ийм утгагуй юм хэрэг алга. Бид 400 гаруй депутат байна, өнеөдөр 1937 он гэдэг чинь хардлаг, сэргэлэгээс эхэлсэн.1937 оноо давтах гээгүй юм бол нээрээ больцгооё та минь.Энэ бол утгагуй, ийм л байна.

—Хурлын
даргаа Дашбалбараас нэг юм асуумаар байна.Ямар ноцтой юм гарах юм бэ тэрийг асуугаач.

О.Дашбалбар -Би ноцтой юмыг чинь хэлээд өгье.Ямар ноцтой юм гэж хэлж байгаа юм бэ гэхээр тэртээ тэргүй тэмцлийн хэлбэр бол ажил хаялт юм уу, өлсгөлөн зарлах, жагсаал, цуглаан хийх байдаг.Ажил хаяна гэдэг асуудлыг олон салбар хороод юм уу, мөн янз бурийн хэсгүүд тавьж байгаа.Харин бид ажил хаялтыг ерөөсөө байж болохгүй, улс орноо аварна гэж байгаа бол ажил хаялт гэдэг чинь улс орны эдийн засгийг улам туйлдуулна, ийм учраас ажил хаялтыг бид больё.Асуудлыг Их Хуралдаа тавья гэдгийн үүднээс цуглааныг хийгээд, ажил хаялтын бүх замыг энэ арван салбар хороо нийлж ярилцаад болиулсан.Тэгээд дээрээс нь бид Их Хуралдаа асуудлаа хуулийн дагуу уриалга гаргаад тавьсан. Би уншиж өгье гэсэн.Өчигдөр Их Хурлын дарга уншиж хэрэггүй, дэгээ хэлэлцээд дууссаны дараа хэлэлцэх асуудлын өмнө уншаарай гэж хэлсэн.Би маргааш өглөө уншаад албан ёсоор гардуулж өгнө.Ийм байна.

Ч.Тэрбиш /406 дугаар тойргийн депутат/ -Энд нэг их сүйд болоод сандраад байх юм өрдөө санагдахгүй байна.Хувь хүн юм уу,

албан газар мэдээлэл өгөө л биз. Мэдээллийг Ардын Их Хурал сонсоо л биз. Энэнээс болоод үймээд, тэрэнд автагдаад бид чинь заавал тэдний саналаар яваад байх ч юм байхгүй. Албан ёсоор буртгэгдсэн, буртгэгдээгүй гэж маргаад байх ч юм байхгүй. Бидний өнгөрсөн жилийн туршлагууд бий. Албан ёсоор буртгэгдээгүй байхдаа олон нийтийн байгууллагаас та шаардлага тавьж ирээд шаардлагаа тавьж л байсан, хэрэгтэй гэснийг нь авч л байсан. Хэрэггүй гэдгийг нь болж л байсан. Ер нь одоо бид нэг сандраад байлгүй ажлаа явуулмаар байна.

О.Дашбалбар /10 дугаар тойргийн депутат/-...

...баталгаатай хэлж чадаж байна. Бид нараас ямар ч тохиолдолд хунт гарагчтай. Та нар одоо энэнд санаа зовохгүй байж болно. Ардчиллыг бид тууштай дэмжинэ. Эдийн засгийн өөрчлөлтийг дэмжинэ гэдгээ хэлчихсэн шүү дээ. Харин ардчиллын нэрээр цөөн хэсэг хүн тоглоом тавьж, жужиг наадахыг ^{дэмжинэ гэдгээ} хусэхгүй. Түүнээс биш жинхэнэ ардчиллыг, жинхэнэ утгаар нь ! хэлээд байхад та нар яагаад мушкиад байгаа юм бэ? Энийгээ сайн ойлгоорой.

Ж.Уртнасан -За депутатууд аа.

Дахин нэг зарлал байна. Өнөөдрийн хуралдааны дараа аймаг, хотын МАХН-ын хорооны дарга нар Даш-ёндөнгийн өрөөнд цугларна уу гэсэн зарлал байна. Улаанбаатар хотын 52 тойргоос сонгогдсон депутатуудаас МАХН-ын бүлэгт орох саналтай депутатууд одоо эндээ түр үлдэнэ уу. МАХН-ын бүлгийн ахлагч гэсэн зарлал байна.

Хажуу талын зүүн хонгилд энэ хуралдаан эхлэхийн өмнө харсвтай дөрвөн узэг харандаа хаясан тул олсон хүн байвал өгч тусална уу? 33 дугаар тойргийн депутат Мөнхөө гэсэн ийм зарлавууд байна.

Редакцийн груп II дүгээр өрөөнд очоорой.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Алтанцэцэг

д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Т.Уранчимэг